




**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**



**Japan
Fund for
Poverty
Reduction**



**ХӨДӨӨ АЖ АХУЙ ХӨДӨӨГИЙН ХӨГЖЛИЙН - НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ ТӨСӨЛ
ХӨДӨӨ АЖ АХУЙН НЭМҮҮ ӨРТГИЙН СҮЛЖЭЭГ ДЭМЖИХ ТЕХНИК ТУСЛАЛЦАА
TA8960 MON ТӨСӨЛ**



ОЙРХ ДОРНОДЫН ОРНУУДЫН МАХНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА

(Саудын Араб, Кувейт, Катар)



**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**



**Japan
Fund for
Poverty
Reduction**



**ХӨДӨӨ АЖ АХУЙН НЭМҮҮ ӨРТГИЙН СҮЛЖЭЭГ ДЭМЖИХ ТЕХНИК ТУСЛАЛЦАА
ТА8960MON ТӨСӨЛ**

**ОЙРХ ДОРНОДЫН ОРНУУДЫН МАХНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

(Саудын Араб, Кувейт, Катар)

Хугацаа: 2019 оны 1 дүгээр сар – 7 дугаар сар (6 сар)

Гүйцэтгэгч: Эй Ар Эн Эй ХХК

УБ, Хан-Уул дүүрэг, 2 хороо

Утас: 99017050, 99713272

Е-майл: dosku05@gmail.com, jagalbayt@gmail.com

АГУУЛГА

1. ТОВЧ ХУРААНГУЙ	8
2. ТАНИЛЦУУЛГА	10
2.1. ХЭРЭГЖИХ ХУГАЦАА.....	10
2.2. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ.....	10
2.3. СУДАЛГААНЫ БАГ.....	11
2.3.1. Багийн бүрэлдэхүүн болон ажлын хуваарь.....	11
2.4. АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	12
3. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	13
4. ЗОРИЛТОТ ОРНУУДЫН ХЭРЭГЛЭГЧИЙН ЗАН ТӨЛӨВ, УЛАМЖЛАЛ, ОНЦЛОГ	17
4.1. ХЭРЭГЛЭГЧИЙН ЗАН ТӨЛӨВ, УЛАМЖЛАЛ.....	17
4.2. ХАЛАЛЫН ТУХАЙ.....	18
5. ЗОРИЛТОТ ОРНУУДЫН МАХНЫ ЗАХ ЗЭЭЛ	18
5.1. ЗОРИЛТОТ ОРНУУДЫН МАХНЫ ХЭРЭГЛЭЭ.....	18
5.1.1. Саудын Араб улсын хүн амын махны хэрэглээ.....	21
5.1.2. Кувейт улсын хүн амын махны хэрэглээ.....	21
5.1.3. Катар улсын хүн амын махны хэрэглээ.....	22
5.1.4. Малайз улсын хүн амын махны хэрэглээ.....	23
5.1.5. Индонез улсын махны хэрэглээ.....	23
5.2. ЗОРИЛТОТ ОРНУУДЫН МАХНЫ ИМПОРТ.....	24
5.2.1. Саудын Араб улсын хонь, ямааны махны импортын зах зээл.....	26
5.2.2. Кувейт улсын хонь, ямааны махны импортын зах зээл.....	28
5.2.3. Катар улсын хонь, ямааны махны импортын зах зээл.....	30
5.2.4. Малайз улсын хонь, ямааны махны импортын зах зээл.....	32
5.2.5. Индонез улсын хонь, ямааны махны импортын зах зээл.....	34
5.3. ЗОРИЛТОТ ОРНУУДЫН АМЬД МАЛЫН ИМПОРТЫН ЗАХ ЗЭЭЛ.....	35
5.4. МАЛЫН ДАЙВАР БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТЫН ЗАХ ЗЭЭЛ.....	35
5.5. НӨӨШИЛСӨН МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТЫН ЗАХ ЗЭЭЛ.....	37
5.6. ЗОРИЛТОТ ОРНУУДЫН МАХНЫ ҮНИЙН СУДАЛГАА.....	38
5.6.1. Зорилтот орнуудын хонины махны үнэ.....	38
5.6.2. Зорилтот орнуудын ямааны махны үнэ.....	39
5.6.3. Хонины махны жижиглэнгийн дундаж үнэ.....	40
5.7. ЭЦСИЙН ХЭРЭГЛЭГЧДИЙН СУДАЛГАА.....	40
5.7.1. Нэг хүнд ногдох жилийн махны хэрэглээ кг.....	40
5.7.2. Зорилтот зах зээлийн махны борлуулалтын суваг.....	41
5.8. ЗОРИЛТОТ ОРНУУДЫН ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ, ХУДАЛДААНЫ ЗОХИЦУУЛАЛТ.....	43
5.8.1. Саудын Арабын Хаант улс.....	43
5.8.2. Катарын Хаант улс.....	46
5.8.3. Кувейт улс.....	49
5.8.4. Персийн булангийн Арабын орнуудын хамтын ажиллагааны зөвлөл.....	52
5.8.5. ПБХАЗ-ийн Худалдааны хууль, эрх зүйн зохицуулалт (Саудын Араб, Катар, Кувейт).....	55
5.8.6. ПБХАЗ –ийн Гаалийн холбоо.....	55
5.8.7. ПБХАЗ-ийн худалдааны зохицуулалт.....	56
5.8.8. ПБХАЗ-ийн Гаалийн холбооны тарифийн зохицуулалт.....	68
5.8.9. ПБХАЗ-ийн Гаалийн холбооны тарифийн бус зохицуулалт.....	70
5.8.10. Малайз Улс.....	72
5.8.11. Индонези Улс.....	72
5.8.12. Журам, стандарт.....	73
6. МОНГОЛ УЛСЫН МАХНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	80

6.1. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, МАХНЫ НӨӨЦ.....	80
6.2. МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ	80
6.3. МАХНЫ ЭКСПОРТ	83
7. МОНГОЛ МАЛЫН МАХНЫ ЭКСПОРТОД ТУЛГАМДАЖ БУЙ БЭРХШЭЭЛҮҮД	85
7.1. МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД	85
7.1.1. Малын өвчнөөс эрүүлжих арга зам	87
7.1.2. Малын эрүүл мэнд- хууль эрх зүй	89
7.1.3. Халал бүтээгдэхүүний лабораторийн шинжилгээ	91
7.2. МАХНЫ ҮЙЛДВЭРИЙН ТЕХНОЛОГИ, ЭРҮҮЛ АХУЙ.....	95
7.2.1. Ойрх дорнодын орнууд руу мах бэлтгэх үйлдвэрт тавих шаардлага	95
7.2.2. Мал төхөөрөх технологи	96
7.2.3. Халал бүтээгдэхүүнд тавих шаардлага	97
7.2.4. Малд тавих шаардлага	97
7.2.5. Хүнсний аюулгүй байдлын менежмент	98
8. ЗОРИЛТОТ ОРНУУДАД МАХ НИЙЛҮҮЛЭХ ГИНЖИН ХЭЛХЭЭ	102
8.1. МОНГОЛ МАЛЫН МАХНЫ ЭКСПОРТЫН ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭ	102
8.1.1. Экспортын мах ханган нийлүүлэх сүлжээ	102
8.1.2. Экспортыг хөнгөвчлөхөд тулгарч буй бэрхшээлүүд	106
8.1.3. Монгол малын мах Ойрх Дорнодод экспортлох боломжийн талаарх тойм	107
8.1.4. SWOT шинжилгээ.....	108
8.1.5. Маркетингийн шинжилгээ	112
8.1.6. Хонины Халал махны экспортын үр ашгийн тооцоолол (Жишээ)	116
8.2. ТЭЭВЭРЛЭЛТ	117
8.2.1. Зорилтот орнуудад тээвэрлэлтийн оновчтой байдал	117
8.2.2. Зорилт улсуудын тухайн боомтууд хүртэлх тээврийн зардал	121
9. ДҮГНЭЛТ	123
10. ЗӨВЛӨМЖ	124
11. ХАВСРАЛТ	127

ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Багийн бүрэлдэхүүн болон ажлын хуваарилалт	11
Хүснэгт 2. Ажлын төлөвлөгөө	12
Хүснэгт 3. Персийн булангийн орнуудын махны хэрэглээ, мянган тонн.....	19
Хүснэгт 4. Персийн булангийн орнуудын махны хэрэглээний төсөөлөл 2019-2021 он, мянган тонн.....	20
Хүснэгт 5. Саудын Арабын махны хэрэглээ төрлөөр, мянган тонн	21
Хүснэгт 6. Кувейтийн хүн амын махны хэрэглээ төрлөөр, мянган тонн	21
Хүснэгт 7. Катарын махны хэрэглээ төрлөөр, мянган тонн.....	22
Хүснэгт 8. Малайзын махны хэрэглээ төрлөөр, мянган тонн.....	23
Хүснэгт 9. Индонезын махны хэрэглээ төрлөөр, мянган тонн	23
Хүснэгт 10. Персийн булангийн орнуудын махны импортын хэмжээ, сая ам доллар	24
Хүснэгт 11. ПБХАЗ орнуудад мах экспортлогч гол улсууд, сая ам доллар	24
Хүснэгт 12. Персийн булангийн орнуудын махны импорт төрлөөр, сая ам доллар	25
Хүснэгт 13. Саудын Араб улсын хонь, ямааны махны импортын хэмжээ	27
Хүснэгт 14. Саудын Араб улсын хонь, хурга болон ямааны махны импортын дундаж үнэ, \$/кг	27
Хүснэгт 15. 2018 онд Саудын Араб улсад хонь, ямааны мах экспортлогчид болон импортын үнэ, тариф	28
Хүснэгт 16. Кувейт улсын хонь, ямааны махны импортын хэмжээ	29
Хүснэгт 17. Кувейт улсын хонь, хурга болон ямааны махны импортын дундаж үнэ, \$/кг	29
Хүснэгт 18. 2018 онд Кувейт улсад хонь, ямааны мах экспортлогчид болон импортын үнэ, тариф	29
Хүснэгт 19. Катар улсын хонь, ямааны махны импортын хэмжээ	31
Хүснэгт 20. Катар улсын хонь, хурга ба ямааны махны импортын дундаж үнэ, \$/кг	31
Хүснэгт 21. 2018 онд Катар улсад хонь, ямааны мах экспортлогчид болон импортын үнэ, тариф	32
Хүснэгт 22. Малайз улсын хонь, ямааны махны импортын хэмжээ	32

Хүснэгт 23. Малайз улсын хонь, хурга ба ямааны махны импортын дундаж үнэ, \$/кг	33
Хүснэгт 24. 2018 онд Малайз улсад хонь, ямааны мах экспортлогчид болон импортын үнэ, тариф	33
Хүснэгт 25. Индонез улсын хонь, ямааны махны импортын хэмжээ.....	34
Хүснэгт 26. Индонез улсын хонь, хурга болон ямааны махны импортын дундаж үнэ, \$/кг	34
Хүснэгт 27. 2018 онд Индонез улсад хонь, ямааны мах экспортлогчид болон импортын үнэ, тариф ...	34
Хүснэгт 28. Зорилтот зах зээлийн импортолсон хонь, ямааны тоо толгой.....	35
Хүснэгт 29. Саудын Араб улсын Lulu хайпер маркетийн махны дундаж үнэ	40
Хүснэгт 30. Хонины махыг худалдаж авахад нөлөөлөх хүчин зүйлс	41
Хүснэгт 31. ПБХАЗ-ийн харьяа байгууллагууд.....	54
Хүснэгт 32. Мал эмнэлэг, эрүүл ахуйн гэрчилгээнд дагалдах мэдээллийн хураангуй.....	57
Хүснэгт 33. Экспортын бүтээгдэхүүний хадгалалт, савлагааны стандарт	60
Хүснэгт 34. Зөвшөөрөл хүсэх байгууллагуудын орон тус бүрээр	64
Хүснэгт 35. Тарифын зохицуулалт	69
Хүснэгт 36. Мах үйлдвэрлэлийн сүүлийн 8 жилийн харьцуулсан судалгаа	81
Хүснэгт 37. Махны үйлдвэрүүдийн техникийн чадавхи	82
Хүснэгт 38. Халал аргаар бэлтгэсэн хонь ямааны махны экспорт (2018 оны 12 сарын байдлаар).....	83
Хүснэгт 39. Хонь, ямааны махны экспортын судалгаа /оноор/	84
Хүснэгт 40. Хяналт ба шалгуур үзүүлэлт	92
Хүснэгт 41. Үйлдвэрийн процесст тавигдах шаардлага ба стандарт	95
Хүснэгт 42. Халал мах үйлдвэрлэхэд тавигдах үндсэн 4 шаардлага:	95
Хүснэгт 43. НАССР-ын эрх зүйн баримт бичгийн жагсаалт	101
Хүснэгт 44. Монголын экспортыг хөнгөвчлөхөд тулгарч буй бэрхшээлүүд	106
Хүснэгт 45. Халал аргаар ангилж савалсан махны үйлдвэрлэлийн дундаж өртөг	116
Хүснэгт 46. Экспортын үнийн задаргааны жишээ	116
Хүснэгт 47. Улаанбаатараас Ойрхи Дорнод хүртэлх тээврийн зардал	121
Хүснэгт 48. Улаанбаатараас Зүүн Ази хүртэлх тээврийн зардал.....	121

ГРАФИК

График 1. Саудын Араб, Кувейт, Катар улсуудын махны хэрэглээний өсөлт	19
График 2. Бүс нутгийн махны хэрэглээ, төрлөөр	20
График 3. Зорилтот зах зээлийн хонь, ямааны махны хэрэглээ, 2012-2021 он.....	22
График 4. Персийн булангийн орнуудад хонь, ямааны махны гол экспортлогчид	25
График 5. Зорилтот зах зээлийн хонь, ямааны махны импортын үзүүлэлтүүд.....	26
График 6. Саудын Араб улсын импортын хонь, ямааны махны эзлэх хувь	26
График 7. Кувейт улсын импортын хонь, ямааны махны эзлэх хувь	28
График 8. Катар улсын импортын хонь, ямааны махны эзлэх хувь	30
График 9. Зорилтот зах зээлийн малын дайвар бүтээгдэхүүний импорт, 2018.....	36
График 10. Хонь, ямааны дайвар бүт, 2018 График 11. Австрали улсын экспорт, 2018	36
График 12. Зорилтот зах зээлийн нөөшилсөн махан бүтээгдэхүүний импорт, 2018	37
График 13. Нөөшилсөн бүтээгдэхүүн экспортлогчид, 2018	37
График 14. Зорилтот орнуудын хонины махны дундаж үнэ, \$/кг	38
График 15. Зорилтот орнуудын ямааны махны дундаж үнэ, \$/кг	39
График 16. Персийн булангийн орнуудын хонины махны борлуулалтын суваг	41
График 17. Персийн булангийн орнуудын хүн амын тоо, худалдан авах чадвар	42
График 18. Халал баталгаажуулалтын байгууллагууд.....	78
График 19. Махны үйлдвэрийн нөөц, малын тоо толгой, сүргийн бүтэц	80
График 20. Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах (2017 оны эцсийн байдлаар).....	81

ЗУРАГ

Зураг 1. Персийн булангийн орнуудын нэг хүнд ногдох жилийн махны хэрэглээ, кг	40
Зураг 2. Импортын үйл явцын зураглал ба стандартууд	57
Зураг 3. Дотоодын зах зээлд борлуулалт худалдаа эрхлэх бүтэц	63
Зураг 4. Түнш, харилцагчтай холбоо тогтоох дараалал.....	63
Зураг 5. 2019 оны байдлаар ДМАЭМБ-ын гишүүн орнууд дахь шүлхий өвчний статус.	85
Зураг 6. Саудын Араб Улсын Хүнс, Эрүүл мэндийн яамны веб хаягт Монгол оронд тавьсан хоригийг харуулсан байдал.	86
Зураг 7. Катар улсын хүнс, эрүүл мэндийн яамнаас Монгол оронд тавьсан хориг.	86

Зураг 8. Шүлхий өвчин, нөхцөл байдлыг харуулсан зураглал.....	87
Зураг 9. Малын гоц халдварт өвчнөөс эрүүл бүс тогтоох зураглал	88
Зураг 10. Хамгаалагдсан аж ахуйн загвар.....	88
Зураг 11. Бүртгэл мэдээллийн системийн бүтэц зохион байгуулалт.	91
Зураг 12. Махны хяналт шинжилгээ, баталгаажуулалтын ерөнхий схем	94
Зураг 13. Бод малыг халал аргаар төхөөрөх хялбарчилсан төхөөрөмж	97
Зураг 14. Суурь, ферм, нэгжийн хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо.	98
Зураг 15. Хүнсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны ерөнхий схем	99
Зураг 16. Суурьт хэрэгжих хяналтын тогтолцооны ерөнхий бүтэц.....	100
Зураг 17. Мал төхөөрөх үйлдвэрт хэрэгжих хяналтын тогтолцооны ерөнхий бүтэц	100
Зураг 18. Экспортын бүрдүүлэлт хийх ерөнхий схем	101
Зураг 19. Махны экспортын ханган нийлүүлэлтийн сүлжээ	102
Зураг 20. Маркетингийн 7P шинжилгээ	112
Зураг 21. Идэвхжүүлэлтийн алхамууд	114
Зураг 22. Худалдан авалт	115
Зураг 23. Зорилтот орнуудын боомт хүртэлх тээврийн дундаж замын урт, хугацаа, өртөг	117
Зураг 24. Агаарын, далайн болон авто-замын тээврийн давуу болон сул талууд.....	118
Зураг 25. Австрали улсын далайн тээврийн харьцуулалт	118
Зураг 26. Улаанбаатраас ОХУ-ын Владивосток боомт хүртэлх зураглал	119
Зураг 27. Саудын Араб улсын Даммам боомт хүртэлх зураглал	119
Зураг 28. Катар улсын Доха боомт Кувейт улс хүртэлх зураглал	120
Зураг 29. Владивостокийн боомтоос Индонез, Малайз улс хүрэх зураглал.....	120
Зураг 30. БНХАУ-Пакистаны эдийн засгийн коридорын зураглал.....	122

СХЕМ

Схем 1. Судалгаа гүйцэтгэх арга зүйн схем зураг	14
Схем 2. ПБХАЗ-ийн үндсэн зорилго.	53
Схем 3. ПБХАЗ - ийн бүтэц, зохион байгуулалт.....	53
Схем 4. ПБХАЗ-ийн орнуудын хилээр бараа импортлох үйл явц.....	71
Схем 5. Аккредитаци, магадлан итгэмжлэх үйл явцын ерөнхий зураглал	77
Схем 6. Баталгаажуулалтын ерөнхий схем	78
Схем 7. Халал аргаар мал төхөөрөх дараалал.....	96

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Халал аргаар мал төхөөрөх	127
Хавсралт 2. ПБХАЗ-ийн мах, махан бүтээгдэхүүний стандартууд	128
Хавсралт 3. ПБХАЗ-ийн Гаалийн тухай хууль 2003 он.....	130
Хавсралт 4. ПБХАЗ-ийн орнуудад импортлогдох хүнсний бүтээгдэхүүнд тавих хяналт, шаардлагын удирдамж 2016 он	130
Хавсралт 5. Гаалийн холбооны импортын тариф 2017 он.....	131
Хавсралт 6. ПББТ –ийн талаарх мэдээлэл, холбогдох хаяг	133
Хавсралт 7. Мах, Махан бүтээгдэхүүнийг экспортлоход олгох Халал төхөөрөлтийн гэрчилгээ.	134
Хавсралт 8. Малын гаралтай бүтээгдэхүүнийг экспортлоход олгох Халал гэрчилгээ.....	135
Хавсралт 9. Малын гаралтай бүтээгдэхүүнийг экспортлоход олгох Эрүүл ахуйн гэрчилгээ.	136
Хавсралт 10. Ойрх Дорнодод хийсэн уулзалтууд- Анхдагч судалгаа	137
Хавсралт 11. Монгол улсад хийсэн уулзалтууд - Хоёрдогч судалгаа	137
Хавсралт 12. Ойрх Дорнодод хийсэн уулзалтуудын илтгэх хуудас	138
Хавсралт 13. Тайлангийн хэлэлцүүлгийн тэмдэглэл	140
Хавсралт 14. Судалгааны асуумж.....	144
Хавсралт 15. Эрүүл ахуйн гэрчилгээний загварын жишээ	146
Хавсралт 16. Импортлогч компаниудын жагсаалт	148

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧЛОЛ

АХБ	Азийн хөгжлийн банк
ГХЯ	Гадаад харилцааны яам
ГХ	Гаалийн холбоо
ДБ	Дэлхийн банк
ДГХ	Дэлхийн гаалийн холбоо
ДМАЭМБ	Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДХТ	Дэлхийн худалдааны төв
ИОБ	Исламын орнуудын байгууллага
ИХБ	Исламын хөгжлийн банк
ИНКОТЕРМС	Олон усун худалдааны нэр томьёо
ЖАКИМ	Малайзын стандартын байгууллага
МАА	Мал аж ахуй
(МАР)	Агаарын найрлагыг өөрчилсөн савлагаа
МҮХАҮТ	Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим
МЭАЦ шаардлага	Малын эрүүл мэнд, ариун цэврийн
НҮБ	Нэгдсэн Үндэстэний Байгууллага
ОУ	Олон улсын
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ОУХСТ	Олон улсын хэрэглэгчдийн судалгааны төв
ПАФН	Хүнсний хангамжийн асуудал хариуцсан газар
ПББТ	ПБХАЗ-ийн баталгаажуулалтын байгууллага
ПСХ	ПБХАЗ-ийн статистикийн хороо
ПХХ	ПБХАЗ-ийн хэмжилзүйн хороо
ПБХАЗ	Персийн булангийн Арабын орнуудын хамтын ажиллагааны зөвлөл
САХЭХГ	Саудын Араб улсын хүнс болон эмийн хяналтын газар
СХБ	ПБХАЗ-ийн стандарт, хэмжилзүйн байгууллага
ҮБДГ	Үйлдвэрлэлийн бодлого, дэмжлэгийн газар
ФАСАХ	Нэг цонхны үйлчилгээ
ХАА	Хөдөө аж ахуй
ХИБ	Халал итгэмжлэлийн байгууллага
ХХБ	Халал хяналтын байгууллага
ХББ	Халал баталгаажуулалтын байгууллага
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХЭЗХ	Хүнсний хууль эрх зүйн хороо

ОРШИЛ

“Ойрх Дорнодын орнуудын махны зах зээлийн судалгаа” (Саудын Араб, Кувейт ба Катар)-ын энэхүү тайлан нь ХХААХҮЯ-ны Хүнсний Үйлдвэрийн Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын захиалга, Азийн хөгжлийн банкны “Хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг дэмжих техник туслалцааны төсөл”-ийн санхүүжилтээр Эй Ар Эн Эй ХХКомпаний зөвлөх багийн гүйцэтгэсэн судалгааны ажлын үр дүн болно.

ХХААХҮЯ, Хүнсний Үйлдвэрийн Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, дэлхий дахины мах махан бүтээгдэхүүний зах зээлийн эрэлт хэрэгцээ, цаашдын хандлага, стратеги, мал эмнэлэг, ариун цэвэр эрүүл ахуйн олон улсын шаардлагыг судлан улмаар манай орны мал аж ахуйн бүтээгдэхүүнийг эдийн засгийн эргэлтэд оруулах, ялангуяа малын мах, хиам, лаазалсан, савласан зэрэг дулааны аргаар боловсруулсан бүтээгдэхүүнийг гадаадын зах зээлд гаргахад дэмжлэг үзүүлэх, худалдаатай холбоотой бодлого боловсруулж төрийн үйлчилгээг хөнгөвчлөх зорилт дэвшүүлэн ажилладаг билээ.

“Хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг дэмжих техник туслалцааны төсөл” нь мал аж ахуйн салбар дахь үр шимийг нь бүрэн дүүрэн хараахан ашиглаж чадахгүй байгаа мах, махан бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээн үнэ цэнийг нэмэгдүүлэн, экспортод гаргах талаар дэмжлэг үзүүлж байна.

Монгол улсын УИХ, Засгийн газар нь “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” хөгжлийн зорилтыг тодорхойлж, дөрвөн үндсэн салбарт “Эдийн засгийн тогтвортой хөгжил”, “Нийгмийн тогтвортой хөгжил”, “Байгаль орчны тогтвортой хөгжил”, “Тогтвортой хөгжлийн засаглал”-тай эдийн засгийн олон салбар бүхий улс болох зорилт тавьсан. Тогтвортой хөгжлийн зорилтыг хангахын тулд эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэн, ХАА-н салбарыг тэргүүлэх салбар болгохоор тодорхойлсон байдаг. Иймд Монгол малын мах, махан бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд гаргах бодлогын хүрээнд Ойрх Дорнодын орнуудын махны зах зээл, Ислам шашинтай улсуудын ёс заншил, хоол хүнсний соёл, “Халал” хүнсний стандарт шаардлагыг судлах шаардлагатайг тогтоон, “Хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг дэмжих техник туслалцааны төсөл”-ийн дэмжлэгтэйгээр энэхүү судалгааны ажил хийгдсэн болно.

Мөн тус судалгааны хүрээнд өөрийн орны мал аж ахуйн өнөөгийн байдал, зорилтот орнуудад мах экспортлох боломж, үйлдвэрүүдийн хүчин чадал, олон улсын стандарт, шаардлагуудыг хэрхэн хангаж байгаа байдалд нөхцөл байдлын үнэлгээ хийж, мах экспортлогчдод болон үйлдвэрүүдэд зориулсан гарын авлага хэвлэгдэн гарсан.

1. ТОВЧ ХУРААНГУЙ

Персийн буланд орших “Арабын ертөнц” гэж нэрлэгддэг орнууд нь шашин шүтлэг нэгтэй, зан үйл, ёс заншил, хоол хүнс ижил, Куран судар болон Гэгээн элчийн сунна буюу Ислам шашны хэм хэмжээгээр улс төр, эрх зүйн тогтолцоогоо зохицуулдаг олон талаараа адил ойролцоо улсууд юм. Тэд газрын тос, байгалийн шатдаг хийн олборлолтоор эх орныхоо баялагийг бүрдүүлж, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээгээрээ дэлхийн орнуудыг тэргүүлдэг. Арабын ертөнцийн орнууд нь асар их хэмжээний мах, махан бүтээгдэхүүн импортлогч маш том зах зээл бөгөөд жилийн хэрэглээ ба худалдаа нь хэдэн их наяд төгрөгт хүрдэг аж.

Персийн булангийн Арабын орнуудын хамтын ажиллагааны зөвлөл (ПБХАЗ¹) 1981 онд байгуулагдаж Арабын Нэгдсэн Эмират, Саудын Араб, Катар, Кувейт, Оман, Бахрейн зэрэг 6 орон бүс нутгийн интеграцлалд шилжсэн байна. Өөрөөр хэлбэл улс төр, худалдаа, эдийн засаг, гааль татвар, газрын тосны бодлогын хүрээнд хүчээ нэгтгэсэн. Хэдийгээр шашны хэм хэмжээг баримталдаг боловч олон улсын 5,000 гаруй стандартыг мөрдөж байгаа бөгөөд ялангуяа хүнсний стандартыг дэлхийн жишгийн дагуу боловсруулж мөрддөг болжээ.

Ойрх Дорнодын орнууд ундны цэнгэг уснаас эхлээд хүнсний бүтээгдэхүүний 90 шахам хувийг, ялангуяа мах, махан бүтээгдэхүүнийг гадны импортоор хангадаг бөгөөд тоо хэмжээ нь жилээс жилд өсөн нэмэгдэх хандлагатай байна. Энэ нь манай орон Ойрх дорнодод тогтвортой мах экспортлох боломжтой томоохон зах зээл байгааг илтгэж байна. Монгол оронд голлон Буддын шашны соёл уламжлагдан дэлгэрсэн нь Ойрх Дорнодын Ислам шашинтай орны ард түмний соёл зан заншлаас ихээхэн ялгаатай. Иймд монголын мах экспортлогчдод тодорхой ойлголт өгөх үүднээс Ойрх Дорнодын орнуудын эдийн засаг, улс төрийн тогтолцоо, визны нөхцөл, манай улстай хийсэн засгийн газар хоорондын болон мал эмнэлгийн гэрээ хэлэлцээрүүд, нийгэм соёл, хэл, шашин шүтлэг, шинжлэх ухаан-технологийн түвшин, хууль эрх зүй, экологи, байгаль орчны тухай улс тус бүрээр танилцуулсан болно. Ялангуяа “Халал”-ын тухай үндсэн ойлголт, халал хүнс, халал мах гэж юу болох талаар нарийн судалж тайланд тусгасан. Мөн бүтээгдэхүүнд халал гэрчилгээ олгох, түүнийг итгэмжлэх Итгэмжлэлийн байгууллага, Халал баталгаажуулалтын байгууллага манай улсад зайлшгүй хэрэгтэй болохыг тайланд дэлгэрэнгүй тайлбарласан. Мал төхөөрөх газрын Халал гэрчилгээ, Халал бүтээгдэхүүний гэрчилгээ, Мал эмнэлэг, эрүүл ахуйн гэрчилгээ, Хүнсний гэрчилгээ, цахим үйлчилгээ (E-Service), Импортын хориг, Импортын зөвшөөрлийн талаар орон тус бүрээр гаргаж тайланд тусгав.

Ойрх Дорнодын орнууд үлэмж их хэмжээний хүнсээ импортолдог учраас хүн амын хэрэглээнд учирч болзошгүй эрсдлийг хамгийн бага буюу эрсдэлгүй байлгахад чиглэгдсэн өндөр шаардлага тавьдаг. Экспортлогч орны бүтээгдэхүүний гарал үүсэл, баталгаажуулалтын баримт бичгүүд, үзлэг шинжилгээ, хадгалалт, савлагаа, дээжийн шинжилгээ зэргийг цогцоор нь хангасан байхыг хатуу баримталдаг байна. Үүнтэй холбоотой Исламын Шариатын хуулийн дагуу мал төхөөрөх, Халал мах үйлдвэрлэх үндсэн 4 шаардлага, Халал бүтээгдэхүүний хаяг, шошго, Саудын Араб, Катар, Кувейт улсуудад мах, махан бүтээгдэхүүн импортлоход тавигдах шаардлага, холбогдох баримт бичгүүдийн талаар дэлгэрэнгүй бичиж оруулав.

Улс тус бүрийн Засгийн газрын цахим сүлжээнээс импортлогч, экспортлогч, далайн, агаарын

¹ ПБХАЗ-Персийн булангийн Арабын орнуудын хамтын ажиллагааны зөвлөл

болон газрын ачаа эргэлт, агент, брокеруудын нэгдсэн санд бүртгэх, баримт бичиг бүрдүүлэх, түншээ олж сонгох, мөн дотоод худалдааны зохицуулалт зэрэг үйлчилгээг судлах боломжтой цахим сүлжээний хаягийг (линкийг) ажил хөнгөвчлөх үүднээс тодорхой оруулж өгсөн. Судалгаанд мах, махан бүтээгдэхүүнийг зорилтот орнуудын боомтууд хүртэл тээвэрлэх боломж, оновчтой чиглэлүүд болон дундаж зардлуудыг тооцсон бөгөөд тус орнууд руу шууд хүрэх агаарын зам, хамгийн бага дамжин өнгөрч хүрэх далайн тээвэр, хэд хэдэн улсаар дамжин хүрэх авто тээвэр болон төмөр замын тээврийг судалж тодорхой дүнг тайланд тусгасан. Үүнд агаарын тээвэр богино хугацаанд шууд тээвэрлэх боломжтой ч зардал өндөр, далайн тээвэр зардал бага боловч тээвэрлэх хугацаа урт, авто-замын тээвэр олон улс дамжин өнгөрөх шаардлагатай гэх зэрэг онцлогуудыг харьцуулан үзэж боломжит хувилбаруудыг тодорхойлсон.

Зорилтот орнуудын зах зээлд худалдаалагдаж буй чанартай махны үнэ харьцангуй өндөр байгаа нь Монгол орны бэлчээрийн малын амт чанар сайтай махыг одоо экспортолж байгаа дундаж үнээс харьцангуй илүү өндөр үнээр борлуулах боломжтойг харуулж байна. Нөгөөтэйгүүр гадаад талд ийм боломж байгаа ч манай улсын мал аж ахуйн салбарын өнөөгийн дотоод нөхцөл байдалд анхаарах зүйл багагүй байгаа нь ажиглагдсан ба энэ тухай тайланд тодорхой тусгав. Монгол улс өөрийнхөө бүтээгдэхүүний аюулгүй байдал, амт чанарыг гадны худалдааны түншүүддээ батлан харуулж чадахгүй байгаа нь сүүлийн арваад жил Монгол улстай алдаг оног, зайгаа барьсан худалдаа хийж байгаагаас харагдаж байна. Тухайлбал манай орны мах бэлтгэх, мах боловсруулах үйлдвэрүүдийн барилга байгууламж, эрүүл ахуйн нөхцөл, махны хяналтын олон улсын шаардлага хангасан үйлдвэр цөөн, махны үйлдвэрийн тоо нэмэгдэж байгаа боловч хөгжлийн зөв чиг хандлага бүрэлдэхгүй байна. Цаашид HACCP, ISO 9001, ISO 22000 стандартуудыг хэрэгжүүлэх, дотоод хяналтын лабораторитой болох шаардлагатай байгааг тайланд тодорхой тусгасан болно.

Сүүлийн жилүүдэд манай Улсын Их Хурал, Засгийн газраас мал аж ахуйн салбарт олон чухал арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Монгол Улсын Их Хурал малын эрүүл мэндийг хамгаалах эрх зүйн орчинг шинэчилж, “Мал амьтны эрүүл мэндийн тухай” хууль 2018 оны 06 дугаар сарын 01-нээс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Монгол Улсын Засгийн газраас 2017 онд “Малын гоц халдварт өвчингүй, хорио цээрийн тусгаарласан бүс байгуулах тухай” 284 дүгээр тогтоол, МЭҮГ (хуучнаар)-ын даргын 2018 оны 04-р сарын 24-ны өдрийн А/17 тоот “Малын гоц халдварт өвчингүй, тусгаарласан аж ахуйд мөрдөх мал эмнэлэг, хорио цээрийн зааварчилгаа”-г гарган хэрэгжүүлж байна. ДМАЭМБ-ын хуурай газрын мал амьтны эрүүл мэндийн олон улсын кодын 8-р бүлгийн 8-р заалтын дагуу эрүүл бүс (Diseases free zone) болон олон улсын худалдаанд хориг тавьдаг халдварт өвчнөөс тусгаарлагдсан эрүүл аж ахуйг (Compartmentalisation) зохион байгуулах, улмаар ДМАЭМБ-аар баталгаажуулах замаар хүнсний аюулгүй байдлын тогтолцоог бий болгож байна. Манай улс 18 улстай мал эмнэлгийн салбарт хамтран ажиллах 39 нэрийн хэлэлцээр, харилцан ойлголцлын санамж бичиг, 19 оронтой 47 нэрийн мал, амьтан тэдгээрийн гаралтай тэжээл, түүхий эд, бүтээгдэхүүнд мал эмнэлгийн ариун цэвэр, эрүүл мэндийн гэрчилгээ, шаардлага, нөхцлийг харилцан тохиролцсон байдаг. Монгол Улсын Засгийн газраас авч буй дээр дурдсан арга хэмжээнүүд нь манай орны махны экспортыг нэмэгдүүлэх, баталгаат байдлыг хангах талаар хийсэн томоохон алхам болж байна.

Тайлбар: Ойрх Дорнодын орнууд дотроос Саудын Араб, Катар ба Кувейт улсуудын махны зах зээлийг судлах нь судалгааны багийн үндсэн үүрэг бөгөөд тус тайлангийн зарим хэсэгт дээрх гурван орныг “Зорилтот орнууд” гэж товчлон бичив.

ДУГНЭЛТ

Ойрх Дорнодод халал аргаар бэлтгэсэн мах, махан бүтээгдэхүүн экспортлох боломжийн талаар судалж үзэхэд гадаад, дотоод хоёр эерэг хүчин зүйл давуутай харагдаж байна.

1-рт: Гадаад хүчин зүйл: Халал аргаар бэлтгэсэн Монгол малын махыг Ойрх дорнодод гаргахад, импортлогч талын зах зээлийн багтаамж их, махны эрэлт хэрэгцээ жилээс жил ирэх тутам өсөх хандлагатай, хүчирхэг эдийн засагтай, монгол малын махыг авах сонирхолтой байна.

2-рт: Дотоод хүчин зүйл: Манай улсын Засгийн газар сүүлийн жилүүдэд авч хэрэгжүүлж буй олон чухал арга хэмжээ, олон улсын гэрээ, хэлэлцээрийн нөхцөл, монголын мал сүргийн өсөлт, эргэлт зэрэг нь Ойрх Дорнодын зах зээлд мах, махан бүтээгдэхүүний худалдааг хөгжүүлэх бүрэн боломжтой байгааг судалгааны дүн харуулсан.

- Монголын мал аж ахуйн өнөөгийн байдал, дан ганц бэлчээрийн хариуллага маллагаатай, элдэв нэмэлт тэжээл, тэжээлийн нэмэлт хэрэглэдэг уламжлалгүй, зорилтот орны сонирхолтой нийцэж байна.
- Мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрүүдэд халал аргаар мах бэлтгэх тодорхой ойлголттой (мэдлэгтэй), Халал аргаар мал төхөөрөх зан заншил, ёс зүйг мэддэг Мусулман шашинтай иргэд, малын эмч, мэргэжилтнүүдтэй учраас мах экспортлох үйлдвэрүүдэд Халал стандарт нэвтрүүлэх боломж бүрэн байна.

Олон улсын худалдаанд хориг тавьдаг гоц халдварт шүлхий өвчин гадаад худалдаанд том бэрхшээл учруулж байгаа боловч тус өвчинтэй тэмцэх талаар ДМАЭМБ-ын Хуурай газрын мал амьтны эрүүл мэндийн кодын дагуу манай улсын Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд нь тус бэрхшээлийг даван туулснаар бид эрүүл хүнс, ялангуяа халал хүнс бэлтгэх бүрэн боломжтой байна гэж үзлээ.

2. ТАНИЛЦУУЛГА

2.1. ХЭРЭГЖИХ ХУГАЦАА

Нийт хугацаа: 6 сар

Эхлэх хугацаа: 2019 оны 1-р сарын 4

2.2. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

- Монгол малын (үүний дотор хонь, ямааны) махыг тогтвортой экспортлох боломж, зорилтот хэрэглэгчдийг тодорхойлох, экспортлогчдыг бодит мэдээллээр хангах
- Монгол малын мах, махан бүтээгдэхүүнийг Ойрх Дорнодын тодорхой орнуудад болон зүүн Азийн Малайз, Индонез орнуудад экспортлох боломжийг судалж, хэрэглэгчийн зан төлөвийн үнэлгээ хийх
- Ойрх Дорнодын орнууд болон зүүн Азийн Малайз, Индонез орнуудын дотоодын болон импортын мах, махан бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг ялангуяа хүнс тэжээлийн үнэт чанар, савлагаа, үнэ бүрдэлт, түгээлт, зах зээлд эзлэх байр суурьтай холбон харьцуулж, үнэлэх

2.3. СУДАЛГААНЫ БАГ

2.3.1. Багийн бүрэлдэхүүн болон ажлын хуваарь

Судалгааны ажилд голлон оролцох судлаачид, салбарын мэргэжилтнүүдийн хариуцах ажил, судалгааны чиг үүрэг болон багийн гишүүдийн талаарх мэдээллийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1. Багийн бүрэлдэхүүн болон ажлын хуваарилалт

Нэр	Албан тушаал	Хариуцах ажил
Елтай Тилеубек	Зөвлөх, Багийн ахлагч	Судалгааны багийг удирдан зохион байгуулах, чиглүүлэх, судалгааны арга зүй болон төлөвлөгөөний дагуу ажиллаж Ойрх Дорнодын болон Малайз, Индонез улс руу Монгол Улсаас мах экспортлох боломжийг судалж тайлагнах, зөвлөх.
Содном Лхагвасүрэн	Махны эрүүл ахуйч	Малын эрүүл мэнд, махны үйлдвэрийн техникийн хүчин чадал, малын өвчний хараат байдлаас гарах боломжийн судалгаа, зөвлөгөө. Лабораторийн шинжилгээний нэр төрөл, шат дараалал, итгэмжлэгдсэн байгууллагууд.
Долоонжин Оргил	Малын эрүүл мэнд, хорио цээрийн Зөвлөх	Малын эрүүл мэнд, мал эмнэлэг, хорио цээрийн байгууллагын импортын мах, махан бүтээгдэхүүнд тавих шаардлага Эрүүл ахуй, халдваргүйжүүлэлтийн үйл явц, хэлбэр, технологи, нэр төрөл, одоо хэрэгжиж буй туршлага.
Кадер Сайраан	Ойрх Дорнодын харилцааны Зөвлөх	Ойрх Дорнодын орнуудад хийх судалгааны ажлыг ахалж гүйцэтгэх, Саудын Араб руу нэвтрэн орох (Төрийн болон шашны зорилгоос бусад үед нэвтрэхэд шаардлага өндөр), байрлах болон судалгаа явуулах нөхцлөөр хангаж, холбогдох байгууллагуудтай харилцах, Ойрх Дорнодын орнуудын худалдааны бодлого, харилцааны онцлог, Зах зээлийн тогтвортой байдал, өрсөлдөөний эрсдэл, улс төрийн эрсдэл, эдийн засгийн эрсдэл, хорио цээр, хоригийн эрсдэлийг судлах.
Хафа Амир	Харилцаа, Тээвэр логистикийн Зөвлөх	Зорилтот орнуудад мах нийлүүлэх тээвэрлэлтийн арга замууд, транзит тээврийн зохицуулалтууд, түгээлт, тээвэрлэлтэд тавигдах тусгай шаардлага, хадгалалтын горим, ачилт буулгалтын дүрэм, журмуудыг судлах, зөвлөх.
Энхтайван Нямбаяр	Маркетингийн Зөвлөх	Зорилтот зах зээлийн багтаамж, хэрэглэгч, тэдний ангилал, мах, махан бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг тодорхойлох.
Бейсен Ерболат	Эдийн Засгийн Зөвлөх	Зорилтот орнуудын хүн амын худалдан авах чадвар, онцлог, хэрэглээ, хэмжээ болон махны зах зээлийн эргэлт, импортын болон дотоодын багтаамж, үнэ бүрдэлтийг судлах.
Даваасүрэн Нар Од	Санхүүгийн Зөвлөх	Зорилтот орнуудын бөөний болон жижиглэнгийн үнийн түвшин, хэлбэлзэл, цаг хугацаа, улирлын нөлөө, үнэ тогтооход нөлөөлөх хүчин зүйлүүдийг тодорхойлох.
Хадыс Батырбек	Шашин, Халал стандартын Зөвлөх	Зорилтот орнуудын хүн амын мах, махан бүтээгдэхүүний хэрэглээний уламжлал, онцлог. Махны чанарт тавьдаг онцлог шаардлага, хэрэглэгчийн сонирхол.

Хуанбай Елтай	Техник, технологи, арга зүйн Зөвлөх	Мах бэлтгэл, анхан шатны боловсруулалтад тавигдах шаардлага, хэрэглэж буй арга хэлбэр, технологийн шийдлүүд, мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хэлбэр, нэр төрөл, хадгалалтын горим шаардлага.
Дашрэнцэн Билгүүн	Хууль эрх зүйн Зөвлөх	Гадаад, дотоод худалдааны эрх зүйн зохицуулалт, ОУ-ын гэрээ хэлэлцээр болон бусад эрх зүйн актуудын судалгаа. Тарифийн болон, тарифийн бус зохицуулалт, гаалийн татвар, нэмэгдсэн өртгийн татвар, худалдааны болон хэрэгжиж буй бусад татвар, хураамжийн хэрэгжилтийн байдлын үнэлгээ.
Алданыш Досымбек	Захиргаа, бичиг хэрэг	Зөвлөхүүдийн хэвийн ажиллах нөхцлийг хангах, ажлын байрны болон судалгааны явцын бичиг хэрэг хөтлөх.

2.4. АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Судалгааны ажлын гүйцэтгэлийн нарийвчилсан төлөвлөгөөг дараах хүснэгтээр харуулав. Тус төлөвлөгөөг нийт 6 сарын хугацаанд, 7 хоногоор гаргаж ажлын багаар батлуулав.

Хүснэгт 2. Ажлын төлөвлөгөө

№	Сар/7 хоног	1				2 сар				3 сар				4 сар				5 сар				6 сар			
		1	1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4	5	1	2	3	4		
1	Зөвлөх үйлчилгээ гүйцэтгэх гэрээ байгуулах																								
2	Судалгаа явуулах хүрээ, арга зүйг тодорхойлох																								
3	Эхлэлийн тайлан																								
4	Зорилтот орнуудаас мэдээлэл солилцох байгууллага, иргэдтэй хамтран ажиллах																								
5	Зорилтот орнуудад очиж анхдагч судалгаа явуулах, мэдээлэл цуглуулах,																								
6	Өөрийн орны холбогдох байгууллага, холбоод, компаниудтай уулзаж хоёрдогч судалгаа явуулах																								
7	Нэмэлт мэдээлэл худалдаж авах, боловсруулах																								
8	Явцын тайлан 1																								
9	Багийн зөвлөгөөн, мэдээлэлд анализ																								

орнуудын хамтын ажиллагааны зөвлөлийг (ПБХАЗ) зайлшгүй судлах шаардлагын дагуу Худалдаа эдийн засгийн нэгдсэн тогтолцоотой гишүүн орнууд болох Оман, Бахрейн, Арабын нэгдсэн Эмират улсуудыг нэмж судалж судалгааны хүрээг тэлсэн болно. Түүнчлэн Персийн булангийн (ПБХАЗ) орнуудад 2019 оны 2-р сарын 05-наас 2-р сарын 28-ны хооронд ажиллаж зорилтот орнуудын хонь (HS0204), ямааны (HS0204) махны хэрэглээ, дотоодын үйлдвэрлэл, импорт болон хэрэглэгчийн зан төлөв, бусад хүчин зүйлсийг хамруулан судлав.

Схем 1. Судалгаа гүйцэтгэх арга зүйн схем зураг



Анхдагч судалгаа

Анхдагч судалгаагаар зорилтот орнуудын махны эрэлт хэрэгцээний хэмжээ ба импортын дүрслэлийг гаргаж манай улсаас экспортлох махны төрөл, хэмжээг харьцуулан судлав. Ингэхдээ тухайн улс орнуудын импортын болон дотоодын бүтээгдэхүүний тоон мэдээллийг холбогдох байгууллага, Олон улсын худалдааны төв, мөн судалгаа шинжилгээний хүрээлэнгүүдээс авав.

Ойрх Дорнодын орнуудын мэдээлэл цахим орчинд байх боловч ихэнхдээ 2016 оноос өмнөх мэдээлэл байх агаад тэр нь хуучирсан, эх сурвалж нь тодорхойгүй байсан тул судалгааг газар дээр нь очиж хийсэн нь мэдээлэл үнэн зөв байх, хугацаа хожих, импортлогчидтой бодит харилцаа тогтоох боломж олгож байна. Олон улсын судалгаа шинжилгээний байгууллагууд Ойрх Дорнодын орнуудын талаарх мэдээллийг нууцалдаг нь бизнесийн нэг арга бөгөөд хэрэгцээ бүхий судлаачид худалдаж авах боломжтой. Гэвч тоон болон чанарын мэдээлэл худалдаж авах нь асар өндөр үнэтэй бөгөөд зарим талаараа хүссэн мэдээллээ олж авах нь төвөгтэй байв. Жишээ нь Евро-мониторинг байгууллага нэг багц мэдээллээ 14,000 Америк доллараар (37,000,000 төг) үнэлж байв.

Анхдагч судалгаагаар зорилтот орнуудын махны хэрэглээ, зах зээл, худалдаа импорттой холбоотой мэдээллүүдийг төрийн болон төрийн бус байгууллагууд, хувийн компаниуд, иргэдээс авч байв. Тухайн орны төрийн байгууллагын онцлог нь мэдээллээ шууд гаргаж өгдөггүй, албан хүсэлт, уулзалт товлож байж өгдөг онцлогтой юм байна. Судалгааны асуумж,

мэдээллийг хавсаргав (Хавсралт 13). Тус орнуудын экспорт хийх хамгийн дөт арга, боломжит хувилбаруудыг судалж мах экспортлох боломжийн талаар салбар хариуцаж буй түшмэдтэй уулзаж санал бодлоо хуваалцсан болно. Мөн импортлогчдын зах зээлийн багтаамж болон хэрэгцээг харгалзан махны төрөл, сав баглаа боодол болон чанарыг судлав (Хүснэгт 33 харна уу). Тухайн зах зээлд нэвтрэхэд шаардлагатай хууль эрх зүйн орчин, татвар, чанар, стандарт зэрэг олон баримтуудыг цуглуулав.

Импортын хүнсэнд нэгдүгээрт Ислам шашны, хоёрдугаарт эрүүл ахуйн хатуу шаардлага тавьж оруулдаг. Иймд Исламын бус улсаас хүнс импортолж байгаа тохиолдолд тус бүтээгдэхүүнийг халал байх шаардлагыг өндөр түвшинд тавьж, хяналтын бүхэл бүтэн албан газар байгуулж ажиллуулдаг байна. Энэ тухай 5.8.12-р хэсгээс дэлгэрэнгүй үзнэ үү.

Арабын орнуудтай худалдаа, наймаа хийхийг зорьж байгаа тохиолдолд тус орнуудын экспорт, импорттой холбоотой хууль эрх зүйн орчин болоод хуулийн хэрэгжилтийг сайтар судалж үзэх зайлшгүй шаардлагатай байна. Үүний тулд ПБХАЗийн талаар судлах хэрэгтэй ба энэ тухай тайлангийн 5.8.4-р хэсэгт дэлгэрэнгүй оруулсан.

Анхдагч судалгааны хамрах хүрээ:

- Тус судалгаа нь Ойрх Дорнодын орнуудын халал махны (хонь, ямаа) худалдаа, импорттой холбоотой, мөн чанар, хууль эрх зүй, сүүлийн үеийн ахиц дэвшлийн талаар тайлагнах;
- Ойрх Дорнодын зах зээлд өрнөж байгаа халал махтай холбоотой худалдааны боломжууд, үнэ, эцсийн хэрэглэгчид болон бусад бэрхшээлүүдийг тодорхойлох;
- Бүтээгдэхүүний тээвэрлэлт, төрөл, халал, эрүүл ахуй, (сэврээсэн, хөлдүү, лаазалсан) шаардлагыг нарийвчлан судлах;
- Нийлүүлэлтийн суваг, зах зээлийг үйл ажиллагааных нь хэжээгээр (сегментчлэлээр) нь бөөний, жижиглэнгээр болон бусад сувгуудаар нийлүүлэлт хэрхэн хийдгийг судлах;
- Ойрх Дорнодын орнуудын худалдааны хамтын ажиллагаа, гаалийн нэгдсэн холбооны зохицуулалтыг судлах;
- Анхдагч судалгаагаар зорилтот орнуудын экспорт, импортын шийдвэр гаргадаг болон гүйцэтгэдэг төрийн байгууллагуудын түшмэд, ажилтнуудтай уулзах, үйлдвэрлэгч болон хэрэглэгчдийн төлөөлөлтэй уулзах, орон нутгийн махны борлуулалт болон махны үйлдвэрийн газруудаар судалгаа хийх.

Судалгааг ихэвчлэн асуумж (interview) болон багаар ярилцах (Focus group discussion) байдлаар явуулсан бөгөөд арга зүйн дагуу судалгааны асуумжуудыг бэлдсэн байв.

Монгол Улсаас Ойрх Дорнодын орнуудад суугаа дипломат төлөөлөгчийн газрын ажилтнууд маш их цаг зав гарган дэмжиж, уулзалт бүрт орчуулгын ажилд туслаж байсныг онцлон тэмдэглэж байна.


Хоёрдогч
судалгаа

Ойрх Дорнодын орнуудад мах экспортлох боломжуудыг судлах ажлын хүрээнд өөрийн орны махны экспорттой холбоотой төрийн болон төрийн бус байгууллага, үйлдвэрлэгчид, малчид, тээвэр ложистикийн төлөөллүүдтэй уулзаж судалгаа явуулав.

ХХААХҮ-ийн сайд, ГХ-ны сайд, хөдөө аж ахуйн болон худалдааны салбарын бодлого боловсруулагчид, мал эмнэлгийн газар, эрдэм шинжилгээний хүрээлэн, төрийн бус байгууллагууд, хувийн аж ахуй, үйлдвэр зэрэг шаталсан байдлаар экспортын бүх оролцон тоглогчидтой уулзаж, ярилцлага зохион байгуулав.

Дэлхийн худалдааны байгууллага, Дэлхийн Банк, НҮБ-ийн Хүнс, Хөдөө аж ахуйн байгууллага зэрэг олон улсын байгууллагуудын тайлан болон ОУ-ын судалгааны байгууллагын


төлбөртэй мэдээллүүдийг цуглуулж энэхүү судалгаанд ашигласан болно.




Судалгааны арга зүйн дагуу анхдагч судалгааны үр дүнд тулгуурлан бодит бэрхшээлүүдийг тодорхойлж тэдгээр асуудлыг хамаарсан эрх бүхий байгууллагуудтай уулзаж хоёрдогч судалгааны дүнг гаргаж, түүндээ задлан шинжилгээ хийв.

Хоёрдогч судалгааны явцыг анхдагч судалгаатай харьцуулж үзэхэд Ойрх Дорнодын орнуудын зах зээл нь тодорхойгүй, харилцаа холбоо ашиглах суваг нээлттэй бус, судалгаа хийхэд маш их бэрхшээлтэй мэт боловч импортын бараа бүтээгдэхүүндээ тавьж буй шаардлага, үндэслэл нь тодорхой, ойлгомжтой байлаа. Харин эсрэгээрээ манай дотоодын үйлдвэрүүдийн хүчин чадал хийгээд мах экспортлох нөөц бололцоо дутмаг, ойлгомжгүй, баталгаатай бус байгаа нь ажиглагдав. Мөн манай орны холбогдох хууль, эрх зүйн орчин нь байгаа мөртлөө хэрэгждэггүй байдал нь экспортыг хойш нь чангааж байна гэж ойлгогдож байна.


Анхдагч болон хоёрдогч судалгааны үр дүнд тэдгээр баримтуудыг батлах, тайлбарлахын тулд нэмэлт мэдээлэл цуглуулах шаардлагатай байв. Үүний тулд Ойрх Дорнодын болон өөрийн орны холбогдох байгууллагуудтай харилцааны олон төрлийг (уулзалт, e mail, skype) ашиглан уулзалт зохион байгуулж, мэдээлэл цуглуулав. Арабын булангийн орнуудын (ПБХАЗ) худалдаа хариуцсан байгууллагын түшмэд, ажилтнуудаас нэмэлт мэдээллүүдийг цаг тухайд авч байсан нь тэдгээр орнууд хүнсний импортодоо маш их анхаарал хандуулдгийг харуулж байна. Зорилтот орнуудын хүнсний зах, агуулах, тээвэрлэлт, хяналт шалгалт болон энгийн иргэдийн үйлчлүүлдэг өдөр тутмын дэлгүүр, цайны газар болон тээвэрлэлттэй холбоотой зураг, мэдээллүүдийг авч нягтлан судалж байв.



Судалгааны арга зүй ба төлөвлөгөөний дагуу зорилтот орнуудын махны зах зээл, экспорт импортын талаархи статистик тоо баримтууд, хууль дүрэм журам, үйлдвэрлэл, Халал хяналт гээд маш их баримт мэдээлэл цуглуулсан бөгөөд тэдгээр мэдээллийг судалгааны үндсэн зорилгын хүрээнд боловсруулж нягтлахад бэлдэв. Ингэхдээ өөрийн орны эрдэмтдийн боловсруулсан судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх арга зүйг² ашиглан хийв. Судалгааны материалын агуулга, салбаруудыг хамааруулсан байдал болон хүртээмжинд үнэлэлт, дүгнэлт хийж дутуу болон чанаргүй мэдээлийг нэмж цуглуулав.




Хэдийгээр судалгааны ажлын гол зорилго нь зорилтот орнуудын махны зах зээлийн судалгаа хийх байсан боловч ажлын даалгаварт өөрийн орны мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн хүчин чадал, мал сүргийн эргэлт, тээвэрлэлт, маркетинг болон экспортод тулгамдаж буй бэрхшээлүүдийн талаар судлах ёстой байв. Иймд судалгааны багт махны үйлдвэрийн эксперт, зөвлөхүүд болон нарийн мэргэжлийн экспертүүд оролцон ажиллав. Мэдээлэлд эксперт үнэлгээ хийх нь мэдээлэл боловсруулах үеийн өмнөх шат бөгөөд мэдээллийг бодитой, цэгцтэй болоход эерэг нөлөөтэй аргачлал юм.



Салбар бүрийг хариуцсан судлаачид, зөвлөхүүд анализ хийж салбарын экспертүүдийн үнэлгээг авч дүгнэгдсэн мэдээллийг боловсруулсан. Мэдээллийг боловсруулахдаа тухайн салбарт тохирсон аргачлалуудыг хэрэглэсэн бөгөөд тайланг уншиж буй хүнд ойлгомжтой, тодорхой, дүгнэлт анализ хийх боломжийг олгохоор хийв. Багийн гишүүдийн

² Ч. Авдай, Д. Энхтуяа <http://mandakh.edu.mn/news/187/single/2156>

боловсруулсан мэдээллийн хүрээнд тус тайланд нийт 46 хүснэгт, 30 зураг, 7 схем, 20 график, 60 тайлбар (footnote) байна.



Тус судалгааг захиалагчдаас ирүүлсэн даалгаврын дагуу үндсэн гурван үе шатанд бичиж тайлагнаж байна. Үе шат бүрт тайланг цахим болон хэвлэмэл байдлаар захиалагчдад хүргүүлж санал, зөвлөгөө, шүүмж авч байв. Үе шат бүрийн хугацааг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгав. Тайлан Монгол, Англи хэл дээр бичигдсэн байна. Тайлан бичих үе шат нь 1. Эхлэлтийн тайлан, 2. Явцын тайлан, 3. Эцсийн тайлан байна.

4. ЗОРИЛТОТ ОРНУУДЫН ХЭРЭГЛЭГЧИЙН ЗАН ТӨЛӨВ, УЛАМЖЛАЛ, ОНЦЛОГ

4.1. ХЭРЭГЛЭГЧИЙН ЗАН ТӨЛӨВ, УЛАМЖЛАЛ

Судалгааны зорилтот Саудын Араб, Катар, Кувейт, Арабын Нэгдсэн Эмират улсуудын зах зээлийн үндсэн хэрэглэгч болох иргэд нь Ислам шашин шүтдэг ба улс төр, эдийн засгийн тогтолцоо нь Ислам шашны зан үйлтэй шууд холбоотой байна. Эдгээр орнуудыг Персийн булангийн буюу Арабын ертөнцийн гол оролцогч улсууд гэж үздэг.

ПБХАЗ-ийн гишүүн орнууд болох Саудын Араб, Арабын Нэгдсэн Эмират улс, Кувейт, Бахрейн, Оман, болон Катар улс нь 56.0 сая гаруй хүн амтай бөгөөд нэг хүнд оногдох ДНБ³-ий хэмжээгээрээ (дундаж 69,000 ам доллар) дэлхийн хамгийн баян орнуудад тооцогдож байна. Тус орнууд нь шашин шүтлэг, төрийн байгуулалтаараа төдийгүй эдийн засгаараа ч ижил байдаг ба хүн амд оногдох баялаг болон орлогын хэмжээгээрээ бусад хөрш орнуудтайгаа харьцуулшгүй өндөр бөгөөд гол төлөв газрын тос, байгалийн хийн олборлолтоор төсвийн орлогоо бүрдүүлдэг. Гэсэн хэдий ч газар зүйн байрлалаас шалтгаалан цэвэр усны болон газар тариалангийн талбайн хомсдолтой байдгаас шалтгаалан эдгээр улс орнууд хүнсний бүтээгдэхүүнийхээ 90 орчим хувийг импортоор хангаж байна. Дэлхий дээр Исламын шашинтай 1.8 тэрбум гаруй хүн аж төрж байна. Тэд шашны ёс заншлын дагуу зөвхөн халал аргаар боловсруулсан махыг өдөр тутамдаа хэрэглэдэг.

Судалгаагаар хонь, хурганы махыг Ойрх Дорнодын орнуудын хүн ам хэрэглэх дуртай болох нь харагдаж байна. Хурганы мах нь коллаген ихтэй, зөөлөн, амттай, шарж хуурч иддэг нь хэрэглэгчийн эрэлтэд тодорхой хэмжээгээр нөлөөлж байна. Мөн уураг ихтэй хонины махыг шашин болон баяр ёслолын үед хэрэглэж ирсэн уламжлалтай. Арабын орнуудад махны хэрэглээ, ялангуяа хонины махны хэрэглээ нь орон нутгийн уламжлал, шашны баяр наадам, тухайлбал Хаж⁴ улиралтай холбоотой эрэлтийн хэмжээ нэмэгддэг. Уг шашны зан үйл нь нэгээс хоёр долоо хоног хүртэл үргэлжилдэг. Энэ зан үйлийн үргэлжлэл болох Курбан буюу тахил өргөх ёслолын баярын үед амьжиргааны боломжоосоо хамаарч өндөр орлоготой хүмүүс их тооны, дунд орлоготой хүмүүс цөөн тоогоор тахил өргөж (хонь, ямаа, үхэр гаргаж) амьдралын бололцоо доогуур, ядуу зүдүү улсуудад тараадаг уламжлалтай. Курбан нь зөвхөн Араб улсад бус тухайн цаг хугацаанд дэлхийн аль ч газарт ислам шашинтай хүмүүс үйлдэх боломжтой байдаг ажээ.

³ Дотоодын нийт бүтээгдэхүүн (тодорхой хугацаанд тухайн оронд шинээр бүтээгдсэн бараа болон үйлчилгээнүүдийн зах зээлийн үнийн нийлбэр)

⁴ Хаж - Дэлхийн өнцөг булан бүрийн Ислам шашинтнууд (ойролцоогоор 3 сая хүн) Саудын Араб улсын Меккад ирж мөргөл үйлддэг

4.2. ХАЛАЛЫН ТУХАЙ

Тус судалгааны хүрээнд Мусулман хүмүүсийн хэрэглэдэг халал хүнс, халал махны шаардлагуудын тухай мэдээллийг судалж мусулман болон мусулман бус хүмүүсийн хоорондох халал хүнстэй холбоотой хэрэглээний онцлогийг тодорхой гаргаж тайлагнахыг зорив. Ингэснээр Ойрх Дорнодын орнуудад халал мах экспортлох зорилготой өөрийн орны үйлдвэрлэгчид Ислам шашин, Мусулман хүн, халал хүнсний талаар дэлгэрэнгүй, зөв ойлголттой болж тэдгээрийн шаардлагыг хангаж урт хугацаанд тогтвортой халал мах нийлүүлэх эх суурь болох болно. Ислам шашинтай хүмүүсийн баримталдаг зарчим нь халал буюу ариун хүнс хэрэглэх явдал юм. Халал гэдэг нь Араб үг бөгөөд Монголоор “цэвэр ариун”, “зөвшөөрөгдсөн” гэсэн утгатай. Халал-ын эсрэг утгатай үг нь Харам юм. Энэ нь ариун бус гэсэн санааг илэрхийлнэ. Жишээ нь, гахайн мах, архи, согтууруулах ундаа “харам” бүтээгдэхүүнд тооцогдоно.

Халал хүнсний бүтээгдэхүүний ихэнх хувийг эзэлдэг, үндсэн суурь нь Халал мах юм. Хүнсний бүтээгдэхүүн харам болох нь ихэнхдээ орцонд нь халал аргаар төхөөрөөгүй мах, махан бүтээгдэхүүн болон спиртлэг зүйлсийг агуулсантай холбоотой байдаг. Эм болон эмийн төрлүүд, гоо сайхны бараануудад хүртэл орцонд нь халал аргаар төхөөрөөгүй мах, махан бүтээгдэхүүн болон спиртлэг зүйлс агуулсанаараа шалтгаалан харам, халал хэмээн ялгардаг аж. Үүнээс гадна ислам шашны дагуу бохир хэмээн хориглодог цус, гахайн төрлийн мах, эд эрхтэн, өтгөн шингэн г.м бохир зүйлс агуулдаг бүтээгдэхүүнийг халал бус хэмээн тооцдог.

Мах болон махан бүтээгдэхүүн нь хүнсний хувьд ч, хэрэглээний хувьд ч Исламын ертөнцөд хамгийн хурдацтай хөгжиж байгаа салбар. Статистик судалгааны үр дүнд Ислам шашинт улс орнууд өөр улс орнуудтай харьцуулахад мах их хэрэглэдэг болох нь тодорхой байна. Гэгээн элч Мухаммед нэгэн сургаалдаа: “Хоолны агуу нь мах” гэсэн байдаг. Тийм учраас Исламын ертөнцөд хэдэн зуун жилийн өмнөөс эхлэн мах болон махан бүтээгдэхүүн онцгой байр суурь эзэлдэг юм. Ялангуяа исламын ертөнцөд махаар хийдэг хоолны төрөл их, бас сайн хөгжсөн байдаг.



5. ЗОРИЛТОТ ОРНУУДЫН МАХНЫ ЗАХ ЗЭЭЛ

5.1. ЗОРИЛТОТ ОРНУУДЫН МАХНЫ ХЭРЭГЛЭЭ

Олон улсын судалгааны байгууллагуудын судалгаагаар⁵ 2030 он гэхэд дэлхийн ислам шашинтай хүн амын тоо 35-аас дээш хувиар өсч 2.2 тэрбумд хүрэх төлөвтэй байна. Бүс нутгийн ислам шашинтай залуу хүн амын тоо 3.3%-иар өсч байгаа нь дэлхийн дундаж өсөлт 1.1%-иас их юм. Өнгөрсөн таван жилийн хугацаанд Саудын Араб, Катар, Кувейт багтсан Персийн булангийн хамтын ажиллагааны орнуудын мах, махан бүтээгдэхүүний хэрэглээ 28 хувиар нэмэгдсэн байна. Персийн булангийн орнууд нь хүн амын өсөлт, амьжиргааны түвшин, хотжилтын явц, аялал жуулчлал, хязгаарлагдмал хөдөө аж ахуйн үйлдвэрлэл зэргээс шалтгаалан халал махны хэрэглээ нь хамгийн хурдацтай өсч буй бүс нутгуудын нэгт тооцогддог.

⁵ Pew Research Center” судалгааны байгууллага/ <https://www.pewresearch.org/>


Хүснэгт 3. Персийн булангийн орнуудын махны хэрэглээ, мянган тонн

Улсын нэр	2012	2013	2014	2015	2016	2017	2018	Хувь
Саудын Араб	1,334.40	1,389.00	1,395.40	1,426.80	1,463.30	1,500.40	1,531.20	54.7%
АНЭмират Улс	369.40	392.40	420.20	452.30	481.40	515.80	555.70	19.9%
Кувейт	208.00	224.50	235.30	260.50	282.00	305.60	331.30	11.8%
Оман	166.90	185.60	203.70	216.20	225.50	231.70	236.20	8.4%
Бахрейн	48.00	49.10	50.20	50.80	51.60	51.90	57.10	2.0%
Катар	55.25	58.00	63.30	76.63	75.79	81.38	87.96	3.1%
Нийт	2,181.95	2,298.60	2,368.10	2,483.23	2,579.59	2,686.78	2,799.46	100.0%

Эх сурвалж: Евромонитор⁶

Персийн булангийн орнуудын дотоодын махны үйлдвэрлэлийн нөөц, хүчин чадал нь дотоодын зах зээлийн эрэлт хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй бөгөөд 2018 онд нийт 4.2 тэрбум гаруй ам доллар бүхий махыг 12 орноос импортлон хэрэглэсэн байна. Бүс нутгийн нийт махны (үхэр болон тугалын мах, хонь, хурга болон ямааны мах, шувууны мах) хэрэглээ 2018 онд 2.79 сая тн хүрч 2012 оныхоос 28.7%-иар өссөн байна. Саудын Арабын хүн амын тоо (33.4 сая) Персийн булангийн орнуудын (ПБХАЗ) хүн амын (56 сая) 60%-ийг бүрдүүлж байгаа ба бүс нутгийн махны борлуулалтын 54.7%-ийг эзэлдэг байна.

График 1. Саудын Араб, Кувейт, Катар улсуудын махны хэрэглээний өсөлт




Эх сурвалж: Евромонитор

Өсөлт = Жилийн нийлмэл өсөлтийн хувь

Персийн булангийн орнуудын сүүлийн 6 жилийн махны хэрэглээний нийлмэл өсөлтийн дундаж 3,4% байна. Үүнээс Катар 8.1%, Кувейт 8.1%, Саудын Араб 2.3%-тай байна. Хэдийгээр Саудын Арабын өсөлтийн хувь бага боловч тоон (1,5 сая тн) дүн болон хэрэглээгээрээ бусад улсуудаас өндөр бөгөөд 196.8 мянган тонноор өссөн дүнтэй байна. Ялангуяа сүүлийн 4 жилд Саудын Арабын махны хэрэглээ жил бүр 30 мянган тонноор нэмэгджээ.

⁶ Евромонитор international – Олон улсын судалгааны байгууллага

График 2. Бүс нутгийн махны хэрэглээ, төрлөөр



ПБХАЗ-ийн бүс нутгийн 2018 оны нийт махны хэрэглээг авч үзвэл тахиа, шувууны мах зонхилж жилд 2.1 сая тонн, үхрийн мах 301 мянган тонн, хонь, ямааны мах 397.21 мянган тонн байсан ба үүнээс хонь, ямааны мах нийт хэрэглээний 14%-ийг эзэлж байна.

Тахиа болон шувууны махны хэрэглээ өндөр байгаа нь хэрэглэгчдэд хүртээмжтэй, ханган нийлүүлэлт их, хадгалалтын хялбар горим, хямд үнэтэй, мөн тухайн орнуудад ажиллаж амьдардаг цагаач иргэд ихээр хэрэглэдэгтэй холбоотой байна. Тус бүс нутагт олон тооны түр оршин суугч гадаадын иргэд амьдардаг. Ялангуяа Кувейт болон Катарын хүн амын 70-80%-ийг гадаадын түр оршин суугч иргэд бүрдүүлдэг. Өрхийн орлого нэмэгдэх үе болон баяр ёслолын үед хэрэглэгчдийн махны сонголт өөрчлөгдөж үхэр болон хонины махны эрэлт тодорхой хэмжээгээр нэмэгддэг.

Хүснэгт 4. Персийн булангийн орнуудын махны хэрэглээний төсөөлөл 2019-2021 он, мянган тонн

Улсын нэр	2019	2020	2021	Өсөлт 2019-2021
Саудын Араб	1,558.70	1,582.00	1,602.40	2.8%
АНЭмират Улс	602.00	651.40	692.10	15.0%
Кувейт	361.30	392.20	418.60	15.9%
Оман	240.50	245.90	237.80	-1.1%
Бахрейн	62.80	68.90	74.40	18.5%
Катар	97.28	106.81	115.51	18.7%
Нийт	2,922.58	3,047.21	3,140.81	7.5%

Эх сурвалж: Евромонитор

Ирэх 3 жилд бүс нутгийн махны хэрэглээ 7.5%-иар өсч 3.1 сая тн хүрнэ гэсэн төсөөлөл байна. Үүнээс Катар улсын махны хэрэглээ хамгийн их өсөлтийн хувьтай байх бөгөөд тоон дүнгээр Кувейт улсын хэрэглээ 57.3 мянган тонноор нэмэгдэж зорилтот зах зээлийг тэргүүлэхээр байна. Саудын Арабын хувьд 2021 он гэхэд махны хэрэглээ 43.70 мянган тонноор нэмэгдэнэ гэж үзэж байна.

5.1.1. Саудын Араб улсын хүн амын махны хэрэглээ

Хүснэгт 5. Саудын Арабын махны хэрэглээ төрлөөр, мянган тонн

Махны төрөл	2012	2013	2014	2015	2016	2017	2018	Эзлэх хувь
Үхрийн мах	110.40	117.30	117.70	122.00	125.80	129.30	132.50	8.7%
Хонины, ямааны мах	125.60	146.60	139.80	144.20	148.10	151.60	154.70	10.1%
Тахиа, шувуу, бусад	1,098.40	1,125.10	1,137.90	1,160.60	1,189.40	1,219.50	1,244.00	81.2%
Нийт	1,334.40	1,389.00	1,395.40	1,426.80	1,463.30	1,500.40	1,531.20	100.0%

Эх сурвалж: Евромонитор

Саудын Арабын хүн амын махны хэрэглээ 2012 оноос 2018 хооронд 196.8 мянган тонноор нэмэгдэж жилийн дундаж өсөлт нь 2.3% байна. Сүүлийн жилүүдэд нийт махны хэрэглээ 30 мянган тонноос дээш, хонь, ямааны махны хэрэглээ жил бүр 3 мянган тонн дүнгээр нэмэгдсэн байна. Энэ улсад хонь, ямааны махны хэрэглээ нийт махны хэрэглээний 10.1%-ийг эзэлдэг бөгөөд 2018 онд 154.70 мянган тонн хүрч 2012 оныхоос 23.2%-иар буюу сүүлийн 6 жилд дунджаар 3.5%-иар өссөн байна.

5.1.2. Кувейт улсын хүн амын махны хэрэглээ

Хүснэгт 6. Кувейтийн хүн амын махны хэрэглээ төрлөөр, мянган тонн

Махны төрөл	2012	2013	2014	2015	2016	2017	2018	Эзлэх хувь
Үхрийн мах	40.00	42.10	43.70	48.60	52.80	57.40	62.40	18.8%
Хонь, ямааны мах	35.40	37.80	39.40	43.40	47.10	51.70	56.80	17.1%
Тахиа, шувуу, бусад	132.60	144.60	152.20	168.50	182.10	196.50	212.10	64.0%
Нийт	208.00	224.50	235.30	260.50	282.00	305.60	331.30	100.0%

Эх сурвалж: Евромонитор

Кувейт улсын нийт махны хэрэглээ 2012 оноос 2018 хооронд жилийн 8.1%-ийн дундаж өсөлтөөр 123.3 мянган тонноор нэмэгджээ. Сүүлийн жилүүдийн тооцооллоор нийт махны хэрэглээ 20 мянган тонноос дээш, хонь, ямааны махны хэрэглээ жил бүр 4 мянган тонноор өсч байна. Хонь, ямааны махны хэрэглээ тус орны нийт махны хэрэглээний 17.1%-ийг эзэлдэг бөгөөд 2018 онд 56.80 мянган тонн хүрч 2012 оныхоос 60.5%-иар өссөн дүнтэй байна.

5.1.3. Катар улсын хүн амын махны хэрэглээ


Хүснэгт 7. Катарын махны хэрэглээ төрлөөр, мянган тонн

Махны төрөл	2012	2013	2014	2015	2016	2017	2018	Эзлэх хувь
Үхрийн мах	7.10	7.20	7.80	8.90	10.10	11.30	12.50	14.2%
Хонь, ямааны мах	23.85	25.20	27.50	35.83	29.69	29.58	34.86	39.6%
Тахиа, шувуу, бусад	24.30	25.60	28.00	31.90	36.00	40.50	40.60	46.2%
Нийт	55.25	58.00	63.30	76.63	75.79	81.38	87.96	100.0%

Эх сурвалж: Евромонитор

Катар улсад махны хэрэглээ жилийн 8.1% дундаж өсөлттэй буюу 2012 - 2018 онуудад тоон дүнгээр 32.71 мянган тонноор нэмэгдсэн байна. Хонь, ямааны махны хэрэглээ тус улсын нийт махны хэрэглээний 39.6%-ийг эзэлдэг бөгөөд 2018 онд 34.86 мянган тонн хүрч сүүлийн 6 жилийн дунджаар 6.5%-иар буюу тоон дүнгээр 5,2 мянган тонноор өссөн үзүүлэлттэй байна. Мөн тус улсад 2020 оны 11-р сард хөл бөмбөгийн Дэлхийн аварга зохион байгуулагдахтай холбогдсон арга хэмжээнүүд, жуулчин, зочдын урсгал нэмэгдэхтэй холбогдуулан ирэх 3 жилд хонь, ямааны махны хэрэглээ өсөх хандлагатай байна.

График 3. Зорилтот зах зээлийн хонь, ямааны махны хэрэглээ, 2012-2021 он



Эх сурвалж: Евромонитор

Зорилтот зах зээлийн хонь, ямааны махны жилийн хэрэглээ нь 246.11 мянган тонн бөгөөд Саудын Араб тус зах зээлийн 62.9%-ийг, Катар улс 12.1%-ийг эзэлдэг байна. Сүүлийн 6 жилийн дундаж өсөлт 5.5%-тай байна. 2021 онд зорилтот зах зээлийн хонь, ямааны махны хэрэглээ жилд 4.8%-иар өсч 283.21 мянган тонн хүрнэ гэсэн төсөөлөл байна.

5.1.4. Малайз улсын хүн амын махны хэрэглээ

Хүснэгт 8. Малайзын махны хэрэглээ төрлөөр, мянган тонн

Махны төрөл	2013	2014	2015	2016	2017	2018	Эзлэх хувь
Үхрийн мах	204.70	210.40	236.00	224.00	217.60	223.70	11.4%
Хонь, ямааны мах	27.46	33.31	36.35	35.04	37.40	38.25	1.9%
Тахиа, шувуу, бусад	1,472.18	1,590.55	1,630.53	1,648.21	1,670.00	1,700.10	86.6%
Нийт	1,704.34	1,834.26	1,902.88	1,907.25	1,925.00	1,962.05	100.0%

Эх сурвалж: Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (Хоёр дахь хэвлэлт 2018)⁷: НҮБ-ын ХХААБ, Хөдөө аж ахуйн тойм

Малайз улсын хүн амын махны нийт хэрэглээ 1.9 сая тонн ба 2013-аас 2018 оны жилийн дундаж өсөлт нь 2.3% байна. Хонь, ямааны мах нийт махны хэрэглээний 1.9%-ийг эзэлдэг бөгөөд 2018 оны хэрэглээ 38.25 мянган тонн байгаа нь ижил хүн амын тоотой Саудын Арабын хэрэглээнээс дөрвөн дахин бага юм. Гэхдээ энэ хэрэглээний 90-ээд хувийг импортоор хангадаг. Жилд дунджаар 36 мянган тонн хонь, ямааны мах, түүний дотор 22 мянган тонн хонины хөлдүү ястай мах импортолдог нь нийт хонь, ямааны махны импортын зах зээлийн 60-аас дээш хувийг эзэлж байна.

5.1.5. Индонез улсын махны хэрэглээ

Хүснэгт 9. Индонезын махны хэрэглээ төрлөөр, мянган тонн

Махны төрөл	2013	2014	2015	2016	2017	2018	Эзлэх хувь
Үхрийн мах	648.40	631.10	589.60	663.60	685.60	697.00	23.6%
Хонь, ямааны мах	114.04	110.68	109.73	108.09	107.70	110.89	3.8%
Тахиа, шувуу, бусад	1,873.76	1,979.77	2,055.46	2,074.37	2,093.56	2,141.48	72.6%
Нийт	2,636.20	2,721.55	2,754.79	2,846.06	2,886.86	2,949.37	100.0%

Эх сурвалж: Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (Хоёр дахь хэвлэлт 2018)

Индонез улсын махны нийт хэрэглээ ПБХАЗ-ийн орнуудынхаас их боловч Саудын Арабын хонь, ямааны махны хэрэглээнээс бага байна. 2018 онд хонь, ямааны мах нийт махны хэрэглээний 3.8%-ийг бүрдүүлжээ. Индонез улс жилд ердөө 2 мянган орчим хонь, ямааны мах импортолдог ба энэ нь нийт хонь, ямааны махны хэрэглээний 2%-ийг эзэлдэг байна.

⁷ Organisation for Economic Co-operation, Development – Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага

5.2. ЗОРИЛТОТ ОРНУУДЫН МАХНЫ ИМПОРТ

Хонь, ямааны махыг дэлхийн 200 гаруй орон хэрэглэдэг. Исламын хамтын ажиллагааны байгууллагын мэдээлснээр дэлхийн Халал хүнсний зах зээл 436,8 тэрбум ам доллар ба ирэх 5 жилд дунджаар 6.1%-иар өснө. Халал махан бүтээгдэхүүн экспортлогч орнуудыг Бразил, Австрали, Энэтхэг, Франц зэрэг улс тэргүүлж байна. Харин хамгийн том импортлогч нь Саудын Араб, Малайз, Арабын Нэгдсэн Эмират, Египет юм.

Хүснэгт 10. Персийн булангийн орнуудын махны импортын хэмжээ, сая ам доллар

Улсын нэр	2012	2013	2014	2015	2016	2017	2018	Эзлэх хувь
Саудын Араб	2,127.10	2,370.90	2,193.10	2,358.90	2,119.84	1,879.40	1,528.52	36%
АНЭмират	1,184.90	1,285.30	1,356.10	1,375.10	1,602.74	1,681.44	1,427.91	34%
Кувейт	447.30	455.90	447.10	506.30	475.15	550.95	447.05	11%
Катар	271.70	282.70	335.40	366.30	374.70	429.02	375.10	9%
Оман	240.20	262.60	254.80	266.50	272.51	241.28	272.57	6%
Бахрейн	137.30	190.10	187.00	173.40	218.28	226.28	167.50	4%
	4,408.50	4,847.50	4,773.50	5,046.50	5,063.22	5,008.36	4,218.65	100%

Эх сурвалж: Олон улсын худалдааны төв⁸

Персийн булангийн орнуудын махны импортын хэмжээ 2018 онд 4.2 тэрбум ам доллар хүрсэн бөгөөд бүс нутгийн импортын зах зээлийн 36%-ийг Саудын Араб эзэлдэг, Катар улсын импортын жилийн дундаж өсөлт 5.5%-иар бүс нутгийн хамгийн өндөр өсөлтийн үзүүлэлттэйд тооцогдож байна.

Хүснэгт 11. ПБХАЗ орнуудад мах экспортлогч гол улсууд, сая ам доллар

Улсын нэр	2012	2013	2014	2015	2016	2017	2018	Эзлэх хувь
Бразил	2,350.0	2,514.0	2,245.0	2,434.0	2,273.0	2,248.4	1,893.9	45%
Австрали	453.0	614.0	760.0	717.0	584.0	577.7	486.6	12%
Энэтхэг	520.0	612.0	667.0	663.0	518.0	512.4	431.6	10%
АНУ	266.0	278.0	276.0	214.0	215.0	212.7	179.1	4%
Франц	342.0	362.0	280.0	302.0	207.0	204.8	172.5	4%
Шинэ Зеланд	151.0	151.0	178.0	181.0	126.0	124.6	105.0	2%
Этиоп	70.0	70.0	80.0	94.0	93.0	92.0	77.5	2%
Өмнөд Африк	1.0	7.0	20.0	34.0	39.0	38.6	32.5	1%
Аргентин	42.0	27.0	36.0	70.0	31.0	30.7	25.8	1%
Иордан	1.0	1.0	1.0	12.0	26.0	25.7	21.7	1%
Турк	6.0	10.0	15.0	20.0	24.0	23.7	20.0	0%
Канад	3.0	15.0	8.0	20.0	21.0	20.8	17.5	0%
Бусад	203.5	186.5	207.5	285.5	906.2	896.4	755.1	18%
	4,408.50	4,847.50	4,773.50	5,046.50	5,063.22	5,008.36	4,218.65	100%

Эх сурвалж: Олон улсын худалдааны төв

⁸ Олон улсын худалдааны төв, www.trademap.org


Хүснэгт 12. Персийн булангийн орнуудын махны импорт төрлөөр, сая ам доллар

	2012	2013	2014	2015	2016	2017	2018	Эзлэх хувь
Тэжээвэр шувуудын мах	2,764.7	3,143.6	2,788.5	3,026.9	3,008.6	2,722.8	2,127.4	50.4%
Хонь, ямааны мах	596.8	644.8	825.7	780.4	822.8	925.8	776.9	18.4%
Үхрийн шинэ, хөлдүү мах	763.6	808.5	913.0	1,192.8	1,187.5	1,314.6	1,277.7	30.3%
Бусад	283.4	250.6	246.3	46.4	44.2	45.2	36.6	0.9%
	4,408.5	4,847.5	4,773.5	5,046.5	5,063.2	5,008.4	4,218.6	100.0%

Эх сурвалж: Олон улсын худалдааны төв

Импортын махны нийт зах зээлийн 50%-ийг тахиа, шувууны мах эзэлдэг. Хонь, ямааны махны импортын жилийн дундаж өсөлт 4.5% бөгөөд бүс нутгийн хамгийн өндөр өсөлттэй махны төрөлд тооцогдож байна.

График 4. Персийн булангийн орнуудад хонь, ямааны махны гол экспортлогчид




Эх сурвалж: Олон улсын худалдааны төв

Персийн булангийн орнуудад хонь, ямааны мах экспортлогч гол орнууд Австрали, Энэтхэг, Этиоп болон Шинэ Зеланд юм. Тухайлбал, тус орнуудад мах нийлүүлэгч гол улс Австрали Ойрх Дорнодын бүс нутгийн хонь, хурганы махны импортын 53 хувийг дангаар эзэлж, монополь тогтоогоод байна.

Дэлхийн мах, махан бүтээгдэхүүний нийт эргэлт нь жилд 260 сая гаруй тонн байдаг. Дэлхийн зах зээл дээрх мах, махан бүтээгдэхүүний ойролцоогоор 40 хувийг Азид үйлдвэрлэдэг, үхрийн махны гол үйлдвэрлэгч Европ нийт зах зээлийн гуравны нэгийг, 10-20 хувийг Америк тив эзэлж байна. Харин Африк болон далайн орнуудын хувьд мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл маш бага байдаг.

График 5. Зорилтот зах зээлийн хонь, ямааны махны импортын үзүүлэлтүүд



Эх сурвалж: Олон улсын худалдааны төв

Зорилтот орнуудын нийт зах зээл дахь (Саудын Араб, Кувейт, Катар) хонь болон ямааны махны импортын хэмжээ 2018 онд 396.0 сая ам доллар болж сүүлийн 3 жилд буурсан үзүүлэлттэй байна. Гэвч үүнийг улс тус бүрийн жилийн дунджаар авч үзэхэд Катар 5,1%, Кувейт 8.9%-иар өсч, Саудын Арабын импорт 14,4%-иар буурсан үзүүлэлттэй байна.

5.2.1. Саудын Араб улсын хонь, ямааны махны импортын зах зээл

График 6. Саудын Араб улсын импортын хонь, ямааны махны эзлэх хувь



Эх сурвалж: Олон улсын худалдааны төв

Саудын Араб улс 2018 онд 154.7 мянган тонн хонь, ямааны мах хэрэглэсэн бөгөөд үүний 20%-ийг импортлосон байна. 2015 онд нийт хэрэглээний 40%-ийг импортлож байсан ба сүүлийн гурван жилд тус улсын засгийн газар дотоодын мах үйлдвэрлэгчдийг дэмжсэн бодлого барьж, хөнгөлөлттэй зээл олгож эхэлсэнээс хойш импортын хэмжээ буурсан үзүүлэлттэй байна. Гэвч сүүлийн 5 жилийн хонь, ямааны махны хэрэглээний жилийн дундаж нь 2.6% өсөлттэй байгаа юм.

Хүснэгт 13. Саудын Араб улсын хонь, ямааны махны импортын хэмжээ

Хонь, ямааны махны төрөл	2014	2015	2016	2017	2018	2018 оны хувь
	тонн	тонн	тонн	тонн	тонн	
Хонины хөлдүү мах, ястай	29,985.00	32,360.00	13,945.00	15,763.00	18,861.00	61.3%
Хонины хөлдүү мах, ясгүй	3,653.00	3,098.00	4,091.00	4,627.00	5,271.00	17.1%
Хонины шинэ, хөргөсөн гулууз болон өрөөл мах	7,642.00	10,064.00	7,988.00	8,444.00	2,372.00	7.7%
Хонины шинэ, хөргөсөн ястай нь хэсэглэсэн бусад мах	2,460.00	2,574.00	2,309.00	1,474.00	2,227.00	7.2%
Хурганы шинэ эсвэл хөргөсөн гулууз болон өрөөл мах	6,233.00	6,948.00	9,175.00	4,295.00	820.00	2.7%
Хурганы хөлдүү гулууз болон өрөөл мах	1,085.00	518.00	466.00	1,527.00	437.00	1.4%
Ямааны мах	6,078.00	5,560.00	3,397.00	2,939.00	353.00	1.1%
Хонины шинэ эсвэл хөргөсөн ясгүй мах	65.00	107.00	170.00	215.00	234.00	0.8%
Хонины хөлдүү гулууз болон өрөөл мах	-	-	5,004.00	5,840.00	192.00	0.6%
Нийт	57,201.00	61,229.00	46,545.00	45,124.00	30,767.00	100.0%

Эх сурвалж: Олон улсын худалдааны төв

Саудын Араб улс 2018 онд хонь, ямааны 9 төрлийн махыг импортолжээ. Үүний дотор хонины ястай хөлдүү махны хэмжээ энэ онд импортолсон нийт хонь, ямааны махны 61.3 хувийг эзэлж өмнөх оноос 20-иар өссөн байна. Ямааны махны импорт 7 хувийг эзэлж, 2017 онд 2.9 мянган тонныг импортолсон байна. Мөн хурганы шинэ болон хөлдүү махны импорт их эрэлттэй харагдаж байна. 2016, 2017 онуудад хонь, ямааны махны нийт импортын дотор хурганы мах 13-аас 21%-ийг эзэлж байжээ.

Хүснэгт 14. Саудын Араб улсын хонь, хурга болон ямааны махны импортын дундаж үнэ, \$/кг

Махны төрөл	2014	2015	2016	2017	2018
Хонины мах	5.51	4.99	4.69	5.30	5.03
Хурганы мах	5.77	5.73	5.83	6.18	5.93
Ямааны мах	4.66	4.64	4.74	5.38	5.89

Эх сурвалж: Олон улсын худалдааны төв

Саудын Араб улсад хурганы махны импортын үнэ бусад төрлөөс махнаас үнэтэй бөгөөд цаашид ч өсөх төлөвтэй байна. 2018 онд хурганы махны импорт 4.5 мянган тонноор буурсан нь хонины ястай болон ясгүй хөлдүү махны импортын эзлэх хувийг 45%-иас 78% хүртэл өсөхөд нөлөөлжээ.

Хүснэгт 15. 2018 онд Саудын Араб улсад хонь, ямааны мах экспортлогчид болон импортын үнэ, тариф


Экспортлогчид	Импорт дүн, мянган \$	Хувь	Импорт хэмжээ, тн	Нэгж үнэ, \$/тн	Дундаж тариф, %
Австрали	85,432.00	54.7%	18,326.00	4,662.00	2.7
Шинэ Зеланд	47,326.00	30.3%	8,654.00	5,469.00	2.7
Энэтхэг	13,655.00	8.7%	2,084.00	6,552.00	2.7
Пакистан	7,010.00	4.5%	1,052.00	6,663.00	2.7
Испани	2,805.00	1.8%	647.00	4,335.00	2.7
Франц	13.00	0.0%	2.00	6,500.00	2.7
Нийт	156,241.00	100.0%	30,765.00	5,079.00	

Эх сурвалж: Олон улсын худалдааны төв

Саудын Араб улс 2018 онд 30.7 мянган тонн бүхий 156.2 сая ам долларын хонь, ямааны махыг 6 улсаас импортолжээ. Импортын зах зээлийн 54.7%-ийг Австрали, 30.3%-ийг Шинэ Зеланд эзэлж байна. 2018 оны хонь, ямааны махны импортын зах зээлийн дундаж үнэ 5 \$/кг, Энэтхэг, Пакистан, Францаас орж ирсэн махны үнийн дундаж 6.5 \$/кг буюу хамгийн өндөр үнэтэй байна. Хонь, ямааны махны импортын дундаж тариф 2.7%-иар тооцогдсон байна. Саудын Араб нь дэлхийн хонь, ямааны махны импортын зах зээлийн 2%-ийг эзэлдэг ба импортын зах зээлийн 14-р байранд жагсаж байна.

5.2.2. Кувейт улсын хонь, ямааны махны импортын зах зээл

График 7. Кувейт улсын импортын хонь, ямааны махны эзлэх хувь



Эх сурвалж: Олон улсын худалдааны төв

Кувейт улс 2018 онд 56.8 мянган тонн хонь, ямааны мах хэрэглэсэн бөгөөд 28.3%-ийг импортолжээ. Сүүлийн 5 жилийн хонь, ямааны махны хэрэглээний жилийн дундаж өсөлт нь 9.6% байсан, импортын жилийн дундаж өсөлт нь 8.9% байна. Мөн 2014 оноос хойш хэрэглээ 17.40 мянган тонноор нэмэгдэж 44%-иар өссөн байна.

Хүснэгт 16. Кувейт улсын хонь, ямааны махны импортын хэмжээ

Хонь, ямааны махны төрөл	2014	2015	2016	2017	2018	2018 оны хувь
	тонн	тонн	тонн	тонн	тонн	
Хурганы шинэ, хөргөсөн гулууз болон өрөөл мах	1,400.00	1,441.00	1,711.00	3,168.00	5,651.00	35.2%
Хонины хөлдүү мах, ястай	3,023.00	3,750.00	3,285.00	4,447.00	4,156.00	25.9%
Хонины шинэ, хөргөсөн гулууз болон өрөөл мах	2,433.00	1,900.00	2,171.00	2,724.00	2,364.00	14.7%
Хонины хөлдүү мах, ясгүй	2,175.00	3,553.00	1,231.00	1,877.00	1,526.00	9.5%
Хонины шинэ, хөргөсөн ястай нь хэсэглэсэн бусад мах	816.00	977.00	589.00	449.00	1,150.00	7.2%
Хонины хөлдүү гулууз болон өрөөл мах	591.00	529.00	623.00	436.00	698.00	4.3%
Хурганы хөлдүү гулууз болон өрөөл мах	475.00	417.00	462.00	453.00	406.00	2.5%
Ямааны мах	452.00	888.00	43.00	102.00	54.00	0.3%
Хонины шинэ эсвэл хөргөсөн ясгүй мах	48.00	36.00	74.00	54.00	44.00	0.3%
Нийт	11,413.00	13,491.00	10,189.00	13,710.00	16,049.00	100.0%

Эх сурвалж: Олон улсын худалдааны төв

Кувейт улс 2018 онд хонь, ямааны 9 төрлийн махыг импортолсон дотор хурганы мах 37.7%-ийг эзэлж өмнөх оноос 78.4%-иар өссөн байна. Сүүлийн дөрвөн жилд хонь, ямааны махны импорт жилд дунджаар 8.9%-иар өсч 2018 онд 16 мянган тонн мах импортолсон байна. Үүний дотор хурганы махны импорт дунджаар 41.7%-иар өсч 5.6 мянган тонн хүрчээ. Ямааны махны импортын хэмжээ бага байна.

Хүснэгт 17. Кувейт улсын хонь, хурга болон ямааны махны импортын дундаж үнэ, \$/кг

Махны төрөл	2014	2015	2016	2017	2018
Хонины мах	5.64	4.92	5.01	5.76	5.18
Хурганы мах	7.45	7.11	6.55	7.85	6.62
Ямааны мах	8.50	6.17	3.79	4.48	4.98

Эх сурвалж: Олон улсын худалдааны төв

Олон Улсын Худалдааны Төвийн статистик мэдээгээр Кувейт улсын 2018 оны импортын хурганы махны дундаж үнэ 6.62 \$/кг байгаа нь бусад махнаас үнэтэй байна.

Хүснэгт 18. 2018 онд Кувейт улсад хонь, ямааны мах экспортлогчид болон импортын үнэ, тариф

Экспортлогчид	Импорт дүн, мянган \$	Хувь	Импорт хэмжээ, тн	Нэгж үнэ, \$/тн	Дундаж тариф, %
Австрали	64,764.00	70.5%	11,255.00	5,754.00	2.70
Энэтхэг	11,411.00	12.4%	1,841.00	6,198.00	2.70


Шинэ Зеланд	6,848.00	7.5%	1,040.00	6,585.00	2.70
Испани	2,737.00	3.0%	757.00	3,616.00	2.70
Пакистан	1,156.00	1.3%	179.00	6,458.00	2.70
Гүрж	1,075.00	1.2%	149.00	7,215.00	2.70
Уругвай	973.00	1.1%	246.00	3,955.00	2.70
Румын	830.00	0.9%	256.00	3,242.00	2.70
Молдова	512.00	0.6%	122.00	4,197.00	2.70
Турк	373.00	0.4%	15.00	24,867.00	2.70
Хятад	289.00	0.3%	35.00	8,257.00	2.70
Итали	272.00	0.3%	75.00	3,627.00	2.70
Их Британи	241.00	0.3%	24.00	10,042.00	2.70
Ливан	109.00	0.1%	8.00	13,625.00	-
Казакстан	102.00	0.1%	16.00	6,375.00	2.70
Египет	40.00	0.0%	9.00	4,444.00	-
АНУ	36.00	0.0%	4.00	9,000.00	2.70
Украин	34.00	0.0%	9.00	3,778.00	2.70
Армен	28.00	0.0%	4.00	7,000.00	2.70
Танзани	5.00	0.0%	3.00	1,667.00	2.70
Нийт	91,835.00	100.0%	16,047.00	5,723.00	

Эх сурвалж: Олон улсын худалдааны төв

Кувейт улсын хонь, ямааны махны импортын 70%-ийг Австрали улс хангадаг. 2018 оны хонь, ямааны махны импортын дундаж үнэ 5.7 \$/кг байсан бөгөөд Австрали улс дундаж үнийн түвшинд нийлүүлсэн нь Кувейтийн импортыг давамгайлахад нөлөөлсөн байна. Мөн Казакстан улс 16 тонн махыг 6.3 \$/кг-аар нийлүүлжээ 2018 оны хонь болон ямааны махны импортын дундаж тариф нь 2.7% байжээ. Кувейт нь дэлхийн хонь, ямааны махны импортын зах зээлийн 1.2%-ийг эзэлдэг ба импортын зах зээлийн 20-р байранд жагсаж байна.

5.2.3. Катар улсын хонь, ямааны махны импортын зах зээл

График 8. Катар улсын импортын хонь, ямааны махны эзлэх хувь



Эх сурвалж: Олон улсын худалдааны төв

Катар улсын 2018 оны хонь, ямааны махны хэрэглээ нь 34.86 мянган тонн, үүний 72.7%-ийг импортоор хангажээ. Катарын хонь, ямааны махны зах зээл сүүлийн 5 жилд 27%-иар өсч, жилийн дундаж өсөлт нь 5.1% хүрсэн бөгөөд жилд 25,3 мянган тонн хонь, ямааны мах импортолдог байна.

Хүснэгт 19. Катар улсын хонь, ямааны махны импортын хэмжээ

Хонь, ямааны махны төрөл	2014	2015	2016	2017	2018	2018 оны хувь
	тонн	тонн	тонн	тонн	тонн	
Хурганы шинэ эсвэл хөргөсөн гулууз болон ерөөл мах	9,655.00	13,544.00	14,664.00	12,982.00	18,107.00	71.4%
Хонины шинэ, хөргөсөн гулууз болон ерөөл мах	3,291.00	4,216.00	2,335.00	3,115.00	4,462.00	17.6%
Хонины хөлдүү мах, ястай	1,693.00	2,841.00	2,555.00	1,933.00	1,704.00	6.7%
Хонины хөлдүү мах, ясгүй	948.00	1,146.00	608.00	619.00	376.00	1.5%
Хонины шинэ, хөргөсөн ястай нь хэсэглэсэн бусад мах	222.00	311.00	553.00	453.00	299.00	1.2%
Хонины хөлдүү гулууз болон ерөөл мах	187.00	141.00	304.00	819.00	282.00	1.1%
Хонины шинэ эсвэл хөргөсөн ясгүй мах	283.00	533.00	93.00	109.00	54.00	0.2%
Хурганы хөлдүү гулууз болон ерөөл мах	381.00	29.00	82.00	218.00	50.00	0.2%
Ямааны мах	4,142.00	5,070.00	102.00	323.00	22.00	0.1%
Нийт	20,802.00	27,831.00	21,296.00	20,571.00	25,356.00	100.0%

Эх сурвалж: Олон улсын худалдааны төв

Катарт хонь, ямааны мах, ялангуяа хурганы махны хэрэглээ маш өндөр бөгөөд 2018 онд хурганы махны импорт нийт импортын 71.4%-ийг эзэлж өмнөх оноос 39.5%-иар өсчээ. Сүүлийн дөрвөн жилийн хонь, ямааны махны импорт 5.1%-иар өсч 2017 онынхоос 4.7 мянган тонн илүү байна. Үүний дотор хурганы махны импорт сүүлийн 4 жилд дунджаар 17.0%-иар өсч 18.1 мянган тонн хүрчээ. Ямааны махны импортын хэмжээ бага байна.

Хүснэгт 20. Катар улсын хонь, хурга ба ямааны махны импортын дундаж үнэ, \$/кг

Махны төрөл	2014	2015	2016	2017	2018
Хонины мах	5.20	5.03	4.71	5.17	5.22
Хурганы мах	7.41	6.04	4.92	5.80	6.07
Ямааны мах	3.49	3.14	5.83	4.86	8.86

Эх сурвалж: Олон улсын худалдааны төв

Катар улсын 2018 оны импортын ямааны махны үнэ 8.86 \$/кг буюу бусад махны үнээс илүү үнэтэй харагдаж байгаа боловч тухайн жилд импортолсон ямааны махны хэмжээ зөвхөн 22 тонн байна. Энэ нь 2018 онд импортолсон нийт хонь, хурга, ямааны махны хэмжээний 0.1% нь юм. Хурганы мах бусад улсынхтай адил үнэтэй бөгөөд импортолдог хэмжээ нь их байна.

Хүснэгт 21. 2018 онд Катар улсад хонь, ямааны мах экспортлогчид болон импортын үнэ, тариф

Экспортлогчид	Импорт дүн, мянган \$	Хувь	Импорт хэмжээ, тн	Нэгж үнэ, \$/тн	Дундаж тариф, %
Австрали	130,385.00	88.1%	22,187.00	5,877.00	2.7
Энэтхэг	11,432.00	7.7%	1,883.00	6,071.00	2.7
Испани	1,895.00	1.3%	531.00	3,569.00	2.7
Шинэ Зеланд	1,456.00	1.0%	188.00	7,745.00	2.7
Молдова	760.00	0.5%	251.00	3,028.00	2.7
Пакистан	705.00	0.5%	96.00	7,344.00	2.7
Болгар	600.00	0.4%	56.00	10,714.00	2.7
Румын	425.00	0.3%	131.00	3,244.00	2.7
Турк	113.00	0.1%	5.00	22,600.00	2.7
Хятад	61.00	0.0%	7.00	8,714.00	2.7
Ливан	51.00	0.0%	21.00	2,429.00	-
Нидерланд	31.00	0.0%	2.00	15,500.00	2.7
АНУ	8.00	0.0%	1.00	8,000.00	2.7
Нийт	147,922.00	100.0%	25,359.00	5,833.00	

Эх сурвалж: Олон улсын худалдааны төв

Катар улсын хонь, ямааны махны импортод Австрали давамгайлж, нийт импортын зах зээлийн 88.1%-ийг эзэлж байна. 2018 онд хонь, ямааны махны импортын зах зээлийн дундаж үнэ 5.7 \$/кг, импортын дундаж тариф нь 2.7% байна.

Катар улс хонь, ямааны махны импортын дэлхийн зах зээлийн 1.9%-ийг эзэлдэг ба импортын зах зээлийн 15-рт бичигдэж байна.

5.2.4. Малайз улсын хонь, ямааны махны импортын зах зээл

Хүснэгт 22. Малайз улсын хонь, ямааны махны импортын хэмжээ

Хонь, ямааны махны төрөл, хэмжээ	2014	2015	2016	2017	2018	2018 оны хувь
	тн	тн	тн	тн	тн	
Хонины хөлдүү мах, ястай	14,906.00	17,993.00	18,846.00	21,763.00	22,158.00	61.0%
Хонины хөлдүү гулууз болон өрөөл мах	7,410.00	8,156.00	6,990.00	8,617.00	6,436.00	17.7%
Хонины шинэ, хөргөсөн ястай нь хэсэглэсэн бусад мах	3,215.00	2,733.00	2,505.00	3,435.00	3,174.00	8.7%
Хонины хөлдүү мах, ясгүй	3,856.00	2,947.00	3,084.00	2,781.00	2,416.00	6.7%
Хурганы хөлдүү гулууз болон өрөөл мах	1,020.00	1,300.00	1,186.00	1,338.00	1,412.00	3.9%

Хонины шинэ эсвэл хөргөсөн ясгүй мах	295.00	624.00	464.00	112.00	281.00	0.8%
Ямааны мах	354.00	315.00	51.00	285.00	199.00	0.5%
Хурганы шинэ эсвэл хөргөсөн гулууз болон өрөөл мах	95.00	88.00	86.00	54.00	150.00	0.4%
Хонины шинэ, хөргөсөн гулууз болон өрөөл мах	70.00	1.00	204.00	243.00	75.00	0.2%
Нийт	31,221.00	34,157.00	33,416.00	38,628.00	36,301.00	100.0%

Эх сурвалж: Олон улсын худалдааны төв

Малайз улс жилд Саудын Арабтай ойролцоо хэмжээний хонь, ямааны махыг импортолдог, хонины ястай хөлдүү мах нийт махны 61%-ийг эзэлдэг. Хурганы махны импорт 4%, ямааны мах 0.5%-ийг эзэлж байна.

Хүснэгт 23. Малайз улсын хонь, хурга ба ямааны махны импортын дундаж үнэ, \$/кг

Махны төрөл	2014	2015	2016	2017	2018
Хонины мах	4.90	3.93	3.58	4.73	5.03
Хурганы мах	4.36	3.88	3.99	5.03	5.10
Ямааны мах	4.49	3.56	3.35	4.89	5.12

Эх сурвалж: Олон улсын худалдааны төв

Малайзад хурганы махны үнэ сүүлийн 5 жилийн дунджаар 4% өсч 5.10 \$/кг хүрсэн байна.

Хүснэгт 24. 2018 онд Малайз улсад хонь, ямааны мах экспортлогчид болон импортын үнэ, тариф

Экспортлогчид	Импорт дун, мянган \$	Хувь	Импорт хэмжээ, тн	Нэгж үнэ, \$/тн
Австрали	127,313.00	69.7%	25,800.00	4,935.00
Шинэ Зеланд	52,522.00	28.8%	9,759.00	5,382.00
Энэтхэг	739.00	0.4%	245.00	3,016.00
Хятад	620.00	0.3%	153.00	4,052.00
Вьетнам	428.00	0.2%	87.00	4,920.00
Итали	279.00	0.2%	26.00	10,731.00
Монгол	175.00	0.1%	87.00	2,011.00
Хонг Конг	136.00	0.1%	56.00	2,429.00
Канада	124.00	0.1%	33.00	3,758.00
Аргентина	112.00	0.1%	25.00	4,480.00
АНУ	88.00	0.0%	14.00	6,286.00
Уругвай	56.00	0.0%	16.00	3,500.00
Япон	14.00	0.0%	1.00	14,000.00
Нийт	182,606.00	100.0%	36,302.00	5,030.00

Эх сурвалж: Олон улсын худалдааны төв

Австрали улс Малайз улсын хонь, ямааны махны импортын 69.7%-ийг эзлэх бөгөөд махны дундаж үнэ нь 4.9 \$/кг байна.

5.2.5. Индонез улсын хонь, ямааны махны импортын зах зээл

Хүснэгт 25. Индонез улсын хонь, ямааны махны импортын хэмжээ

Хонь, ямааны махны төрөл	2014	2015	2016	2017	2018	2018 оны хувь
	Тонн	тонн	тонн	тонн	тонн	
Хонины хөлдүү мах, ясгүй	247.00	383.00	382.00	539.00	687.00	33.8%
Хонины шинэ, хөргөсөн ястай нь хэсэглэсэн бусад мах	403.00	729.00	558.00	836.00	653.00	32.1%
Хонины хөлдүү гулууз болон өрөөл мах	277.00	937.00	730.00	738.00	383.00	18.8%
Хурганы хөлдүү гулууз болон Өрөөл мах	105.00	484.00	389.00	397.00	289.00	14.2%
Хонины хөлдүү мах ястай	49.00	53.00	23.00	15.00	13.00	0.6%
Хонины шинэ эсвэл хөргөсөн ясгүй мах	11.00	26.00	14.00	11.00	10.00	0.5%
Хурганы шинэ эсвэл хөргөсөн гулууз болон өрөөл мах	20.00	-	-	-	-	0.0%
Хонины шинэ, хөргөсөн гулууз болон өрөөл мах	-	8.00	-	-	-	0.0%
Ямааны мах	818.00	113.00	-	4.00	-	0.0%
Нийт	1,930.00	2,733.00	2,096.00	2,540.00	2,035.00	100.0%

Эх сурвалж: Олон улсын худалдааны төв

Индонез улсын хонь, ямааны махны импортын хэмжээ 269 сая хүн амтай улсын хувьд маш бага байна.

Хүснэгт 26. Индонез улсын хонь, хурга болон ямааны махны импортын дундаж үнэ, \$/кг

Махны төрөл	2014	2015	2016	2017	2018
Хонины мах	6.44	5.43	5.44	6.00	6.89
Хурганы мах	1.00	1.00	1.00	1.00	1.00
Ямааны мах	1.00	1.00	-	1.00	-

Эх сурвалж: Олон улсын худалдааны төв

Индонез улсын импортын төрөлд хонины мах зонхилж байгаа ч харьцангуй бага хэмжээтэй харагдаж байна.

Хүснэгт 27. 2018 онд Индонез улсад хонь, ямааны мах экспортлогчид болон импортын үнэ, тариф

Экспортлогчид	Импорт дүн, мянган \$	Хувь	Импорт хэмжээ, тн	Нэгж үнэ, \$/тн	Дундаж тариф,%
Австрали	13,553.00	99.8%	2,033.00	6,670.00	4.80
АНУ	23.00	0.2%	2.00	11,500.00	5.00
	13,576.00	100.0%	2,035.00	6,675.00	

Эх сурвалж: Олон улсын худалдааны төв

Индонез улс 2018 онд зөвхөн Австрали улсаас дунджаар 6.6 \$/кг үнээр бага хэмжээний хонь, ямааны махыг импортолсон байна.

5.3. ЗОРИЛТОТ ОРНУУДЫН АМЬД МАЛЫН ИМПОРТЫН ЗАХ ЗЭЭЛ

Саудын Арабын Мекке хотод болох Ислам шашинтнуудын ариун Хаж мөргөл болон Рамадан буюу мацаг барих сарын үед хүнсний хэрэглээ ялангуяа махны хэрэглээ үлэмж нэмэгддэг. Амьд хонь, ямааны импорт Хаж мөргөлийн үед бусад сарын дунджаас 3 дахин, Рамадан сарын үед 20%-иас дээш нэмэгддэг байна. Хаж болон Рамадан саруудад импортолсон амьд хонь, ямааны тоо толгой нь тухайн жилийн нийт импортын 40-өөс дээш хувийг эзэлдэг.

Хүснэгт 28. Зорилтот зах зээлийн импортолсон хонь, ямааны тоо толгой

Малын төрөл	Улс	Хүн амын тоо	Амьд малын тоо толгой	Импортолсон тоо толгой
Хонь	Саудын Араб	33,413,660.00	9,328,455.33	5,907,566.67
	Кувейт	4,640,415.00	768,200.86	825,450.00
	Катар	2,743,932.00	861,309.52	653,925.00
Ямаа	Саудын Араб	33,413,660.00	3,670,439.68	648,680.00
	Кувейт	4,640,415.00	180,191.88	18,300.00
	Катар	2,743,932.00	380,575.25	48,520.00
Нийт	Саудын Араб	33,413,660.00	12,998,895.00	6,556,246.67
	Кувейт	4,640,415.00	948,392.73	843,750.00
	Катар	2,743,932.00	1,241,884.78	702,445.00

Эх сурвалж: Олон улсын худалдааны төв

Саудын Арабын хувьд нийт амьд малын импортын 90 орчим хувь нь хонь, ямаа байна. Энэ нь Хаж мөргөлийн улиралд голдуу хонь, ямаагаар тахил өргөдөгтэй холбоотой. Ойрх Дорнод болон Хойд Африкийн орнуудын амьд хонины импортын зах зээл нь шашны баяр тэмдэглэх хугацаанаас хамааран улирлын чанартай байдаг.


Австрали улс жилд 2 сая толгой хонь экспортолдог ба амьд хонины гол зах зээл нь Ойрх Дорнод, Хойд Африкийн орнууд юм. Үүний дотор Кувейт болон Катар улсын хонины зах зээлийн 70 орчим хувийг хангадаг. 2018 онд Австрали нэг хонийг Кувейт улсад 93, Катар улсад 94 ам.доллараар экспортолсон байна.

Австрали улсын гол өрсөлдөгчид Сомали болон Судан улс Саудын Араб улсын амьд хонины зах зээлийн 90%-ийг хангадаг.

5.4. МАЛЫН ДАЙВАР БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТЫН ЗАХ ЗЭЭЛ

Малын дайвар бүтээгдэхүүний импорт Саудын Араб, Кувейт, Катар улсуудад нийт мах, махан бүтээгдэхүүний импортын 1-2%-ийг, Малайз улсад 4%, Индонез улсын хувьд 22%-ийг эзэлдэг байна.

График 9. Зорилтот зах зээлийн малын дайвар бүтээгдэхүүний импорт, 2018




Эх сурвалж: Олон улсын худалдааны төв


Индонез улс 2018 онд 106.9 сая ам.долларын үнэ бүхий 46.8 мянган тонн малын дайвар бүтээгдэхүүн импортлосон нь хонь, ямааны махны импортоос 23 дахин их юм. Энэ нь үхрийн хөлдүү махны импортын дараах хэмжээ болно. Тус улс гол төлөв үхрийн дайвар бүтээгдэхүүн болох хэл, элэг зэрэг бүтээгдэхүүнийг импортлодог байна.

График 10. Хонь, ямааны дайвар бүт, 2018

График 11. Австрали улсын экспорт, 2018



Эх сурвалж: Олон улсын худалдааны төв



Саудын Араб 2018 онд нийт 9.7 мянган тонн хонь, ямааны дайвар бүтээгдэхүүн импортлосон бөгөөд энэ нь нийт зах зээлийн 75%-ийг эзэлж байна.

Кувейт улс жилд 500 гаран тонн, Катар улс 200 гаран тонн хонь, ямааны дайвар бүтээгдэхүүн импортлодог. Кувейт улсын импортын дайвар бүтээгдэхүүний 42%, Катар улсын хувьд 21% нь үхрийн хөлдүү дайвар бүтээгдэхүүн байна.


Малайз улс сүүлийн 3 жилд дунджаар 300 гаран тонн хонь, ямааны дайвар бүтээгдэхүүн импортложээ. Үхрийн хөлдүү дайвар бүтээгдэхүүн Малайз улсын дайвар бүтээгдэхүүний импортын 76%-ийг эзэлсэн байна.

Саудын Араб, Кувейт, Катар улсуудын малын дайвар бүтээгдэхүүний импортын зах зээлийн 50-иас дээш хувийг Австрали улс дангаараа хангадаг.

5.5. НӨӨШИЛСӨН МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТЫН ЗАХ ЗЭЭЛ

Зорилтот зах зээлийн орнуудад малын гаралтай нөөшилсөн махан бүтээгдэхүүний импортын хэмжээ 2018 онд 33.88 мянган тонн бүхий 151.2 сая ам.доллар, үүний дотор Саудын Араб улсынх 60.6 сая ам.доллар байна.


График 12. Зорилтот зах зээлийн нөөшилсөн махан бүтээгдэхүүний импорт, 2018



Эх сурвалж: Олон улсын худалдааны төв

Нөөшилсөн махан бүтээгдэхүүний импорт Саудын Араб улсын 2018 оны хонь, ямааны махны импортын 40 гаран, Кувейтийн хувьд 30 гаран, Катар, Малайз улсад 20 гаруй хувийг эзэлж байна. Харин Индонез улсад нөөшилсөн махан бүтээгдэхүүний импорт хонь, ямааны махны импортоос 2 дахин их байна. Дээрх улсууд голдуу загасны нөөшилсөн бүтээгдэхүүнийг импортолдог бөгөөд энэ нь импортын нийт нөөшилсөн бүтээгдэхүүний зах зээлийн 50-аас дээш хувийг эзэлж байна.

График 13. Нөөшилсөн бүтээгдэхүүн экспортлогчид, 2018



Эх сурвалж: Олон улсын худалдааны төв

ПБХАЗ-ийн орнуудад нөөшилсөн бүтээгдэхүүний импортын зах зээлийн 50-иас дээш хувийг Арабын Нэгдсэн Эмират дангаараа хангадаг.




5.6. ЗОРИЛТОТ ОРНУУДЫН МАХНЫ ҮНИЙН СУДАЛГАА

Чанартай махны эрэлт хэрэгцээ олон улсын зах зээл дээр нэмэгдэж байгаа нь махны үнэ аажмаар өсөхөд нөлөөлж байна. Иймээс импортлогчид өрсөлдөхүйц үнийг санал болгож чадах мах нийлүүлэгчдийг хайж байна. Олон улсын зах зээл дээр махны үнэ өндөр байгаа нь (Монгол улсын 2018 оны хонины махны экспортын дундаж үнэ 2,54 \$/кг) Монгол улсыг өрсөлдөхүйц чанартай мах, мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэн нийлүүлэгчдийн эгнээнд орох боломж байгааг харуулж байна.

5.6.1. Зорилтот орнуудын хонины махны үнэ

График 14. Зорилтот орнуудын хонины махны дундаж үнэ, \$/кг



Эх сурвалж: АНУ, Хөдөө аж ахуйн газар; Блүмберг; Дэлхийн банк

Хонины махны үнэ ПБХАЗ-ийн орнуудад 2014-2016 оны хооронд дунджаар 14%-иар буурсан нь 2014-2016 онд газрын тосны үнэ буурч, тус бүсийн засгийн газар болон хэрэглэгчдийн орлогод нөлөөлсөнтэй холбоотой юм. Харин сүүлийн 2 жилийн дунджаар 11%-иар өсч 2018 онд дундаж үнэ 5.87 ам.доллар хүрчээ.

Саудын Арабын хувьд шувууны махыг маш их хэрэглэдэг ч тансаг хэрэглээний зэрэглэлд хүрээд байгаа хонь, ямаа, үхрийн махны хэрэглээ буураагүй ба үнийн өсөлт нь худалдан


авалтын түвшинд сөргөөр нөлөөлөхгүй байна. Сүүлийн жилүүдэд Саудын Арабын засгийн газраас хүнсний салбарын үндэсний үйлдвэрлэгчдээ дэмжсэн бодлого гарган хөнгөлөлттэй зээл олгож байгааг (Тахиа, шувууны аж ахуй, үйлдвэрүүд ихээр олшроод байгаа) мөн дурдах нь зүйтэй.

Катар улсын хүн амын өсөлт, эдийн засгийн өсөлтийн хурдац, хүн амын худалдан авах чадвар өсч байгаа, 2020 онд зохион байгуулагдах хөл бөмбөгийн дэлхийн аваргын тэмцээнтэй холбогдолтой арга хэмжээ, зорчигчдын урсгалтай холбогдон 3 жилд тус улсын хэрэглээ өсөх хандлагатай байна.

Кувейт улс дэлхийд мах, махан бүтээгдэхүүний хэрэглээ, импортын хэмжээгээрээ дээгүүр ордог улс. Дотоодын мал аж ахуй хөгжөөгүй, үйлдвэрлэлийн өртөг өндөр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл хөгжих нөөц нь хязгаарлагдмал байдал нь дотоодын махны үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлдөг байна.

5.6.2. Зорилтот орнуудын ямааны махны үнэ

График 15. Зорилтот орнуудын ямааны махны дундаж үнэ, \$/кг



Эх сурвалж: АНУ, Хөдөө аж ахуйн газар; Блүмберг; Дэлхийн банк

Австрали улсад сүүлийн жилүүдэд дараалан гантай байсан нь ямааны махны экспортод хүчтэй нөлөөлж экспортын үнийг дунджаар 8% өсгөсөн байна. Кувейт, Малайз болон Индонез улсуудад ямааны махны импортын хэмжээ маш бага, жилд дунджаар 300 орчим тонн ямааны мах импортолдог. Харин Саудын Араб улс жилд дунджаар 5-6 мянган тонн ямааны мах импортолдог бөгөөд энэ нь нийт бог малын махны импортын 9-10%-ийг эзэлдэг байна. Катар дунджаар 5 мянган тонн ямааны мах импортолдог ба нийт богийн махны импортын 18-19%-ийг эзэлдэг байна.

5.6.3. Хонины махны жижиглэнгийн дундаж үнэ

Саудын Араб улсын “Lulu” хайпер маркетийн хонины дундаж үнэ дараах байдалтай байна:

Хүснэгт 29. Саудын Араб улсын Lulu хайпер маркетийн махны дундаж үнэ

Австрали хонины мах	Шинэ Зеланд хонины мах	Пакистан хонины мах	Энэтхэг хонины мах
			
20.89 \$/кг	17.89 \$/кг	16.69 \$/кг	15.09 \$/кг


5.7. ЭЦСИЙН ХЭРЭГЛЭГЧДИЙН СУДАЛГАА

Ойрх Дорнодын орнуудын хэрэглэгчид хонины махыг түлхүү хэрэглэдэг ба хурганы махыг мөн тодорхой хэмжээгээр хэрэглэдэг онцлогтой. Ойрх Дорнодын хэрэглэгч, худалдан авагч, жижиглэн худалдаа эрхлэгчид халал аргаар боловсруулсан хурга, төлөгний (1-2 насны бага насны малын) мах авах сонирхолтой байна.

5.7.1. Нэг хүнд ногдох жилийн махны хэрэглээ кг

Кувейт улс нэг хүнд ногдох жилийн хонь болон ямааны махны хэрэглээгээр бүс нутагтаа тэргүүлж байна.


Зураг 1. Персийн булангийн орнуудын нэг хүнд ногдох жилийн махны хэрэглээ, кг



Ойрх Дорнодын улсууд дотор Саудын Араб нь хамгийн их жуулчид хүлээн авдаг орон. Ялангуяа Хаж мөргөл үйлдэхээр тус улсад жилд 3 сая орчим хүн зочилдог.

5.7.2. Зорилтот зах зээлийн махны борлуулалтын суваг

График 16. Персийн булангийн орнуудын хонины махны борлуулалтын суваг



Эх сурвалж: Олон улсын хэрэглэгчдийн судалгааны төв

Саудын Араб улсын эцсийн хэрэглэгчид махыг зориулалтын газраас авахыг илүүд үздэг байна. Ойрх Дорнодын орнуудад мах болон махан бүтээгдэхүүнүүд голдуу хайпермаркет, супермаркет-үүд, махны төрөлжсөн дэлгүүрүүд, ресторан, зоогийн газруудаар дамжиж эцсийн хэрэглэгчдэд хүрч байна. Түүн дотор дотоодын сүлжээний ханган нийлүүлэлтийн “Carrefour”, “Lulu” болон “Panda and Danube” зэрэг олон улсын худалдааны хүнсний сүлжээнүүд голлох байр суурь эзэлж байна.

Хүснэгт 30. Хонины махыг худалдаж авахад нөлөөлөх хүчин зүйлс

Саудын Араб Улс	Бусад ПБХАЗ орнууд
Худалдааны төвийн сурталчилгаа	Зурагтын хоолны нэвтрүүлэг
Найз нөхөд, танил	Алдартай тогоочийн зөвшөөрөл
Зурагтын зар сурталчилгаа	Радио хоол хийх нэвтрүүлэг
Сонин, сэтгүүл	Найз нөхөд, танил
Радио хоол хийх нэвтрүүлэг	Зурагтын зар сурталчилгаа


Эх сурвалж: Олон улсын хэрэглэгчдийн судалгааны төв

Сүүлийн жилүүдэд бүс нутгийн иргэдийн худалдан авах чадвар нэмэгдэж, зорчигчдын тоо нэмэгдэж байгаатай холбоотой ресторан, амралтын газруудын тоо олширч байна. Энэ нь зах зээлийн зарчмаар хоол хүнсний зах зээлийг тэлж буй хүчин зүйлсийн нэг юм.

Персийн булангийн орнуудын нэг хүнд оногдох ДНБ-ний дундаж хэмжээ нь 63.6 мянган ам доллар, Саудын Араб улсад 56.8, Кувейт улсад 74.2, Катар улсад 136.3 мянган ам доллар буюу дэлхийд хамгийн өндөрт тооцогдож байна. Сүүлийн 5 жилд бүс нутгийн хүн амын тоо

12%, нэг хүнд ногдох дундаж орлого нь 7% тус тус өссөн байна.


График 17. Персийн булангийн орнуудын хүн амын тоо, худалдан авах чадвар



Эх сурвалж: Исламын Хөгжлийн Банк (PPP- Хүн амын худалдан авах чадвар)

5.8. ЗОРИЛТОТ ОРНУУДЫН ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ, ХУДАЛДААНЫ ЗОХИЦУУЛАЛТ

Зорилтот орнуудын эдийн засаг, улс төрийн тогтолцоо, визны нөхцөл, манай улстай хийсэн засгийн газар хоорондын болон мал эмнэлгийн гэрээ хэлэлцээрүүд, нийгэм соёл, хэл, шашин шүтлэг, шинжлэх ухаан-технологийн түвшин, хууль эрх зүй, экологи, байгаль орчны тухай цогц ойлголт авах үүднээс (PESTLE) шинжилгээ хийсэн ба улс тус бүрээр танилцуулсан болно.



5.8.1. Саудын Арабын Хаант улс

Улс төр, төрийн тогтолцоо -P-(Political)

- Саудын Араб улс нь тусгаар тогтносон Арабын исламын хаант улс.
- Нийслэл – Эр Рияд.
- Хүн ам – 33,87 сая.
- Газар нутаг - 2149,7 км2.
- Монгол улстай 2007 онд Дипломат харилцаа тогтоосон⁹.
- Найрсаг харилцаа, хамтын ажиллагаатай.
- Дипломат харилцааг Кувейт улсад суугаа Монгол улсын Элчин сайдын яам, БНХАУ-д суугаа Саудын Арабын хаант улсын Элчин сайдын яамдуудаар хавсран хэрэгжүүлж байгаа.
- 2010, 2014, 2016 онуудад харилцан айлчлалууд хийгдсэн.
- Харилцан визийн нөхцөлтэй.
- Засгийн газрын түвшинд байгуулсан гэрээ хэлэлцээр байхгүй.
- Төрийн эрх мэдлийн хэлбэр нь Хаант улс бөгөөд хааны эрх мэдэл хөвгүүдэд нь үе залгамжлан өвлөгдөж явдаг. Хаан өөрийн зарлигаар Хунтайжийг сонгож бас өөрчилнө.
- Хаант улсын төрийн байгуулалт нь, хууль тогтоох засаглал, гүйцэтгэх засаглал, шүүх засаглалаас бүрдэх ба эдгээрийн дээд удирдлага нь Хаан байна.
- Гүйцэтгэх эрх мэдэл нь Сайд нарын зөвлөл байх ба Ерөнхий сайд, Шадар сайд болон хорин сайдаас бүрдэнэ. Сайд нар нь Хааны ойр дотны садан төрлүүдээс бүрдэх ба Хаан томилно.
- Хууль тогтоох байгууллага нь парламенттай ойролцоо тогтолцоотой Зөвлөлдөх хуралдаан (Маджлис аш-Шура) ба нийт 150 эрэгтэй гишүүнийг Хаан 4 жилийн хугацаатай томилно.
- Улс төрийн хувьд Хааны удам залгах уламжлалтай тул харьцангуй тогтвортой.
- 2019 оны 04 сарын 29-нд Саудын Арабын Жидда хотод Монгол Улсын Өргөмжит консулаар Хишам бин Абдулрахман бин Салех Аль-Амуди томилогдон ажиллаж байна.
- Нэгдсэн Үндэстэний Байгууллага, Дэлхийн Худалдааны Байгууллагын гишүүн орон.

⁹ <http://www.mfa.gov.mn>

Эдийн засаг - E-(Economic)

- Саудын Арабын эдийн засаг түүхий эд түүний дотор газрын тосноос хамааралтай ба нийт орлогын 90%-ийг газрын тосны худалдаанаас бүрдүүлдэг. Саудын Араб нь дэлхийн газрын тосны 25 хувь орчмын нөөцтэй ба газрын тос экспортлогчдыг тэргүүлж тус салбарын гол тоглогчдын нэг.
- Дотоодын нийт бүтээгдэхүүн 22,5 мянган ам. доллар¹⁰.
- Инфляцийн түвшин 2,6%¹¹.
- ДНБ-ний бодит өсөлт 1,8%.
- Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан мэдээгээр дундаж цалин 1868,24 ам.доллар.¹²
- Банк, санхүүгийн салбараа хөгжүүлж байгаа ба өөрийн онцлогийг агуулдаг.
- Монгол улстай худалдааны эргэлт – 2 587,5 мянган ам.доллар¹³ (2018 он). Манай улс Саудын Арабаас элсэн чихэр голдуу импортолж, хивс, бусад төрлийн амьд амьтан экспортолсон ба гадаад худалдааны тэнцэл өссөн үзүүлэлттэй.
- Мөн төмрийн хүдэр, алт, зэс, фосфат болон ураны тодорхой нөөцтэй.
- Химийн үйлдвэрлэл үлэмж хөгжсөн ба бордоо, пластик, техникийн хий зэргийг үйлдвэрлэдэг.
- Усны нөөц хязгаарлагдмал тул хөдөө аж ахуй, газар тариалан сул хөгжсөн боловч сүүлийн жилүүдэд хөдөө аж ахуйн салбартаа хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж байна. Мал аж ахуй эрхэлдэг, тодорхой тооны малтай. Тэмээ ихтэй орон.
- Аялал жуулчлалын салбарт ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийж байна.

Нийгэм соёл - S-(Social)

- Саудын Арабын нийгэм, соёлын онцлог нь Ислам шашинтай шууд бөгөөд салшгүй холбоотой. Нийгмийн харилцааны хэм хэмжээ бүхэлдээ шашны ёс, дэг жаягт нийцэж тогтсон байдаг. Саудын Араб улс нь Ислам шашны өлгий нутаг гэж тооцогддоогоороо шашны ёс жаяг, нийгмийн харилцааны хэм хэмжээний тулгуурыг бүрдүүлж байдаг. Шашны хэм хэмжээг зөрчигдөхөөс сэргийлэх шашны цагдаагийн албатай.
- Албан ёсны хэл –Араб хэл.
- Нийт иргэдийн 95% нь Ислам шашинтай бөгөөд гол төлөв суннитийн чиглэлийг баримталдаг. Үлдсэн 5%-ийг христийн болон бусад шашны төлөөлөл эзэлдэг.
- Саудын Арабын арабууд нүүдэлчин соёл иргэншилтэйд тооцогддог боловч сүүлийн жилүүдэд хөгжлийн өндөр түвшинд хүрч орчин үеийн хотжилтын түвшингээрээ богино хугацаанд том амжилтанд хүрсэн.
- Арабууд хонь, хурга, шувууны махыг цагаан будаа, үзэмтэй хамт төрөл бүрийн хоол бэлддэг. Мөн шөлтэй хоол болон шарсан махтай хоол их дэлгэрсэн байдаг. Хоолонд жимс, жимсгэнэ, самар, ногоо их хэрэглэдэг. Кофе уух соёл нилээн дэлгэрсэн ба тэмээ, хонь, ямааны сүү гол төлөв хэрэглэдэг.
- Эрүүл мэндийн салбар сайн хөгжсөн ба 100% үнэгүй үйлчилгээ үзүүлдэг.
- Боловсролын салбар мөн адил төрөөс санхүүждэг ба иргэдийн 95% нь боловсрол эзэмшсэн байдаг.
- Тус улсад согтууруулах, мансууруулах төрлийн ундаа, бүтээгдэхүүн хэрэглэхийг хориглосон байдаг.

¹⁰ www.imf.org

¹¹ www.imf.org

¹² http://fincan.ru/articles/35_srednyaja-zarplata-po-stranam-mira-2018/

¹³ Үндэсний статистикийн хороо - <http://1212.mn>

- Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь тодорхой цензуртэйгээр үйл ажиллагаа явуулдаг.

Технологи -Т-(Technology)

- Саудын Араб улс технологийн хөгжилдөө хөрөнгө зарж тоон системийг гүйцэд нэвтрүүлэхээр сүүлийн жилүүдэд багагүй чармайж, нэн тэргүүнд газрын тосны салбарт дэвшилтэт өндөр технологийг нэвтрүүлэхээр ажиллаж байна.
- Мэдээлэл харилцааны олон улсын холбооны – мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн түвшингийн индексээр¹⁴ - 6,67 оноотой.
- ПБХАЗ-ийн интеграцын түвшинд гишүүн орнууд ИТ технологийг өргөнөөр ашиглах зайлшгүй шаардлагын дагуу хөрөнгө оруулж байна. Булангийн орнуудын мэдээллийн баазууд Европын дата баазуудыг түшиглэсэн байдаг ба бүс нутгийнхан Ойрх Дорнодын өөрийн мэдээллийн дата баазыг хоёр газар байгуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.
- Ердийн амьдралын хэрэгцээнд мөн төрийн байгууллагууд нь сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашиглаж байна.
- Төрийн үйлчилгээг цахимжуулах ажлууд хийгдэж байгаа ба гааль, хяналтын байгууллагуудын зарим үйлчилгээг нэвтрүүлсэн байдаг.

Хууль эрх зүй - L-(Legal)

- Арабын исламын хаант улс бөгөөд Үндсэн хууль нь КУРАН судар болон Гэгээн элчийн сунна буюу Ислам шашны хэм хэмжээгээр зохицуулагдана. 1992 онд Саудын Арабын Хаант улсын Үндсэн Низам (Куран судар болон Гэгээн элчийн суннагийн дараа орох эрх зүйн баримт бичиг) гэж нэрлэгдэх баримт бичиг гаргаж түүнд хууль эрх зүй болон төрийн тогтолцооны тухай тусгасан байдаг.
- Шариат бол Ислам шашны ёс суртахуунд нийцсэн шашны хэм хэмжээ, залбирал, мөргөл бүхий зан үйл, мөн түүнтэй холбоотой горим журмын нийлмэл цогцыг хэлнэ. Шариатын дагуу Саудын Арабын Хаант улсын төр барих үндсэн зарчим нь шударга ёс, хэлэлцэх зарчим, тэгш байдал гэж үздэг. Хаант улсын төрийн байгуулалт нь, хууль тогтоох засаглал, гүйцэтгэх засаглал, шүүх засаглалаас бүрдэх ба эдгээрийн дээд удирдлага нь Хаан байна.
- Нийтлэг эрх зүйн зарчим нь хууль тогтоох үйл ажиллагааны үндсэн тулгуур нь шариат. Хаан болон Сайд нарын зөвлөл шариатын хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна. Төрийн аливаа баримт бичиг Хааны зарлигаар хүчин төгөлдөр болно. Хууль гэдэг нэр томъёоллыг хэрэглэдэггүй, зарчмын хувьд эрх зүйн заавал биелэгдэх хуулийн хэм хэмжээг зөвхөн Агуу бүтээгч Аллахаас тогтоодог ойлголтыг зөрчихгүйн тулд Низам буюу эрх зүйн баримт бичиг гэдэг нэршлээр хэрэглэгддэг.
- Саудын Арабын эрх зүйн тогтолцоонд Шариатын хуулийн хүрээнд гаргасан иргэний, худалдааны, эрүүгийн гэх мэт салбарын болон нийгмийн харилцааг зохицуулсан низамууд үйлчилдэг.
- 1981 оноос Персийн булангийн Арабын орнуудын хамтын ажиллагааны Зөвлөлийн үүсгэн байгуулагч гишүүн, 2003 оноос ПБХАЗ-ийн Гаалийн холбооны гишүүн.
- Эрх зүйн зохицуулалтуудаа тус байгууллагын 2002 онд баталсан Гаалийн тухай хууль болон бусад эрх зүйн актуудад нийцүүлэн хэрэгжүүлдэг.

¹⁴ International Telecommunication Union: ОУХТ Хөгжлийн индекс 2017.

Байгаль орчин, экологи - E-(Ecology)

- Саудын Арабын хаант улс нь газар нутгийн хувьд бүс нутгийн 80 орчим хувийг эзэлдэг ба гол төлөв элсэн цөл, цөлөрхөг нутагтай
- Цаг агаар нь хуурай, өвлийн улиралд 8-21 хэм дулаан, зуны улиралд 26-54 хэм халуун байна
- Усны нөөцийн хомсдолтой. Байнгын урсацтай гол, мөрөн байхгүй. Усны нөөцөө далайн усыг шүүж, гүний худаг, артезианы худгуудаас авдаг
- Ой мод газар нутгийн 1%, тариалалтын талбай 2%, 50% орчим нь мал аж ахуй эрхлэхэд тохиромжтой байна
- Ургамалын төрөл зүйл цөөн, элсэрхэг газрын ургамлуудтай
- Ан амьтны төрөл зүйл олон



5.8.2. Катарын Хаант улс

Улс төр, төрийн тогтолоцоо - P-(Political)

- Тусгаар тогтносон, хэмжээгүй эрхт хаант засаглалтай орон.
- Нийслэл – Доха хот.
- Хүн ам – 2,75 сая.
- Газар нутаг - 11,437 км2.
- Монгол улстай 1998 онд Дипломат харилцаа тогтоосон¹⁵, найрсаг харилцаа, хамтын ажиллагаатай.
- Дипломат харилцааг Кувейт улсад суугаа Монгол улсын Элчин сайдын яам, БНХАУ-д суугаа Катарын хаант улсын Элчин сайдын яамдаар хавсран хэрэгжүүлдэг.
- Харилцан визийн нөхцөлтэй.
- Эдийн засаг, худалдаа, техникийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Катар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр 2007 онд, Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Монгол Улсын Засгийн газар, Катар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр (2007 он).
- Монгол Улсын Засгийн газар, Катар Улсын Засгийн газар хооронд мал эмнэлэг, хорио цээрийн салбарт хамтран ажиллах тухай Харилцан ойлголцлын санамж бичиг (2007 он).
- Монгол Улсын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Катар Улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхим хоорондын санамж бичиг (2007 он).
- Төрийн эрх мэдэл нь Аль Тани Эмирийн удмынханы дунд өв залгамжлах хэлбэрээр явагддаг.
- Засаг захиргааны 10 нэгжтэй: Ад-Давва, Аль-Джувария, Аль-Джумалия, Аль-Хор, Аль-Вафра, Ар-Райян, Джарайян аль-Батна, Аш-Шамаль, Умм Саид, Умм Салаяль.
- Гүйцэтгэх засаглалыг Сайд нарын зөвлөл хэрэгжүүлдэг боловч түүний дээд удирдлага нь Эмир байна. Эмир төрийн эрх мэдлийг бүхэлд нь төвлөрүүлсэн бөгөөд шариатын хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулна. Мөн Эмирийн төр барих үйл

¹⁵ <http://www.mfa.gov.mn>

ажиллагаанд зөвлөх үүрэгтэй Зөвлөлдөх хуралдааныг тус орны шашны эрдэмтэд, зөвлөхүүд ажиллана.

- Зөвлөлдөх хуралдаан (Шура) нь эрх зүйн баримт бичиг гаргах эрхгүй, зөвхөн зөвлөх үүрэгтэй. Эрх зүйн баримт бичиг санаачлах эрхийг Сайд нарын зөвлөл хэрэгжүүлдэг ч зөвхөн Эмирийн шийдвэрээр хүчин төгөлдөр ба хүчингүй болдог.
- Хаант улсын төрийн байгуулалт нь, хууль тогтоох засаглал, гүйцэтгэх засаглал, шүүх засаглалаас бүрдэх ба эдгээрийн дээд удирдлага нь Хаан байна.
- Нэгдсэн Үндэстэний Байгууллага, Дэлхийн Худалдааны Байгууллагын гишүүн орон.

Эдийн засаг - E-(Economic)

- Катарын эдийн засаг түүхий эд түүний дотор газрын тосноос хамааралтай ба нийт орлогын 90%-ийг газрын тосны худалдаанаас бүрдүүлдэг, дэлхийн газрын тосны 25 хувь орчмын нөөцтэй ба газрын тос экспортлогчдыг тэргүүлж буй улсын нэг.
- Дотоодын нийт бүтээгдэхүүн 70,29 мянган ам. доллар¹⁶, ДНБ-ний бодит өсөлт 2,6%, Инфляцийн түвшин - 0,1%¹⁷.
- Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан мэдээгээр дундаж цалин 3372,63 ам.доллар¹⁸.
- 2018 оны байдлаар Монгол улсаас Катар гаргасан экспорт 419,6 мянган ам.доллар, импорт 6.2 мянган ам.доллар байна. Катар амьд амьтад гаргаж, аяны хөнжил, даавуу, бүтээлэг зэрэг гэр ахуйн бараа, бүтээгдэхүүн, цөөн тооны хөдөлгүүр, автомашины эд ангийг импортолсон.
- Химийн үйлдвэрлэл үлэмж хөгжсөн ба бордоо, цемент, төмөрлөгийн үйлдвэрүүдтэй.
- Банк, санхүүгийн салбараа хөгжүүлж байгаа ба өөрийн онцлогийг агуулдаг.
- Усны нөөц хязгаарлагдмал тул хөдөө аж ахуй, газар тариалан сул хөгжсөн байдаг.
- Цөөн тооны мал аж ахуй эрхэлж тэмээ, үхэр үржүүлдэг. Мөн сувд олборлох, загас агнуурын аж ахуй тодорхой хэмжээгээр хөгжсөн.
- Аялал жуулчлалын салбарт хөрөнгө оруулалт хийж байгаа.

Нийгэм соёл -S-(Social)

- Катар улсын нийгэм, соёлын онцлог нь Ислам шашинтай шууд холбоотой. Нийгмийн харилцааны хэм хэмжээнүүд бүхэлдээ шашны ёс, дэг жаягт нийцэж тогтсон байдаг.
- Албан ёсны хэл –Араб хэл боловч англи хэл түгээмэл хэрэглэгддэг хэлний тоонд орно.
- Нийт иргэдийн 95% нь Ислам шашинтай бөгөөд гол төлөв суннитийн чиглэлийг баримталдаг.
- Катар улсын арабууд нүүдэлчин соёл иргэншилтэйд тооцогддог боловч сүүлийн жилүүдэд газрын тосны орлого нь нэмэгдэж хөгжлийн өндөр түвшинд хүрч орчин үеийн хотжилтын соёл иргэншилд шилжсэн.
- Арабуудын хоолны соёл: хонь, хурга, шувууны махыг цагаан будаа, үзэмтэй хамт төрөл бүрийн хоол бэлддэг. Мөн шөлтэй хоол болон шарсан махтай хоол их дэлгэрсэн байдаг. Хоолонд жимс, жимсгэнэ, самар, ногоо их хэрэглэдэг. Кофе уух соёл нилээн дэлгэрсэн ба тэмээ, хонь, ямааны сүү гол төлөв хэрэглэдэг.
- Эрүүл мэндийн салбар үнэгүй үйлчилгээ үзүүлдэг.

¹⁶ www.imf.org

¹⁷ www.imf.org

¹⁸ http://fincan.ru/articles/35_srednyaja-zarplata-po-stranam-mira-2018/

- Боловсролын салбар мөн адил төрөөс санхүүждэг ба иргэдийн 90% нь боловсролтой.
- Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь тодорхой цензуртэйгээр үйл ажиллагаа явуулдаг боловч “Аль Жазира” сувгийн ачаар Катар улс бүс нутгийн хэвлэл мэдээллийн салбарт тэргүүлэх байр суурь эзэлсэн.

Технологи - Т-(Technology)

- Газрын тосны салбарт дэвшилтэт өндөр технологийг нэвтрүүлж ажиллаж байна.
- Мэдээлэл харилцааны олон улсын холбооны – мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн түвшингийн индексээр¹⁹ - 7,21 оноотой.
- ПБХАЗ-ийн интеграцын түвшинд гишүүн орнууд ИТ технологийг өргөнөөр ашиглах зайлшгүй шаардлагын дагуу хөрөнгө оруулж байгаа.
- Ердийн амьдралын хэрэгцээнд мөн төрийн байгууллагууд нь сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашиглаж байна.
- Төрийн үйлчилгээг цахимжуулах ажлууд ПБХАЗ-ийн хүрээнд хийгдэж байгаа ба гааль, хяналтын байгууллагуудын зарим үйлчилгээг нэвтрүүлсэн байдаг.

Хууль эрх зүй - L-(Legal)

- Катар нь - түр үйлчлэх Үндсэн хуультай.
- Шүүхийн тогтолцоо нь шариатын хуулийг үндэс болгодог ба шүүхийн дээд байгууллага нь давж заалдах шатны шүүхийн шийдвэр байх ба Эмирийн эцсийн шийдвэрээр баталгаажиг хэрэгжинэ.
- Катарын эрх зүйн тогтолцоонд Шариатын хуулийн хүрээнд гаргасан иргэний, худалдааны, эрүүгийн гэх мэт салбарын болон нийгмийн харилцааг зохицуулсан эрх зүйн баримтууд үйлчилдэг ба нийтлэг эрх зүйн зарчим нь шариат дээр үндэслэгдэнэ.
- 1981 оноос Персийн булангийн Арабын орнуудын хамтын ажиллагааны Зөвлөлийн үүсгэн байгуулагч гишүүн, 2003 оноос ПБХАЗ-ийн Гаалийн холбооны гишүүн ба гадаад худалдааны эрх зүйн зохицуулалтуудаа тус байгууллагын 2002 онд баталсан Гаалийн тухай хууль болон бусад эрх зүйн актуудад нийцүүлэн хэрэгжүүлж байгаа.

Байгаль орчин, экологи - (Ecology)

- Катарын хаант улс нь газар нутгийн хувьд Арабийн хойгийн зүүн хэсэгт байрласан харьцангуй жижиг газар нутагтай, гол төлөв элсэн цөл, цөлөрхөг тал нутагтай улс.
- Цаг агаарын дундаж 22-35 хэм халуун байна.
- Усны нөөцийн хомсдолтой ба усны нөөцөө далайн усыг шүүж, гүний худаг, артезианы худгаас авдаг.
- Хөдөө аж ахуй эрхлэх боломжит талбай 67 мянган га²⁰.
- Ургамлын төрөл зүйл цөөн, элсэрхэг газрын ургамлуудтай.
- Ан амьтны төрөл зүйл бага, загасны төрөл ихтэй.

¹⁹ International Telecommunication Union: ОУХТ Хөгжлийн индекс 2017.

²⁰ <http://www.fao.org/countryprofiles/index/ru/?iso3=QAT>



5.8.3. Кувейт улс

Улс төр, төрийн тогтолоцоо - P-(Political)

- Кувейт – үндсэн хуульт хаант улс.
- Нийслэл – Эль Кувейт.
- Хүн ам – 4,7 сая.
- Газар нутаг - 1782 км хавтгай дөрвөлжин.
- Монгол улстай 1975 онд Дипломат харилцаа тогтоосон²¹.
- Найрсаг харилцаа, хамтын ажиллагаатай
- Дипломат харилцааг Кувейт улс дахь Монгол улсын Элчин сайдын яам, Монгол улс дахь Кувейт улсын Элчин сайдын яамдуудаар хэрэгжүүлж байгаа.
- Олон удаагийн харилцан айлчлалууд хийгдсэн.
- Харилцан визийн нөхцөлтэй.
- Засгийн газар хоорондын 15 хэлэлцээр хийгдсэн ба үүнээс Монгол Улсын Засгийн газар, Кувейт Улсын Засгийн газар хоорондын худалдааны хэлэлцээр (2007 он).
- Мал эмнэлэг, хорио цээрийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Кувейт Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр (2011 он).
- Төрийн эрхийг Эмир ас-Сабах-ын удмынхан ард түмний төлөөлөлтэй хувааж хэрэгжүүлдэг.
- Үндсэн хуулинд зааснаар хууль тогтоох эрх мэдэл Эмир болон Үндэсний хуралдаанд (парламент) олгогдсон. Үндэсний хуралдаан нь сонгуулиар бүрддэг нь бусад хаант улсуудаас онцлогтой. Үндэсний хуралдааны бүрэлдэхүүнд Засгийн газрын гишүүд нь бүгд ордог ба батлагдах хууль, эрх зүйн баримт бичгүүдэд Эмир хориг тавих эрхтэй. Үндэсний хуралдаан нь 75 гишүүнтэй ба 50 гишүүн нь сонгуулиар, 25 гишүүнийг Эмир шууд томилдог байна.
- Гүйцэтгэх засаглалыг Эмир болон Засгийн газар (Сайд нарын зөвлөл) хэрэгжүүлнэ. Үндсэн хуульд зааснаар Эмир Ерөнхий сайд (Сайд нарын зөвлөлийн Тэргүүн)-ээр хааны удмын Хунтайжийг томилж, Ерөнхий сайдын санал болгосноор салбарын сайд нарыг батламжилна.
- Нэгдсэн Үндэстэний Байгууллага, Дэлхийн Худалдааны Байгууллагын гишүүн орон.

Эдийн засаг - E-(Economic)

- Кувейт улсын эдийн засгийн гол тулгуур нь газрын тос ба төсвийн орлогын 75%-ийг эзлэдэг.
- Дотоодын нийт бүтээгдэхүүн 29,3 мянган ам. доллар²².
- Инфляцийн түвшин 2,5%²³.
- ДНБ-ний бодит өсөлт 2,5%.
- Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан мэдээгээр дундаж цалин – 2358,91 ам.доллар.²⁴

²¹ <http://www.mfa.gov.mn>

²² www.imf.org

²³ www.imf.org

- Монгол улстай худалдааны эргэлт – 121,8 мянган ам.доллар²⁵ (2018 он). Манай улс Кувейт улсаас бөс бараа, аялалын хэрэгсэл голдуу импортолж, хивс болон бусад төрлийн амьд амьтан экспортлосон ба гадаад худалдааны тэнцэл өссөн үзүүлэлттэй.
- Химийн, цахилгаан эрчим хүч, өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэл хөгжсөн.
- Банк, санхүүгийн салбараа хөгжүүлж байгаа ба Исламын банкны зарчмууд үйлчилдэг.
- Харилцаа холбооны салбар маш сайн хөгжсөн ба шилэн кабелиар өндөр хурдтай. мэдээлэл дамжуулах салбарт хөрөнгө оруулсан.
- Усны нөөц хязгаарлагдмал байгаатай холбогдуулан хөдөө аж ахуй, газар тариалан сул хөгжсөн.
- Мал аж ахуй эрхэлдэг, тодорхой тооны малтай. Тэмээ үржүүлэх нь элбэг.
- Аялал жуулчлалын салбарт хөрөнгө оруулалт хийж байгаа.
- Зэвсэгт хүчний салбарт маш их хөрөнгө зарцуулдаг.

Нийгэм соёл - S-(Social)

- Кувейтийн нийгэм, соёлын онцлог нь бусад Арабын улсуудын мөн адил Ислам шашинтай салшгүй холбоотой. Нийгмийн харилцааны хэм хэмжээнүүд бүхэлдээ шашны ёс, дэг жаягт нийцэж тогтсон байдаг. Нүүдлийн соёл иргэншлээс суурин соёл иргэншилд шилжиж орчин үеийн соёлын хэв маяг хүчтэй орж ирж байгаа боловч харилцаа, хувцаслалт, шашны хэм хэмжээ бүхий заншлуудаа сайн баримталдаг. Хувцасны соёл нь хэвээрээ хадгалагдаж байгаа нь шашин, тус улсуудын цаг агаарын байдалтай холбоотой.
- Албан ёсны хэл –Араб хэл, англи хэлийг түгээмэл хэрэглэдэг.
- Нийт иргэдийн 85% нь Ислам шашинтай бөгөөд гол төлөв суннитийн чиглэлийг баримталдаг. Бусад шашны төлөөллүүдийг гадаадын ажиллагсад ихэвчлэн эзэлдэг аж
- Хонь, хурга, шувууны махыг цагаан будаа, үзэмтэй хамт төрөл бүрийн хоол бэлддэг. Мөн шөлтэй хоол болон шарсан махтай хоол их дэлгэрсэн байдаг. Хоолонд жимс, жимсгэнэ, самар, ногоо их хэрэглэдэг. Кофе уух соёл нилээн дэлгэрсэн ба тэмээ, хонь, ямааны сүү гол төлөв хэрэглэдэг байна. Кофе санал болгоход татгалзах нь хүндэтгэлгүй хандсаныг илэрхийлдэг.
- Эрүүл мэнд, боловсрол үнэгүй.

Технологи - T-(Technology)

- Кувейт улс технологийн хөгжилдөө хөрөнгө зарж сүүлийн жилүүдэд шинэ бүтээн байгуулалтуудад өргөнөөр ашиглаж байна. Хотуудаа “Ухаалаг хот” болгох талаар багагүй анхаарч байгаа.
- Мэдээлэл харилцааны олон улсын холбооны – мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн түвшингийн индексээр²⁶ - 5,98 оноотой.
- ПБХАЗ-ийн интеграцын түвшинд гишүүн орнууд ИТ технологийг өргөнөөр ашиглах зайлшгүй шаардлагын дагуу хөрөнгө оруулж байгаа.
- Ердийн амьдралын хэрэгцээнд мөн төрийн байгууллагууд нь сүүлийн үеийн дэвшилтэт технологийг элбэг ашиглаж байна.

²⁴ http://fincan.ru/articles/35_srednyaja-zarplata-po-stranam-mira-2018/

²⁵ Үндэсний статистикийн хөроо - <http://1212.mn>

²⁶ International Telecommunication Union: The ICT Development Index 2017.

- Төрийн үйлчилгээг цахимжуулах ажлууд ПБХАЗ-ийн хүрээнд хийгдэж байгаа ба гааль, хяналтын байгууллагуудын зарим үйлчилгээг нэвтрүүлсэн байдаг.

Хууль эрх зүй - L-(Legal)

- Кувейтийн эрх зүйн тогтолцоонд Шариатын хуулийн хүрээнд гаргасан иргэний, худалдааны, эрүүгийн гэх мэт салбарын болон нийгмийн харилцааг зохицуулсан эрх зүйн баримтууд үйлчилдэг ба нийтлэг эрх зүйн зарчим нь шариат дээр үндэслэгдэнэ. Мөн худалдаа эдийн засаг, техник технологийн гэх мэт салбарын хуулиудтай.
- Шүүхийн тогтолцоо нь 4 шатлалын шүүхээс бүрддэг. Анхан, давж заалдах, хяналтын болон дээд шатны. Шүүх нь дотроо хувийн хэрэг, эрүүгийн, иргэний, худалдаа, захиргааны гэх мэт төрөлжсөн байна. Түүнчлэн хувийн хэрэг шийдвэрлэх хэсгийнхэн дотроо суннитуудын, шиитүүдийн болон мусулман бус хүмүүсийн гэж ангилагддаг байна.
- 1981 оноос Персийн булангийн Арабын орнуудын хамтын ажиллагааны Зөвлөлийн үүсгэн байгуулагч гишүүн, 2003 оноос ПБХАЗ-ийн Гаалийн холбооны гишүүн ба гадаад худалдааны эрх зүйн зохицуулалтуудаа тус байгууллагын 2002 онд баталсан Гаалийн тухай хууль болон бусад эрх зүйн актуудад нийцүүлэн хэрэгжүүлж байгаа.

Байгаль орчин, экологи - E-(Ecology)

- Кувейт улс нь Арабийн хойгийн зүүн эрэг дагуу байрласан, газар нутгийн хувьд бага зэргийн налуу хавтгай бүс нутаг. Элсэн цөл, цөлөрхөг нутагтай.
- Цаг агаар нь хуурай, өвлийн улиралд 13-35 хэм дулаан, зуны улиралд 37-50 хэм халуун байна.
- Усны нөөцийн хомсдолтой. Усны нөөцөө далайн усыг шүүж, гүний худаг, артезианы худгаас авдаг.
- Ой мод газар нутгийн 6,25 мянган га, тариалалтын хөдөө аж ахуйн зохимжтой талбай 150 мян га²⁷.
- Ургамлын төрөл зүйл цөөн, элсэрхэг газрын ургамлуудтай.
- Ан амьтны төрөл зүйл цөөн.

²⁷ <http://www.fao.org/countryprofiles/index/ru/?iso3=KWT>

5.8.4. Персийн булангийн Арабын орнуудын хамтын ажиллагааны зөвлөл



The Cooperation Council for the Arab States of the Gulf GCC

Персийн булангийн Арабын орнуудын хамтын ажиллагааны зөвлөл нь (цаашид ПБХАЗ гэх) 1981 онд Арабын Нэгдсэн Эмират, Саудын Араб, Катар, Кувейт, Оман, Бахрейн зэрэг зургаан орны түүх соёл, газар нутаг, итгэл үнэмшил санаачилгаар байгуулагдсан бүс нутгийн интеграцлалд чиглэсэн байгууллага юм.

Тус байгууллага нь өнөөдрийг хүртэл улс төр, худалдаа эдийн засаг, гааль татварын, газрын тосны бодлогын хүрээнд хүчээ нэгтгэхэд тодорхой алхмуудыг хийж ирсэн байна. Тус гишүүн орнууд бүгд мал, малын гаралтай бүтээгдэхүүнүүд, хүнсний хангамжийн үлэмж хэсгийг импортолдог онцлогтой. Үүнтэй холбогдуулж хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөгүй хүнсний хангамжийг бий болгох зохицуулалтуудыг 2007 оноос хийж эхэлсэн байдаг. Үүнд: ПБХАЗ-ийн Сайд нарын зөвлөлийн Хүнсний аюулгүй байдлын хорооноос Нэгдсэн хууль болон бусад эрх зүйн актуудыг батлах санал гарган хэрэгжүүлэн ажилласан байна.




2001 онд тус байгууллага Худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулж, 2002 онд Нэгдсэн гаалийн тухай хуулийг баталж, 2003 оноос Арабын Нэгдсэн Эмират, Саудын Араб, Катар, Кувейт, Оман, Бахрейн улсуудын Гаалийн нэгдсэн холбоог байгуулсан. Гаалийн нэгдсэн холбоо худалдаа эдийн засгийн нэгдсэн тарифын болон тарифийн бус зохицуулалтыг хөнгөвчлөх талаар тодорхой алхмуудыг хийсэн.

ПБХАЗ-ийн дэргэд Стандартын асуудал хариуцсан байгууллага 2001 онд байгуулагдаж 2003 оноос Гаалийн холбооны хүрээнд үйл ажиллагаагаа бүрэн явуулж эхэлсэн. Тус байгууллага гишүүн орнуудын хоорондын худалдааны саад бэрхшээлүүдийг арилгах, импорт, экспорт, тарифийн болон тарифийн бус болон бусад нэгдсэн зохицуулалтуудыг агуулсан нийт 5000 гаруй стандартын баримт бичиг гаргасан байна. Эдгээрээс зорилтот орнуудад мах, махан бүтээгдэхүүн импортлоход хамаарах 49 стандартын баримт бичгийг онцолж болно²⁸.


Судалгааны зорилтот Саудын Араб, Катар, Кувейт улсуудтай худалдаа-эдийн засгийн харилцаа, импорт, экспортын зохицуулалтууд нь ПБХАЗ-ийн эрх зүйн хэм хэмжээний хүрээнд зохицуулагдах ба ПБХАЗ-ийн улсуудын харьяа байгууллагууд хэрэгжүүлэх үүрэгтэй байдаг. Өөрөөр хэлбэл бараа, таваар импортлох явцыг гишүүн улсуудын тус бүрийн эрх бүхий байгууллагууд Гаалийн нэгдсэн холбооныхоо зохицуулалтын хэм хэмжээний дагуу хэрэгжүүлдэг.

²⁸ Хавсралт 2

Схем 2. ПБХАЗ-ийн үндсэн зорилго.



Схем 3. ПБХАЗ - ийн бүтэц, зохион байгуулалт



Дээд зөвлөл нь тус байгууллагын удирдах дээд байгууллага бөгөөд гишүүн орнуудын төрийн тэргүүн нараас бүрдэж ба жилд нэг удаа хуралддаг байна. Дээд зөвлөлийг орнууд ээлжлэн даргалах ба түүний дэргэд Зөвлөлдөх хороо 30 гишүүнтэйгээр (орон тус бүрээс 5 төлөөлөл) 3 жилийн хугацаатай томилогдон ажилладаг. Мөн маргаан шийдвэрлэх комисс нь маргаан гарсан тохиолдолд бүрэлдэн ажилладаг байнгын бус статустай.

Сайд нарын зөвлөл нь тус улсуудын Гадаад харилцааны сайд нар эвсэл дэд сайдуудаас бүрдэж улиралд нэг удаа ээлжит хуралдаанаа хийдэг.

Ерөнхий нарийн бичгийн газар нь зөвлөлийн байнгын ажлын албаны үүргийг гүйцэтгэдэг бөгөөд түүнийг Дээд зөвлөлөөс 3 жилийн хугацаатай томилсон Ерөнхий нарийн бичгийн дарга тэргүүлнэ. Ерөнхий нарийн бичгийн дарга нь салбар хариуцсан 8 туслахтай бөгөөд тэд ПБХАЗ-ийн эрх зүйн хэм хэмжээний хүрээнд улс

төр, худалдаа-эдийн засаг, түүх соёлын, аюулгүй байдлын, хүмүүнлэгийн, байгаль орчны, мэдээлэл технологи, санхүү, захиргаа зэрэг салбаруудыг хариуцан ажилладаг. Тус улсуудын

Европын холбооны Брюссель дэх болон НҮБ-ийн төлөөлөгчийн газруудын тэргүүн нар мөн Ерөнхий нарийн бичгийн газрын гишүүнээр тооцогддог байна. Ерөнхий нарийн бичгийн дарга эрх мэдлийнхээ хүрээнд салбар хариуцсан байгууллагуудын захирлуудыг томилж чөлөөлнө. Түүнчлэн, Бахрейны Хаант улсад байрлах харилцаа холбооны удирдах газар, Демпингийн²⁹ эсрэг техникийн нарийн бичгийн газар, Оманд байрлах Зөвлөлдөх хорооны удирдах газар болон ПБХАЗ-ийн Европын холбоо болон НҮБ дэхь төлөөллүүд нь Ерөнхий нарийн бичгийн газрын шууд харьяанд үйл ажиллагаа явуулдаг байна.

Хүснэгт 31. ПБХАЗ-ийн харьяа байгууллагууд

Байгууллага	Байгууллагын тухай	Холбоо барих хаяг
 <p>مركز الإعتام الخليجي GCC ACCREDITATION CENTER</p>	ПБХАЗ-ийн Магадлан итгэмжлэх төв	Kingdom of Saudi Arabia P.O.Box 85245 Riyadh 11691Tel: +966114567698 E-mail: info@ПББТ.org.sa
 <p>هيئة التقييس لدول مجلس التعاون لدول الخليج العربية GCC Standardization Organization</p>	ПБХАЗ-ийн Стандартын байгууллага	GCC Standardization Organization - СХБ P.O. Box - 85245, Olaya Street Al Ghadeer, Riyadh - 11691 Kingdom of Saudi Arabia +966 11 274 6655 , csc@СХБ.org.sa
 <p>المركز الإحصائي لدول مجلس التعاون لدول الخليج العربية GCC-STAT</p>	ПБХАЗ-ийн Статистикийн хороо	GCC Statistical Center (ПБХАЗ-STAT) Al Maardih St., 677 - 2 nd Floor Sultanate of Oman, P.O.Box: 840 +(968)24-346-499 , +(968)24-343-228 info@gccstat.org
 <p>ULFMET التجمع الخليجي للتكنولوجيا</p>	ПБХАЗ-ийн Хэмжил зүйн байгууллага	Al Ghadir, Riyadh 13311 Saudi Arabia Telephone: +966 11 274 6655 Email: info@gulfmet.org
 <p>المجلس النقدي الخليجي Gulf Monetary Council</p>	ПБХАЗ-ийн Мөнгөний бодлогын зөвлөл	7206 King Fahad Rd, Al-Muhammadiyah Dist. Riyadh 12361 - 4831 Kingdom of Saudi Arabia Tel. +966 11 2614999
 <p>GCC Electrical Testing Laboratory المفتبر الفليبي لفحص المعدات الكهربائية</p>	ПБХАЗ-ийн Лаборатори	Saudi Arabia Wasel Address: Building No 7457 Zip code: 32235 Additional No. 2623 UnitTelephone: +966 13 868 9800
 <p>Patent Office Of Cooperation Council for The Arab States of The Gulf</p>	ПБХАЗ-ийн Патентын газар	Riyadh, Saudi Arabia PO Box 11333 340 227 Phone : 0966112551516
 <p>GOIC Gulf Organization for Industrial Consulting منظمة الخليج للاستشارات الصناعية Gulf Organization For Industrial Consulting</p>	ПБХАЗ-ийн Аж үйлдвэрийг дэмжих байгууллага	Gulf Organization for Industrial Consulting PO Box 5114, Doha, Qatar Tel: (+974) 44858888 goic@goic.org.qa

²⁹ Demping – Үнийн хөөрөгдөл

5.8.5. ПБХАЗ-ийн Худалдааны хууль, эрх зүйн зохицуулалт (Саудын Араб, Катар, Кувейт)

Зорилтот орнуудын худалдааны хууль тогтоомж, эрх зүйн үйлчлэх хүрээ дотоодын болон ПБХАЗ-ийн байгууллагуудын Гаалийн холбооны эрх зүй, олон улсын гэрээ, хэлэлцээрт тулгуурласан байна. Саудын Араб, Катар, Кувейт улсууд нь Дэлхийн Худалдааны байгууллага, Дэлхийн гаалийн байгууллагын гишүүн улсууд учир олон улсын худалдааны хэм хэмжээг өөрсдийн хууль тогтоомждоо тусгасан байдаг.

ПБХАЗ-ийн улсуудын худалдааны гол баримт бичиг нь 1981 онд байгуулагдсан Нэгдсэн эдийн засгийн хэлэлцээр байсан ба 1983 онд нэмэлт өөрчлөлт орж нэгдсэн Гаалийн холбоо байгуулах суурь тавигдсан байна. Улмаар 2001 онд гишүүн орнууд тус хэлэлцээрийг шинэчлэн “Эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээр” нэртэй баталж нэгдсэн Гаалийн холбооны эрх зүйн үндэс бүрэлдсэн байна. Гаалийн холбооны эрх зүйгээр гишүүн орнууд нь нэг гаалийн нутаг дэвсгэр, нэг гаалийн бүс, нэг тариф, худалдааны нэг санхүүгийн болон захиргаа удирдлагын нөөцтэй байхаар зохицуулсан байна. Энэ нь 2003 онд батлагдаж одоо мөрдөгдөж байгаа “Нэгдмэл гаалийн тухай хууль” бөгөөд тус хуулийг батлахад олон улсын хэм хэмжээнд нийцүүлэхийн тулд Дэлхийн худалдааны болон Гаалийн байгууллагаар хянуулсан байдаг байна.

Түүнтэй зэрэгцэн хуулийг хэрэгжүүлэх дүрэм, журмууд хамт батлагдан гарсан байна. Тус хууль нь худалдааны зохицуулалтын гол баримт бичиг бөгөөд 17 бүлэг 179 заалттай. Хуулинд гаалийн үйл ажиллагааны тухай, тариф, төлбөр хураамжийн зарчим, хориглох, хязгаарлалтын талаар, барааг мэдүүлэх, хяналт тавих, гаалийн брокеруудын үйл ажиллагаа, гаалийн байгууллагын болон албан тушаалтны эрх зүйн байдлын тухай зохицуулалтууд орсон байдаг. Мөн хуулинд гаалийн зөрчлийн талаар нилээн дэлгэрэнгүй тусгагдсан онцлогтой.

ПБХАЗ-ийн хууль эрх зүйн баримт бичгүүд олон биш боловч зохицуулах хүрээ нь өргөн байгаа тул зарим зохицуулалтуудыг тухайн хилээр нэвтэрч буй улсын дотоод хууль тогтоомжоор зохицуулсан байдаг. Жишээлбэл: Тухайн оронд импортлох, тээвэрлэхийг хориглосон барааны жагсаалтыг гишүүн орнуудын эрх бүхий байгууллагууд гаргаж хяналт тавина.

ПБХАЗ-ийн хууль эрх зүйн орчин нь төгөлдөржих шатанд байгаа тул худалдааны олон зохицуулалтуудын интеграцийн үйл явц нь нэгдсэн зохицуулалтанд шилжиж байгаа нь анзаарагдаж байна. Гэвч үндсэн гол зохицуулалтуудаа цөөхөн хууль болон олон журам, стандарт, бусад эрх зүйн актуудаар зохицуулсан байна. Жишээлбэл: ПБХАЗ-ийн дэргэдэх Стандартын байгууллага нь гаалийн холбооны нутаг дэвсгэрт мөрдөх нийт 5,000 гаруй стандартын бичиг баримтыг батлуулсан байна.

Олон улсын гаалийн эрх зүйд гаалийн хэрэг зөрчлийг гаалийн хууль тогтоомжийг зөрчсөнд тооцдог “Гаалийн хялбарчилсан журам ба уялдаа холбооны тухай Киотын конвенц” зарчмыг дээрх хууль тогтоомж өөртөө тусгаж хэрэгжүүлдэг ба аливаа зөрчлийг арилгах болон урьдчилан сэргийлэх, бараа таваар, тээврийн хэрэгслийг түр саатуулах, хураах үйл явцад хамааруулдаг. Киотын конвенцид АНЭ, Катар, Саудын Араб нэгдсэн байдаг.

5.8.6. ПБХАЗ –ийн Гаалийн холбоо

Гаалийн холбоо – гишүүн орнуудын хоорондын худалдааны гаалийн татвар хураамжаас чөлөөлөгдсөн саадгүй, хяналтын болон тусгай журамгүй бараа бүтээгдэхүүний эргэлттэй бүс нутаг байх ба гуравдагч буюу гишүүн бус улс орнуудтай худалдаа, гаалийн нэгдсэн дүрэм журам, татвар хураамж үйлчилдэг бүс нутгийг нэрлэж байгаа.

ПБХАЗ-ийн Гаалийн холбооны гишүүн орнууд: **Саудын Араб, Катар, Кувейт, Оман, Бахрейн, Арабын Нэгдсэн Эмират.**

ПБХАЗ-ийн Гаалийн холбооны үндсэн зарчмууд:

- ПБХАЗ-ийн Гаалийн холбооны бус улсуудаас импортлох бараа таваарын нэгдсэн тариф байна;
- Нэгдсэн гаалийн тухай хууль;
- Гишүүн улсуудын олон салбарт адил хэрэглэгдэх дүрэм, журам болон гаалийн журамтай байх;
- ПБХАЗ-ийн орнуудын импорт, экспорт, рээкспорттой холбоотой гааль, санхүү болон захиргааны дүрэм, журмуудыг нэгтгэсэн тогтолцоотой байх;
- Импортын болон импортын татвар төвлөрөх гаалийн орох нэг цэг (Гишүүн орнуудын усан, агаарын болон газрын боомт нь ПБХАЗ-ийн Гаалийн холбооны гаалийн нэг цэг болж тооцогддог);
- Мал эмнэлэг, хорио цээрийн болон хориотой бараа бүтээгдэхүүний шаардлагыг харгалзан гишүүн улсуудын хоорондын ямар нэгэн гаалийн болон гаалийн бус саадгүйгээр чөлөөт худалдаа эрхлэх;
- ПБХАЗ-ийн аль ч оронд үйлдвэрлэгдсэн бараа бүтээгдэхүүнийг үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнд тооцох (Тухайн таваарын 40% буюу түүнээс дээш хувь нь гишүүн орнуудын нутаг дэвсгэрт үйлдвэрлэгдсэн тохиолдолд үндэсний бараа гэж тооцдог).

ПБХАЗ-ийн хууль дүрмийн дагуу гишүүн орнуудад гуравдагч орнуудаас импортлогдож буй бүх бараа таваарт үйлчлэх журмууд нь нэг байна (ПБХАЗ-ийн Гаалийн тухай хууль 2003 он, ПБХАЗ-ийн орнуудад импортлогдох хүнсний бүтээгдэхүүнд тавих хяналт, шаардлагын удирдамж 2016 он, Гаалийн холбооны импортын тариф 2017 он).

5.8.7. ПБХАЗ-ийн худалдааны зохицуулалт

ПБХАЗ-ийн импортын зохицуулалтууд

ПБХАЗ-ийн орнууд руу мах, махан бүтээгдэхүүн импортлоход “ПБХАЗ-ийн Нэгдсэн гаалийн тухай хууль³⁰” (Common customs Law of the GCC States), “ПБХАЗ-ийн орнуудад импортлох хүнсний хяналт 2016 он³¹” (GCC Guide For Control On Imported Foods – 2016), ПБХАЗ-ийн Стандартын байгууллага (GSO)-аас гаргасан стандартууд³², ПБХАЗ-ийн Итгэмжлэлийн байгууллага (GAC)-ын эрх олгосон баталгаажуулалтын гэрчилгээнүүд³³ болон холбогдох шийдвэрүүдийг³⁴ үндэслэл болгоно.

Импортын хүнсний эрсдлийн үнэлгээний зарчим

Импортын хүнсний хэмжээ үлэмж байдагтай холбогдуулан ПБХАЗ-ийн импортын бүтээгдэхүүнүүдийг хүн амын хэрэглээнд учирч болзошгүй эрсдлийг хамгийн бага буюу эрсдэлгүй байлгахад чиглэгдсэн шаардлагуудыг тавьдаг. Үүнд экспортлогч орны эрх бүхий байгууллагуудын мэдээлэл, олон улсын байгууллагуудын мэдээлэл, тухайн орноос хийгдсэн импортын түүх, баталгаажуулалтын баримт бичгүүд, бараа таваарын үзлэг шинжилгээ,

³⁰<https://www.dubaicustoms.gov.ae/en/Publications/Documents/GCCCommonCustomsLawEnglish.pdf>

³¹https://members.wto.org/cnattachments/2017/sps/bhr/17_0268_00_e.pdf

³²<https://www.gso.org.sa/en/standards/standards-store/>

³³<http://www.gac.org.sa/en/>

³⁴<http://www.gcc-sg.org/en-us/Pages/default.aspx>

хадгалалт, савлагаа, дээжийн шинжилгээ, мэдүүлэгчийн мэдээлэл зэргийг цогцоор нь боловсруулж, үнэлгээ хийж шаардлага хангасан эсэхийг тодорхойлох зарчмыг баримталдаг.

Гааль

ПБХАЗ-ийн гишүүн орнууд Саудын Араб, Катар, Кувейт улсууд нь Дэлхийн худалдааны байгууллага, Дэлхийн Гаалийн байгууллагын гишүүн орнууд ба гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд Бараа бүтээгдэхүүний кодын олон улсын уялдуулсан (HS) тогтолцоог хэрэглэдэг. Гаалийн тухай хуулийн дагуу импортын бараа бүтээгдэхүүн агаарын, далайн болон газрын тээврийн гаалийн цэгүүдэд бүрдүүлэлт хийнэ. Дэлхийн худалдааны байгууллага, Дэлхийн гаалийн байгууллагын дүрэм журмыг мөрдөж ажилладаг.

Эрүүл ахуйн хяналт

Мах, махан бүтээгдэхүүн импортлох үйл явцад - мал бэлтгэл, үйлдвэрлэл, мах бэлтгэл, савлалт, тээвэрлэлт, импортын бүх үе шатуудад эрүүл ахуйн болон халалын стандартын биелэлтэнд маш өндөр шаардлага тавьдаг.

Зураг 2. Импортын үйл явцын зураглал ба стандартууд



ПБХАЗ-ийн орнууд нь хүнсний импортын үйл явцын бүхий л хэлхээнд мөрдөх стандартуудыг баталсан бөгөөд түүнд нийцсэн байх шаардлагыг тавьдаг (зураг 2).

Мах махан бүтээгдэхүүний эрүүл ахуйн шалгуур

Экспортлогч талын эрх бүхий байгууллагаас мах, махан бүтээгдэхүүний эрүүл ахуйн шалгуурыг хангасан талаар Мал эмнэлэг, эрүүл ахуйн гэрчилгээнд дагалдуулж дараах мэдээллүүдийг заавал бичгээр илэрхийлэх шаардлагатай.

Хүснэгт 32. Мал эмнэлэг, эрүүл ахуйн гэрчилгээнд дагалдах мэдээллийн хураангуй

Мах, махан бүтээгдэхүүн нь эрүүл ахуйн шаардлага хангасан, хүнсэнд хэрэглэхэд зохимжтой ³⁵ эсэх
ПБХАЗ-ийн эрх олгосон экспортлогч орны хяналтын эрх бүхий байгууллагын хяналтанд байгаа үйлдвэрт төхөөрч бэлтгэгдсэн эсэх
Мах, махан бүтээгдэхүүн нь экспортлогч орны эрх бүхий байгууллагын томилсон малын эмч төхөөрөхийн өмнөх болон дараах үзлэг хийсэн эсэх
Мах, махан бүтээгдэхүүн нь хяналтын эрх бүхий байгууллагын хяналтанд байгаа, НАССП

³⁵ Махны төрлийг заавал тусгасан байна. (хонь, ямаа, үхэр г.м)

болон түүнтэй дүйцэх тогтолцоог хэрэгжүүлж буй үйлдвэрээс гарсан эсэх
Мал эмнэлгийн сайн туршлага хэрэглэгдсэн, эм, бэлдмэл, вакцин нь ПБХАЗ-ийн стандартын дагуу хийгдсэн эсэх (өсөлтийн гормон, хөдөө аж ахуйн зориулалттай химийн бордоо болон бусад бэлдмэл, тэдгээрийн мах, махан бүтээгдэхүүн дэхь үлдэгдэл)
Амьтны гаралтай боловсруулсан уураг орсон тэжээлээр тэжээсэн малын мах, махан бүтээгдэхүүн эсэх (Төхөөрөх малд загасны төрлийн амьтны гаралтай тэжээл өгөх болон тухайн малыг төл байх үед сүү орлуулагчаар тэжээхийг зөвшөөрдөг)
Нэмэлт эрүүл ахуйн шалгуурыг хангасан эсэх (шаардсан тохиолдолд)
Мал, амьтан нь экспортлогч оронд үржиж өссөн эсвэл ПБХАЗ-ийн орнуудад экспортлох зөвшөөрөлтэй улс орноос албан ёсоор импортлогдсон эсэх
Мах, махан бүтээгдэхүүн нь ... улсын, ...газар өссөн малын гаралтай (Бүс, газар нутгийн нэр заах)
Мах, махан бүтээгдэхүүн нь генийн болон генийн инженерийн ямар нэгэн өөрчлөлтийн нөлөөгүй тухай
GSO 714, GSO 1400 стандартын шаардлагын хангасан фермүүдээс тээвэрлэсэн эсэх
GSO 996 стандартын дагуу гулууз болон хэсгүүдэд мал эмнэлэг, эрүүл ахуйн үзлэг хийж тэмдэглэл хөтөлсөн эсэх
Мах, махан бүтээгдэхүүн нь GSO 1016 стандартад заасан микробиологийн шалгууруудыг хангасан эсэх
Мах, махан бүтээгдэхүүн нь GSO 815, GSO 232 стандартуудын дагуу хадгалах, тээвэрлэх шаардлагуудыг хангасан эсэх
Мах, махан бүтээгдэхүүн нь GSO 2481 стандартын дагуу эм, бэлдмэлийн үлдэгдлийн дээд хэмжээний шаардлагыг хангасан эсэх
Мах, махан бүтээгдэхүүнд GSO 993 стандартын дагуу хийгдсэн ПБХАЗ-ийн орнуудад зөвшөөрөгдөх “Халал” сертификат дагалдаж байгаа эсэх
Мах нь төхөөрсний дараах доод тал нь 24 цаг +2 хэмээс доошгүй нөхцөлд сэврээсэн эсэх
Мах, махан бүтээгдэхүүн нь ДМАЭМБ-ын 2016 оны “Хуурай газрын мал амьтны эрүүл мэндийн код”-ын 1b- 14.8.1 шаардлагыг хангасан эсэх
Мах, махан бүтээгдэхүүн нь дээрх болон холбогдох шаардлагуудыг хангаагүй мах, махан бүтээгдэхүүнээс ангид бэлтгэсэн эсэх

Хаяг, шошго³⁶

Зорилтот улсуудад хөдөө аж ахуйн гаралтай болон хүнсний бараа, бүтээгдэхүүн импортлоход түүнд тавигдах шаардлагад нийцэж буй эсэх нь маш чухал.

Хаяг шошго нь заавал Араб хэл дээр бичигдсэн байх шаардлагатай (Англи хэл дээр хамт бичиж болно) ба дараах мэдээллүүдийг заавал агуулсан байна.

- i. Бараа бүтээгдэхүүний нэр ба худалдааны нэршил (Брэнд)
- ii. Бүтээгдэхүүний орц найрлага (нэмэгдэл)
- iii. Бүтээгдэхүүний жин
- iv. Бүтээгдэхүүн үйлдвэрлэгдсэн улсын нэр
- v. Үйлдвэрлэсэн огноо
- vi. Дуусах хугацаа (хадгалах)
- vii. Хадгалах горим болон хэрэглэх заавар (шаардлагатай бүтээгдэхүүнд)

Сав баглаанд тусгагдсан мэдээллүүд барааны тээврийн бичиг баримтад байгаа мэдээлэлтэй зөрөх ёсгүй. Үйлдвэрлэсэн огноо болон дуусах хугацааны тухай мэдээлэл нь анхан шатны савлагаан дээр арилдаггүй, уусдаггүй аргаар тавигдсан байна.

³⁶ GSO 2231, GSO 150, GSO 9

Сав баглаа, боодол

ПБХАЗ-ийн орнуудад хүнсний бүтээгдэхүүн импортлоход сав баглаа, боодолд тавигдах шаардлагууд нь тус зөвлөлийн Стандартын байгууллагаас (GAC) гаргасан стандартуудаар зохицуулагдана. Хүнсний бүтээгдэхүүний сав баглаанд нэн тэргүүнд тавигдах шаардлага нь эрүүл ахуйн буюу хүний биед болон хүнсний бүтээгдэхүүнд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлийг багасгахад чиглэгдэж байна. Хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодол нь Хүнсний сав баглааны техникийн ерөнхий шаардлагад (GSO 839 "Food packages- part 1: general requirements")³⁷, (GSO 997 "Chilled beef, buffalo, mutton and goat meat")³⁸, GSO 2231/2012 (General requirements for materials intended to come into contact with food), (GSO 1863 "Food packages – Part 2: Plastic package – General requirements")³⁹ нийцсэн байх шаардлагатай. Сав баглааны ерөнхий шаардлагад мах, махан бүтээгдэхүүний бүхий л савлагаа нь эрүүл мэндэд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлдэггүй, механик болон байгалийн нөлөөнд тэсвэртэй, ямар нэгэн химийн урвалд ордоггүй байх ерөнхий шаардлагыг тавьдаг. Мөн вакумдах болон (MAP)⁴⁰ зэрэг дэвшилтэт технологи бүхий савлагааг ашиглахыг зөвшөөрдөг. Хийн найрлагыг өөрчилсөн савлагаа (MAP) нь бүтээгдэхүүний хадгалах хугацааг уртасгах зорилгоор савлагаан дотор хийн найрлагыг өөрчилсөн савлах дэвшилтэт технологи юм. Савлагаан доторх агаарын найрлагыг бүтээгдэхүүнээсээ хамаарч технологийн дагуу нүүрсхүчлийн хий, азот, хүчилтөрөгчөөр хувь тэнцүүлэн хуваарилж савлах боломжтой. Сав баглаа нь хүний бие болон бүтээгдэхүүний чанарт сөрөг нөлөө үзүүлдэггүй материалаар хийгдсэн байх шаардлагатай. Гадна талдаа шошго байрлах хангалттай зай үлдээсэн байна. Мөн харагдах байдал нь хэрэглэгчийг төөрөгдүүлэхгүй байх, онгойлгоход хялбар мөртлөө тээвэрлэлт, хадгалалтанд бат бөх байх, савлагдсан бүтээгдэхүүний хэмжээнд таарсан байх, нарны шууд тусгал ба байгалийн үзэгдэлд химийн урвалд орж бүтээгдэхүүнд шингэхгүй байх зэрэг шинжүүдийг агуулсан байх шаардлагуудыг тавьдаг. Вакумдсан болон найрлагыг тохируулсан хийгээр савласан мах, махан бүтээгдэхүүний савлагаа нь чийг нэвтрүүлдэггүй, битүүмж сайтай байх ёстой. Нэг савлагаанд зөвхөн нэг малын махыг бусад махтай холихгүйгээр савлана. Мөн зориулалтын хэмд хадгалах, тээвэрлэх гулууз болон өрөөл махыг энгийн савлагааны төрлөөр савлаж, баглах боломжтой. Үүнд махны гадаргууг зориулалтын материалаар (1±0.5) хэмд битүү орооно. Ороох материалыг зөвхөн нэг удаа хэрэглэнэ. Бүтээгдэхүүн савлаж буй хуванцар савлагаануудын гарал үүсэл, орц нь тодорхой байх шаардлагатай. Хатуу хуванцар савлагаа нь 75 см өндрөөс 3 удаа унахад битүүмж, чанараа алдахгүй байх ёстой. Бүх төрлийн савлагааны төрөл нь ариун чанараа хадгалдаг, органик бүтээгдэхүүнтэй урвалд орохгүй байх чанарыг агуулсан байна. Хуванцар савлагаануудын шаардлага "EU" маркийн шаардлагуудыг хангасан байх шаардлагатай.

Хадгалах хугацаа

Бүтээгдэхүүнд эсвэл түүний савлагаанд хадгалах хугацааг үйлдвэрлэсэн хугацааны хамт заавал тусгах ба арилдаггүй, уусдаггүй аргаар тэмдэглэж, харуулсан байна. Жишээлбэл үйлдвэрлэсэн хугацааг дараах байдлаар тусгана:

- ✓ 3 сараас доош хадгалах хугацаатай хүнсний бүтээгдэхүүнд - [өдөр-сар-жил]
- ✓ 3 сараас дээш хадгалах хугацаатай хүнсний бүтээгдэхүүнд [сар-жил эсвэл өдөр/ сар / жил]
- ✓ Хадгалах хугацааг дараах байдлаар тусгана:

³⁷ <https://www.gso.org.sa/en/standards/>

³⁸ <https://www.gso.org.sa/en/standards/>

³⁹ <https://www.gso.org.sa/en/standards/>

⁴⁰ modified atmosphere packaging/агаарын найрлагыг өөрчилсөн савлагаа

- хэрэглэх хугацаа; -хүртэл хэрэглэх: (огноо);
- үйлдвэрлэснээс хойшхүртэл хэрэглэнэ,
-хүртэл худалдаанд гаргах:(огноо) гэх мэтээр тэмдэглэхийг зөвшөөрдөг. Үйлдвэрлэсэн болон хадгалах хугацааг наалтаар хийхийг хориглодог. Хугацаанууд товойлгосон тоо, үсгээр эсвэл зориулалтын хэвлэл, дардсаар зөвхөн үйлдвэрлэгчээр тавигдсан байна. Үйлдвэрлэсэн болон хадгалах хугацаануудын талаар мэдээлэл нь хэрэглэгчид шууд харагдах байдлаар хийгдсэн байна. Нэг бүтээгдэхүүнд нэгээс илүү хадгалах хугацаа тавихгүй.

Хадгалах хугацаа хүнсний бүтээгдэхүүний төрлөөс хамаарч өөр өөр байх бөгөөд мах, махан бүтээгдэхүүнтэй холбоотой ПБХАЗ-ийн стандартуудад заасан байдаг. Жишээлбэл: GSO/FDS 997/2015 – “Үхэр, Буффало, хонь, ямааны хөргөсөн болон хөлдөөсөн мах” стандартын хэсгээс (Хүснэгт 33) харж болно.

Хүснэгт 33. Экспортын бүтээгдэхүүний хадгалалт, савлагааны стандарт

Бүтээгдэхүүн	Савлагааны төрөл	Хадгалах хугацаа
Мах, махан бүтээгдэхүүн		
Нүүрстөрөгчийн давхар исэл бүхий агаарт савласан, хөргөсөн мах (CO2)	Хий нэвтрүүлдэггүй зориулалтын савлагаа	Төхөөрсөнөөс хойш 90 хоног
Дайвар бүтээгдэхүүн (Элэг, бөөр, хэл, зүрх...)	Савлагаа нь тус стандартын шаардлагын талаар унших боломжтой байх	Төхөөрсөнөөс хойш 7 хоног
Хонь, ямааны мах	Зориулалтын контейнер	Төхөөрсөнөөс хойш 14 хоног

ПБХАЗ-ийн (GSO/FDS 997/2015 - Үхэр, Буффало, хонь, ямааны хөргөсөн болон хөлдөөсөн мах) стандартад эдгээр малын махыг төхөөрсөнөөс хойш хадгалах, савлах, тээвэрлэх шаардлагыг тусгасан байна (Хүснэгт 33). Үүнд малыг төхөөрсөний дараа гулууз болон хэсэглэсэн махыг (0-+4 ± 0,5) ° С 36 цаг хүртэл хугацаанд сэврээнэ. Хөлдүү мах бэлтгэхэд доод тал нь 18 цаг сэврээж хөлдөөх камерт (- 40) градуст байлгаж махны гүн дэх хэм -18° С хүртэл түргэн хугацаанд хөлдөөж үргэлжлүүлэн -18 хэмийг тогтвортой барина. Хөлдөөх камерууд нь түргэн хөлдөөх шаардлагыг хангасан байна. Махыг хадгалах, тээвэрлэх үйл явцад байнгын тогтмол хэмийг хадгална. Тогтмол хэмийн хяналтын горимийн тасралтгүй бичигчтэй байхыг шаарддаг ба хэмийн хазайлт ±2 хэмээс ихгүй байна.

Хамаатуулан үзэх стандартууд:

- GSO 9 "Labeling of prepackages food stuffs"
- GSO 839 " Food packages- part 1: general requirements".
- GSO 150 " Expiration Periods of food products".
- GSO 2515 " Food packages made of aluminum foil "
- GSO OIML R 79:2007 “Labeling requirements for prepackaged products”
- GSO 1791 "Three piece steel round cans used for canning food stuffs".
- GSO 1794 "The two piece steel round cans used for canning food stuffs".
- GSO CAC /GL 1 “General guidelines on claims”.
- GSO 124/1990 “General Requirements for Fresh Fruits and Vegetables Boxes”.

Хонь, ямааны хөргөсөн болон хөлдүү маханд тавигдах шаардлага

Хөргөсөн мах:

- Хонь, ямааны мах нь мал эмнэлгийн урьдчилсан болон төхөөрсний дараах үзлэг хийгдсэн байна;
- Маханд гормон болон антибиотикийн үлдэгдэл (GSO CAC/MRL 02:2009 Maximum residues limits (MRLS) of veterinary drugs in food)⁴¹ стандартад заасан хэмжээтэй нийцэж байх шаардлагатай;
- GSO 993 "Slaughtering requirements according to the Islamic Rules" стандартын дагуу Халал төхөөрсөн байх;
- Малын өвчнөөс эрүүл бүсэд байрласан газар төхөөрсөн байх;
- Цэвэрлэгээнд хүнсэнд хэрэглэхэд зөвшөөрсөн ус хэрэглэсэн байх;
- Мал төхөөрөх газар нь гахай төхөөрдөггүй байх;
- Ямар нэгэн эвгүй үнэр, толбо нөсөө үүсээгүй байх;
- Савлагдсан хөргөсөн махны савалгаан дотор конденсатын усны дусал хуримтлагдаагүй байх шаардлагатай;
- Махан дахь азотын хэмжээ GSO/FDS 997 / 2015 стандартад нийцсэн байх;
- рН 6,2 –оос давахгүй байх;
- 1 кг бүтээгдэхүүнд тиобарабитиорын хүчлийн хэмжээ 0,09 мг/кг-аас хэтрэхгүй байх;
- Пестицидийн үлдэгдэл (GSO 382, 383" Maximum limits for pesticide residues in food products and their methods of determination) стандартад нийцсэн байх;
- Микробиологийн шаардлагууд нь (GSO 1016 "Microbiological Criteria for Foodstuffs – Part 1") стандартын дагуу байна;
- Цацрагийн үлдэгдлийн түвшин (GSO 988 "limits of radiation levels permitted in foodstuffs") стандартад зөвшөөрөгдсөн хэмжээнд байна;
- ПБХАЗ-ийн нутаг дэвсгэрт 3 наснаас дээш хонь, ямааны махыг оруулахыг тус стандартаар хязгаарласан;
- ПБХАЗ-аас хяналтын тогтолцоог хэрэгжүүлэхээр эрх авсан импортлогч орны зохих байгууллагаас олгосон /Тэжээлд нь мал, амьтны гаралтай уураг ороогүй, төхөөрсний дараа 12 цагийн дотор малын эмчээр үзлэг хийгдэж эрүүл, хүнсэнд хэрэглэхэд тохиромжтой нь тогтоогдсон тухай/ тусгасан сертификат дагалдана; Сертификатанд дараах мэдээллийг тусгасан байна:
 - а) Малын төрөл, жин болон ойролцоо нас;
 - б) Төхөөрсөн огноо;
 - с) Бүтээгдэхүүний төрөл, нэр, савлагаа, чанарын тухай мэдээлэл;
 - д) Үйлдвэрлэгч улс;
- Вакумдсан болон инертийн хийн орчинд (MAP) савлагдсан бол хийн даралт болон битүүмжлэлийн бүрэн бүтэн байдлыг шалгасан байх зэрэг шаардлагуудтай.

Хөлдүү мах:

- Хонь, ямааны мах нь мал эмнэлгийн урьдчилсан болон төхөөрсний дараах үзлэг хийгдсэн байна;
- Маханд гормон болон антибиотикийн үлдэгдэл (GSO CAC/MRL 02:2009 Maximum residues limits (MRLS) of veterinary drugs in food)⁴² стандартад заасан хэмжээтэй нийцэж байх шаардлагатай;

⁴¹<https://www.gso.org.sa/en/standards/>


⁴²<https://www.gso.org.sa/en/standards/>

- GSO 993 "Slaughtering requirements according to the Islamic Rules" стандартын дагуу Халал төхөөрсөн байх;
- Малын өвчнөөс эрүүл бүсэд байрласан газар төхөөрөгдсөн байх;
- Цэвэрлэгээнд хүнсэнд хэрэглэхэд зөвшөөрсөн ус хэрэглэсэн байх;
- Мал төхөөрөх газар нь гахай төхөөрдөггүй байх;
- Ямар нэгэн эвгүй үнэр, толбо нөсөө үүсээгүй байх;
- Махан дахь азотын хэмжээ GSO/FDS 997 / 2015 стандартад нийцсэн байх;
- рН 5,4-5,8 хооронд байна;
- 1 кг бүтээгдэхүүнд тиобарабитиорын хүчлийн хэмжээ 0,09 мг/кг-аас хэтрэхгүй байх;
- Пестицидийн үлдэгдэл (GSO 382, 383" Maximum limits for pesticide residues in food products and their methods of determination) стандартад нийцсэн байх;
- Микробиологийн шаардлагууд нь (GSO 1016 "Microbiological Criteria for Foodstuffs – Part 1") стандартын дагуу байна;
- Цацраг идэвхжилтийн нөлөөний түвшин (GSO 988 "limits of radiation levels permitted in foodstuffs") стандартад зөвшөөрөгдсөн хэмжээнд байна;
- ПБХАЗ-ийн нутаг дэвсгэрт 3 наснаас дээш хонь, ямааны махыг оруулахыг тус стандартаар хязгаарласан;
- ПБХАЗ-аас хяналтын тогтолцоог хэрэгжүүлэхээр эрх авсан импортлогч орны зохих байгууллагаас олгосон /тэжээлд нь мал, амтны гаралтай уураг ороогүй, төхөөрсний дараа 12 цагийн дотор малын эмчээр үзлэг хийгдэж эрүүл, хүнсэнд хэрэглэхэд тохиромжтой нь тогтоогдсон тухай/ тусгасан сертификат дагалдана; Сертификатанд дараах мэдээллийг тусгасан байна:
 - е) Малын төрөл, жин болон ойролцоо нас;
 - f) Төхөөрсөн огноо;
 - g) Бүтээгдэхүүний төрөл, нэр, савлагаа, чанарын тухай мэдээлэл;
 - h) Үйлдвэрлэгч улс.
- Вакумдсан болон инертийн хийн орчинд (MAP) савлагдсан бол хийн даралт болон битүүмжлэлийн бүрэн бүтэн байдлыг шалгасан байх;
- Хөлдүү савласан махны доторх дусал нийт жингийн 4%-иас хэтрэхгүй байна GSO/FDS 997 / 2015 стандартад заасан бусад шаардлага.

ПБХАЗ-ийн дотоод худалдааны зохицуулалт

Зорилтот орнуудад худалдааны үйл ажиллагаа явуулахад хамтран ажиллах түнш зайлшгүй байх шаардлагатай. Энэ нь “Худалдааны компани болон агентын тухай” хуулиар хуульчлагдсан байдаг. Мөн гишүүн орнуудад хамтарсан үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд 51 хувийг эзэмшигч үүсгэн байгуулагч нь ПБХАЗ-ын гишүүн орнуудын иргэн байхыг шаарддаг.

Зураг 3. Дотоодын зах зээлд борлуулалт худалдаа эрхлэх бүтэц




Тус зах зээлд байр сууриа эзэлсэн компаниудын туршлагаас харахад хамтран ажиллах түншийг олоход дараах боломжуудыг ашигладаг байна. Үүнд:

- Тухайн салбарын (Хүнс, Хөдөө аж ахуйн) олон улсын үзэсгэлэнд оролцох (оролцогчоор эсвэл сонирхогчоор). Голлох үзэсгэлэнгүүд “Gulfood”, “AGRA Middle East”, “Yummex Middle East”, “SIAL Middle East” г.м.;
- Тус орнуудын Худалдаа аж үйлдвэрийн танхимын мэдээллийн сан, өөрийн улсын Худалдаа аж үйлдвэрийн танхимаар дамжуулж албан ёсоор түнш зарлан хайх, мэдээлэл авч холбогдох;
- Тухайн улсад суугаа Элчин Сайдын яамдаар дамжуулж түнш хайх;
- Нээлттэй мэдээллийн эх сурвалжуудаас хаяг авч шууд холбогдох зэрэг байдаг байна.

Жишээ: (www.indexuae.com, www.ameinfo.com, www.zawya.com, www.uaebusinessdirectory.com, http://yellowpages.ae, www.reachuae.com, www.dubaieexporters.com). Түнш, харилцагчтай холбоо тогтоох арга замыг зураг 4-т үзүүлэв.

Зураг 4. Түнш, харилцагчтай холбоо тогтоох дараалал



ПБХАЗ болон Саудын Араб, Катар, Кувейт орнуудын импортын бүрдүүлэлт

ПБХАЗ болон Саудын Араб, Катар, Кувейт орнуудын импортын бүрдүүлэлт
Дээрх Ойрх Дорнодын орнуудад мах, махан бүтээгдэхүүн экспортлох аж ахуйн нэгжүүд дараах мэдээллүүдийг анхаарах шаардлагатай:

Импортын хориг⁴³

Саудын Араб, Кувейт, Катар болон ПБХАЗын бусад улс руу ДМАЭМБайгууллага (OIE), Дэлхийн хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (FAO), Дэлхийн худалдааны байгууллага (WTO)-ын зүгээс болон эдгээр байгууллагын албан ёсны мэдээллийн дагуу мал эмнэлгийн болон аливаа хорио цээр тогтоогоогүй, эсвэл холбогдох байгууллагаар хүлээн зөвшөөрүүлсэн эрүүл бүстэй, мөн тус улсуудын холбогдох эрх бүхий байгууллагуудаас импортыг зөвшөөрсөн тохиолдолд мах, махан бүтээгдэхүүн экспортлох боломжтой.

Импортын зөвшөөрөл

Тус гишүүн орнуудад мах импорлогч аж ахуйн нэгжүүд дараах газруудтай холбогдож зөвшөөрөл авна.

Хүснэгт 34. Зөвшөөрөл хүсэх байгууллагуудын орон тус бүрээр

№	Зорилтот орон	Байгууллага
1	Саудын Араб Улс	Saudi Food and Drug Authority
2	Кувейт Улс	Public Authority for Food and Nutrition
3	Катар Улс	Ministry of Health – Port Health and Food control section

Саудын Араб улсын “Saudi Food and Drug authority⁴⁴” Саудын Арабын хүнс болон эмийн хяналтын газраас (цаашид САХЭХГ гэх) тус улсад мах, махан бүтээгдэхүүн импортлох эрх авсан байна. (Экспортлогч орны малын эрүүл мэнд, хорио цээр, ариун цэврийн хяналтын эрх бүхий байгууллагад САХЭХГ-аас хяналтын итгэмжлэх эрх олгох ба шаардлага хангасан аж ахуйн нэгжүүд тус байгууллагаар уламжлан импортын эрх авна)⁴⁵.

Саудын Арабын хүнс болон эмийн хяналтын газар “Saudi Food and Drug authority ”	
 	<i>Postal address :</i> Saudi Food & Drugs Authority (3292) North Ring Road - Al Nafal Unit (1) Riyadh 13312 - 6288 Saudi Arabia
	<i>Please contact the International Cooperation Department (Governance) on</i> <i>Email: ICD@sfda.gov.sa</i> <i>Phone: 0112038222 extention: 2070 or 2273</i>
	<i>For International Business Support (Business)</i> <i>Email: CEC@sfda.gov.sa</i>

⁴³ САХЭХГ-ын (SFDA) 1435 Н (26/8/2014)-ний 125/135 тоот шийдвэр (https://www.fsvps.ru/fsvps-docs/ru/importExport/sa/files/sa_sfda_125-135.pdf)

⁴⁴ <https://www.sfda.gov.sa/en/Pages/default.aspx>

⁴⁵ https://www.fsvps.ru/fsvps-docs/ru/importExport/sa/files/sa_sfda_124-735.pdf

Кувейт улсад мах импортлогч аж ахуйн нэгж Кувейт улсын “Public authority for Food and Nutrition⁴⁶” Хүнсний хангамжийн асуудал хариуцсан улсын газраас тус улсад мах, махан бүтээгдэхүүн импортлох эрх авсан байна. (Экспортлогч орны малын эрүүл мэнд, хорио цээр, ариун цэврийн хяналтын эрх бүхий байгууллагын итгэмжилсэн, шаардлага хангасан аж ахуйн нэгжүүд импортын эрх авна).

<p>Кувейт улсын Хүнсний хамгамжийн асуудал хариуцсан улсын газар “Public authority for Food and Nutrition”</p>	
 <p>الهيئة العامة للغذاء والتغذية PUBLIC AUTHORITY FOR FOOD AND NUTRITION P. A. F. N</p>	<p>Public authority for Food and Nutrition External Relation and Organization Department Community Nutrition Sector e-mail: m.alnajjar@pafn.gov.kw twitter: pafn_kw +965 94028286 (29.2646792, 48.0780883) Sabah Al Salem 737H+V6 +965 1807 770</p>

Катар улсад мах импортлогч аж ахуйн нэгж Катар улсын Эрүүл мэндийн яамны Эрүүл мэнд, хүнсний хяналтын газраас “Ministry of Health – Port health and Food control section⁴⁷” тус улсад мах, махан бүтээгдэхүүн импортлох эрх авсан байна. Мөн тус улсын Засаг захиргаа, хүрээлэн буй орчны яамны мал, амьтны газарт “Ministry of Municipality and Environment – Livestock department⁴⁸” заавал бүртгүүлсэн байх шаардлагатай.

<p>Катарын Эрүүл мэндийн яамны Эрүүл мэнд, хүнсний хяналтын газар -“Ministry of Health of Qatar – Port health and Food control Section”</p>	
	<p>Qatar, Doha, P.O.box : 42 Phone : 44070000 Ministry of Public Health Port Health and Food Control Section 0097444070210 009744070211 0097444070209 Email: port.health@MOPH.GOV.QA</p>
<p>Катарын Засаг захиргаа, хүрээлэн буй орчны яамны мал, амьтны газар “Ministry of Municipality and Environment of Qatar– Livestock department</p>	
	<p>Ministry of Municipality and Environment Livestock Department Public Relation: +974 - 44348038 Fax: +974 - 44437993 P.O. Box: 22332 address: Main Building Ministry, Al Cornish Street. E-mail: info@mme.gov.qa tel: +974 44070000, 44070270</p>

⁴⁶ <https://www.e.gov.kw/sites/kg0English/Pages/HomePage.aspx>

⁴⁷ <https://www.moph.gov.qa/health-services/Documents/food%20Importers%20guide%20ENG%20online-oct09-2017.pdf>

⁴⁸ <http://www.mme.gov.qa/cui/view.dox?id=1460&contentID=3843&siteID=2>

Халал төхөөрсөн гэрчилгээ

Мах, махан бүтээгдэхүүн экспортлогчид Халал төхөөрсөн гэрчилгээг GSO 993 болон холбогдох стандартын шаардлагыг хангаснаар ПБХАЗ-ийн Стандартын байгууллагаас Итгэмжлэлийн Эрх авсан байгууллагаас эрх олгосон Баталгаажуулалтын байгууллагаас авсан байна. Халал төхөөрөх газрын гэрчилгээ нь мал бэлтгэх, мал төхөөрөх үйл явцыг хамаарна. Ийм гэрчилгээ олгоход мал төхөөрөх үйлдвэрүүд GSO 993 болон холбогдох стандартуудын шаардлага хангасан байна.

Халал бүтээгдэхүүний гэрчилгээ

Халал бүтээгдэхүүний гэрчилгээг ПБХАЗ-ийн Стандартын байгууллагын GSO 2055-1, GSO 2055-2, GSO 2055-3 болон холбогдох стандартын дагуу Итгэмжлэлийн Эрх авсан байгууллагын эрх олгосон Баталгаажуулалтын байгууллагаас авсан байна. Халал бүтээгдэхүүний гэрчилгээ нь мах, махан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, бэлтгэх, савлах, эцсийн бүтээгдэхүүн гаргах үйл явцыг хамаарна. Халал бүтээгдэхүүний гэрчилгээ олгоход мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрүүд GSO 993, GSO GSO 2055-1, GSO 2055-2, GSO 2055-3 стандартуудын шаардлага хангасан байна.

Мал эмнэлэг, эрүүл ахуйн гэрчилгээ

Мал эмнэлэг, эрүүл ахуйн гэрчилгээ - Мал болон малын гаралтай бүтээгдэхүүн импортлоход шаарддаг. Гэрчилгээ нь мал болон малын гаралтай бүтээгдэхүүн нь халдварт өвчинд нэрвэгдээгүйг болон эрүүл бүсээс гаралтай гэдгийг гэрчилнэ. Гэрчилгээг мал эмнэлэг, эрүүл ахуйн асуудал хариуцсан байгууллагаас авна. Импортлогч орноор хүлээн зөвшөөрөгдсөн экспортлогч орны мал эмнэлгийн эрх бүхий байгууллагаас олгосон байх шаардлагатай.

Хүнсний гэрчилгээ

Хүнсний гэрчилгээ – бүтээгдэхүүнд цикламат натри болон түүний орцгүйг тодорхойлсон гэрчилгээг лабораторийн шинжилгээг үндэслэн авсан байна.

Цахим үйлчилгээ (E-Service)

➤ САУДЫН АРАБ

Саудын Араб улс нь ПБХАЗ-ийн эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд гааль, худалдааны үйлчилгээнүүдээ цахим хэлбэрээр хөгжүүлж байгаа бөгөөд дараах хаягуудаар хандах боломжтой:

Саудын Арабын хүнс болон эмийн хяналтын газар – импортын хүнсний бүтээгдэхүүний хяналт, зөвшөөрлийн бүх төрлийн үйлчилгээ үзүүлнэ;

<https://www.sFDA.gov.sa/en/Eservices/Pages/default.aspx>

Нэг цонхны үйлчилгээний FASAH систем – импортлогч, экспортлогчдод далайн, агаарын болон хуурай газрын ачаа эргэлт, бүрдүүлэлт, агент, брокеруудын нэгдсэн санд бүртгэх, баримт бичиг бүрдүүлэх зэрэг үйлчилгээ үзүүлнэ; <https://www.fasah.sa/trade/home/en/>

Саудын Арабын гааль – Бараа бүтээгдэхүүний импорт, экспортын үйлчилгээ үзүүлнэ;

<https://www.customs.gov.sa/en/general/import-instructions>

Худалдаа аж үйлдвэрийн танхим – Бараа бүтээгдэхүүний ангилал, худалдааны зохицуулалтууд, компаниудын жагсаалт, арга хэмжээнүүд, арбитр, бүтээгдэхүүн баталгаажуулалтын үйлчилгээ үзүүлдэг; <https://www.icci.org.sa/English/Pages/default.aspx>

<https://www.chamber.sa/en/Pages/default.aspx>

➤ **КАТАР**

Катар улсын цахим Засгийн газар “HUKOOMI” – Катар улсын төрийн байгуулалт, төрийн үйлчилгээ, салбарын мэдээлүүдийг дэлгэрэнгүй авах боломжтой;

<https://portal.www.gov.qa/wps/portal/opendata>

Нэг цонхны үйлчилгээний AI-NADEEB систем – импортлогч, экспортлогчдод далайн, агаарын болон хуурай газрын ачаа эргэлт, бүрдүүлэлт, агент, брокеруудын нэгдсэн санд бүртгэх, баримт бичиг бүрдүүлэх зэрэг үйлчилгээ үзүүлнэ;

<https://www.ecustoms.gov.qa/qccsw/jsf/common/custExternalHome.jsf?lang=en>

Катарын гааль – Бараа бүтээгдэхүүний импорт, экспортын үйлчилгээ үзүүлнэ;

<http://www.customs.gov.qa/eng/index.php>

Худалдаа аж үйлдвэрийн танхим – Бараа бүтээгдэхүүний ангилал, худалдааны зохицуулалтууд, компаниудын жагсаалт, арга хэмжээнүүд, арбитр, бүтээгдэхүүн баталгаажуулалтын үйлчилгээ үзүүлдэг;

<https://qatarchamber.com/single-window-initiative/>

➤ **КУВЕЙТ**

Цахим Засгийн газар - Зарим төрийн үйлчилгээг цахим Засгийн газрын сайтаар дамжуулж авах боломжтой;

<https://www.e.gov.kw/sites/kgoEnglish/Pages/HomePage.aspx>

Кувейт улсын гааль – Бараа бүтээгдэхүүний импорт, экспортын үйлчилгээ;

<https://www.customs.gov.kw/>

Худалдаа аж үйлдвэрийн танхим – Бараа бүтээгдэхүүний ангилал, худалдааны зохицуулалтууд, компаниудын жагсаалт, арга хэмжээнүүд, арбитр, бүтээгдэхүүн баталгаажуулалтын үйлчилгээ үзүүлдэг;

<http://kuwaitchamber.org.kw/echamber/website/index.jsp?sessionID=1ebb73817de8166cc59c434fc2d0ca9b6ad097bbce5de100975b8903a57cddbc>

Кувейтийн компаниудын нэгдсэн сан;

<https://www.kuwait-toplist.com/>

Саудын Араб, Кувейт, Катар улсад бараа импортлоход дагалдах баримт бичгийн жагсаалт

I. Нэхэмжлэх (Invoice), (эхь хувь болон гурван хуулбар). Нэхэмжлэх нь экспортлогч орны Худалдаа аж үйлдвэрийн танхимаар баталгаажсан ба дараах мэдээллийг агуулсан байна:

- a. Бараа хүлээн авагчийн нэр, хаяг;
- b. Олон улсын барааг тодорхойлох, кодлох (HS) уялдуулсан системийн дагуу барааны кодыг тусгаж барааг тодорхойлоно;
- c. Нэгж бүтээгдэхүүний үнэ (Нийт дүнг аливаа хөнгөлөлтийг тооцож тусгана);
- d. Барааны тоо хэмжээ;
- e. Тооцоо хийсэн валютаар барааны дүнг тусгах;
- f. Барааг үйлдвэрлэгчийн нэр, хаяг;
- g. Худалдааны нэршил;
- h. Үйлдвэрлэгч улсын нэр;
- i. Тээврийн төрөл;
- j. Ачааг илгээх цэг;
- k. Тээвэрлэгчийн нэр;
- l. Барааны жин (цэвэр жин болон бохир жин);
- m. Баглаа боодлын тоо хэмжээ;

n. Тээврийн нөхцөл (EXW, FOB, CIF, CFR г.м.)⁴⁹.

II. Экспортлогч орны Худалдаа аж үйлдвэрийн танхимаар баталгаажсан Гарал үүслийн эрчилгээ (эх хувь). Гарал үүслийн гэрчилгээ нь дараах мэдээллийг агуулсан байна:

- a. Бараа хүлээн авагчийн нэр, хаяг;
- b. Нэхэмжлэхийн (Invoice) дугаар;
- c. Барааны тодорхойлолт (баглаа боодлын тоо хэмжээ, төрөл, цэвэр, бохир жинг зэргийг тусгасан байх шаардлагатай);
- d. Үйлдвэрлэгчийн нэр, хаяг;
- e. Үйлдвэрлэгч улсын тухай (Үйлдвэрлэлд Израиль улсын гарал үүслийн хамааралгүйг заавал тусгах шаардлагатай);
- f. Тээвэрлэгчийн нэр;
- g. Тээврийн төрөл;

III. Тээврийн бичиг баримт (эх хувиар 2). Тээврийн бичиг баримт нь дараах мэдээллийг агуулсан байна:

- a. Хүлээн авагчийн нэр;
- b. Барааны дүнг шилжүүлсэн валют;
- c. Баглаа, боодлын тоо, хэмжээ;
- d. Жин (цэвэр болон бохир) болон овор хэмжээ;
- e. Барааны тодорхойлолт;
- f. Тээврийн зардал;
- g. Ачааг хүлээн авах цэг (Порт, боомт).

IV. Баглаа, боодлын жагсаалт (Эх хувь болон 3 хуулбар). Баглаа, боодлын жагсаалт нь дараахь мэдээллийг агуулсан байна:

- a. Хүлээн авагчийн нэр, хаяг;
- b. Нэхэмжлэхийн дугаар;
- c. Баглаа боодлын төрөл, тоо хэмжээ, боодол тус бүр дэх барааны тоо ширхэг;
- d. Олон улсын барааг тодорхойлох, кодлох (HS) уялдуулсан системийн дагуу барааны кодыг тусгаж барааг тодорхойлоно;
- e. Үйлдвэрлэгчийн нэр, хаяг;
- f. Жин (цэвэр болон бохир) болон овор хэмжээ.

V. Даатгалын баримт бичиг

5.8.8. ПБХАЗ-ийн Гаалийн холбооны тарифийн зохицуулалт

ПБХАЗ-ийн Гаалийн тухай хуулиар тус орнуудад импортлох бараа, бүтээгдэхүүнүүдийн тариф 0-5 хувийн хооронд байна. Үүнд мах махан бүтээгдэхүүний тариф нь тухайн махны төрлөөс хамаарч өөр өөр байна. 2017 онд “ПБХАЗ-ийн Гаалийн холбооны 2017 онд (The Unified Customs Tariff for GCC States 2017) тогтоосон тарифийн нэр төрлөөс судалгаанд хамаарах махны төрлийн тарифийг доорх хүснэгтээс харж болно. Мах, махан бүтээгдэхүүний тарифийн квот байхгүй. НӨАТ-ын татварыг Саудын Араб улс 2018 оноос 5% тогтоож ногдуулж эхэлсэн ба Катар, Кувейт улсууд 2020 онд ПБХАЗ-ийн хүрээнд 5%-иар тогтоохоор саналаа оруулсан байгаа.

⁴⁹ Инкотермс тээврийн нөхцлүүд: https://www.ubchamber.mn/uploads/Incoterms_2010.pdf

“ПБХАЗ-ийн Гаалийн холбооны 2017 онд (The Unified Customs Tariff for GCC States 2017) тогтоосон импортын тарифийн хэсэг Хүснэгт 35.

Хүснэгт 35. Тарифын зохицуулалт

Нэгдүгээр бүлэг: Амьд мал, амьтан		
HS код	Нэр, төрөл	Тарифийн хэмжээ
01. 04	Амьд хонь, ямаа	
	Хонь	
01 04 10 10	- Үүлдрийн	Байхгүй
01 04 10 90	- Бусад	Байхгүй
	Ямаа	
01 04 20 10	- Үүлдрийн	Байхгүй
01 04 20 90	- Бусад	Байхгүй
Хоёрдугаар бүлэг: Мах, махан бүтээгдэхүүн		
02. 04	Хонь, ямааны мах, шинэ, сэврээсэн, хөлдүү	
02 04 10 00	Шинэ болон сэврээсэн хурганы гулууз, өрөөл мах	Байхгүй
	Бусад хонины шинэ болон сэврээсэн гулууз, өрөөл мах	
02 04 21 00	Гулууз болон өрөөл мах	Байхгүй
02 04 22 00	Ястай хэсэглэсэн мах	Байхгүй
02 04 23 00	Ясгүй мах	Байхгүй
02 04 30 00	Хурганы гулууз болон өрөөл мах Хөлдүү мах	5%
	Бусад хонины хөлдүү мах	
02 04 41 00	Гулууз болон өрөөл мах	5%
02 04 42 00	Ястай хэсэглэсэн мах	5%
	Ясгүй мах	
02 04 43 10	Татсан мах	5%
02 04 43 90	Бусад	5%
	Ямааны мах	
	Гулууз болон өрөөл мах	
02 04 50 11	Шинэ болон сэврээсэн	Байхгүй
02 04 50 12	Хөлдүү	5%
	Ясгүй	
02 04 50 31	Шинэ болон сэврээсэн	Байхгүй
02 04 50 32	Хөлдүү	5%

5.8.9. ПБХАЗ-ийн Гаалийн холбооны тарифийн бус зохицуулалт

Зорилтот орнуудын эрх баригчид дэлхийн зах зээлд байр сууриа бэхжүүлж газрын тосноос хэт хамааралтай эдийн засгаа солонгоруулах талаар авч буй арга хэмжээнүүдийн нэг нь худалдааны саад бэрхшээлийг багасгахад чиглэж байна. Зорилтот булангийн орнуудын худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх зорилгоор Гаалийн холбооны хүрээнд дотоод худалдааны тарифийн болон тарифийн бус саад бэрхшээлүүдийг (зарим нэр төрлийн барааны хязгаарлалтаас бусад) байхгүй болгожээ.

Дэлхийн худалдааны байгууллага, Гаалийн байгууллагын холбооны худалдааны саад бэрхшээлүүдийг багасгах талаар шаардлага, санал зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар ажиллаж 2016 онд Хүнсний импортын хяналтын удирдамжийг гаргахдаа Дэлхийн худалдааны байгууллагаар хянуулж, саналыг тусгасан байдаг юм. Зорилтот орнуудын мах, махан бүтээгдэхүүний импортын хувьд тарифийн бус зохицуулалтууд нь гол төлөв хүнсний аюулгүй байдалтай холбогдсон байдаг.


Зах зээлээ хамгаалах, экспортоо дэмжих үүднээс импортод тавих тарифийн бус зохицуулалтууд хууль эрх зүйн хүрээнд ороогүй байдаг нь тус орнууд хүнсний хангамжийн ихээхэн хувь нь импортоос хамаардагтай холбоотой (жишээлбэл хонины махны импортын квот гэж байхгүй г.м). Хүнсний аюулгүй байдал, байгаль орчны талаас тогтоосон тарифийн бус зохицуулалтууд нь дүрэм, журмын хэлбэрээр илэрдэг. Жишээлбэл: Олон төрлийн сертификатууд шаарддаг, зарим улс орнуудаас зарим төрлийн бараа бүтээгдэхүүнийг оруулахыг хориглодог г.м (Гаалийн байгууллагын дотоод дүрэмд Израил улсаас бараа оруулахыг хориглодог). Саудын Араб сүүлийн жилүүдэд мал аж ахуй, махны салбараа дэмжих бодлого гаргаж үндэсний үйлдвэрүүддээ хөнгөлөлттэй зээл олгож дэмжиж байна. Мах, махан бүтээгдэхүүн импортлогчид нийлүүлэгчдэд тавьж буй стандартын шаардлагууд (Халал), импортын эрх олгох зөвшөөрөл олгож байгаа нь тарифийн бус зохицуулалтыг хамаарч байна.

Гадаад худалдааны бараа нийлүүлэх суурь нөхцөл Инкотермс - Incoterms⁵⁰

Гадаад худалдаанд худалдах, худалдан авах гэрээ байгуулахад талуудын сонгосон Инкотермс-ийн бараа нийлүүлэх суурь нөхцлөөс хамаарч зардал, эрсдлийг хариуцах тал тогтоогдох бөгөөд энэ нь барааны үнэ бүрдэлтэнд шууд нөлөөлнө. Иймээс гэрээ байгуулах, хэрэгжүүлэх явцад гарч болох үл ойлголцол, цаг хугацаа, хөрөнгө мөнгөний алдагдлаас сэргийлэхийн тулд олон улсын худалдааны үйл ажиллагаанд өргөн хэрэглэгддэг, нийтээр хүлээн зөвшөөрч Инкотермс-ийн худалдааны нэр томъёог зөв ойлгож хэрэглэх шаардлагатай юм.


⁵⁰ Парист байрлах Олон улсын худалдааны танхимаас Incoterms-ийг боловсруулан гаргадаг бөгөөд энэ нь олон улсын худалдааны үйл ажиллагаанд оролцогч худалдагч болон худалдан авагчийн зардал, эрсдэл, үүргийг тодорхойлсон Олон улсын худалдааны нэр томъёо

Схем 4. ПБХАЗ-ийн орнуудын хилээр бараа импортлох үйл явц



ПБХАЗ-ийн орнуудын хилээр бараа бүтээгдэхүүн импортлоход хилийн боомт дээр бараа ирмэгц гаалийн зуучлагчаар эсвэл импортлогч өөрөө барааг мэдүүлнэ. Импортлогч гаалийн цахим үйлчилгээг ашиглан барааг урьдчилан мэдүүлж болох ба шаардлагатай баримт бичгүүдийг хамт өгнө. Гаалийн байгууллага барааны онцлогоос хамааран эрсдлийн үнэлгээг тодорхойлж шалгалтын хэлбэрийг сонгоно. Эхэлж баримт бичгийн бүрдлийн шалгалт хийгдэж баримт бичгийн зөрчилгүй тохиолдолд бараанд гаалийн биет үзлэг хийгдэж, лабораторийн шинжилгээнд хамруулна. Баримт бичгийн болон барааны биет үзлэгийн үеэр аливаа ноцтой бус зөрчил гарвал залруулах боломж олгодог ба зөрчлийг арилгасан тохиолдолд эрх бүхий байцаагчийн дүгнэлтээр барааг нэвтрүүлнэ.

5.8.10. Малайз Улс



Малайз улс - Үндсэн хуульт хаант засаглалтай холбооны улс. Улсынх нь албан ёсны удирдагч эзэн хааныг 5 жилийн хугацаатайгаар баруун Малайзийн 9 үе дамжсан султануудын удмаас сонгодог. Хууль тогтоох байгууллага нь 2 танхимтай Холбооны Их хурлын (Парламент) бөгөөд дээд танхим – Сенат,

доод танхим нь Төлөөлөгчдийн танхим. Сенатын гишүүдийн 1/3 тойргоос шууд сонгогддог бол 2/3-ыг Эзэн хаан шууд томилдог байна. Харин доод танхим буюу Төлөөлөгчид нь ард түмнээс намын харьяаллаар сонгогддог байна. Гүйцэтгэх засаглалыг Засгийн газар хэрэгжүүлэх бөгөөд Ерөнхий сайдыг Төлөөлөгчдийн танхимаас томилдог. Эзэн хаан Ерөнхий сайдтай зөвшилцөж кабинетаа байгуулж, сайд нараа томилдог. Ерөнхий сайд болон кабинетийн сайд нар нь Холбооны Их хурлын гишүүн байна. Хятад, Энэтхэг мөн далайн худалдаа даган ирсэн Европчуудын нөлөөллийн улмаас Малайз улсын хүн ам, урлаг соёл, худалдаа нь олон талын соёл шингэсэн онцлогтой.

Малайз (Malaysia) нь 13 муж, 3 холбооны нутгаас бүрддэг. Малайз нь Тайланд, Индонез, Сингапур, Бруней, Филиппинтэй хиллэнэ. Нийт хүн ам 32 сая бөгөөд 60 хувь нь Ислам шашинтай. Улсын газар нутаг нь Өмнөд Хятадын тэнгисээр зааглагдсан хоёр салангид, тодруулбал Энэтхэг-Хятадын хойг дахь Баруун Малайз, Калимантан арал дахь Зүүн Малайзаас бүрдэнэ.

Ойрх Дорнодын махны зах зээлийн судалгааны ажлын хүрээнд нэмэлтээр Малайз, Индонези улсуудын талаар анхан шатны нээлттэй мэдээллүүдийг боловсруулсанаар монгол малын мах экспортлох боломжит зах зээл болох магадлалтай эсэхийг тодорхойлох судалгаа хийв.

Малайз улсын хувьд Азийн орнуудын дунд ДНБ тогтвортой өсөлт (дундаж өсөлт 6,5 %), хөдөө аж ахуйн хязгаарлагдмал нөөцтэй түүний дотор мал аж ахуйн салбар маш сул хөгжсөн нь бэлчээрийн хүрэлцээгүйтэй холбоотой. Гэсэн хэдий ч аялал жуулчлалын салбар эрчимтэй хөгжиж, иргэдийн орлого нэмэгдсэн нь чанартай хоол хүнс, махны хэрэглээ өсөхөд нөлөөлж байгаа нь импортын хэмжээг нэмэгдүүлэх зүй тогтолыг бүрдүүлж байна гэж үзсэн. Мөн хүн амын дийлэнх хувь нь ислам шашинтай улсын хувьд халал аргаар бэлдсэн чанартай монгол махыг өрсөлдөхүйц үнээр экспортлох магадлал зэргийг үндэслэсэн болно.

5.8.11. Индонези Улс



Индонези – Ерөнхийлөгчийн бүгд найрамдах улс. Улсын тэргүүн нь Ерөнхийлөгч бөгөөд 5 жилийн хугацаатайгаар сонгогддог. Хууль тогтоох байгууллага нь 2 танхимтай Ардын зөвлөлдөх конгресс (Парламент) бөгөөд Ардын төлөөлөгчдийн зөвлөлийн танхим, Орон нутгийн төлөөлөгчдийн зөвлөлийн танхимаас бүрддэг байна. Гүйцэтгэх засаглалыг Засгийн газар хэрэгжүүлэх бөгөөд Ерөнхийлөгч Ерөнхий сайдын албыг давхар хашдаг. Олон намын тогтолцоотой. Нийт хүн ам 269 сая бөгөөд 80 хувь нь Ислам шашинтай.

Шүүхийн тогтолцооны ром-германы эрх зүйд хамаарах бөгөөд дээд байгууллага дээд шүүх бөгөөд иргэний, эрүүгийн, худалдааны, захиргааны гэх мэт салбар шүүхтэй. Үндсэн хуулийн цэц хууль эрх зүйн Үндсэн хуулинд нийцэж буй эсэхэд хяналт тавьж ажиллана. Индонез улсын хувьд Азийн орнуудын дунд эдийн засгийн эрчимтэй өсөлттэй хөгжиж буй оронд тооцогдож байгаа ба сүүлийн 8 жилд эдийн засгийн өсөлт нь 6% хүрээд байгаа. Мөн хүн

амын тоо нь 270 сая бөгөөд малын тоо толгой нь хүн амын тоотой харьцуулахад харьцангуй цөөн статистик үзүүлэлттэй, нийт иргэдийн 88% нь ислам шашинтай зэргийг үндэслэж зах зээлийн боломжийг нэмэлтээр судаллаа.

5.8.12. Журам, стандарт

Саудын Араб, Катар, Кувейт

Ойрх Дорнодын орнуудын хүнсний бүтээгдэхүүнд тавьдаг Халал болон эрүүл ахуйн шаардлага нь ямагт нэгдүгээрт тавигддаг чухал зүйл учраас гаднаас импортоор авдаг хүнсний бүтээгдэхүүнийг (зөвхөн хүнс биш) Халал байлгахын тулд тодорхой стандартуудыг мөрдөхийг шаардаж гүйцэтгэлд нь хяналт тавьж, үнэлж зах зээлд нэвтрүүлдэг байна. Арабын орнуудад хүнсний бүтээгдэхүүн экспортлох нь нэлээдгүй их ажил, хөрөнгө хүч, цаг хугацаа зарцуулдаг болох нь энэ судалгааны явцад харагдаж байна. Нэн түрүүнд Персийн булангийн Арабын орнуудын хамтын ажиллагааны зөвлөлийг судалж (ПБХАЗ) тэдгээр зөвлөлийн шийдвэрээр байгуулагдсан тус бүрийн өөр статустай стандарт хэмжилзүйн байгууллага, баталгаажуулалтын төв байгууллага болоод гишүүн орнуудын өөрийн баталгаажуулалтын болон стандарт хэмжилзүйн байгууллагуудыг судлах, тэдгээрийн ажлын уялдаа хамаарлыг тогтоох шаардлагатай байдаг байна. Гэвч Ойрх Дорнодын орнуудын Халал хүнсэнд тавьж буй шаардлагууд нь цэгцтэй, ойлгомжтой олон улсын жишгийн дагуу байдаг юм байна. Нэгэнт Халал хүнсэнд тавьж буй шаардлагыг хангаж, стандартад нь нийцсэн хүнс санал болгосон тохиолдолд (малын эрүүл мэндийн статус тусдаа) Монгол улсаас мах, махан бүтээгдэхүүн худалдан авах маш их сонирхолтой байдгаа шат шатны удирдлагууд илэрхийлсэн.

Булангийн орнуудын Стандарт, Хэмжилзүйн Байгууллага (СХБ)⁵¹



СХБ нь тус бүс нутгийн стандарт, хэмжилзүйн асуудлыг хариуцдаг байгууллага бөгөөд хамтын ажиллагааны зөвлөлийн (ПБХАЗ) шийдвэрээр байгуулагдсан байна. Тус байгууллага 2001 онд байгуулагдсан ч 2004 оноос үйл ажиллагаагаа албан ёсоор

эхлүүлсэн. Гишүүн орнууд нь Саудын Араб, Бахрейн, Арабын нэгдсэн Эмират, Оман, Катар болон Кувейт зэрэг улсууд юм. 2010 оноос зөвлөлийн шийдвэрээр Иемен улсыг гишүүн орноор элсүүлсэн. СХБ байгууллагын ерөнхий чиг үүрэг нь булангийн гишүүн орнуудын эдийн засаг, хамтын ажиллагааны төлөө байх бөгөөд салбар бүрт стандарт боловсруулан суулгаж тэдгээрийн биелэлт, хэрэгжилтийг хангахад оршино. Чингэхдээ гишүүн орнуудын стандарт баталгаажуулалтын байгууллагуудтай харилцан уялдаатай ажиллаж үйлдвэр, үйлчилгээний салбарыг хөгжүүлэх, үйлдвэржилтийг нэмэгдүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, байгаль орчинд ээлтэй, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилготой байдаг байна.

Стандартыг хэвшүүлж мөрдсөнөөр бүс нутгийн эдийн засаг, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх чадамжтай байх ба Булангийн орнуудын болоод Гаалийн холбоо, Нэгдсэн худалдааны байгууллагуудын шаардлагуудыг хангана гэж үздэг байна. Булангийн орнуудын стандарт, хэмжилзүйн газар (СХБ) нь зөвхөн стандартууд боловсруулж хэрэгжүүлдэг, судалж хянадаг асар том бүтэцтэй байгууллага юм. Тус байгууллагын боловсруулдаг стандартуудын талаар судалж үзэхэд дараах байдалтай байна.

⁵¹ GSO – Gulf Standardization Organization буюу Персийн булангийн гишүүн орнуудын Стандарт, Хэмжилзүйн газар



Стандартууд: Техникийн хороо, бизнесийн байгууллагууд болон гишүүн байгууллагуудын захиалгын дагуу стандартуудыг боловсруулж хэрэгжүүлдэг байна. Тус байгууллага нь ажилтнууддаа маш өндөр шалгуур тавьдаг агаад тухайн мэргэжлээр мэргэшсэн олон жилийн туршлагатай байхаас гадна зөвхөн тус салбараас сонгон дэвшүүлдэг байна. Гишүүн орнуудын хувьд СХБ-гаас боловсруулсан стандартыг авч өөрийн орны үндэсний стандарт болгон мөрдүүлдэг аж.

Түүнчлэн гишүүн орнуудын аль нэг стандарт нь СХБ ийн стандарттай харшилж байгаа тохиолдолд өөрийн стандартаа хүчингүйд тооцож СХБ ийн шинэ стандартыг албан ёсоор мөрддөг. Ийм учраас СХБ-гийн 1 стандарт нь гишүүн 7 орны үндэсний стандарт болдог байна. Тус байгууллагын стандартуудын 80 хувь нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн цахим болон тусгай төхөөрөмжүүдэд зориулагдсан электрон хувилбартай байдаг аж. Хүнсний бүтээгдэхүүний маш олон стандарт байдгаас мах, махан бүтээгдэхүүн тэр дундаа хонь, ямааны махтай холбоотой стандартуудыг хавсралтаар харуулав. /Хавсралт 2/.

ПББТ – Персийн Булангийн Арабын орнуудын баталгаажуулалтын төв



Персийн Булангийн Арабын орнуудын зөвлөлөөс “Персийн Булангийн орнуудын баталгаажуулалтын төв (ПББТ)”-ийг (цаашид ПББТ⁵² гэх) санаачлан байгуулж тус байгууллагын чиг үүргийг тодорхойлж өгсөн байна. Тус баталгаажуулалтын төвийн гол зорилго нь гишүүн орнуудын бодлого, хууль эрх зүйн хэрэгжилтийг судлан улмаар үйлдвэрлэлийг дэмжих, ажил хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, булангийн орнуудын зах зээл дээр гарч байгаа хүнсний болон бусад бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах, лаборатори болон мэргэжлийн хяналтын үйлчилгээг нэмэгдүүлж магадлан итгэмжлэх, баталгаажуулах боломжоор хангахад оршдог байна. Тус баталгаажуулалтын төв нь булангийн орнуудын хувьд болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага бөгөөд мөн асар том бүтэцтэй.

ПББТ - ийн эрх:

- ПББТ нь татгалзах, цуцлах, хардах болон өөрийн итгэмжилсэн баталгаажуулалтын байгууллагын эрхийг бүрэн түдгэлзүүлэх эрхтэй. Итгэмжлэгдсэн болон баталгаажуулалтын шалгуурыг хангаагүй, холбогдох хуулийн журмыг мөрдөөгүй, эсвэл хуурамч мэдээлэл хүргүүлж тэр нь хуурамч болох нь нотлогдсон тохиолдолд дээрх арга хэмжээг авах эрхтэй;
- ПББТ ийн тодорхой шалгуурыг хангаагүй, шаардсан мэдээллийг хүргүүлээгүй, бүх шатанд хамтарч ажиллах төлөвлөгөө гаргаагүй хүсэлт гаргагчийн материалыг баталгаажуулалтын байгууллагаас авахгүй байх;
- Шалгалтын асуумж, дэгийг өөрчлөх эрхтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд гэнэтийн шалгалт хийх нэн ялангуяа хэрэглэгчээс эсвэл байгууллагын үнэт зүйлийг мөрдөхгүй байгаа гэж сэжиглэсэн тохиолдолд зарлахгүйгээр шалгалт зохион байгуулах эрхтэй;
- ПББТ-нь хамтран ажиллаж буй баталгаажуулалтын байгууллагын үйл ажиллагааны зохион байгуулалтыг судлах, баталгаажуулалтын байгууллагыг итгэмжлэх шатанд тухайн байгууллагын байршил болон тоног төхөөрөмж, хүчин чадлыг судлах эрхтэй.

⁵² ПББТ – Персийн булангийн Арабын орнуудын баталгаажуулалтын төв

ПББТ - ийн үүрэг:

- Баталгаажуулалтын байгууллагын тухай судалгаа хийж шалгуурт нийцэх эсэхийг тодруулах нарийн төлөвлөгөө гаргаж цаг баримтлах;
- Шулуун, шударга ажиллах;
- Тухайн судалж буй баталгаажуулалтын байгууллагын мэдээллийг чандлан нууцлах/эсвэл тухайн хууль, журамд зааснаар хаах;
- Итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагад аливаа нэг өөрчлөлттэй холбоотой мэдээллийг цаг тухайд нь өгч байх;
- Итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагуудын талаарх мэдээллийг өөрийн цахим орчинд байрлуулах.

Халал магадлан итгэмжлэл гэдэг нь Халал стандартыг баталгаажуулагч байгууллагаас тодорхой бараа, үйлчилгээ нь халал стандартыг хангасан талаар гэрчилж, сертификат олгон албан ёсоор бүртгүүлэхийг хэлнэ. Манай орны хувьд магадлан итгэмжлэх эрх авч шинжээчдээ сургалтанд хамруулан өөрийн орны хүнсний бүтээгдэхүүнийг баталгаажуулан Халал хүнс экспортлох орчин бүрдүүлэх бүрэн боломжтой юм. ПББТ-ийн талаарх мэдээлэл, холбогдох хаягийг 6-р хавсралтаас харна уу.

- Манай орны мах, махан бүтээгдэхүүн экспортлогч болон экспортлохыг зорьж буй үйлдвэр, хувь хүн болон байгууллагуудад Халал Итгэмжлэл, Халал баталгаажуулалтын талаар дэлгэрэнгүй хүргэе.

Халал Итгэмжлэл болон баталгаажуулалтын байгууллагын үйл ажиллагааг тодорхой стандартын дагуу мөрдөнө.

- GSO 9 “савласан бүтээгдэхүүний хаяг, шошго”.
- GSO 993 “Исламын Шариатын хуулийн дагуу мал төхөөрөх нөхцөл”.
- GSO 21 “Хүнсний үйлдвэрийн ба үйлдвэрийн ажилтны эрүүл ахуйн нөхцөл” гм.

ПБХАЗ ын стандартын тодорхойлолт

Үндсэн шаардлага

Бүтээгдэхүүнд Халал гэрчилгээ олгох Баталгаажуулалтын байгууллага

ПБХАЗ-ийн ПББТ байгууллагын албан ёсны зөвшөөрлийг авсан байгууллага нь хүнсний зориулалттай бүтээгдэхүүнд “Халал” гэрчилгээ олгож тус бүтээгдэхүүнийг Халал мөн болохыг батлах эрхтэй болдог байна.

Магадлан Итгэмжлэх төв нь Баталгаажуулалтын байгууллагыг итгэмжилнэ

Бүтээгдэхүүнд Халал гэрчилгээ олгодог баталгаажуулалтын байгууллагыг итгэмжлэх Итгэмжлэлийн байгууллага нь Халал хүнсийг гэрчлэх үйл ажиллагаанд оролцоно.

Хяналтын байцаагч ба шалгагч

Насанд хүрсэн Мусулман хүн нь мал төхөөрөх газраас хүргүүлсэн хүсэлтийг шалгаж хянах ба тэдгээр нь Ислам шашны Шариатын хуулийн дагуу ба дээрх GSO 9, GSO 993, GSO 21 стандартуудыг мөрдөж шаардлага хангасан эсэхийг нягтална.

Халал баталгаажуулалтын байгууллагын менежер

Насанд хүрсэн Мусулман хүн нь баталгаажуулалтын Халал гэрчилгээнд гарын үсэг зурж, тамгална.

Үндсэн нөхцлүүд

- ✓ Халал баталгаажуулалтын байгууллага нь зайлшгүй итгэмжлэгдсэн байх, мөн олон нийтийн итгэлийг даасан, шаардлагуудыг бүрэн хангасан байх.
- ✓ Тус баталгаажуулалтын байгууллага нь тухайн оронд ажлын албан хаягтай, орон тооны хариуцлагатай ажилтнуудтай, мөн эцсийн Халал гэрчилгээнд гарын үсэг зурж тамгалах хүний нэр ус, албан тушаал тодорхой байх.
- ✓ Халал баталгаажуулалтын үйл ажиллагааг тогтвортой явуулах санхүүгийн чадамжтай байх, мөн бүтээгдэхүний чанар болон зорилгод сөргөөр нөлөөлж болох өөр байгууллагуудын нөлөөнд автахгүй байх.
- ✓ Хариуцлагатай өндөр албан тушаалтны удирдлаган доор ажиллах чадвартай мэргэжлийн баг бүрэлдэхүүнийг сонгон ажиллуулж Халал гэрчилгээ олгох үйл явцыг мэргэжлийн хэмжээнд явуулах.

Бүртгүүлэх ба Баримтжуулах

Баталгаажуулалтын байгууллага нь одоогийн дүрэм журмыг ягштал мөрдөх мөн дотоод үйл ажиллагааг хянаж байхын тулд баримтжуулах, тайлагнах дүрмээр ажиллана:

- ✓ Халал төхөөрч буй ажилчдын нэрсийг бичих, “Мунтакин” буюу мал төхөөрдөг Мусулман хүн болон ахлагчид ба тэдний баталгаажуулсан гарын үсэг;
- ✓ Итгэмжилсэн хяналтын ажиллагааны тайлан;
- ✓ Мал төхөөрөх газрын хяналтын ажлын тайлан;
- ✓ Олгосон Халал гэрчилгээний тоо, дугаарыг тайлагнах;
- ✓ Хамгийн чухал бичиг баримтыг сайн хөтөлж бэлэн байлгах, удирдлагад хүссэн үед нь гаргаж үзүүлэх боломжтой байх;
- Байцаагч болон ажлын хэсгийн даргад үнэмлэх олгох, тэд үйлдвэрт ажиллах хугацаандаа тогтмол зүүж явах;
- ПБХАЗ-ийн 993 стандартын дагуу мал төхөөрөх үйлдвэрийн ажилчдыг сургалтанд хамруулах;
- Халал баталгаажуулалтын байгууллага нь үйлчилгээ үзүүлэх дотоод журам боловсруулж үйл ажиллагаандаа хяналт тавих ёстой ба үзүүлж буй үйлчилгээний хөлсийг тогтоож үйлчилгээний хөлс авна;
- Халал баталгаажуулалтын байгууллага нь гэрчилгээ олгох бөгөөд гэрчилгээ олгохтой холбоотой материалыг маш сайн хадгална;
- Халал баталгаажуулалтын байгууллагууд удирдлага, ажлын ахлагч ба “Мунтакин” ажилчдаа бүтээгдэхүүнээ экспортолж буй орнууд руу явуулж судалгаа хийлгэх, туршлага солилцуулахыг зөвлөдөг байна;
- Халал баталгаажуулалтын байгууллагууд нь үйл ажиллагааны тайланг 6 сар тутамд явуулж хийж гүйцэтгэсэн ажлын чанар, олгосон гэрчилгээний тоо болон удирдлагын асуултанд хариу өгөх замаар удирдлагыг мэдээллээр хангаж үйл ажиллагаандаа үнэлэлт, дүгнэлт авахыг зөвлөдөг.

Халал Баталгаажуулалтын байгууллагыг Итгэмжлэх үйл явц

Халал баталгаажуулалтын байгууллага нь ПБХАЗ-ийн ПББТ-д хүсэлт гаргана. Хүсэлт гаргахаас өмнө тэдний тавьж буй бүх шаардлага, шалгуурыг хангасан талаар баталж өргөдөл өгөх журмын дагуу бичиг баримтаа бүрдүүлнэ. Нэгэнт шаардлага хангасан тохиолдолд итгэмжлэх олгох бөгөөд зарим тохиолдолд түдгэлзсэн хариу ирдэг байна. ПББТ-ээс ямар учраас түдгэлзүүлсэн болохоо тайлбарладаггүй байна.

Халал баталгаажуулалтын байгууллага нь ПББТ-ийн стандартуудыг маш чанд сахин биелүүлэхээ амлаж бичгээр тангараг өгөх бөгөөд GSO 993 стандартаар мал төхөөрөхдөө Исламын Шариатын хуулийг даган мөрдөж Шариатын журмаар төхөөрөх, Халал хүнс үйлдвэрлэнэ гэж бичих ёстой аж.

Тус Баталгаажуулалтын байгууллагыг хүлээн зөвшөөрч итгэмжлэл олгож байгаа тохиолдолд ПБХАЗ-ийн аль нэг орноос мэргэжилтэн ирж тус баталгаажуулалтын байгууллагын хүчин чадал, шаардаж буй нөхцлүүдийг биелүүлэх боломжтой эсэхийг газар дээр нь шалгаж танилцана. Хүсэлтийг хүлээн авч баталгаажуулалтын байгууллагыг зөвшөөрсөн тохиолдолд 2 жилийн хугацаатай сунгаж болох статустай итгэмжлэл олгох бөгөөд тус баталгаажуулалтын байгууллагын үйл ажиллагааны үр дүнг харгалзан итгэмжлэлийн эрхийг сунгана. ПБХАЗ-ийн ПББТ нь урьдаас зохион байгуулалттай эсвэл мэдэгдэлгүйгээр гэнэтийн шалгалтаар ирж итгэмжлэлийн эрхийг сэргээх, эс сэргээх, сунгах, цуцлах эрхтэй байдаг.


- Мах, махан бүтээгдэхүүний хувьд - Халал гэрчилгээ дараах мэдээллийг агуулна:
 - a) Мал төхөөрсөн өдөр, сар, жил;
 - b) Малын эрүүл мэндийн гэрчилгээний дугаар.

- Хүнсний бүтээгдэхүүний хувьд - Халал гэрчилгээ дараах мэдээллийг агуулна:
 - a) Үйлдвэрлэсэн хугацаа;
 - b) Гарал үүслийн бичгийн дугаар;
 - c) Бүтээгдэхүүний найрлаганд орсон Халал материалын тоо, тэдгээрийн гэрчилгээний хуулбар.

Халал гэрчилгээ, шошго


Халал бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй аливаа аж ахуйн нэгж, үйлдвэрүүд ХАЛАЛ хэмээх нэрийг ашиглах эрхтэй, бүтээгдэхүүндээ Халал лого нааж болох бөгөөд гагцхүү ПБХАЗ-ийн GSO 9 “Савласан бүтээгдэхүүний хаяг, шошго” стандартыг- ыг мөрдөнө.

Схем 5. Аккредитаци, магадлан итгэмжлэх үйл явцын ерөнхий зураглал



ПБХАЗ-ийн Халал баталгаажуулалтын байгууллагаас (ПББТ) итгэмжлэл авах, хамтарч ажиллах үйл ажиллагааны дэс дараалал, ерөнхий явцыг дээрхи зургаар харуулав. Хүсэлт гаргахдаа Англи хэл дээр баримтаа бүрдүүлж болно (Схем 5).


График 18. Халал баталгаажуулалтын байгууллагууд



Ойрх Дорнодын орнуудад Халал мах, махан бүтээгдэхүүн экспортолж буй улс, орнуудын талаар судалж үзэхэд ихэнх нь Исламын бус орнууд (Хүснэгт 11) байдаг. Хөдөө аж ахуйн салбар нь хязгаарлагдмал хөгжиж буй Ойрх Дорнодын орнуудын хүнсний хэрэгцээ, шаардлагыг үндэслэн өөрийн хүнсний бүтээгдэхүүнээ тогтвортой экспортлохын тулд эдгээр орнууд “Халал” хүнс үйлдвэрлэж түүнийгээ баталгаажуулдаг, баталгаажуулалтын байгууллагуудаа итгэмжлэх итгэмжлэлийн эрхийг авч олон жилийн тогтвортой үйл ажиллагаа явуулах боломжоо өөрсдөө бүрдүүлж байна.

Дээрхи график дээр (График 18) ПББТ ийн итгэмжлэлийг авч түүнтэй хамтран ажилладаг улс орнуудыг харуулсан бөгөөд экспортлогч орон болгон итгэмжлэл, баталгаажуулалтын байгууллагатай байдаг аж. Мөн түүнчлэн зарим туршлагатай орнууд Халал баталгаажуулалтыг бизнес болгон хөгжүүлсэн байдаг ба хэрэгцээ бүхий орнуудад зөвлөж үйлчилгээ үзүүлдэг байна. Энэ нь нэг талдаа сайн хэрэг боловч үйлчилгээ авч буй орнууд экспорт хийх тоолонд бусдад зүгээр мөнгө төлөх сул зардал гаргах эрсдэлтэй юм. Азийн хөгжингүй орнууд болох Гонконг, Сингапур, Малайз зэрэг орнууд өндөр хүчин чадал бүхий хүнсний лабораториудаар магадлан шинжилгээ хийж үйлчилгээ үзүүлдэг байна. Бүтээгдэхүүний Халал мөн эсэхийг баталгаажуулах үйл явцад лабораториуд заавал ордог байна.

Схем 6. Баталгаажуулалтын ерөнхий схем



Энэхүү схем зургаар Халал хүнс импортлогч болон экспортлогч орнуудын баталгаажуулалт, итгэмжлэл, стандарт, лаборатори аудитын байгууллагууд болон үйлдвэрлэгч, хэрэглэгчидийн харилцан хамаарал ба эргэх холбоог тодорхой харуулж байна.

Индонез Улс

Зүүн Азийн орнууд дотроос Индонез улс нь 269 сая хүн амтай ба Мусулман шашинтай орон. Ард иргэдийн 90 гаруй хувь нь зөвхөн Халал хүнс хэрэглэдэг онцлогтой. Индонез улс нь 2014 онд хүнсний тухай хуулиндаа өөрчлөлт оруулж 2020 оноос зах зээл дээр байгаа бүх төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг Халал байлгахгаар болж байгаа бөгөөд 2019 оны сүүлчээр шилжилтийн хугацаа дуусах болно. Индонез улсын №. 33/2014 хуулиар Халал баталгаажуулалт нь зайлшгүй шаардлага бөгөөд бүх төрлийн хүнс, ундаа, эм, гоо сайхны бүтээгдэхүүн, химийн бүтээгдэхүүн (хүний хэрэглээнд), органик болон тус улсад зарагдаж буй генийн өөрчлөлттэй бүтээгдэхүүнд хамааралтай ба дээрхи зүйлсийг үйлдвэрлэхэд ашиглаж байгаа бүх төрлийн машин, тоног төхөөрөмжинд ч шаарддаг байна. 2017 онд Халал бүтээгдэхүүний итгэмжлэлийн байгууллага нь улсын шашны асуудлыг хариуцдаг яамны харьяанд орсон байна <https://kemenag.go.id/>. Халал баталгаажуулалт нь 2019 онд албан ёсоор хэрэгжиж эхлэхээр гүйцэтгэлийг Халал итгэмжлэлийн байгууллага буюу (ХИБ)⁵³ хянаж ажиллах юм байна.

Халал гэрчилгээ олгох явц

Индонез улсад халал сертификатыг ХИБ олгодог бөгөөд бусад төлөөлөгчдөөс ирүүлсэн хүсэлтийн дагуу тэдгээр бүтээгдэхүүнүүд нь Халал мөн, биш эсэхийг батлагаажуулах явцыг Халал хяналтын байгууллага буюу “ХХБ⁵⁴” хариуцдаг байна. Мөн тус байгууллага нь тухай бүтээгдэхүүний түүхий эд болон үйлдвэрлэх явц, тоног төхөөрөмжийг шалгадаг байна. ХББ Хяналтын байгууллагыг төрийн байгууллага эсвэл улсын их сургуулиуд байгуулдаг байна. ХББ үйл ажиллагаагаа эрхлэхийн тулд ХИБ-ээр итгэмжлүүлж хамгийн багадаа 3 байцаагч ажиллуулах ба өөрийн харьяа лабораторитай байх эсхүл өөр лаборатори байгууллагатай хамтарч ажиллахыг шаарддаг. Халал баталгаажуулалтын байгууллага маш олон байдаг ба дараах холбоосоор орж мэдээлэл авах боломжтой. <https://www.hq.org/legal-articles/halal-regulation-in-indonesia-after-the-establishment-of-bpjph-law-46723>

Хориг арга хэмжээ

Халал баталгаажуулалттай холбоотой хуулийн арга хэмжээ тун хатуу байх бөгөөд Харам зүйлийг Халал болгон баталгаажуулсан тохиолдолд тухайн бизнес эрхлэгч 5 жилийн хорих ял шийтгэл хүлээх эсвэл 2 тэрбум Индонез доллароор торгуулах заалттай ажээ.

Импортын хүнсэн дэх Халал

Гадны аливаа нэг орноос импортоор орж ирсэн Халал гэрчилгээтэй халал хүнсийг хүлээн зөвшөөрдөг. Хүлээн зөвшөөрөх нь экспортлогч орон өөрийн бүтээгдэхүүний Халал мөн эсэхэд хөдөлшгүй нотолгоо гаргах, хоёр орны худалдаа хамтын ажиллагааны гэрээ бэлдэж аль нэг тал нь хариуцлага хүлээдэг зэрэг олон шат дараатай ажиллагааг хэлнэ.

⁵³ ХИБ- Халал итгэмжлэлийн байгууллага


⁵⁴ ХББ- Халал хяналтын байгууллага

6. МОНГОЛ УЛСЫН МАХНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

6.1. МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, МАХНЫ НӨӨЦ

Хөдөө аж ахуйн салбарт ажиллагчдын гуравны нэг нь зөвхөн мал аж ахуйн салбарт ажилладаг. Улсын хэмжээгээр 2018 оны эцэст 66.5 сая мал, үүнээс 3.9 сая адуу, 4.4 сая үхэр, 459.7 мянган тэмээ, 30.6 сая хонь, 27.1 сая ямаа тоологдов. Малын нийт тоо өмнөх оноос 240.3 мянга (0.4%), үүнээс адуу 229 толгой (0.006%), тэмээ 25.6 мянга (5.9%), хонь 444.5 мянга (1.5%)-аар тус тус өсөж, үхэр 7.6 мянга (0.2%), ямаа 222.4 мянга (0.8%)-аар буурчээ. 2018 онд нийт мал сүрэгт хонь 46.0 хувь, ямаа 40.8 хувь, үхэр 6.6 хувь, адуу 5.9 хувь, тэмээ 0.7 хувийг эзэлж, өмнөх оноос хонины эзлэх хувь 0.5 пунктээр өсөж, ямааных 0.5 пунктээр буурч, адуу, үхэр, тэмээнийх өмнөх оны төвшинд байна. Хөвсгөл, Дорнод, Хэнтий, Дундговь, Архангай, Сүхбаатар, Дорноговь, Увс, Сэлэнгэ зэрэг 9 аймагт малын тоо 30.1-412.1 мянгаар өсөж, Дархан-Уул, Орхон, Говь-сүмбэр, Завхан, Өмнөговь, Булган, Баян-Өлгий, Төв, Говь-Алтай, Өвөрхангай, Ховд, Баянхонгор зэрэг 12 аймаг, Улаанбаатар хотод 4.9-338.3 мянган толгойгоор буурсан байна. Хамгийн олон мал тоолуулсан аймгаар Хөвсгөл (5 сая 709.9 мянга), Архангай (5 сая 481.1 мянга, Өвөрхангай (5 сая 461.3 мянга), Хэнтий (4 сая 644.9 мянга), Төв (4 сая 582.1 мянга) аймгууд тэргүүлж байна.

График 19. Махны үйлдвэрийн нөөц, малын тоо толгой, сүргийн бүтэц



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

6.2. МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Монгол улсад үйлдвэрийн аргаар бэлтгэсэн малын мах 2017 онд 2015-2016 оныхтой харьцуулахад 2-2,6 дахин нэмэгдсэн байна. Хүнсэнд хэрэглэсэн малын 92%-ийг бог мал, 8%-ийг бод мал эзэлж байгаа бөгөөд оны эхэнд байсан адууны 13.2%, үхрийн 21.3%, тэмээний 10.4%, хонины 31.5%, ямааны 27.7%-ийг хүнсэнд хэрэглэсэн байна.

ХАА-гаас үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах, үйлдвэрлэсэн мах, дайвар, түүхий эдийн үйлдвэрлэлийн хэмжээ өмнөх онуудаас өссөн байна. Харин боловсруулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурах хандлагатай байна.

Хүснэгт 36. Мах үйлдвэрлэлийн сүүлийн 8 жилийн харьцуулсан судалгаа

Агуулга	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Нийт малын тоо, мян.толгой	32 729.5	36 335.8	40 920.9	45 144.3	51 970.4	55 957.2	61 500	66 215.8
Хонь	14480.4	15668.5	18141.4	20066.4	23214.8	24933.4	27853.4	30,108.0
Ямаа	13883.2	15934.6	17558.7	19227.6	22008.9	23582.2	25572.2	27,346.1
Хүнсэнд хэрэглэсэн малын тоо, мян.толгой	8 373.7	8 283.2	8 365.0	10205.0	10102.6	14563.7	12768.8	17689.5
Хонь	4 326.3	4 415.8	3 679.6	5 015.3	4995.5	7301.9	6254.3	8814.9
Ямаа	3 431.9	3182.8	3 952.0	4 486.6	4306.5	6094.7	5358.6	7989.8
ХАА-гаас бэлтгэсэн мах, мал төхөөрөх жингээр мян.тн	204.4	210	220.4	249.7	245.3	448.3	401.7	499.8
Хонины	77.4	78.4	67.2	92.4	92	134.6	116.2	265.8
Ямааны	49.1	44.7	56.3	64.1	61.2	86.4	86.9	144.5
Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах, мя.тн	12	13.2	19.8	23.6	15.1	12.6	8.9	24.5
Хиаман төрөл	1734.8	2204.4	2222.7	2347.2	3388.2	3987.5	4125.7	3284.1
Махан нөөш,	178.4	114.6	130.6	231.2	*	350.7	398	153.9
Бууз, банш,тн			1901.4	1646.7	1796.5	2812.6	310.6	1529.4
Малын дайвар бүтээгдэхүүн, тн	213.7	414.5	838.1	790.3	202.8	427	390	662.6

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

График 20. Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах (2017 оны эцсийн байдлаар)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХАА-н салбар нь Монгол орны нийгэм эдийн засгийн тэргүүлэх чиглэл юм. Манай мал сүрэг өсөж 2017, 2018 онд 66 гаруй сая толгой малтай боллоо. Энэ нь жилд 600-700 гаруй мянга тонн мах үйлдвэрлэх нөөц байгаа бөгөөд Эрдэнэт, Оюу Толгой, Таван Толгойгоос олох орлогоос ялгаатай нь дуусахгүй, нөхөн төлжих орлогын эх үүсвэр билээ. Малын ашиг шим, таваарлаг чанар, ус, бэлчээрийн даацыг тэтгэх, малчны орлогыг нэмэгдүүлэх үүднээс малын зарлагыг жил жилээр төлөвлөн эргэлтэд оруулах зайлшгүй шаардлагатай байна. Монголын мах үйлдвэрлэл 70 жилийн түүхтэй, багагүй хүчин чадалтай, Азийн орнууд дундаас доогуур орохооргүй өнгө төрхтэй. 2018 оны байдлаар, манай улсын хэмжээнд үйлдвэрийн аргаар

мал төхөөрөх шугам, хөргөлтийн систем бүхий махны үйлдвэр 53, мал төхөөрөх цех 27, хөргөлт, хадгалах агуулахтай, мах шулж, ангилан савлах үйлдвэр 20 гаруй, итгэмжлэл бүхий мах боловсруулах үйлдвэр 10 гаруй, хагас боловсруулсан ба бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх 130 гаруй цех, нийт 230 гаруй үйлдвэр, цех ажиллаж байна.

Үйлдвэрийн барилга байгууламж, технологи эрүүл ахуйн нөхцөл нь махны хяналтын олон улсын шаардлагыг хангасан мал төхөөрөх үйлдвэр гарын таван хуруунд багтааар байна. Тоо баримтаар харуулбал “AAA”, “AA” зэргийн итгэмжлэлтэй 43 үйлдвэр, HACCP нэвтрүүлсэн 9 үйлдвэр, үүний хоёр нь олон улсын итгэмжлэлтэй, ISO9001 чанарын удирдлагын шаардлага хангасан 4, ISO 22000:2007-ын итгэмжлэлтэй 3 үйлдвэр, нийт үйлдвэрийн 25% экспортын эрх авсан, 32 үйлдвэр дотоод хяналтын лабораторитой, 7% нь MNS/ISO 17025 стандартын дагуу лабораторио итгэмжлүүлсэн байна. Энэ нь нийт үйлдвэрийн 7% нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ чанар, аюулгүй байдлыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн нөхцөлд баталгаажуулж байна гэсэн үг юм.

Хүснэгт 37. Махны үйлдвэрүүдийн техникийн чадавхи

Бүртгэлтэй мал төхөөрөх, мах ангилан савлах, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийн тоо		230
Мал төхөөрөх, мах эхлэн боловсруулах үйлдвэр		53
Мал төхөөрөх цех (ААН, иргэд)		17
Шулж ангилах, савлах үйлдвэр		20
Боловсруулах	Боловсруулах үйлдвэр /Итгэмжлэгдсэн/	9
	Боловсруулах цех	97
	Хагас боловсруулах цехтэй ААН, иргэд	34
Хөргөлтийн хүчин чадал /тн/хоног	Сэврээх	3,500
	Хөлдөөх	26,490
	Хадгалах	80,737
Үйлдвэрийн хүчин чадлын ашиглалтын хувь		43,385
“AAA” итгэмжлэлтэй		19
“AA” итгэмжлэлтэй		24
HACCP хэрэгжүүлсэн		7
ISO 9001 хэрэгжүүлсэн		4
ISO 22000 хэрэгжүүлсэн		3
Дотоод хяналтын лабораторитой		32

Хэдийгээр махны үйлдвэрийн тоо нэмэгдэж байгаа ч хөгжлийн зөв чиг хандлага бүрэлдэхгүй байна, тухайлбал:

- Малын гоц халдварт өвчний дэгдэлт байнгын шинжтэй, давтамжит хугацаа нь ойрхон болсон;
- Мал бэлтгэлийн төвлөрсөн систем үгүй болсон;
- Махны үйлдвэрүүдийн эрүүл ахуй, эцсийн бүтээгдэхүүний аюулгүй байдлын баталгаажуулалт шаардлага хангахгүй;
- Шинээр байгуулагдаж буй үйлдвэрүүдэд мал эмнэлгийн болон технологи- эрүүл, аюулгүйн хяналт сул байна;
- Хэдийгээр нийт мал сүргийн тоо нэмэгдэж байгаа ч махны экспортод чухал байр суурь эзэлдэг үхэр сүргийн тоо толгой сүүлийн 30 жилийн турш нийт мал сүргийн 6%-аас хэтрэхгүй байна;
- Малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлаас үүдэлтэй дэлхийн худалдаанд учирдаг саад тотгор нэмэгдэж, малын эрүүл мэнд, махны эрүүл ахуй, аюулгүй байдлыг олон улсын шаардлагад нийцүүлэх үүрэгтэй мал эмнэлгийн хяналт

цэгцтэй хэрэгжихгүй байна;

- Махны бизнес эрхлэгчид үнийн нэгдсэн бодлого байхгүй байгаагаас санхүүгийн эрсдэлд өртөх магадлал байна;
- Гадаад зах зээлд мах бэлтгэх цөөн үйлдвэрт өндөр шаардлага тавьж, бусад үйлдвэрийг кластераар хөгжүүлэхэд ихээхэн анхаарах шаардлагатай байна.

Нийт махны дөнгөж 15 орчим хувийг үйлдвэрийн аргаар бэлтгэж байна. Гэтэл махны үйлдвэр, цехүүдэд суурилагдсан хүчин чадлаар тооцож үзвэл нийт мах бэлтгэлийн 50-60 хувийг үйлдвэрийн аргаар бэлтгэх боломжтой байна. Мал төхөөрөх, мах боловсруулах технологи-эрүүл ахуйн шаардлага хангасан үйлдвэргүйгээр махны үйлдвэрлэл, экспортыг хөгжүүлэх болон эцсийн бүтээгдэхүүний аюулгүй байдлын баталгаажуулалтыг олон улсын шаардлагад нийцүүлэх боломжгүй юм.

Монгол дахь Халал бүтээгдэхүүн үйлдвэрлэл

Монгол улс 2010 оноос эхлэн Исламын Бүгд Найрамдах Иран улс, Катар, Кувейт зэрэг орнуудад Халал аргаар бэлтгэсэн хонины махыг экспортолж эхэлсэн хэдий ч Халал стандартыг албан ёсоор баталгаажуулсан үйлдвэр байгаагүй юм. Тухайн импортлогч улсын эрх бүхий байгууллагын төлөөллийн хяналтан дор халал үйлдвэрлэл явагдаж ирсэн. 2018 оны эхний 10 сарын байдлаар Катар, Малайз, Иран, Арабын нэгдсэн Эмират улсуудад 1269 тн буюу 4,981 сая долларын бүтээгдэхүүнийг экспортлоод байна.

Хүснэгт 38. Халал аргаар бэлтгэсэн хонь ямааны махны экспорт (2018 оны 12 сарын байдлаар)

№	Улсууд	Компанийн нэр	Нэр төрөл	Тоо хэмжээ/кг/	Үнийн дүн USD
1	Катар	Аллилайс ХХК-ГХО	Хонь, ямаа	430	1,290
2	Малайз	Хөвсгөл мах маркет	Хонины ангилсан мах	86,520	178,040
3	Иран	Дархан мийт ХХК	Хонины ангилсан мах	562,228	2,526,271
4	Иран	Мах маркет ХХК	Хонины ангилсан мах	340,113	1,457,982
5	Иран	Мах импекс	Хонины ангилсан мах	13,844	41,832
6	Иран	Натурал грийн фүүдс	Хонины ангилсан мах	37,956	91,094
7	Эмират	Эм эн би консталтинг	Хонины ангилсан мах	252	1.386
8	Иран	Зергер интернейшл	Хонины ангилсан мах	228,000	684,000
9	Нийт дүн			1,269,343	4,981,895

Эх сурвалж: Монголын гаалийн газрын статистикийн мэдээлэл <http://www.customs.gov.mn/>

Монгол улс 30 гаруй сая толгой хоньтой бөгөөд жилд дунджаар 3 сая орчим төл мал авдаг. Халал мах хэрэглэгч улсууд хурга болон төлөгний мах ихэвчлэн сонирхдог бөгөөд 2018 онд 130,000 толгой хонины мах экспортолсон бөгөөд энэ нь нийт төлийн 4,3%-ийг эзэлж байгаа нь цаашид тогтвортой өсөх боломжтой, экспортын нөөц юм.

6.3. МАХНЫ ЭКСПОРТ

Сүүлийн 10 жил тогтмол буурсан махны экспорт 2017 оноос эхлэн ихээхэн нэмэгдэж 2018 онд 70.3 мянгад хүрсэн байна. 2018 онд адууны мах 32.2 мян. тн, үхэр 1.1 мян. тн, хонь 4.6 мян. тн, ямаа 1.5 мян. тн, дайвар түүхий эд 1.6 мян. тн, дулааны аргаар боловсруулсан мах 29.2 мян. тн-ыг экспортолсон байна. 2017 онд өмнөх оноосоо хонь ямааны махны экспорт хоёр дахин өсөж, адууны мах болон утсан, хатаасан мах, дайвар бүтээгдэхүүний экспорт тус бүр дөрөв дахин нэмэгджээ.

Хүснэгт 39. Хонь, ямааны махны экспортын судалгаа /оноор/

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Экспортолсон амьд мал	5,453	41	41	47	73	9,020	6,472	117
1 Хонь								
Махны экспорт (мян/тн)	25.8	10.6	3.7	3	2.3	4.7	9.7	29.3
2 Хонь	11.1	0.8	0.7	0.4	0	0	0.5	2.3
Ямаа	0	0	0.5	0	0	0	0.3	1.6

Эх сурвалж: Монголын гаалийн газрын статистикийн мэдээлэл

Гаалийн ерөнхий газрын мэдээллээр 2017 онд 260.2 тонн хонь, ямааны мах экспортолж 8267 ам. долларын орлого олсон нь өнгөрсөн оныхоос 2.4 мянган тонн, 7.9 сая ам. доллароор илүү байна. Нэг тонн хонь, ямааны махны экспортын дундаж үнэ 2739 ам. доллар болсон нь 2016 оныхоос 109.2 хувиар өндөр байна. 2017 оны мах, махан бүтээгдэхүүний экспортын нийт орлого есдүгээр сарын байдлаар 30 сая ам. долларт хүрсэн байна.

Махны экспорт – Ойрх Дорнодын Иран, Төв Азийн орнууд


Монгол Улсаас Исламын Бүгд Найрамдах Иран Улсад хонины хөлдүү болон сэврээсэн мах экспортлох үеийн хорио цээр, мал эмнэлэг ариун цэврийн шаардлагыг 2009 онд албан ёсоор ирүүлсэн байна. Тусгай хэлэлцээр, протокол байгуулаагүй. Энэ шаардлагын дагуу Монгол Улсын мал төхөөрөх үйлдвэрүүдэд Ираны холбогдох мэргэжилтэн ирж мал төхөөрөх ажиллагаанд хяналт тавьж экспортолдог. 2010 онд 1489.2 тн, 2011 онд 30.0 тн, 2012 онд 53.6 тн, 2013 онд 336.4 тн хонины мах экспортолсон бол 2010 онд 580.0 тн, 2011 онд 234.0 тн ямааны мах экспортолсон байна. Иранд мах тээвэрлэх тээврийн зардал маш өндөр байдаг бөгөөд 2013 онд Баян-Өлгий аймагт шүлхий өвчин гарсан шалтгаанаар махны экспорт түр зогссон байна.

Киргиз, Азербайжан улсуудтай мах, махан бүтээгдэхүүн экспортлох нөхцөлийн талаар хэлэлцээр, протокол байгуулаагүй боловч Киргиз улсад 2011 он 50 тн хонины мах, 542.5 тн ямааны мах, Азербайжанд 2013 онд 55 тн хонины мах экспортолсон нь шинэ зах зээлийн боломж байгааг харуулж байна.

7. МОНГОЛ МАЛЫН МАХНЫ ЭКСПОРТОД ТУЛГАМДАЖ БУЙ БЭРХШЭЭЛҮҮД

7.1. МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД

Зураг 5. 2019 оны байдлаар ДМАЭМБ-ын гишүүн орнууд дахь шүлхий өвчний статус.



Саудын Араб улс жил бүр 6 сая гаруй хивэгч мал хүнсний зориулалтаар импортлодог. Шүлхий өвчин 2012-2014 гараад 2015 онд бүртгэгдээгүй, 2016 оноос хойш зэрлэг амьтны ба гэрийн тэжээвэр амьтны шүлхийн тохиолдол мэдээлэгдсээр байна. Богийн мялзан болон цэцэг өвчин гэрийн тэжээмэл амьтанд 2016-2017 тохиолдсон. Зэрлэг амьтанд мэдээлэлгүй байна. **Кувейтэд** шүлхий өвчин 2012- 2013 – 2014 онд гараад, хамгийн сүүлд 2016 оны 1-2-р сард илэрсэн, Богийн мялзан болон цэцэг өвчний голомттой хэдий ч богийн мялзан

2009 оны 11 сараас, цэцэг өвчин 4 сараас хойш мэдээлэгдээгүй байна.

Булангийн орнууд 2019 онд шүлхий өвчний байдлаар ДМАЭМБ-ын албан ёсны статусд хамрагдаагүй, манай орон шүлхий өвчний сэжигтэй оронд хамаарагдсан байна (зураг 5).

Катар улсад зэрлэг амьтны шүлхий өвчин 2012- 2013 онд гарч, хамгийн сүүлд 2015 оны 10 сард мэдээлэгдсэн, гэрийн тэжээвэр амьтны шүлхий мэдээлэгдээгүй байна. Гэрийн тэжээмэл ба зэрлэг амьтанд богийн мялзан, цэцэг өвчин бүртгэгдээгүй байна.


Малайз улсын Сабах Сарабах муж шүлхий өвчнөөс эрүүл бүсийн статустай хойт мужид 2016 оноос гэрийн тэжээвэр амьтанд бүртгэгдсэн байна. Зэрлэг амьтанд 2016 оноос хойш мэдээлэгдээгүй байна. Богийн цэцэг, бүртгэгдээгүй мялзан өвчин 2015 онд мэдээлэгдсэн байна.

Манай улс 2000 оноос эхлэн малын гоц халдварт шүлхий, бог малын мялзан, гахайн африкийн мялзан зэрэг олон улсын худалдаанд хориг тавигддаг өвчин гарч, био аюулын эрсдэлтэй оронд тооцогдох боллоо. Малын эрүүл мэндийн статусыг судалж, тайландаа тусгах болсон шалтгаан нь ДМАЭМБ-ын гишүүн Монгол улс түүний гишүүн 180 орны нэгэн адил малын гоц халдварт өвчний эсрэг арга хэмжээг, олон улсын эрх ашгийн үүднээс энэ байгууллагын гаргасан удирдамж, Дэлхийн хуурай газрын мал амьтны эрүүл мэндийн код, дагалдах стандарт зааврын дагуу хэрэгжүүлэх ёстой. Мөн Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орнуудын заавал дагаж мөрдөх гэрээ, хэлэлцээрүүдийн хүрээнд Монгол улс нь мал, амьтны эрүүл мэнд, малаас хүнд халдварладаг өвчнөөс сэргийлэх олон улсын стандарт, удирдамж, заавар, зөвлөмжийг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Нөгөөтэйгүүр судалгааны зорилтот Саудын Араб, Катар, Кувейт улсуудын мал амьтны халдварт өвчний статус нь Дэлхийн худалдаанд хориг тавигддаг малын халдварт өвчний манай орны байдал, экспорт, импортын шаардлагыг уялдуулахад чухал ач холбогдолтой. Учир нь мал амьтны халдварт өвчний ижил статустай орнууд ДМАЭМБ-ын бус тухайн Мал эмнэлгийн байгууллагуудын харилцан тохиролцоо, шийдвэрээр экспорт, импорт хийх боломжтой байдаг билээ.

Саудын Араб, Катар улсуудын зүгээс Монгол улсаас амьд мал, мах импортлоход хориг тавьсан байна. (Зураг 6)

Зураг 6. Саудын Араб Улсын Хүнс, Эрүүл мэндийн яамны веб хаягт Монгол оронд тавьсан хоригийг харуулсан байдал.



Катар улс ДМАЭМБ-ын хамгийн сүүлийн мэдээнд тулгуурлан Монголоос амьд мал, мах, махан бүтээгдэхүүн авахгүй байхаар хориг тавьсан орнуудын жагсаалтын 19-д бичсэн байна (Зураг 7).

Зураг 7. Катар улсын хүнс, эрүүл мэндийн яамнаас Монгол оронд тавьсан хориг.

Ministry of Public Health Port Health and Food Control Section		وزارة الصحة العامة قسم صحة المنافذ ومراقبة الأغذية		List of Banned Imported Foodstuff to Qatar قائمة المواد الغذائية المحظور استيرادها إلى دولة قطر	
م	country / State	Foodstuff	Justification	Details of Ban	Update
19	Mongolia	Cow/veal ,Sheep and goat meat and meat products	The prevalence of foot-and-mouth disease (FMD), based on the latest reports of the Animal Health Organization (OIE)	Importing mentioned meat and meat products accepted within these requirements: 1. Meat must be deboned and eviscerated or 2. Meat and meat products must be heat treated with sufficient temperature to kill the virus..	28 March 2019

For more information, please contact on: 0097444070226, 0097444070209, 0097444070210, 0097444070236 / port.health@moph.gov.qa
لمزيد من المعلومات يمكن التواصل على:


Хэдий хориг тавьсан ч холбогдох байгууллагад тавьсан бидний нэмэлт лавлагаа, асуултын хариуд мах, махан бүтээгдэхүүнийг дараах шаардлагуудыг хангасан тохиолдолд импортлох боломж байгаа тухай тайлбар өглөө: Үүнд:

- Махыг яснаас нь салгасан ба гэдэс дотрыг нь арилгасан тохиолдолд;
- Мах, махан бүтээгдэхүүнийг өндөр хэмд дулааны аргаар боловсруулж вирусыг устгасан тохиолдолд.

Дээрхи хоёр шаардлагыг биелүүлж бүтээгдэхүүнээ Халал мөн болохыг баталж байгаа тохиолдолд Катар улсад мах, махан бүтээгдэхүүн экспортолж болохоор байна. Өвчнийг устгасан, тархалтыг хязгаарласан, эсвэл үргэлжлэн гарч байгаагаас үл хамааран улс орнууд амьд мал, малын гаралтай бүтээгдэхүүнийхээ олон улсын худалдааг зогсоохгүй байх, улмаар тогтвортой өргөжүүлэх үүднээс ДМАЭМБ-ын зөвлөмж, зааварчилгааг баримтлан улс орноо бүхэлд нь биш тодорхой бүс нутгаа гоц халдварт өвчнөөр тайван болгох, түүнийгээ өөрийн мал эмнэлэг болон ДМАЭМБ-д тайлагнах, үнэлүүлж шалгуулснаар эрүүл бүс нутгаа эсвэл “хамгаалагдсан” аж ахуйн системээ импортлогч тал болон ДМАЭМБ-д хүлээн

зөвшөөрүүлэх арга зам байна. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд Монгол улсын Засгийн газраас тусгаарлагдсан эрүүл бүс байгуулах шийдвэр гаргасан байдаг. Монгол улс 2017 онд ДМАЭМБ-ын Хуурай газрын амьтны эрүүл мэндийн кодын 8-р бүлгийн заалтуудын дагуу шүлхий өвчний албан ёсны хяналтын хөтөлбөрөө батлуулсан гишүүн оронд бүртгэгдсэн. Шүлхийн вирусын эсрэг эсрэгбиеийн бүтцийн бус уургийн тандан судалгааг тогтмол хийж, шүлхийтэй тэмцэх арга хэмжээ, стратеги төлөвлөгөөгөө өөрчлөн, ДМАЭМБ-ын зөвлөмжөөр ажиллаж байна.

Зураг 8. Шүлхий өвчин, нөхцөл байдлыг харуулсан зураглал



Сүүлийн 2 жилийн тандан шинжилгээгээр Монгол орны баруун бүсийн мал сүрэгт шүлхий өвчний вирусын байгалийн голомт илрээгүй байна (зураг 8).

Шүлхийн вирусын бүтцийн биш уураг (NSP-Ab)-ийн шинжилгээ нь ДМАЭМБ-ын зөвшөөрөгдсөн тандан шинжилгээний арга юм.

7.1.1. Малын өвчнөөс эрүүлжих арга зам

Монгол Улсын Засгийн газраас 2017 онд “Малын гоц халдварт өвчингүй, хорио цээрийн тусгаарласан бүс байгуулах тухай” 284 дүгээр тогтоол батлан гаргасан. Тогтоолыг хэрэгжүүлэн, малын гоц халдварт өвчнөөр тйван орон болох, олон улсын худалдаанд чөлөөтэй оролцох төрийн бодлогыг хэрэгжүүлэх үүднээс МЭҮГ (хуучнаар)-ын даргын 2018 оны 04-р сарын 24-ны өдрийн А/17 тоот “Малын гоц халдварт өвчингүй, “хамгаалагдсан”⁵⁵ аж ахуйд мөрдөх мал эмнэлэг, хорио цээрийн зааварчилгаа”-г гарган хэрэгжүүлж эхлээд байна. Эдгээрийг хэрхэн хийж, хэрэгжүүлэх талаар Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага (ДМАЭМБ), Хуурай газрын мал амьтны эрүүл мэндийн олон улсын кодоод тодорхой заасан байна.


Үүнд:

- 4-р бүлэг, 4.1 Малын бүртгэлжүүлэлт, мөшгилт;
- 4.2- Бүртгэлжүүлэлт, мөшгилтийг хэрэгжүүлэх зарчим, аргачлал;
- 4.3- Бүсчилэх тусгаарлах тухай;
- 5-р бүлэг. Экспорт, импорт дэх мал эмнэлгийн гэрчилгээ, баталгаажуулалт;
- 5.3-Малын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ;
- 6-р бүлэг-Нийтийн эрүүл мэнд мал эмнэлгийн үйлчилгээ;

⁵⁵ “Хамгаалагдсан” – Олон улсын санхүүгийн хамтын ажилдаа (IFC)-ны байгууллагын санаачлагаар НҮБ-ийн ХХААБ, Мерсикор ОУБ, Мал эмнэлгийн ерөнхий газраас “Тусгаарлагдсан аж ахуй” (Compartmentalization)-ын тухай ойлголт, нэршлийг “Хамгаалагдсан аж ахуй” гэж ойлгох, нэрлэхээр тогтоосон.

- г. 6.2-Хүнсний аюулгүй байдал дахь мал эмнэлгийн үйлчилгээ;
- h. 6.3- Биоаюулгүй байдлын хяналт;
- i. 6.4- Малын эрүүл мэнд, тэжээлийн хяналт;
- j. 7-р бүлэг-Хүнсний малыг арчлах, хамгаалах,
- к. 8.8-Шүлхий өвчний үеийн тусгаарлалт зэрэг бүлгийн холбогдох зүйл заалтыг харгалзан эрүүл бүс тогтоох (Diseases free zone) ба “Хамгаалагдсан” аж ахуйн (Compartmentalisation), системийг авч хэрэглэснээр хүнсний аюулгүй байдлын тогтолцоог бий болгож болно.

Зураг 9. Малын гоц халдварт өвчнөөс эрүүл бүс тогтоох зураглал



Тодорхойгүй бүсээс хамгаалах зурвас, завсарын бүс, эрүүл бүс түүний орц гарцыг тогтоосон, хаягласан байна.

Эрүүл бүс гэж гоц халдварт өвчний голомтгүй, эпидемиологийн давуу тал бүхий газар зүйн нөөцөд тулгуурлан МЭЕГ болон ДМАЭМБ-аар үнэлгээ баталгаажуулалт хийлгэж, зөвшөөрөл авсан бүс нутаг (тодорхой улс, орон нутгийн хүрээнд) гэж ойлгож болохоор байна. Эрүүл бүсийг хаягжуулж замын дагуух орц, гарц бүхий газруудад хүмүүст харагдахуйц таних тэмдэг тавина. Энэ бүхэн мал

эмнэлгийн байгууллагын тодорхой шийдвэрийн дагуу хийгдэнэ. Тодорхойгүй бүс гэдэг нь хяналт тавих боломжгүй, шүлхийгийн тандалт шинжилгээнд хамаарагдаагүй газар нутаг. Завсарын бүс нь хяналт, тандалт шинжилгээнд орсон мал бүхий эрүүл бүсийг хамгаалах зурвас нутаг гэж ойлгож болно. Тусгаарлалт гэдэг нь тодорхой өвчнийг хязгаарлах, малын гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн үйлдвэрлэлийн систем, дэд бүтэц, өвчний тандалтын хүчин зүйлтэй холбоотой био аюулгүй ажиллагаа юм. “Хамгаалагдсан” аж ахуй нь газар зүйн байрлалын хувьд бусад мал амьтан, зэрлэг амьтнаас тусгаарлагдсан, Мал эмнэлгийн байгууллагаар үнэлгээ баталгаажуулалт хийлгэж, био аюулгүй үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж гэж ойлгоно (зураг 9).

Зураг 10. Хамгаалагдсан аж ахуйн загвар



Хамгаалагдсан аж ахуй нь Мал хүлээн авах, хорио цээр, малын тэжээллэг, арчилгаа, маллагааны хэсэг гэсэн үндсэн гурван хэсгээс бүрдэх ба хадлан, бэлчээрийн талбай, туслах байгууламжууд болон дэд бүтцээс бүрдэнэ (зураг 10). Энд өвчний тандалт, малын ялган бүртгэлжүүлэлт, мөшгилт, малын хөдөлгөөн, халдварт өвчний эпидемиологи, зэрлэг амьтан болон байгаль орчны нөлөө, бүтээгдхүүн үйлдвэрлэл ба био аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн горим зэргийг хамруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Хамгийн чухал нь “хамгаалагдсан”

аж ахуй, мал эмнэлэг хоёр хамтарч ажилласнаар үр дүнд хүрнэ. Гишүүн орон өөрийн орны нутаг дэвсгэр дээр нэг ба түүнээс олон бүс, тусгаарлалт хийж болно (4.3.2). “хамгаалагдсан” аж ахуй болон мал эмнэлэг, мал эмнэлгийн лабораториудын ажил үйлчилгээ нэг цул болж шударга ажиллах гол үүрэгтэй (хуурай газрын код 3.1, 3.2) өвчний тандалт, тайлагналт, лабораторийн оношлогоо, холбогдох вакцинжуулалт зэрэгт аудит хийнэ. (4.3.3). Хамгаалалтыг хийхдээ бусад мал амьтнаас аль болох хол: тухайлбал - зэрлэг ан амьтан

тэдгээрийн зам, гүйдэл, төхөөрөх болон мал амьтны дайвар эрхтэн боловсруулах үйлдвэр, малын тэжээлийн цех, худалдааны зах, үзэсгэлэн худалдаа, ХАА- н арга хэмжээ, мал амьтны уралдаан тэмцээн, амьтны хүрээлэн, цирк, зэрэг мал амьтан цуглаж болох газруудаас хол (4.4.3), ойролцоогоор 3км-ын тойрогт байна (МЭЕГ заавар). Мөн ДМАЭМБ-ын хуурай газрын мал амьтны эрүүл мэндийн кодын 6-р бүлгийн дагуу хүнсний аюулгүй байдал дахь мал эмнэлгийн үйлчилгээг хэрэгжүүлнэ. Чанарын хяналтын шаардлага хангасан албан ёсны лаборатори дээжинд шинжилгээ хийнэ. Лабораторийн шинжилгээний дүн нь өвөрмөц өвчинд хийх лабораторийн шинжилгээтэй нийцэж байна. Лаборатори бүр мал эмнэлгийн эрх бүхий байгууллагад шинжилгээний дүнг шууд мэдээлэх системд холбогдсон байна. (4.4.6; 4.4.8). Энэхүү шаардлагаас харахад махны үйлдвэрлэл экспорт болон Халал бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон эцсийн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын баталгаажуулалтанд өндөр түвшний лаборатори зайлшгүй хэрэгтэй байна.

Дэлхийн худалдаанд хориг тавигддаг өвчний таагүй статустай боловч, олон улсын энэхүү хууль, мөн хөрш зэргэлдээ орны туршлагыг хэрэгжүүлэн амьд мал, малын гаралтай бүтээгдэхүүнийхээ олон улсын худалдааг үргэжлүүлэх боломж, өргөн уудам газар нутагтай Монгол оронд хангалттай байна.

7.1.2. Малын эрүүл мэнд- хууль эрх зүй

Монгол Улсын малын эрүүл мэндийг хамгаалах эрх зүйн орчин “Мал, амьтны эрүүл мэндийн тухай” шинэ хуулийг 2018 оны 06 дугаар сарын 01-нээс эхлэн хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн. Энэ хууль хэрэгжсэнээр тандалт, судалгаанд тулгуурлан мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, Мал эмнэлгийн салбарын бодлого, түүний хэрэгжилт, удирдлага, хяналт, үйлчилгээний нэгдмэл байдал хангагдаж, малын гаралтай бүтээгдэхүүнд хяналт тавих таатай нөхцөл бүрдэнэ. Дотоод, гадаад зах зээлд нийлүүлж байгаа бүтээгдэхүүний эрүүл ахуй, аюулгүй байдлын шинжилгээ, эргэн мөшгөх тогтолцоо бүрэлдэж, махны хяналтыг дэлхийн стандартын шаардлагад нийцүүлэх МЭ-ийн үндсэн зорилго биелэнэ. Хуулийг дагалдан гарах 200 гаруй дүрэм журам, заавар нь хуулийг хөдөлгөх хүч болж чадна гэж үзэж байна.

Хуулийн дагуу малчид, малын эзний үүрэг хариуцлагыг өндөржүүлж, малын халдварт өвчнийг эрт илрүүлэн шуурхай хариу арга хэмжээ авах, мал сүргийнхээ эрүүл мэндийг тогтмол хянах, өвчингүй, тайван байдлаа хадгалах эрх зүйн орчин бүрэлдэж байна.

“Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагааны MNS5368:2018 стандарт” батлагдлаа. Энэ стандарт нь мал эмнэлгийн нэгжийн удирдлагын ба техникийн шаардлагыг тогтоосон байдаг. Эдгээр хууль эрх зүйн баримт бичгийн ач холбогдол нь мал амьтны халдварт өвчний голомтын тоо бууруулж, улмаар олон улсын худалдаанд саад тотгор үүсгэдэг гоц халдварт өвчингүй, эрүүл статустай бүс нутгийн хэмжээ нэмэгдүүлэхэд оршино.

Ойрх Дорнод болон зарим улс оронтой мал эмнэлгийн нөхцөл тохирсон байдал:

2018 оны байдлаар манай улс гадаад худалдааны харилцаатай орнуудаас ОХУ, БНКАЗУ, БНХАУ, Япон, Украин, БНСВУ, Арабын БН Эмирт Улс гэх мэт 18 улстай мал эмнэлгийн салбарт хамтран ажиллаж, 39 нэрийн хэлэлцээр, харилцан ойлголцлын санамж бичиг, 19 оронтой 47 нэрийн мал, амьтан тэдгээрийн гаралтай тэжээл, түүхий эд, бүтээгдэхүүнд мал эмнэлгийн ариун цэвэр, эрүүл мэндийн гэрчилгээ, шаардлага, нөхцлийг харилцан тохиролцсон. Үүнээс Ойрхи дорнодын орнуудтэй тохирсон баримт бичгийг дурьдвал:

Исламын Бүгд Найрамдах Иран Улс: Монгол Улсаас Исламын Бүгд найрамдах Иран Улсад хонины хөлдөөсөн болон хөргөсөн мах экспортлох үеийн хорио цээр, МЭАЦ-ийн шаардлага (2009); Исламын БН Иран Улсад хонины мах экспортлох үеийн эрүүл ахуйн шаардлага (2010).

Арабын Бүгд Найрамдах Египет Улс: Монгол Улсын Засгийн газар, Арабын БН Египет Улсын Засгийн газар хооронд мал эмнэлэг, хорио цээрийн салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг (2006.05.15).

Катар Улс: Монгол Улсын Засгийн газар, Катар Улсын Засгийн газар хооронд мал эмнэлэг, хорио цээрийн салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг (2007.11.29).

Кувейт Улс: Мал эмнэлэг, хорио цээрийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Кувейт Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр (2011.01.04).

Малын гоц халдварт өвчинтэй тэмцэх талаар хийгдсэн ажил, тэдгээрийн үр дүнг товчлон дүгнэвэл:

- Монгол улс 2016 онд ДМАЭМБ-ын Хуурай газрын кодын 8-р бүлгийн заалтуудын дагуу шүлхий өвчний албан ёсны хяналтын хөтөлбөрөө батлуулсан гишүүн орноор бүртгэгдсэн.
- Засгийн газраас 2017 онд “Малын гоц халдварт өвчингүй, хорио цээрийн тусгаарласан бүс байгуулах тухай” 284 дүгээр тогтоол гаргасан.
- МЭҮГ (хуучнаар)-ын даргын 2018 оны А/17 тоот “Малын гоц халдварт өвчингүй, тусгаарласан аж ахуйд мөрдөх мал эмнэлэг, хорио цээрийн зааварчилгаа”-г гарган хэрэгжүүлж эхлээд байна.
- Шүлхийн вирусын эсрэг биемийн бүтцийн бус уурагийн тандан судалгааг тогтмолжуулж байна. Аймгуудын МЭ-ийн лабораториуд шүлхий, богийн мялзан өвчний шинжилгээг хийх чадавхтай байна
- Шүлхийтэй тэмцэх арга хэмжээ, стратеги төлөвлөгөөгөө өөрчлөн, ДМАЭМБ-ын зөвлөмжөөр ажиллаж байна.

Эргэх хяналт, мөшгөлт, бүртгэл мэдээллийн тогтолцоо

Аливаа халдварт өвчнөөс эрүүлжүүлэх, малын өвчний хяналтыг бодитой явуулах, улмаар махны үйлдвэрлэл экспортод түүхий эд бэлтгэлээс эцсийн бүтээгдэхүүн хүртэл эргэн мөшгөх тогтолцоог бүрдүүлсэн байх нь малын гаралтай бүтээгдэхүүний олон улсын худалдаанд тохиолддог саад тотгороос сэргийлэх нэг алхам болдог.

ДМАЭМБ-ын Хуурай газрын мал амьтны эрүүл мэндийн кодын 4-р бүлэгт заасан малын бүртгэлжүүлэлт, мөшгилт, түүнийг хэрэгжүүлэх зарчим, аргачлал, 4.2-т мал амьтны бүртгэлжүүлэлтийн тогтолцооны загвар, 6-р бүлэгт Нийтийн эрүүл мэнд мал эмнэлгийн үйлчилгээ; 6.2-т заасан Хүнсний аюулгүй байдал дахь Мал эмнэлгийн үйлчилгээ зэрэг зүйл заалтуудыг улс орон бүр хэрэгжүүлж байна.

Мөн махны үйлдвэрүүд дараах стандарт техникийн баримт бичгийн дагуу мөшгөлтийн тогтолцоог хэрэгжүүлж байна. Үүнд:

- a. MNS CAC RCP 58:2013 махны эрүүл ахуйн дадлын дүрэм;
- b. MNS2456: 2009 Үхрийн хэсэглэж ангилсан мах. Техникийн шаардлага;
- c. MNS2457 “Хонь, ямааны хэсэглэж ангилсан мах, Ерөнхий шаардлага”
- d. MNS 0167:2012, “Гахайн хэсэглэж ангилсан мах, Ерөнхий шаардлага”;
- e. MNS 0307 “Тахианы мах, Ерөнхий шаардлага” стандартуудад заасны дагуу гүйцэтгэнэ.

Мал, амьтны эрүүл мэндийн хяналтын бүртгэлийг Мал эмнэлгийн мэдээллийн нэгдсэн санд нийцүүлэн мал, амьтны өвчний байдлыг мэдээлэх механизм бүрдүүлсэн байна.

Тусгаарлах аж ахуй болон махны үйлдвэрт хүлээн авсан мал бүрт дахин давтагдахгүй им тамга, ээмэг ашиглаж бүртгэл мэдээллийн кодын системд нэтгэнэ.

Монгол дахь хүнсний малын бүртгэл мэдээлэл нь малын гарал үүсэл, үйлдвэрлэгчийн өгөгдлийг эргэн тогтоох, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын хяналт, мониторинг хэрэгжүүлэх суурь болохуйц байхыг шаарддаг. Энэ нь дээрх эрх зүйн баримт бичиг, махны техникийн зохицуулалт,

НАССР-ын стандартын дагуу хүлээн авсан малыг бүртгэлжүүлэн, гарал үүсэл, эрүүл мэнд, ашиг шим, эмийн хэрэглээ, вакцинжуулалтын мэдээлэл зэргийг нэгтгэн, нэгдсэн цахим системийн бүртгэлд оруулна. Энэ мэдээлэл, харьяа мал эмнэлэг, лаборатори, махны үйлдвэр зэрэг шаардлагатай байгууллагуудтай нэгдсэн кодоор холбогдсноор Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд мөшгөлт хийх боломж бүрдэж, хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо хэрэгждэг. Энэ мэдээлэлд махны үйлдвэрийн ба экспортын лицензийн модуль агуулсан программ хангамжийн мэдээлэл бүртгэгдэж мал эмнэлгийн байгууллага болон Мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн 3G сүлжээнд нэгдсэн байдаг. Ойрхи Дорнодын орнуудад энэ зарчим нэгэн адил хангагддаг байна.

Энэ нь бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн бүх сүлжээ буюу хүнс бэлтгэх, хадгалах, тээвэрлэх, борлуулах бүх шат дамжлагад хяналт тавих боломжийг бүрдүүлдэг байна.

Зураг 11. Бүртгэл мэдээллийн системийн бүтэц зохион байгуулалт.



7.1.3. Халал бүтээгдэхүүний лабораторийн шинжилгээ

ДМАЭМБ-ын Хуурай газрын мал амьтны эрүүл мэндийн кодын 4.4.6-т заасанчлан малын өвчний ба малын гаралтай бүтээгдэхүүний аюулгүй байдлын тандан шинжилгээг оношлогооны чадавхи, аргачлал, чанарын хяналтын шаардлага хангасан албан ёсны лаборатори хийсэн байна. Бүх лабораторийн шинжилгээний дүн нь өвөрмөц байхаас гадна бусад лабораторийн шинжилгээтэй дүйж байна. Лаборатори бүр мал эмнэлгийн эрх бүхий байгууллагад шинжилгээний дүнг шууд мэдээлэх системд холбогдсон байна. Шаардлагатай гэж үзвэл ДМАЭМБ-ын лавлагаа лабораториор шинжилгээний дүнг баталгаажуулж болно. Лабораториудын ажил үйлчилгээ “хамгаалагдсан” аж ахуй /AA/, нэг цул болж шударга ажиллах гол үүрэгтэй /хуурай газрын код 3.1, 3.2/. Орон нутгийн болоод гадаад зах зээлд үйлчлэх зорилготой лаборатори нь сорилтын лабораторит тавигдах техникийн шаардлагын ISO17025:2018 стандартын шаардлага хангасан байна.

Халал бүтээгдэхүүний эрүүл ахуй аюулгүй байдлын хяналт нь дэлхийн бусад орны ба Европын холбооны улсын стандартын нэгэн адил явагддаг ч илүү онцлог олон үзүүлэлтийг хянах шаардлагатай болдог. Гахай болон зарим махчин амьтны мах, генетикийн өөрчлөлттэй бүтээгдэхүүн хэрэглэдэггүй учраас түүхий ба боловсруулсан бүтээгдэхүүнд өндөр түвшний молекул генетикийн шинжилгээ хийж халал хүнсэнд хориглосон зүйлийг хянах шаардлагатай болдог байна. Энэхүү шаардлагуудын улмаас махны үйлдвэрлэл, экспорт эрхэлж байгаа болон Халал бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн явцад ба эцсийн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын баталгаажуулалтанд өндөр түвшний лаборатори зайлшгүй хэрэгтэй. Энд хүнсний малын эрүүл мэндийн тандалт шинжилгээ, үйлдвэрлэлийн орчны эрүүл ахуй, технологи, хэрэглээний чанарын шинжилгээ, бүтээгдэхүүний аюулгүй байдлын тандан шинжилгээнүүд багтана.

Хүнсний малын гарал үүсэл, эпидемиологийн хамааралаас үүдэн гоц халдварт өвчний тандалт шинжилгээнд хамруулж, эрүүл мал бэлтгэнэ:

- ✓ Шүлхий өвчний хувьд байгалийн омог тухайн мал сүрэгт эргэлдэж байгаа эсэхийг уг вирусын бүтцийн биш уургийг элиза тестээр шинжилж сөрөг үр дүн өгсөн;
- ✓ Богийн мялзан өвчний хувьд олон улсын худалдаанд шаарддаг, ийлдсийн шинжилгээний вирус саармагжуулах урвалаар сөрөг үр дүн өгсөн;
- ✓ Хөх хэлтэх өвчний хувьд ийлдсийн шинжилгээний нэвчин тундасжих урвалаар сөрөг үр дүн өгсөн малыг тус тус хүлээн авна.

Орон нутгийн мал эмнэлэг, махны үйлдвэрийн лаборатори нь хүлээн авсан бэлтгэлийн малын 10-30%-иас бууруулахгүйгээр бруцеллөз, боом, ям, сүрьеэ, галзуу, сальмонеллөз, листериоз зэрэг зооноз өвчний тандалт хийнэ. Энэ нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, хүнсний аюулгүй байдал, НАССР тогтолцооны дагуу хүнс бэлтгэн нийлүүлэгч нь хүнсний хэлхээний өөрт оногдох хэсэг бүрд дотоод хяналт тавих заалтын хүрээнд хийгдэж байгаа болно.

Мөн үйлдвэр, аж ахуйн нэгжийн дотоод хяналтын лаборатори нь мах, махан бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлын тандалт, үйлдвэрлэлийн технологийн шалгуур үзүүлэлт, бүтээгдэхүүнд хамаарагдах гадаад орчинд эрүүл ахуйн шинжилгээг тогтмол хийх үүрэгтэй.

Дотоод хяналтын лабораторит хийгдэж байгаа шинжилгээ болон эцсийн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг итгэмжлэгдсэн хөндлөнгийн лабораторийн харьцуулсан сорилтоор улирал тутам баталгаажуулна. (Зураг 12. Махны хяналт, шинжилгээ баталгаажуулалтын ерөнхий схем). Мах, махан бүтээгдэхүүний технологи, эрүүл ахуй, аюулгүй байдлын дараах шалгуур үзүүлэлтийг хянах шаардлагатай:


Хүснэгт 40. Хяналт ба шалгуур үзүүлэлт

Тодорхойлогдох заалтууд		Шалгуур үзүүлэлтүүд	Шинжлэх арга	Хаана хийх
Хүнсний малын эрүүл мэнд	Малын гоц халдварт өвчний тандалт	Шүлхийн вирусын NSP-Ab бүтцийн биш уураг	ELISA	Аймаг орон нутагт
		Богийн мялзан өвчний ийлдсийн шинжилгээ	Вирус саармагжуулах урвалаар	Аймаг орон нутагт
		Хөх хэлтэх өвчний ийлдсийн шинжилгээ	нэвчин тундасжих урвалаар	Аймаг орон нутагт
	Зооноз өвчний тандалт	Бруцеллөз	Роза бензол	Аймаг орон нутагт
		Ям	Ямлуур	Аймаг орон нутагт
		Сүрьеэ	Сүрьеэлүүр	Аймаг орон нутагт
		Листериоз	ELISA	Аймаг орон нутагт
		Сальмонеллөз	Ийлдэс судлал, ELISA	Аймаг орон нутагт

		Кампилобактериоз	ELISA	Аймаг орон нутагт
		Боом	Бактериологи, PCR	Аймаг орон нутагт
	Малын эмийн үлдэгдлийн тандалт	Үлдэгдэл байгаа эсэхийг	Преми тестээр	Аймаг орон нутагт
Бүтээгдэхүүн түүхий эдийн технологийн ба хэрэглээний чанар	Мах махан бүтээгдэхүүний химийн бүрэлдэхүүн (Чанарын үзүүлэлт)	Нийт уураг	Кельдалын аргаар	Үйлдвэр, аж ахуйн нэгжийн ба итгэмжлэгдсэн хөндлөнгийн лаборатори (Хүнсний лабораториуд)
		Тослог	Сокслет	
		Чийг	Багажаар	
		Актин	Багажаар	
		Миозин	Багаж ба химийн	
		Миоглобин	Багаж ба химийн	
		Коллаген	Багаж ба химийн	
		Эластин	Багаж ба химийн	
		Ретикулин	Багаж ба химийн	
		Эрдэс	Багаж ба химийн	
		Макро, микро элементүүдээс	Кальци	
	Магни		Багажаар	
	Фосфор		Багажаар	
	Технологи йн үзүүлэлт	рН	Багажаар	Үйлдвэр, аж ахуйн нэгжийн лаборатори
		АТФ	Багажаар	
		Усны идэвх	Багажаар	
		Зүсэлтийн хүч	Багажаар	
		Фрагментийн индекс	Багажаар	
		Ус барих чадвар	Багажаар	
Махны гэмтэл		Багаж ба сонгомол		
Махны амин шүвтрийн азот		Багаж ба химийн		
Хиаманд нитритийн хэмжээ		Багаж ба химийн		
Эрүүл ахуй	Ажлын байр, бүтээгдэхүүний эрүүл ахуй	Нянгийн ерөнхий тоо	Микробиологи	Үйлдвэр, аж ахуйн нэгжийн ба итгэмжлэгдсэн хөндлөнгийн лаборатори
		<i>E.coli</i>	Микробиологи, PCR	
		<i>S.aures</i>	Микробиологи, PCR	
		<i>B.cereus</i>	Микробиологи, PCR	
		Хөгц, мөөгөнцөр	Микробиологи, PCR	
		Бүтээгдэхүүний гүний хэм	Багажаар	
		Байр орчны агаарын хэм	Багажаар	
		Байрны харьцангуй чийг	Багажаар	
		Усны нянгийн тоо	Микробиологи, PCR	
		Агаарын нянгийн тоо	Микробиологи, PCR	
Махны магадлан шинжилгээ	Шүүх мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ	Өвчтэй ба үхсэн малын мах	Химийн ба сонгомол	Итгэмжлэгдсэн хөндлөнгийн лаборатори (МЭАЦТЛ, ХАБУЛ. бусад)
		Махны төрөл	PCR, ELISA	
		Генийн өөрчлөлт	PCR, ELISA	
		Гормоны үлдэгдэл	PCR, ELISA	
Биоаюулгүй байдлын тандан шинжилгээ	Зооноз өвчин ба хүнсний халдвар хордлого үүсгэгчид	<i>Salmonella</i>	Нян судлал, PCR, ELISA	
		<i>E.coli O157</i>	Нян судлал, PCR, ELISA	
		<i>Listeria</i>	Нян судлал, PCR, ELISA	
		<i>Campylobacter</i>	Нян судлал, PCR, ELISA	
		<i>Pseudomonas</i>	Нян судлал, PCR, ELISA	
		<i>Aeromonas hydrophila</i>	Нян судлал, PCR, ELISA	

		<i>Shigella spp</i>	Нян судлал, PCR, ELISA	
		<i>B.antrax</i>	Нян судлал, PCR, ELISA	
		Трихинелл (гахай, ан)	Нян судлал, PCR, ELISA	
		Цистицерк, (үхэр)	Нян судлал, PCR, ELISA	
		Саркоцист	Нян судлал, PCR, ELISA	
Химийн аюулын тандан шинжилгээ	Пестицид ⁵⁶	Aldicarb	ELISA, HLCC	Итгэмжлэгдсэн хөндлөнгийн лаборатори (МЭАЦТЛ,ХАБУ Л, бусад)
		Flusilazole	ELISA, HLCC	
		Buprofezin	ELISA, HLCC	
		Azinphosethyl	ELISA, HLCC	
		Boscalid	ELISA, HLCC	
		Azinphosmethyl	ELISA, HLCC	
		Carbendazin	ELISA, HLCC	
	Хүнд металл	Хар тугалга	ELISA, HLCC	
		Кадьми	ELISA, HLCC	
		Хүнцэл	ELISA, HLCC	
	Цацрагийн бохирдол	Стронци 90	ELISA, HLCC	
		Цезий 17	ELISA, HLCC	
		Уран	ELISA, HLCC	
	Малын эмийн үлдэгдэл	Антибиотик	ELISA, HLCC	
Сульфаниламид		ELISA, HLCC		
Паразитын эсрэг эмийн		ELISA, HLCC		
Гормон		ELISA, HLCC		

Зураг 12. Махны хяналт шинжилгээ, баталгаажуулалтын ерөнхий схем



⁵⁶ Пестицид – MNS 5868:2008 стандарт үзүүлэлтийг харгалзав

7.2. МАХНЫ ҮЙЛДВЭРИЙН ТЕХНОЛОГИ, ЭРҮҮЛ АХУЙ

Монголын махны үйлдвэрлэл

ХАА-н салбар нь Монгол орны нийгэм эдийн засгийн тэргүүлэх чиглэл юм. Манай мал сүрэг өсөж 2017, 2018 онд 66 гаруй сая толгой малтай боллоо. Энэ нь жилд 600-700 гаруй мянга тонн мах үйлдвэрлэх нөөц байгаа бөгөөд Эрдэнэт, Оюу Толгой, Таван Толгойгоос олох орлогоос ялгаатай нь дуусашгүй, нөхөн төлжих орлогын эх үүсвэр билээ. Малын ашиг шим, таваарлаг чанар, ус, бэлчээрийн үр шимийг тэтгэх, малчны орлогыг нэмэгдүүлэх үүднээс малын зарлагыг жил жилээр төлөвлөн эргэлтэд оруулах зайлшгүй шаардлагатай байна.

7.2.1. Ойрх дорнодын орнууд руу мах бэлтгэх үйлдвэрт тавих шаардлага

Үйлдвэрийн процесст тавигдах шаардлага: Халал бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн процессын хамгийн чухал шаардлага нь цэвэр, эрүүл ахуйн өндөр дэглэм юм. Мал төхөөрөх, мах эхлэн боловсруулах, ангилах, савлах, тээвэрлэх, хадгалах, аюулгүй байдлыг баталгаажуулах бүх дамжлага дараах стандартын дагуу хийгдэнэ.

Хүснэгт 41. Үйлдвэрийн процесст тавигдах шаардлага ба стандарт

№	Процессын дараалал	Баримтлах стандарт
1	Мал төхөөрөх	GSO 630/1998 Исламын хуулийн дагуу мал төхөөрөхөд тавих шаардлага
2	Мах сэврээх, хөргөх хөлдөөх	GSO 997/2016. Үхэр, хонь, ямааны махыг сэврээх, хөргөх, гүн хөлдөөх
3	Шинэ мах бэлтгэх	GSO 815-2015 Шинэ мах бэлтгэх эрүүл ахуйн горим, тээвэрлэх, хадгалах дүрэм
4	Тээвэрлэх хадгалах	GSO 323.1998 Хөргөсөн, хөлдөөсөн хүнсний бүтээгдэхүүнийг тээвэрлэх, хадгалахад тавих шаардлага
5	Махны аюулгүй байдлын шинжилгээ	GSO 1016-2015. Хүнсний бүтээгдэхүүний микробиологийн үзүүлэлтийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ GSO 2481-2015. Хүнсний бүтээгдэхүүн дэх малын эм бэлдмэлийн үлдэгдлийн дээд хэмжээ
6	Сав баглаа, хаяг шошго	GSO 09.2013. хүнсний бүтээгдэхүүний савлагаа, хаяг шошгонд тавих шаардлага
7	Хил гаалийн хяналт	GCC 2016. Импортын бүтээгдэхүүнд тавигдах хилийн хяналт

Хүснэгт 42. Халал мах үйлдвэрлэхэд тавигдах үндсэн 4 шаардлага:

Мах, махан бүтээгдэхүүн нь хүний хэрэглээнд аюулгүй, тохиромжтой байх
Мал нь Булангийн орны стандартын байгууллагаар зөвшөөрөгдсөн, экспортлогч орны эрх бүхий байгууллагын хяналтан доор төхөөрөгдсөн байх.
Мах махан бүтээгдэхүүн нь тухайн улсын эрх бүхий байгууллагаас итгэмжлэгдсэн малын эмчээр төхөөрөхийн өмнөх ба төхөөрсний дараах үзлэг шинжилгээнд орсон малаас бэлтгэсэн байх.
Мах, махан бүтээгдэхүүнийг эрх бүхий байгууллагаар хянан магадлагаа хийлгэсэн, хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлдэг газар бэлтгэх

1. **Мал төхөөрөх газар** нь ISO 22000, GSO 815 заасан хүнсний аюулгүй байдлын хөтөлбөрийн шаардлагыг хангасан байх ба зөвхөн Халал мал төхөөрнө.
2. Төхөөрөх газрын эрүүл ахуйн нөхцөл байдал нь SAC / RCP 1 стандартын шаардлагыг хангасан байна.

3. Төхөөрөх үйлдвэр нь дараах зүйлсийг заавал хангана. Үүнд:
- Эрүүл мэндийн үзлэг хийхэд тохиромжтой байр.
 - Мал төхөөрөхөд зориулсан тусгай зориулалтын автомат, гар системтэй.
 - Хөдөлгөөний урсгалын дарааллаар нь оруулах гинжээр тоногдсон хөдлөх болон гар ажиллагаатай шугаман системтэй.
 - Ажилчдад зориулсан арьс хуулах, гулууз гаргах хялбар зориулалтын хөдөлгөөнт платформ, буултын талбайтай байх.
 - Жинлэх байгууламжтай.
 - Даралттай ус, угаах байгууламжтай (автоматаар байх давуу).
 - Бохир хэрэгсэл (хутга, гогцоо гэх мэт) угаах, ариутгах, зориулалт бүхий хэрэгсэл.
 - Хөлөөр болон мэдрэгчтэй тоноглогдсон гар угаалтуур.
 - Зориулалтын халуун ус агуулах сав.
 - Усан хангамж, даралтыг тохируулах боломжтой байх.
 - Бүх ариутгалын бодис, ариутгах шингэн нь Халал хүнсний салбарт зөвшөөрөгдсөн.
 - Бэлтгэх, боловсруулах, хадгалах явцад хүнсний бус зүйлтэй харьцахгүй байх.

7.2.2. Мал төхөөрөх технологи


Мал төхөөрөх газрын технологи, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хөдөлмөр хамгаалын хувцас нь ариун цэвэр, халдваргүйжүүлэлтийн хувьд импортлогч орны мал эмнэлгийн албны

шаардлагад нийцсэн, зөвшөөрөгдсөн байна. Малыг мусалман шашинтай хүн Аллах тэнгэрт залбирч “Бисмиллахи Аллаху акбар” гэж шашны ном ёсоор хоолойг нь хэрчих аргаар төхөөрнө.


Халал арга нь бүрэн цусалгаа хийхийг шаарддаг учир хонины цусалгааны зам 10-15м урттай байх ба цусыг юүлэх хугацаа хамгий багадаа 4 минут байна. Цусалтаас хойш олон улсын стандарт жишгээр явна. Халал аргаар мал төхөөрөх арга технологийг Хавсралтаар оруулав.

Бүх төрлийн мэдээгүйжүүлэлтийг хориглодог. Гэхдээ амьтныг тайвшруулж, зайлшгүй шаардлагатай үед зөвшөөрөгдсөн хугацаа болон цахилгаан гүйдлийн хэмжээгээр цахилгаанаар муужруулах арга хэмжээ авна.

Схем 7. Халал аргаар мал төхөөрөх дараалал



Зураг 13. Бод малыг халал аргаар төхөөрөх хялбарчилсан төхөөрөмж



Хөгжингүй орнуудын мал төхөөрөх газарт ашигладаг бод мал төхөөрөхөд зориулагдсан тусгай тоноглол бүхий автомат төхөөрөмж. Тус төхөөрөмж нь мал өөрөө явж ороход зориулагдсан нэг үзүүр нь гэрэлтэй бөөрөнхий баригч бөгөөд малыг үүнд орсны дараа хавчиж сууриараа бүтэн эргэж хоолой хэрчихэд эвтэйхэн, төхөөрөх үед савлаж цус асгаруулахгүй олон сайн талтай төхөөрөмж юм (зураг 13).

7.2.3. Халал бүтээгдэхүүнд тавих шаардлага

Мах нь Халал хүнсний ихэнх хувийг эзэлдэг, халал бүтээгдэхүүний үндсэн суурь бүтээгдэхүүн юм. Мах болон махан бүтээгдэхүүн бэлдэхэд олон улсын стандартыг мөрдөж (хавсралт 2 харах) эрүүл ахуй болон ариун цэврийн хувьд Ислам шашны шаардлагын дагуу хийдэг.

Халал аргаар төхөөрсөн малын маханд тавигдах шаардлага

- i. Ислам шашны хэм хэмжээ, шариатын хууль тогтоомжоор хориглох, эсвэл түүний дагуу төхөөрч болохгүй амьтны гаралтай аливаа эд анги, бүтээгдэхүүнийг оруулах буюу агуулсан байх ёсгүй.
- ii. Шариатын хуулийн дагуу гахайн тос болон өөх, согтууруулах ундаа, бусад харам зүйлс ямарваа нэг хэмжээгээр агуулагдаж болохгүй.
- iii. Үйлдвэрлэл болон тээвэрлэлтийн байр, чингэлэг болон бусад тоног төхөөрөмжүүд Шариатын хуулийн дагуу харам зүйлсээс ангид байх, зөвшөөрөгдсөн тоног төхөөрөмж ашиглан бэлтгэсэн, боловсруулсан буюу үйлдвэрлэгч, тээвэрлэгч байх ёстой.

7.2.4. Малд тавих шаардлага

- i. Мал бэлтгэлийн үйл ажиллагаатай холбоотой хорио цээрийн шаардлагууд нь халал мах бэлтгэх үндэс юм.
- ii. Бэлтгэлийн мал нь мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тогтмол хамрагдаж байсан эрүүл мал сүргээс бэлтгэгдсэн байна.
- iii. Тухайн орон нутагт тэр дундаа тухайн суурьт сүүлийн 12 сард шүлхий болон малын ямар нэгэн гоц болон халдварт өвчин гараагүй байна.
- iv. Мал эмнэлгийн ариун цэврийн гарал үүслийн гэрчилгээ бүхий мал байна.
- v. Бэлтгэлийн мал нь гол төлөв 18 сараас дээшгүй настай эр төлөг /хонь, ямаа/ байвал зохимжтой (ПБХАЗ-ийн стандартад дээд тал нь 36 сар ба түүнээс дээш малыг импортлохыг хориглодог).
- vi. Бэлтгэлийн малыг уургийн болон амьтны гаралтай тэжээлээр тэжээгээгүй байна.
- vii. Импортлогч орны хүсэлтээр антибиотик болон хүнд металлийн үлдэгдэл шалгаж болно.

- viii. Бэлтгэлийн малыг хүлээн авч, хорио цээрийн хязгарлалтанд байх хугацаанд хоёр талын малын эмч мэргэжилтэнгүүд үзлэг хийж нийт малын 20%-аас доошгүй хувьд нь лабораторийн түүвэр шинжилгээ хийж болно.
- ix. Бэлтгэлийн малыг төхөөрөхөөс 24 цагийн өмнө сойж, 18° С усаар усалж, малын бүртгэл хөтлөнө.

Бусад тусгай нөхцлүүд: Махыг орчны хэм 0°С -+4°С, 80-86%-ийн харьцангуй чийгшилтэй өрөөнд (хамгийн дээд хэмжээ нь +7°С хүрч болно) 24-72 цаг сэврээсний дараа хэсэглэнэ. Махны рН 6.2 хүртэл буусан байна. Мах хэсэглэх, шулж ангилах өрөөний хэм нь +10°С буюу түүнээс доош байна. Махнаас бүх тунгалагийн болон мэдрэлийн булчирхайг авсан байна.

Махыг хөргөх, хөлдөөх, ангилан савлах, тээвэрлэх технологи: Толгой салгах, арьс хуулах, гэдэс дотор гаргах хуурай, нойтон цэвэрлэгээ, гулууз махны үзлэгт орсны дараа 80-86 % чийгшилтэй өрөөнд (0+4С⁰ 24 цаг) сэврээхэд махны РН 6,2-т буусан байна. Сэврээсэн махыг тухайн орны стандартын дагуу (хаа, гуя, цээр нуруу, хүзүү, хавирга) болгон ангилж зориулалтын сав, баглаа ашиглах ба тээвэрлэлтийн нөхцөл, хугацаанаас хамаарч савлах технологио сонгож савлан хадгалалтын горимонд шилжүүлнэ. Тээвэрлэлтийн хугацаа урт байх тохиолдолд олон улсад түгээмэл хэрэглэгдэж буй дэвшилтэт савалгааны төрлүүдээс (MAP, CAP, VAC)⁵⁷ сонгож савлах нь зүйтэй. Тээвэрлэхдээ температурын хяналтын бүртгэл бүхий зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

7.2.5. Хүнсний аюулгүй байдлын менежмент

Аливаа улс орны тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлын нэг тулгуур шаардлага нь “Хүнсний аюулгүй байдал” гэж үздэг учраас дэлхийн улс орон бүр хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын шаардлагыг зохицуулж, стандартчилдаг. Дэлхийн хэмжээнд энэ үүргийг Олон улсын стандартчиллын байгууллага (ISO⁵⁸), Хүнсний хууль эрх зүйн хороо (CAC⁵⁹), Исламын шашинтай оронд Исламын дээд байгууллага (OIC⁶⁰) зэрэг байгууллага гүйцэтгэж байна.

Ислам шашинд халалын шаардлагуудын хамгийн эхэнд нь - ариун цэвэр эрүүл ахуйн шаардлага байдаг. Тийм учраас олон улсын HACCP, ISO:22000:2005 стандартын дагуу махны үйлдвэр байгуулсан хэн нэгэн тэр үйлдвэрээ халал стандартын дагуу болгох нь амархан байдаг.

Махны үйлдвэрлэл, экспортод тавигдах стандарт шаардлага нь малын эрүүл мэндийн баталгаажуулалтаас эхлэх ба мал, амьтны халдварт өвчний байдалд статус тогтоох асуудлыг Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага (ДМАЭМБ) хариуцан гүйцэтгэдэг. Монгол улсын махны салбарт эдгээр байгууллагын стандартыг мөрдөж байна.

Зураг 14. Суурь, ферм, нэгжийн хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо.



Хүнсний аюулгүй байдлын менежментийн шаардлага малчны хот (малын тэжээллэг, эрүүл мэнд, малын эмийн хэрэглээ)-ноос эхлээд эцсийн бүтээгдэхүүн хүртэлх үйлдвэрлэлийн бүх сүлжээн дэх үйлдвэрийн зохистой дадал (GMP), угтвар нөхцлийн шаардлага (PrP), эрүүл ахуй дадал (GHP), стандарт ажиллагааны заавар (SOPs), лабораторийн зохистой дадал (GLP), менежментийн зөв тогтолцоо (GMS), бүтээгдэхүүний технологийн ба чанарын хяналт, ариун цэврийн хөтөлбөр гэх мэт маш олон салбарын шинжлэх ухаан, практикийн мэдлэг ур чадвар, дадлага, үйл явцууд багтсан байдаг. Дэлхийн ихэнх улс

⁵⁷ <https://www.sciencedirect.com/topics/food-science/controlled-atmosphere-packaging>

⁵⁸ ISO – Олон улсын Стандартын байгууллага

⁵⁹ CAC – Codex Alimentarius Commission

⁶⁰ OIC – Исламын орнуудын байгууллага

орон хүнсний аюулгүй байдлын баталгаажуулалтад НҮБ-ын ХХААБ, ДЭМБ-ын хамтарсан Хүнсний хууль эрх зүйн хороо (САС) болон Олон улсын стандартчилалын байгууллага (ISO)-аас гаргасан техникийн баримт бичгүүдийг хэрэгжүүлж байна. Эдгээрийг өөрийн орны стандарт техникийн баримт бичгүүдтэй (хавсралт 2-ыг харна уу) харьцуулан судлахад дээрхи баримт бичгийн 70 орчим хувь нь манай улсад үндэсний стандарт болон баталгаажсан байна.

Хүнсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо нь тухайн бүтээгдэхүүний анхдагч үйлдвэрлэлээс хэрэглэгч хүртэлх хүнсний бүх сүлжээнд оролцож байгаа үйлдвэрлэгч, нийлүүлэгч, хэрэглэгч, төр, олон нийтийн байгууллагын оролцоо, тэдгээрийн үүрэг хариуцлага, хэрэглээний соёл, уламжлал, мэдлэг чадвар гэх мэт олон асуудлыг өөртөө багтаасан, хоорондоо нягт уялдаа холбоотой иж бүрэн үйл явцаас бүрэлдэнэ (Зураг 14).

Зураг 15. Хүнсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны ерөнхий схем




Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний аюулгүй байдлын тогтолцоо нь малчны хотноос хэрэглэгч хүртэлх хүнсийг бэлтгэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, борлуулах бүх хэлхээг хамруулан төр, хувийн хэвшил, олон нийтийн байгууллага, үйлдвэрлэгч, хэрэглэгчийн оролцоо шаардлагатайг энэхүү тогтолцооны схемээр харуулав (зураг 15).

Хүнсний аюулгүй байдлын менежментийн үндсэн шаардлага нь НАССР-ын угтвар нөхцлийн стандартууд бөгөөд мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн угтвар нөхцлийн шаардлага нь ISO/ TS 22002-1, 2, 3, 4, 5, 6 цуврал стандартуудаас бүрдэнэ. Олон улсын практикт эдгээр угтвар нөхцөл (PrP), GMP, GHP хангасан болон НАССР нэвтрүүлсэн үйлдвэрт үндэсний ба олон улсын итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагаас гэрчилгээ олгож баталгаажуулдаг.

НАССР-ын зарчим нь бүтээгдэхүүнийг гарал үүсэл, онцлог шинж чанар, хаана хэзээ, хэн үйлдвэрлэснийг мөшгөлтөөр тогтоох боломжийг олгоно. Хүнсний аюулгүй байдлын анхдагч нэгжийн хувьд малчид, фермерүүд малынхаа гарал үүсэл, эрүүл мэнд, арчилгаа маллагаа, тэжээл болон эрүүл ахуйн хувьд (зураг 16-д) үзүүлсэн хяналтыг хэрэгжүүлнэ. Сүлжээний дараах үе шатууд буюу бүтээгдэхүүн үйлдвэрлэл, түгээлтийн шатанд эрүүл ахуй, ариун


цэврийн шаардлага өндөр байх шаардлагатай бөгөөд тэнд хэрэгжих хяналтын тогтолцоог (Зураг 17-д) үзүүлсэн схемийн дагуу хэрэгжүүлнэ.

Зураг 16. Суурьт хэрэгжих хяналтын тогтолцооны ерөнхий бүтэц



Энэхүү зургаар суурьт үйлчлэх мал эмнэлгийн үйлчилгээ болон суурьт хэрэгжүүлэх хүнсний аюулгүй байдлын шаардлагыг харуулав.

Зураг 17. Мал төхөөрөх үйлдвэрт хэрэгжих хяналтын тогтолцооны ерөнхий бүтэц



Энэхүү схемээр махны үйлдвэрт хэрэгжих мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг харуулав.

Удирдлагын ба техникийн бүх шатанд PrP, GMP, GHP-ын шаардлагыг хэрэгжүүлсэн

үйлдвэрт хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоог MNS ISO/IEC 22000:2007 стандартын дагуу, лаборатори нь MNS ISO 17025:2007 стандартын дагуу итгэмжлэгдснээр тухайн бүтээгдэхүүний аюулгүй байдал баталгаажна.

НАССР тогтолцоог хэрэгжүүлэхэд үндэсний хэмжээнд дараах олон улсын ба үндэсний стандартуудыг ашиглаж байна (Хүснэгт 43).


Хүснэгт 43. НАССР-ын эрх зүйн баримт бичгийн жагсаалт

№	Стандарт баримт бичгийн нэр	Дугаар, батлагдсан огноо	Хамрах хүрээ
1	Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим Хүнсний үйлдвэрийн эрүүл ахуйн дадлын ерөнхий зарчмыг тогтоосон	MNS CAC 1-2003	Олон улсын хэмжээнд
2	Хүнсний аюулгүй байдлын тогтолцоо (хүнсний сүлжээн дэх байгууллагуудад тавигдах шаардлага)	MNS/ISO 22000:2007	Олон улсын хэмжээнд
3	“Хүнсний үйлдвэрлэл, эрүүл ахуйн зохистой дадал (GMP, GHP) -ыг үндэсний хэмжээнд нэвтрүүлэх зөвлөмж”	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, Эрүүл мэндийн сайд, ХХААХҮ сайдын хамтарсан 29/289/147 тоот тушаал	Зөвхөн Монголд
4	Мах эхлэн боловсруулах үйлдвэр, Аюулын шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналтын (НАССР) тогтолцооны загвар	MNS 5998:2009	Зөвхөн Монголд
5	Махны эрүүл ахуйн дадлын дүрэм	MNS/ CAC/ RCP 58:2013	Олон улсын хэмжээнд
6	Махны үйлдвэрийн НАССР-ын тогтолцоог баталгаажуулах журам	Стандарт хэмжил зүйн ерөнхий газар, 2011 он	2011

Экспортын махны гаалийн бүрдүүлэлт хийх

Экспортын бүрдүүлэлтийн тухайд, МХЕГ, МХАҮТ, Шинжилгээний байгууллага, СХЗГ оролцдог. Гарал үүслийн гэрчилгээг МХАҮТ, чанарын гэрчилгээг СХЗГ, эрүүл ахуйн гэрчилгээг МХЕГ гаргаж өгдөг. Лаборатори дах шалгалтын тухайд, мал аж ахуйн бүтээгдэхүүн (түүхий эд)-ийг Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори (УМЭАЦТЛ), бусад ХАА-н болон хүнсний бүтээгдэхүүний шинжилгээг ХАБҮЛЛ-д хийж байна. Гаалийн бүрдүүлэлт хийгдэх ерөнхий схем (зураг 17-аар) харуулав.

Зураг 18. Экспортын бүрдүүлэлт хийх ерөнхий схем



8. ЗОРИЛТОТ ОРНУУДАД МАХ НИЙЛҮҮЛЭХ ГИНЖИН ХЭЛХЭЭ

8.1. МОНГОЛ МАЛЫН МАХНЫ ЭКСПОРТЫН ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТИЙН СҮЛЖЭЭ

8.1.1. Экспортын мах ханган нийлүүлэх сүлжээ

Монгол орны махны ханган нийлүүлэлтийн сүлжээ нь үйлдвэрлэгчид, боловсруулагчид, экспортлогчид болон худалдан авагчдын сүлжээн дэх голлох холбоос хэмээн авч үздэг боловч зарим аймгуудад өөрөөр байдаг онцлогтой. Манай орны мах үйлдвэрлэгчдийн олонх нь жижиг компаниуд бөгөөд тэдэнд санхүүжилт, туршлага, үйлдвэрлэлийн цар хүрээгээр үлэмж хязгаарлагдмал байна. Өөрийн орны мах нийлүүлэлтийн зураглал энгийн болоод хямд төсөр зардалтай байдаг бол олон улсын худалдаа эрхлэхэд хүнд суртал ихтэй, стандарт, хууль, дүрэм журам, үйлдвэрлэлийн хүрээнд олон шат дамжлагт нийцүүлэн ажиллах шаардлагатай.

Зураг 19: Махны экспортын ханган нийлүүлэлтийн сүлжээ



Малчид

Эх газрын эрс тэс нөхцөл, байгалийн урт хугацааны шалгарал, мал маллагааны олон зууныг дамжиж ардын селекцийн сонгомол үржүүлгийн үр дүнд биологийн онцгой шинжийг хадгалсан Монгол мал бий болсон. Үүний ард дээрх Төв Азийн байгалийн хатуу ширүүн бүхий л шалгуурыг даван туулж, түүнийг оюун ухаандаа боловсруулж, амьдралдаа зохицуулан хэрэглэж ирсэн агуу их, малчин ард түмэн бий.

Манай орны ХАА-н салбарт нийтдээ 403.5 мянган өрхийн 84.9 % нь мал аж ахуйн салбарт ажиллаж амьдардаг. Одоо 153,085 малчин өрх байгаа бөгөөд түүнд 297,828 малчид ажилладаг гэсэн баримт байна (2015). Мөн манай улсад мал амьтны нийт тооны 99 хувь нь таван хушуу мал бөгөөд ганцхан хувийг гахай, шувуу, зөгий туулай бүрдүүлдэг байна.

Махны экспортын ханган нийлүүлэх сүлжээнд оролцох малчдын үүрэг хариуцлаганд хэд хэдэн хүчин зүйл ихээхэн нөлөөлдөг.

- i. Малчдын хувьд махны экспортод тогтвортой оролцоход эдийн засгийн хүчин зүйлсээс илүүтэйгээр цаг уурын хүчин зүйл ихээхэн нөлөөтэй байдаг. Жишээлбэл Монгол улсын бүх аймгуудыг хамарсан 2000-2003 оны зудаар малын тоо толгой 12.5 сая толгойгоор хорогдсон. Энэ нь тухайн жилийн нийт малын тоо толгой, мах болон малын гаралтай түүхий эдийн нөөцөд нөлөөлөөд зогсоогүй, экспортын эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрт сөргөөр нөлөөлсөн.
- ii. Бэлчээрийн мал аж ахуй цаг уурын улирлын онцлогоос хамааран махны нийлүүлэлтийн улирлын шинж чанартай хомсдолыг бий болгодог.
- iii. Малын тоо толгойн хэт өсөлт, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөтэй хавсарснаас даац хэтэрч улмаар бэлчээр доройтол, цөлжилтийг эрчимжүүлэх үндсэн шалтгаан болж байна.

Махны Үйлдвэр

Махны үйлдвэр гэж Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтын алба баталгаажуулж бүртгэсэн, мал, амьтан төхөөрөх, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах, худалдах, тээвэрлэх үйл ажиллагаа явуулдаг газрыг хэлнэ.

Экспортлогчид

Манай улсад махны чиглэлийн нийт 230 аж ахуй нэгж байгаагийн 28 нь томоохон ААН бөгөөд 85 мянган тн мах үйлдвэрлэж, 40 мянган тн мах хадгалах хүчин чадалтай. Манай улсын хэмжээнд бэлтгэж байгаа нийт махны 25-30 хувийг үхэр, 35-40 хувийг хонь, 10-15 хувийг ямаа, 15-20 орчим хувийг адууны мах эзэлдэг.

Манай орны махны томоохон экспортлогчдыг дурдвал Мах Импекс ХК, Мах Маркет ХХК, Мах Экспо ХХК, Хатансүйх Импекс ХХК, Дархан-Мах Экспо ХХК, МонГема ХХК, Дорнын говь ХХК, Тайж трейд, Эрдэнэт Прогресс ХХК, Баатрууд тэнгэр ХХК зэргийг дурдаж болно. Өөрөөр хэлвэл эдгээр экспортлогчид махны ханган нийлүүлэлтийн сүлжээнд тэргүүлэх байр суурьтай оролцож байна.

Аймгуудад махны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд дотоодын хэрэгцээний мах бэлтгэдэг. Тэд экспортын мах нийлүүлэлтийн сүлжээнд шууд оролцдоггүй гэж хэлж болохгүй юм. Учир нь тэд дотоодын махны хэрэгцээг хангахад томоохон хувь нэмэр оруулж байгаа тул бусад компаниуд мах экспортлох боломж бүрдүүлж байгаа юм.

Дараах асуудлыг шийдвэрлэснээр махны экспортын ханган нийлүүлэлтийн сүлжээнд экспортлогч, үйлдэрлэгчдийг өргөнөөр татан оролцуулах боломж байна гэж үзэж байна. Үүнд :

- i. Хэдий орон нутгийн ДНБ-д махны дэд салбарын эзлэх байр суурь маш өндөр байгаа ч одоохондоо нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг Аж ахуйн нэгж байгууллага хуруу дарам цөөн байна.
- ii. Мах экспортлоход малын эрүүл мэндээс гадна мах боловсруулах технологийн шинэчлэл хэрэгтэй, иймд олон улсын стандартын шаардлагыг хангасан барилга байгууламжтай махны үйлдвэр барих хэрэгтэй байна.
- iii. Махны үйлдвэрлэлийн хамгийн чухал асуудал бол GMP, GHP, HACCP тогтолцоог нэвтрүүлэх явдал. Ингэснээр хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, борлуулах бүхий шатанд шинжлэх ухааны үндэстэй хяналтын тогтолцоо нэвтэрч, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, өөрөө хариуцан мөшгөх, эргүүлэх татах тогтолцоо бий олон улсын жишигт нийцэх болно.
- iv. Махны нийлүүлэлтийн хувьд 1-6 саруудад нийлүүлэлтийн дутагдалтай байдаг ба 7 сараас нийлүүлэлтийн илүүдэлтэй болж эхэлдэг. 7-12 сард бий болох илүүдэл махны нөөцийг махны нийлүүлэлтийн дутагдалтай байдаг саруудад нөөцлөхийн тулд Монголд (-15%)-(-30%)^o С хэмийн хөргөлттэй 70 гаруй мянган тоннын зоорь хэрэгтэй байгаа тул одоогийн байгаа хүчин чадал дээр нэмж 30 гаруй мянган тоннын багтаамжтай хөргөлттэй зоорь барих хэрэгтэй болж байна.

Манай улс мах экспортлоход Монгол улсын Засгийн газраас дараах хоёр зүйлийг анхаарах хэрэгтэй байна.

- a. Мах Махан бүтээгдэхүүнд бүрэн шинжилгээ хийдэг лабораторитой болох, Монгол малыг ээмэгжүүлж эргэн мөшгих арга хэмжээг хэрэгжүүлдэг болох;
- b. Экспортлогч орон цөөн, гааль, боомт, дэд бүтэц хөгжөөгүй, мах экспортлох эрүүл бүс хязгаарлагдмал зэрэг мах экспортлоход саад бэрхшээл болдог хүчин зүйлүүдийг арилгах талаар нэн яаралтай арга хэмжээ авч ажиллах.

Гааль

Гадаад бүрдүүлэлтэд шаардлагатай гадаад худалдааны бичиг баримт. Гадаад улс оронд бараа, бүтээгдэхүүн экспортлоход Монгол улсын гаалийн байгууллага дараах нэр төрлийн бичиг баримт бүрдүүлэхээр заасан байдаг.

Олон улсын худалдааны бичиг баримтыг гүйцэтгэх үүргээс нь хамаарч дараахь бүлгүүдэд хуваадаг. Үүнд :

Авто тээврийн хэрэгслээр:

- авто тээврийн хэрэгслийн гэрчилгээ;
- ачаа тээвэрлэлтийн бичиг баримт;
- худалдааны бичиг баримт;

/Гадаад худалдааны гэрээ, төлбөрийн баримт, үнийн нэхэмжлэх, баглаа боодлын жагсаалт, даатгалын бичиг баримт, техникийн бичиг баримт болон бусад барааг тодорхойлсон шаардлагатай бичиг баримтууд/

Агаарын тээврийн хэрэгслээр:

- тээврийн хэрэгслийн гэрчилгээ;
- ерөнхий мэдүүлэг;
- зорчигчийн нэрсийн жагсаалт;
- ачааны жагсаалт /карго манифест/;
- ачаа тээвэрлэлтийн бичиг баримт;
- аяллын хугацаанд хэрэглэх зорчигчийн хүнс, хэрэгслийн жагсаалт;
- худалдааны бичиг баримт;

Төмөр замаар:

- дамжуулах хуудас;
- вагон хуудас;
- тээврийн бичиг баримт;
- худалдааны бичиг баримт;

Монгол улсаас мах, махан бүтээгдэхүүн экспортлоход дараах баримт бичгүүдийн бүрдүүлэлтэнд анхаарах шаардлагатай:

- Бүтээгдэхүүн нийлүүлэх олон улсын гэрээ /Импортлогч болон экспортлогч аж ахуй нэгжүүдийн гэрээ, хэлэлцэл, мал эмнэлэг хорио цээрийн шаардлагуудыг нарийн тусгасан стандарт бүхий/;
- Транзит тээврийн зөвшөөрөл / дамжин өнгөрөх улс тус бүрийн зөвшөөрөл/;
- Мал эмнэлгийн ерөнхий газрын гэрчилгээ;
- Шаардлагатай лабораторийн шинжилгээний дүгнэлт /елизагийн урвал, хавсран холбох урвал/;
- Мэргэжлийн хяналтын газрын мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт;
- Мэргэжлийн хяналтын газрын мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчийн сертификат;
- Стандартчлал хэмжил зүйн газрын бүтээгдэхүүний тохиргоо, баталгаажуулалтын гэрчилгээ;
- Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимаар баталгаажсан гарал үүслийн гэрчилгээ;
- Холбогдох бусад баримт бичиг.

Чанарын
байцаагчид

Засгийн газрын 2011 оны 310 тогтоолоор үйлдвэр бүр дотоод хяналтын албатай байхаар заасан. Махны үйлдвэр мал төхөөрч эхлэхээс эцсийн бүтээгдэхүүнээ гаргах хүртлэх бүхий л үйл ажиллагаанд хоёр талын мэргэжилтэнгүүдийн хяналт тавьж ажиллах бөгөөд үүнийг үндэслэж мал эмнэлгийн ариун цэврийн сертификат бичиж хоёр талын мэргэжилтэн гарын үсэг зурна.

Ойрхи Дорнодын орнуудын худалдан авагчид ханган нийлүүлэгчдийг Халал гэрчилгээтэй байх шаардлага тавьдаг. Монголын ихэнхи үйлдвэрлэгчид тус шаардлагын талаар тогтсон дэлгэрэнгүй ойлголт авч амжаагүй бөгөөд цөөхөн тооны байгууллагууд Халал сертификат авч үйлдвэрлэл эрхэлж байна. Одоогоор мах үйлдвэрлэгчдэд Халалын шаардлагыг хангаж, гэрчилгээ авах эрх нь нээлттэй ч эрх зүйн орчин төдийлөн бүрдээгүй байна. Иймээс эдгээр үйлдвэрлэгчдийг нэгтгэж Халал гэрчилгээтэй болох арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай байна.

Монгол орны хувьд олон улсын зөвлөх үйлчилгээ хэтэрхий үнэтэй, дотоодын зөвлөх үйлчилгээ хөгжөөгүй байна. Иймээс үйлдвэрлэгчдэд төлбөрийн чадамжтай хамааралтай асуудлууд тулгарч байна. Зөвлөх үйлчилгээний бизнесийн чиглэлээр эрэлт хэрэгцээ бага байна. Дотоодын махны салбарын томоохон үйлдвэрүүд олон улсын худалдаанд тавигдах шаардлагууд, холбогдох журам, өртөг зардлын талаар сайтар ойлголттой байгаа нь сайшаалтай. Гэвч жижиг үйлдвэрлэгчид олон улсын зах зээлийн хэрэгцээ, бүтээгдэхүүний чанарын стандартууд, хаяг шошгонд тавигдах шаардлагууд, сертификатууд, гаалийн дүрэм журам, ложистик болон бусад холбогдох баримт бичгүүдтэй холбоотой мэдээллээр дутмаг ойлголттой байна. Жижиг үйлдвэрүүд ханган нийлүүлэлтийн сүлжээнд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тиймээс Ойрхи Дорнодын худалдан авагчдийн хувьд жижиг үйлдвэрүүдийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ, Халал стандартуудыг үйл ажиллагаандаа чанд баримталдаг эсэхэд ихээхэн анхаарал хандуулна.

Экспортлогчид үйлдвэрлэгчдийг нэгтгэх үүргийг гүйцэтгэж магадгүй, эсвэл гүйцэтгэж болно. Олон улсын экспортлогчдын үндсэн зорилго нь худалдан авагчдын хамт тохирлын үнэлгээ, чанарын шалгалт, баталгаажуулалт, ложистик, менежментийн бүхий л зөвлөлгөөг төлбөртэй хийхийг зорьдог.

Олон улсын гааль болон мэргэжлийн хяналтын байцаагчид махны ханган нийлүүлэлтийн сүлжээнд нэн чухал байр суурь эзэлдэг хэдий ч махны салбар дахь хяналт нь сул байдаг. Монгол оронд гаалийн хяналт шалгалттай холбогдуулан тулгарч буй үндсэн сорилт нь олон улсад хүлээн зөвшөөрөгдөх, итгэлцлийг олох явдал юм. Итгэмжлэгдээгүй байдал нь худалдааны туршлагатай шууд холбоотой байхад Монголын мах, махан бүтээгдэхүүн нь олон улсын стандартад нийцсэн мал эмнэлгийн сертификатгүй байна. Гаалийн хяналт, аюулгүй байдал, чанарт тавигдах шаардлагуудаас гадна олон улсын худалдан авагчид, импортлогчид тус тусдаа шаардлагуудтай байдаг. Тиймээс, тухайн бүтээгдэхүүн гаалийн хяналтыг давж, олон улсын зах зээлд зөвшөөрөгдсөн нөхцөлд ч дэвшилтэт технологи бүхий сав баглаагүй, тээвэрлэлтийн нөхцөл, зах зээлийн одоогийн ханган нийлүүлэлт болон эрэлтийн нөхцөл байдал зэрэг хэд хэдэн шалтгааны улмаас эцсийн шатны худалдан авагчийн зүгээс тавих хяналтуудад бүдрэх тохиолдол гардаг. Иймд, ердийн ханган нийлүүлэлтийн сүлжээ нь стандарттай боловч шат дамжлага тус бүрт хийгдэх хяналт, шалгалтууд нь олон улсын болон тухайн орны махны худалдаатай уялдуулан өндөр түвшний эрсдэл хүлээхүйц байна.

Монгол орны хөдөө аж ахуй, махны салбарт ихээхэн сайжруулалт хийгдэж буй ч өнөөдрийн ихэнх үйлдвэрлэгчид технологийн бэрхшээлтэй тулгарч байна.

Монгол орны хөдөө аж ахуйг шинэчлэн, сайжруулж байгаа ч жижиг үйлдвэрлэгчдийн олонхи нь санхүүгийн чадавхи дутагдалтай байна. Энэ нь техник, технолог алгуур нэвтэрч, үйлдвэрлэл удаашрах, цаг их зарцуулах байдалтай харагдаж байна. Гэвч Монгол орон нь бэлчээрийн мал аж ахуйтай, олон сая тоо толгой малтай стратегийн давуу байдалтай орны хувьд мах, махан бүтээгдэхүүнээ олон улсын худалдаанд гаргах боломжоо ашиглаж, олон улсад тавигдах шаардлаганд технологийн чадавхиа сайжруулж, хөгжүүлэхийг зорьж байна.

Хонь, ямааны өртөг шингээсэн мах, махан бүтээгдэхүүний экспорт хязгаарлагдмал байгаа нь үйлдвэрлэлийн хөгжлийг сааруулах үндсэн хүчин зүйл болж байна.

Дээр дурдсанчилан Монгол малын мах, махан бүтээгдэхүүний олон улсын худалдаа, экспорт нь чамлахаар маш бага байна. Монгол улсад 57.3 сая гаруй хонь, ямаа байгаа боловч жилд гарч байгаа махны тоо 1% д хүрэхгүй бөгөөд үүнээс өчүүхэн төдийг халууны аргаар боловсруулан Хятад улсруу гаргаж байна. Монгол үйлдвэрлэгчдэд тулгарч буй бас нэгэн бэрхшээл нь малчид, махны үйлдвэрүүдэд тавигдах мал эмнэлгийн хяналтууд юм. Олон улсын хэрэглэгчид нэн ялангуяа Ойрх дорнодын орнуудын импортлогчдийн зүгээс мах, махан бүтээгдэхүүнд олон улсын стандартыг хангах мал эмнэлгийн хяналт сул байгааг (OIE⁶¹-ээг үндэслэн) анхааруулж хориг тавьдаг байна. Тиймээс, гадаадын хүчирхэг зах зээл нь Монгол улсаас мах, махан бүтээгдэхүүн худалдан авах сонирхолгүй, идэвхигүй байдаг аж. Энэхүү асуудал нь манай хөрш болох Төв Азийн бусад улс орнуудад ч мөн хамааралтайг энд дурдах хэрэгтэй.

8.1.2. Экспортыг хөнгөвчлөхөд тулгарч буй бэрхшээлүүд

Хүснэгт 44: Монголын экспортыг хөнгөвчлөхөд тулгарч буй бэрхшээлүүд

Хамтын ажиллагаа, мэдлэг хуваалцахад дутагдалтай	<p>Манай орны хөдөө аж ахуй салбар ЖДҮ⁶²-д ихэвчлэн тулгуурладаг учраас дараах чиглэлүүдээр үйлдвэрлэлийн өгөөж дутагдалтай байна, үүнд:</p> <ul style="list-style-type: none">• Олон улсын худалдан авагчдын томоохон эзлэхүүн бүхий эрэлтийг хангах чадавх. Зах зээл дээрх жижиг тоглогчид жижиг цар хүрээтэй захиалгуудтай хэлэлцээ хийж байхад томоохон захиалгууд илүү өртөг-зардал хэмнэсэн, мөн жижиглэнгийн худалдаачдыг мөн оролцуулдаг.• Халал, Даян дэлхийн хөдөө аж ахуйн зохистой дадал, ISO зэрэг үйлдвэрлэлийн чанарын сертификат олгох чадвар. Жижиг үйлдвэрүүд сертификатууд болон холбогдох бусад аудит болон хяналт шалгалтуудын өртгийг сайн дураар төлөх төлбөрийн чадваргүй байдаг.• Салбарын сайн туршлагыг хэрэгжүүлэх чадвар. Хөдөө аж ахуй нь уламжлалт салбар бөгөөд жижиг гэхдээ өндөр инноваци бүхий бизнесийн байгууллагууд байгаа хэдий ч хөдөө аж ахуйн чиглэлийн ихэнх компаниуд мэдлэг ур чадварын хувьд хязгаарлагдмал, олон улсын шилдэг туршлагын хувьд учир дутагдалтай байна.
--	---

⁶¹ Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага

⁶² Жижиг дунд үйлдвэр

Хувийн стандартуудыг хэрэгжүүлэхэд дутагдалтай	<p>Монгол орны үйлдвэрлэгчид стандартуудын ач холбогдлыг бүрэн ойлгож байгаа ч баталгаажуулалтын мэдлэг чадвар дараах чиглэлээр дутагдалтай, үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Стандартын шаардлагыг бүрэн ойлгож, хэрхэн нийцүүлэх талаар туршлагагүй, мэдлэггүй. • Байгууллагын дотоод хяналт шалгалт болон гадны мал эмнэлэг, мэргэжлийн хяналт дутмаг. Иймээс шаардлагат хяналт шалгалтыг тогтмол хийх, сайжруулах ба зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх. • Гадны орны зөвлөхүүд, аудиторуд, байцаагч нар манай улсад урилгаар, гэрээгээр ирж ажиллах боломжтой хэдий ч манай дотоодын үйлдвэрүүд эдгээр зөвлөхүүдийг авч ажиллуулах, стандартуудыг авч хэрэгжүүлэхэд өртөг зардал саад болдог. • Хөдөө аж ахуйн салбар дахь тархай бутархай байдал нь тус тусдаа, жижиг цар хүрээтэй үйлдвэрүүдийг сертификатжуулах боломжийг хязгаарлаж, хамтын ажиллагааны үр шимийг ойлгоогүй экспортлогчид хамтран сертификат авах боломж бүрдээгүй. • Технологийн чадавхи дутагдалтай байгаа нь шаардлагат хяналт шалгалтыг гүйцэтгэх боломжийг олгодоггүй эсвэл хязгаарлагдмал байдлаар хийгдэх нөхцлийг бүрдүүлдэг. • Манай орны махны зах зээлд дээрх ярвигтай асуудлуудыг бүрэн ойлгож, тэдгээрийг сайжруулахад чиглэсэн төлөвлөгөөг боловсруулах, тухайлбал, өөрийн орны баталгаажуулалтын экспертүүд, аудиторудыг бэлтгэх мөн их дээд сургуулиудад тусгай хөтөлбөр бий болгох.
Өндөр өртөгтэй, цаг хугацаа ихтэй ложистикс	Манай орны зах зээлд далайн тээврийн шууд гарц байдаггүйн улмаас махны үйлдвэрүүд, экспортлогчид ложистикийн томоохон бэрхшээлтэй нүүр тулгардаг. Тээвэрлэлтийн бэрхшээлтэй, зардлын тэнцвэргүй байдлаас Ойрх Дорнодын зах зээлд экспортлох Монгол махны үнийг үнэтэй болгож, улмаар бусад улс орнуудын экспортын махан бүтээгдэхүүнтэй өрсөлдөх чадвартай болгож чадахгүй байна.
Санхүүжилтийн боломж дутмаг	Бүс нутгийн хэмжээнд хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчид бэлчээрийг сайжруулах, Хонь, Ямаа худалдан авах зорилгоор бизнесийн зээл, мортгэйж авахад бэрхшээлтэй байдаг. Банкууд хөдөө аж ахуйн зээлдэгч нарт зориулсан бүтээгдэхүүнийг боловсруулж санал болгодог хэдий ч тэдгээрийн шаардлагууд нь ихэнх жижиг дунд үйлдвэрүүдийн хувьд төвөгтэй, шаардлага өндөр, бэрхшээлтэй мөн ойлгомжгүй байна.

8.1.3. Монгол малын мах Ойрх Дорнодод экспортлох боломжийн талаарх тойм

Үйлдвэрийн түүхий эд бэлтгэл, мал төхөөрч, мах боловсруулах технологид эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага, технологийн горимыг чанд баримтлах, мөн Халал гэрчилгээг зохих журмаар авсан тохиолдолд Монгол малын махыг Ойрх Дорнодын зах зээлд экспортлох боломж нээлттэй байна.

Бэрхшээлүүдийг эс тооцвол Монгол мах экспортлогчид өсөн нэмэгдэх хүлээлттэй байна. Манай орны мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл ба экспорт дараагийн 5 жилийн хугацаанд нэмэгдэх хүлээлттэй байна. Манай улсын Засгийн газар, АХБ, НҮБ, Олон улсын худалдааны төв зэрэг олон улсын байгууллагуудын зүгээс үзүүлэх дэмжлэгт тулгуурлаж экспортын журмуудыг хөнгөвчлөх, олон улсын хоёр талт болон олон талт худалдааны хэлэлцээрүүдийг өргөжүүлэх, ялангуяа Ойрх дорнодын орнуудтай хийсэн хэлэлцээрүүдийг дурдаж болно.

Монгол улс нь Дэлхийн Худалдааны Байгууллагын (ДХБ) гишүүн орон бөгөөд Most Favoured Nation (MFN) гэрээний нөхцлүүдийг ч хэрэгжүүлэх боломжтой. Махны тодорхой ангиллыг цар хүрээгээр нь авч үзвэл Монголын мах үйлдвэрлэгчид олон улсын тавцанд мах, махан бүтээгдэхүүний худалдааг хөгжүүлэх бүрэн боломжтой. Мөн байгалийн бэлчээрийн өргөн нутагтай давуу байдлаа ашиглан Монгол улс Халал махны экспортыг хөгжүүлэхэд олон

улсад энэхүү халал махны эрэлт тасралтгүй өсөн нэмэгдсээр байгаа нь бидний судалгаанаас харагдаж байна. Энэхүү зорилгоор Монгол улс Халал мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн талаарх эрх зүйн орчныг бий болгож хууль батлах нь ирээдүйд Монгол бүтээгдэхүүний баталгаажуулалтын тогтолцоог бий болгож тогтвортой зах зээлийн суурийг тавих болно. Доорх SWOT шинжилгээгээр Монгол малын махыг Ойрх Дорнодын орнуудын зах зээлд экспортлох боломжийн тухай шинжилж манай орны үйлдвэрлэгч, экспортлогчдын давуу болон сул талууд, боломж ба бэрхшээлүүдийг тодорхойлов.

8.1.4. SWOT шинжилгээ

Монгол малын мах Ойрх Дорнодын орнуудын зах зээлд экспортлох боломжийн тухай SWOT шинжилгээ

Давуу тал

Монгол улсын хөдөө аж ахуйн салбарын үндсэн бүтээгдэхүүн мах, махан бүтээгдэхүүн

Монгол улс мал аж ахуйн бодлогын хүрээнд махны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийг зорьж байна. Мах үйлдвэрлэгчид, ялангуяа баруун аймгууд болон зарим нөхцөлд төвийн бүсийн үйлдвэрлэгчид хонь, хурга, ямааны хөргөсөн, хөлдөөсөн махыг тэргүүлэх зах зээлд гаргах боломжтой. Монгол улс, мал аж ахуйгаа эдийн засгийн эргэлтэд оруулахын тулд баруун болон төвийн бүс нутгуудад шинээр үйлдвэр барьж технологийн шинэчлэлт хийж Халал, Органик мах, махан бүтээгдэхүүнүүд үйлдвэрлэл хөгжүүлэхэд анхаарч байна.

Олон улсад мах экспортлох боломжууд бий болсон

Хэдэн жилийн өмнөөс Монгол улс Иран, бусад Ойрх Дорнодын орнуудад хонь, ямааны махны экспортыг хөгжүүлэх улмаар олон улсын худалдааг эрчимжүүлэх чиглэлээр ажиллаж байна. Ойрхи Дорнодын орнуудад мах экспортлохын тулд Монголын Засгийн газар, ХХААХҮЯ, МЭЕГ болон мах үйлдвэрлэгчид Олон улсын худалдаанд хориг тавьдаг өвчнөөс эрүүл бүсийн статусын зөвшөөрөл авч тус зах зээлд мах экспортлохоор ажиллаж байна. Иран улсын мал эмнэлгийн албаны төлөөлөгчид манай улсад 2019 онд ирж ажилласан байна. Үүний үр дүнд Монгол улс Иран улсад хонины мах, махан бүтээгдэхүүнийхээ экспортоо үргэлжлүүлэн нэмэгдүүлэх боломжтой болсон.

Голлох экспортлогчид мөнгө хэлэлцэхээс илүү бүтээгдэхүүний үнэ цэнийг эрэлхийлж байна

Монгол улсын эдийн засгийн чадавхи сул байгаач хөдөлмөрийн зах зээл дээр хонь, ямааны аж ахуйн өртөг бага, бусад орнуудтай харьцуулахад эцсийн бүтээгдэхүүнийг хямд үнээр үйлдвэрлэх улмаар голлон нийлүүлэгч орнуудтай өрсөлдөхөд боломж бүрэн байна.

Импортлогч орны иргэд хурга, хонь, ямааны махыг бусад малын махнаас илүү сонгож байна.

Хурга, хонь, ямааны чанартай махыг эрүүл махны сонголтын эхэнд тавьж байна. Эдгээр мах нь өөх тосны агууламж бага, уураг нүүрс ус эрдэс, витамин болон бусад шим тэжээлийн агууламж ихтэй тэнцвэртэй хоол унданд хэрэглэхэд маш баялаг нөөц хэмээн үздэг. Нэн ялангуяа хурганы махны хэрэглээ Ойрх Дорнодын орнуудын соёлд эрүүл мэндийг дэмжигч хүнс хэмээн онцлон үзэж өргөнөөр сонгож байна.

Монгол улс нь бэлчээрийн хэмжээгээр дэлхийд тэргүүлдэг

Монгол улсад хонь, ямааны аж ахуй эрхлэхэд тохиромжтой өргөн уудам бэлчээр нутагтай ба олон улсад мөн бэлчээрийн хэмжээгээр тэргүүлдэг. Иймд Монгол улс дотоод, гадаадад нийлүүлэх махны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бүрэн боломжтой.

Монголын ханган нийлүүлэгчид олон улсын зах зээлийг онилоход зах зээлийн тусгайлсан хэрэгцээг сонгож байна

Персийн булангийн Арабын орнууд махны чанарт өндөр шаардлага тавьдаг тул Монгол улс аль хэдийнээ органик бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тухай хуулийг баталсан нь Персийн булангийн орнуудын зах зээлд нэвтрэх боломжийг нээж байна.

Монгол улс олон улсын худалдааны хэлэлцээрүүдэд нэгдэх нь худалдаанд эерэг нөлөөтэй

Монгол улс ДХБ-ын гишүүн орон болохын хувьд бид MFN (үндэстний нэн тааламжтай тариффын нөхцөл) хэлэлцээрээс ашиг тус хүртдэг.

Олон улсын баталгаажуулалт нь урагшлах арга зам гэдгийг сайтар ухамсарлан ойлгосон

Персийн булангийн Арабын орнуудын худалдан авагчид Халал стандарт, Даян дэлхийн ХААЗД буюу хөдөө аж ахуйн зохистой дадал болон бусад олон улсын баталгаажуулалтын стандартуудыг Монголын үйлдвэрлэгчид олон улсын худалдааны стандарт шаардлага хэмээн хүлээн зөвшөөрч байна. Мөн Монгол улс баталгаажуулалтын чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх боловсролын тогтолцоог хөгжүүлэх шаардлага буй нь ирээдүйд дотоодын үйлдвэрлэгчид олон улсын зөвлөхүүдээс хамааралтай болохгүй.

Сул тал

Монголын мах, махан бүтээгдэхүүн олон улсын хэрэглэгчдэд танигдаагүй

Монгол улсын мах амттай, өндөр чанартай байхад олон улсын хэрэглэгчид энэ талаар сайтар ойлголт мэдлэггүй, Монгол улс мах, махан бүтээгдэхүүний орон гэдэг талаар мэдээлэл дутмаг. Монгол улс Монголд үйлдвэрлэв хэмээх шошготойгоор маркетинг сурталчилгааг дутмаг хийдэг. Монгол улс дахь ихэнхи махны үйлдвэрүүд олон улсын стандартыг хангаж чадахгүй байгаа нь манай орны мах махан бүтээгдэхүүний чанар, баталгаатай эсэхэд эргэлзээ төрүүлдэг байна.

Бүтээмж, үр ашгийг сайжруулна хэмээн төлөвлөсөн ч хэрэгжилт хангалтгүй байна

Монголын хөдөө аж ахуйн салбар тархай бутархай тул зах зээл дээрх жижиг тоглогчид голлох бөгөөд тэд үйлдвэрлэлээ стратегийн түвшинд сайжруулах, мал төхөөрөх газрыг шинэчилах, баталгаажуулалт хийлгэх, тоног төхөөрөмжөө олон улсын түвшинд хүргэх савлагаа болон үйлдвэрлэлийн процесст шинэчлэл хийх санхүүгийн чадамжгүй байна. Арилжааны банкууд хөдөө аж ахуйн бизнес эрхлэгчдэд зээл олгодог хэдий ч хүү өндөр, боломжит зээлийн хэмжээ хангалтгүй, банкны зээл олгох журам төвөгтэй, удаашралтай байгаа нь бичил, жижиг бизнес эрхлэгчдийг боломжуудаас зааглаж байна.

Монгол улс өрсөлдөөн дүнд хямд үнийг санал болгох хэдий ч хөрөнгө оруулалт нэн тэргүүлэх асуудал

Улс орны эдийн засгийн хөгжлийн улмаас хөдөлмөрийн өртөг, үйл ажиллагааны өртөг зардал, газраар тээвэрлэх өртөг, бусад зардлууд хөгжингүй орны өрсөлдөгчидтэй харьцуулахад доогуур байна. Мөн Монголын үйлдвэрлэгчид олон улсын худалдан авагчдын эрэлтийг хангах зорилгоор стандартыг зохих шаардлагыг дагуу боловсруулж, нэвтрүүлэхэд бэлэн байна. Гэвч, монголын үйлдвэрлэгчдэд олон улсын худалдан авагчдын итгэл үнэмшлийг олж авснаар захиалга нэмэгдэнэ.

Байгалийн гаралтай хэдий ч олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нотолгоо үйлдвэрлэлд дутмаг

Монгол малын мах үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн нь байгалийн гаралтай, органик бүтээгдэхүүн байсаар байхад түүнийгээ олон улсын зах зээлд харуулах органик, эко эсвэл био хэмээх баталгаажуулалтыг аваагүй байна. Үүнийг авах шаардлагатай байна.

Мал эмнэлгийн хяналт шалгалт дутмаг байгаа нь олон улсын худалдааны боломжуудад бэрхшээл учруулж байна

Монголын үйлдвэрлэгчдэд тулгарч буй дараагийн нэг сорилт бэрхшээл нь малчид, мал төхөөрөх газруудад мал эмнэлгийн хяналт шалгалт дутмаг явдал. Учир нь олон улсын стандартад нийцүүлэхэд мал эмнэлгийн чанд хатуу хяналт шалгалт байхгүй. Иймд гадаадын олон зах зээл Монголын ханган нийлүүлэгчдээс мах, махан бүтээгдэхүүн авахаас татгалздаг.

Мах экспортлогчид ижил чанартай бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэхэд бэрхшээлтэй тулгардаг

Монгол улс байгалийн бэлчээрийн маллагаатай 30.1 сая хонь, 27.3 сая ямаа байгаа боловч хөдөө аж ахуй нь тархай бутархай, хувиараа аж ахуй эрхлэгчдийн уялдаа холбоо дутмаг тул бүтээгдэхүүний масс хэмжээг бүрдүүлэхэд Монголын экспортлогчдийн бүтээгдэхүүний чанар ялгаатай, мөн мал эмнэлгийн хяналт шалгалт олон янзын түвшинд байгаа нь сөргөөр нөлөөлж байна. Энэхүү асуудлыг Иран болон дотоодын зах зээлд хүлээн зөвшөөрөх ч энэ нь тэргүүлэх зах зээлд буюу Ойрх Дорнодод чанартай бүтээгдэхүүнээ экспортлоход бэрхшээл учруулж байна.

Монголын худалдаа хөрш орнуудад ихээхэн төвлөрч, цаашид төрөлжүүлэхэд дутагдалтай

ОХУ болон Хятад улс нь монголын үйлдвэрлэгчдийн экспортын үндсэн зах зээл хэвээр байсаар байна. Энэ нь газар зүйн байршил, түүх соёлын харилцааны уламжлалтай холбоотой боловч Монголын зах зээлд Хятад улс дангаараа төвлөрөх сонирхол, Монголын үйлдвэрлэгчдийн өөрийнх нь эдийн засгийн чадамж, технологийн шинэчлэл зэрэг асуудал нөлөөлсөн байж болох юм. Иймээс Монголын үйлдвэрлэгчдийн дунд бусад тэргүүлэх зах зээл хөндөгдөхгүй хэвээр байна.

Дотоодын малчид, үйлдвэрлэгчид олон улсын зах зээлийн шаардлагыг мэдэхгүй, мэддэг хэсэг нь түүнд нийцүүлэн ажлын арга барилаа өөрчлөх, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх сонирхолгүй байгаа нь дотоодын болон Хятадын зах зээл дээрх одоогийн үйлдвэрлэлийн ашигтай байдалд сэтгэл ханасан байгаатай холбож болно. Мөн олон улсын зах зээлд экспортлох ашиг тус, шаардлагуудын талаарх мэдээллийг өргөн хүрээнд хуваалцах ажил дутмаг байна.

Баталгаажуулалт болон сайн дурын стандартжуулалт

Монголын үйлдвэрлэгчид олон улсын баталгаажуулалт, худалдан авагчдын Халал, Даян дэлхийн ХААЗД, олон улсын махны үзэсгэлэн худалдааны (шаардлага өндөр) ба ISO 22000 зэрэг стандартын шаардлагуудад нийцэж ажиллах хэрэгцээг ойлгодог. Зарим томоохон үйлдвэрлэгчид ISO 22000 хэрэгжүүлсэн туршлагатай. Гэсэн хэдий ч олонх ЖДҮ-д энэхүү стандарт шаардлага баталгаажуулалтыг зөвхөн онолын хэмжээний ойлголттой, амьдрал дээр хэрэгжүүлэх явдал нэн дутагдалтай байна. Дотоодын үйлдвэрлэгчдэд баталгаажуулалтын үе шатанд туслалцаа үзүүлэх дотоодын баталгаажуулалтын байгууллагууд болон тусгайлан бэлдсэн аудиторуд, зөвлөхүүд хангалтгүй байна. Цаашилбал, ихэнх үйлдвэрлэгчид баталгаажуулалтыг хийлгэх төлбөрийн чадваргүй байна.

Зах зээлд нэвтрэх

Монгол улсад олон улсын худалдааг сайжруулах нь стратегийн зорилт мөн боловч Монголын үйлдвэрлэгчид, мал төхөөрөх газрууд болон экспортлогчид олон улсын зах зээл, Хятадаас бусад гадаадын зах зээлд нэвтрэхэд тэдгээрийн шаардлагуудын талаарх ойлголт мэдлэг сул байна.

Тархай бутархай байдал, үйлдвэрлэлд тулгуурласан эдийн засгийн салбар Ойрхи Дорнод, Персийн булангийн орнуудын зах зээлийн хууль эрх зүйн шаардлагуудын талаарх ойлголт бага байна. Тиймээс тус салбарт сайн дурын баталгаажуулалт, стандартын шаардлагуудын талаар боловсрол мэдээллийг түлхүү олгох шаардлагатай. Мөн олон улсын зах зээлд хөл тавихад экспортын үйл ажиллагааны процессийн талаар албан болон албан бус шугамаар боловсрол олгох шаардлагатай байна.

Персийн булангийн орнууд	Өмнөд Ази
<p>Зах зээл Импортын хамааралтай Персийн булангийн орнуудын зах зээлд хурга, хонь, ямааны махны хэрэглээ ялангуяа шашны зан үйлийн баярын хугацаанд нэмэгддэг.</p>	<p>Зах зээл Малайз, Индонезийн зах зээл гадаад худалдаанаас чанартай халал махны хэмжээг нэмэгдүүлэхийг зорьж байна.</p>
<p>Бүтээгдэхүүн ПБХАЗ-ийн орнуудад дотоодын үйлдвэрлэл хязгаарлагдмал тул импортын хамаарал ихтэй. Тиймээс хурга, хонь, ямааны махны эн тэнцүү боломжууд бий. Гэвч Монголын үйлдвэрлэгчдийн ойлголт мэдлэг дутмагаас худалдааны түншлэлийг бий болгоход махны технологийн чанарын асуудал үндсэн бэрхшээлт асуудал болж байна.</p>	<p>Бүтээгдэхүүн Малайз, Индонезийн зах зээлд дотоодыг махны үйлдвэрлэлийг онцолдог хэдий ч энэ нь тахианы маханд төвлөрч байхад хонь, ямааны Махны үйлдвэрлэл хангалтгүй, үнийн хувьд өндөр, өрсөлдөөнгүй байна. Хонь, ямааны махны боломж нь сайн чанарын бүтээгдэхүүн, органик махны төрөлд хамаарагдаж байна. Энэхүү зах зээл нь эн тэргүүнд жижиглэнгийн эцсийн хэрэглээнд төвлөрдөг ч хоол хүнсний үйлчилгээ томоохон цар хүрээтэй.</p>
<p>Худалдааны гэрээнүүд ПБХАЗ-ийн чөлөөт худалдааны бүс нутаг нь Ойрхи Дорнодод худалдааг давхар экспортлох боломж. Монгол болон ПБХАЗ-ийн орнууд худалдааны томоохон харилцаа дутагдалтайг эс тооцвол хоёр талт худалдааг хөгжүүлэх талаар худалдааны гэрээ байгуулсан.</p>	<p>Худалдааны гэрээнүүд</p>

Бэрхшээлүүд

Зах зээлд нэвтрэх

- ПБХАЗ-ийн орнуудын худалдан авагчид Монголын ханган нийлүүлэгчидтэй худалдааны туршлагагүй. Харин Өвөр Монголтой хийсэн худалдааны сөрөг туршлагаас үндэслэн Монгол улсыг холбон ойлгодог. Иймд Монголын ханган нийлүүлэгчдээс нэмэлт баталгаажуулалт буюу хуулинд нийцсэн эсэх баталгааны талаар шаардлага тавиагүй нөхцөлд ПБХАЗ-ийн орнуудын худалдан авагчдыг чанар, хянан нийцүүлэлтийн асуудлаар ятгах, итгэл үнэмшлийг авахаар зорих хэрэгтэй.
- Тээвэрлэлтийн хувьд Хятад улс Ойрхи Дорнодод хамгийн дөт худалдааны корридор болох хэдий ч Хятад улс хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хорио цээрийн шаардлагын стандарт батлан хэрэгжүүлж байна. Тиймээс Өмнөд Ази, Ойрхи Дорнодыг худалдан авагчидтай худалдааны аливаа харилцааг эхлүүлэхээс урьтаж импорт хорио цээрийн шаардлагын зөвшөөрлийг авах чиглэлээр ажиллах шаардлагатай.

Монголын үйлдвэрлэгчдийн ойлголт мэдлэг дутмаг

Монголын махны үйлдвэрлэгчид тэргүүлэх зах зээлд танигдаагүй тул худалдан авагчид Монголын мах, махан бүтээгдэхүүний тухай ямарч ойлголтгүй, түүнчлэн Ойрх Дорнодын хэрэглэгчид монгол махны чанар, амтыг амталж ч үзээгүй.


Чанарын шаардлагыг хангахад тулгардаг технологийн бэрхшээлүүд

Олон улсын тэргүүлэх зах зээлүүдэд махны чанарт хуулинд заасны дагуух дэлгэрэнгүй шаардлагуудаас илүүтэй хуулинд нийцүүлэн боловсруулсан байх шаардлагуудыг тавьдаг. Тэргүүлэх зах зээлийн орнууд импортолж байгаа бүтээгдэхүүний чанарын хяналт шалгалтыг хангасан тохиолдолд л уг бүтээгдэхүүнийг импортолдог. Иймд Монгол улсын үйлдвэрлэгчид, экспортлогчид бүтээгдэхүүнээ экспортын өмнө бүтээгдэхүүнийхэечанарын стандартыг хэрхэн хангаснаа шалгуулан баталгаажуулах хэрэгтэй. Гэвч дотоодын хяналт шалгалтын лабораториуд тоног төхөөрөмж дутагдалтайн улмаас хөгжингүй орнуудын худалдан авагчдын шаардлагын дагуух хяналт шалгалтуудыг хийж чаддаггүй, хийсэн ч хуучирсан тоног төхөөрөмжийн үр дүн тэр бүр итгэхэд бэрх байгааг анхаарах нь зүйтэй байна.

8.1.5. Маркетингийн шинжилгээ

Аливаа бараа бүтээгдэхүүний тухайн зах зээлд нэвтрэх, борлуулалтын боломжуудаа тодорхойлох, нэмэгдүүлэх зорилгоор маркетингийн ач холбогдол бүхий иж бүрдлүүдийг авч үздэг ба Ойрх Дорнодын орнуудын махны зах зээлд маркетингийн ямар арга хэрэгслүүдийг хэрэглэх талаар олон улсад түгээмэл хэрэглэгддэг 7P шинжилгээг (Зураг 20) хийж тусгалаа.

Зураг 20. Маркетингийн 7P шинжилгээ



Product – Бараа бүтээгдэхүүн

Мах, махан бүтээгдэхүүний зорилтот зах зээлд чиглэсэн таваарын чанар, ангилал, савалгааны онцлог чухал ач холбогдолтой. Манай улсаас ойрх дорнодын улсуудад экспортлох мах, махан бүтээгдэхүүнүүд нь зорилтот хэрэглэгчдийн шаардлагыг хангасан, өрсөлдөх чадвар бүхий чанарыг агуулах нь чухал:

- Барааны тэмдэг, (Брэнд) нэр, шошго нь Монгол улсыг онцолсон, бэлчээрийн мал аж ахуйн шинжийг агуулсан;
- Бараа, бүтээгдэхүүний чанар, онцлог шинж чанаруудыг харуулсан (Халал, эко, органик г.м.);
- Харагдах байдал, хийц, загварын онцлогтой;
- Савлагаа нь энгийн савлагаанаас вакумдах болон дэвшилтэт технологи бүхий савалгааг ашигласан (MAP г.м.);
- Бараа, бүтээгдэхүүний ангилал (Гулууз, өрөөл, ястай болон ясгүй хэсэглэсэн мах г.м.);
- Бараа, бүтээгдэхүүний төрөл (Хонь, ямаа, хурганы г.м.).

Price - Үнэ

Үнэ бол маркетингийн чухал хэрэгслийн нэг бөгөөд байгууллагын эцсийн ашигт шууд нөлөөлдөг хүчин зүйл. Бараа бүтээгдэхүүний үнийг тодорхойлохдоо бүтээгдэхүүний өртөг, тээвэр, өрсөлдөгчдийн санал болгож буй үнэ, ашгийн хувь болон бүтээгдэхүүний чанар, онцлогийг харгалзан үзэх шаардлагатай. Аж ахуйн нэгжүүд өөрсдийн бүтээгдэхүүний үнийн бодлогоо зөв хэрэгжүүлэхийн тулд дараах ангилалуудыг хэрэглэх нь тохиромжтой.

- Зах зээлд нэвтрэх үнэ тогтоох бодлого (шинэ зах зээлд нэвтрэх, өрсөлдөгчдийн дунд хэрэглэгчийн сегментээ тодорхойлох, байр сууриа эзлэх, тэргүүлэх г.м.);
- Гэрээний үнэ – гэрээний үнэ нь худалдагч худалдан авагч хоорондоо гэрээгээр тохиролцсон үнэ ба гэрээний нөхцлийн дагуу гүйцэтгэх үүргээс хамаарч өөр өөр байна (Гэрээнд тээвэрлэлтээ худалдан авагч хариуцах г.м.);
- Жижиглэнгийн үнэ – компани нь эцсийн хэрэглэгч хүртэл борлуулах борлуулалтын компани биш ч гэсэн өөрийн бараа бүтээгдэхүүний хэрэглэгчдэд хүрч буй эцсийн үнийг хянаж байх шаардлагатай (хэрэглэгчдэд хүрэх үнэ нь бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэгчдийн ашиг, татвар хураамжуудыг багтаасан байдаг);
- Борлуулалтын суваг болон хэмжээнээс хамаарч үнэ тогтоох (Худалдан авагч газар Улаанбаатраас шууд худалдан авалт хийх эсвэл тоо хэмжээнээс хамаарч урамшуулалт үнэ зарлах г.м.);
- Багц үнэ тогтоох (Хонь, ямааны махыг багцалж санал болгох);
- Улирлын үнэ тогтоох (Намар мал төхөөрөхөд тохиромжтой үед илүү боломжит үнэ санал болгох г.м.).

Place - Худалдааны талбар (Хуваарилалт)

Бүтээгдэхүүн нь зорилтот хэрэглэгчдийн худалдаа хийх талбар дээр очсон байх шаардлагатай ба хэрэгтэй цагт хэрэгтэй хүнд харагдаж түүнд худалдан авалт хийх боломжийн олгосон байх нь чухал. Үүнтэй холбоотойгоор компани борлуулалтын нөхцөл, сувгуудаа тодорхойно.

- Зах зээл, төлөвлөж буй зах зээлийн сегментүүдийг тодорхойлох (Саудын Араб, Катар эсвэл Кувейт г.м., эсвэл газар зүйн байдлаар эзлэх стратеги);
- Борлуулах сувгаа тодорхойлох (өөрийн орноос, хилийн нөхцлөөр, газар дээр нь, зуучлагчаар дамжуулж г.м.);
- Борлуулалтын хэлбэр (байнгын нийлүүлэлт, хязгаарлагдмал нийлүүлэлт, тодорхой төрлийн нийлүүлэлт г.м.);
- Борлуулалтын нөхцөл (хямдрал, зуучлагчийн хувь, борлуулалтын шаардлага, хүлээлгэх хариуцлага г.м.);
- Өрөл болон байршуулалт, хадгалат (лангууны байршил, байршуулах хэсэг, хадгалалтын горим (хөргөгч, хөлдөөгч), нэр төрөл г.м.);
- Барааны нөөц (Борлуулалтын тогтвортой байдлыг хадгалах нөөцийн хэмжээг хадгалах хугацаатай нь уялдуулж бүрдүүлэх);
- Эцсийн хэрэглэгчид хүрэх борлуулалтын сувгууд нь гипермаркет, супермаркет, махны зориулалтын дэлгүүрүүд, махны захууд, бөөний болон жижиглэнгийн цэгүүд, онлайн худалдаа, сүлжээ худалдааны цэгүүд байх боломжтой).

Promotional – Идэвхжүүлэлт

Идэвхжүүлэлт нь бараа бүтээгдэхүүнд худалдан авагчийн анхаарлыг татаж түүний давуу тал, голлох шинж чанаруудын тухай бүхий л мэдээллийг олгож худалдан авалт хийх болон дахин худалдан авалт хийхэд чиглэсэн аливаа үйл ажиллагааг хамаатуулж ойлгоно (Зураг 21).

- Аливаа аж аж ахуйн нэгж идэвхжүүлэлтийн нөөц бололцоогоо тодорхойлж тодорхой санхүү хуваарилах нь чухал;
- Идэвхжүүлэлтийн зорилтот хэрэглэгчийн онцлогт өөрийн бүтээгдэхүүний онцлогийг шингээж хүргэх (Бэлчээрийн мал аж ахуйн онцлогийг тусгах г.м.);
- Төрөл бүрийн олон улсын худалдааны арга хэмжээ, үзэсгэлэн зэрэгт оролцох;
- Худалдан авагчтай харилцаа тогтоох боломжтой сувгуудаар мэдээллээ хүргэх;
- Харилцаа холбоо тогтоох газар зүйн хуваарилалт хийж түүнд чиглэж ажиллах (Саудын Араб болон Катар г.м.);

- Сурталчилгааны бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, онлайн сурталчилгааг ашиглах (Богино зар сурталчилгаа, кино хийх г.м.);
- Байнгын идэвхжүүлэлтийн механизмийг бий болгох (Бүтээгдэхүүн бүрт дагалдах маркетингийн арга хэлбэрүүдийг ашиглах).

Зураг 21. Идэвхжүүлэлтийн алхамууд



People – Хүмүүс

Маркетингийн үйл ажиллагаанд бүтээгдэхүүний худалдааны бүхий л үйл явцад оролцож буй хүмүүс маш чухал байр суурь эзэлдэг ба эцсийн борлуулалтанд нөлөөлдөг. Иймд үйлдвэрлэл, худалдааны бүхий л хэлхээнд оролцож буй хүн хүч, боловсон хүчний ажлын чанар, хариуцлага, санаачлагад зайлшгүй анхаарах шаардлагатай. Үүнд:

- Аж ахуйн нэгжийг болон бүтээгдэхүүнийг төлөөлж буй ажилтнууд;
- Эцсийн хэрэглэгчидтэй шууд харьцах худалдааны ажилтнууд;
- Нэр хүнд бүхий худалдан авагчид;
- Бараа, бүтээгдэхүүний чанарт шууд нөлөөлөх үйлдвэрийн ажилтнууд;
- Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны явцад шууд бусаар нөлөөлөх ажилтнууд.
- Бизнесийн үйл явцад шууд болон шууд бус оролцоотой хүн хүчний талаар тодорхой хэмжээний бодлого боловсруулан хэрэгжүүлэх нь үр дүнтэй байдаг. Үүнд:
- Компаний ажилтнуудын ур чадвар, хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн урамшууллын тогтолцоо, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх нь чухал;
- Нөлөө бүхий хэрэглэгч болон хэрэглэгчдэд нөлөөлөх албан тушаалтантай ажиллах арга барил, тогтолцоо бий болгох;
- Дахин худалдан авагчдад зориулсан хөтөлбөр;
- Эцсийн хэрэглэгчтэй харьцах худалдааны боловсон хүчнээ чадавхжуулах байнгын сургалтууд хийх;
- Эргэх холбоо бүрдүүлэх арга зүйг ашиглах.

Packing – Сав баглаа

Сав баглаа, боодол нь маркетингийн үндсэн хөшүүргүүдийн нэг бөгөөд борлуулалтанд шууд нөлөөлөх хүчин зүйл. Сав баглаанд тавигдах үндсэн технологийн шаардлагыг зөрчихгүйгээр

хэрэглэгчдийн анхаарлыг татах, бүтээгдэхүүний мөн чанарыг илтгэх мөн бүтээгдэхүүний онцлогийг тусгаж чадах нь өрсөлдөгчид дунд давуу байдлыг олж авах нэг арга хэрэгсэл юм. Мөн сав баглаа нь өөрөө чанарыг илтгэж байх ёстой. Хийц хэлбэр, дизайны хувьд онцлог, материалын сонголт зөв, ялангуяа мах, махан бүтээгдэхүүнд хадгалалт, тээвэрлэлтэнд чанараа алддаггүй сав, баглаа боодлыг сонгох нь зүйтэй. Тухайлбал сэврээсэн махыг тухайн орны стандартын дагуу (хаа, гуя, цээр нуруу, хүзүү, хавирга) болгон ангилж зориулалтын сав, баглаа ашиглах ба тээвэрлэлтийн нөхцөл, хугацаанаас хамаарч савлах технологио сонгож савлан хадгалалтын горимонд шилжүүлнэ. Тээвэрлэлтийн хугацаа урт байх тохиолдолд олон улсад түгээмэл хэрэглэгдэж буй дэвшилтэт савалгааны төрлүүдээс (MAP, CAP, VAC)⁶³ сонгож савлах боломжтой.

Purchase – Худалдан авалт

Маркетингийн чухал хэрэгслийн нэг хэрэглэгчийн худалдан авалтын сувгууд болон түүнд нөлөөлөх хүчин зүйлүүд. Зар сурталчилгааны арга хэлбэрээ сонгож зорилтот хэрэглэгчийн идэвхтэй худалдан авах сувгуудаар явуулах нь тодорхой үр дүнтэй (Зураг 22).

Зураг 22. Худалдан авалт

Худалдан авалт



Эх сурвалж: MLA Global Consumer Tracker,

- Эцсийн хэрэглэгч махыг зориулалтын газраас авахыг илүүд үздэг байна

Худалдаж авахад нөлөөлөх хүчин зүйлс

ПБХАЗ-ын зах зээл
Худалдааны төвийн сурталчилгаа
Найз нөхөд/танил
Зурагтын зар сурталчилгаа
Сонин, сэтгүүл
Хоолны нэвтрүүлэг
Махны гарал үүсэл

Эх сурвалж: MLA Global Consumer Tracker,

Маркетингийн онолын түвшинд аливаа бүтээгдэхүүний олон улсын зах зээлд гарахад хангасан байх нийтлэг шаардлагуудыг гаргасан байдаг. Үүнээс дараах гурван үндсэн шаардлагыг онцлон тэмдэглэв.

1. **Тохиромжтой байх:** Зорилтот хэрэглэгчийн эрэлтэнд нийцсэн байх буюу энэхүү нийцэл нь шаардлагатай технологи, стандартуудын шаардлагыг бүрэн биелүүлсэн байх.
2. **Хэрэглэхэд хялбар:** Ажиллагаа багатай, савалгааг онгойлгох, авч явах болон хэрэглэхэд хялбар, жин, нэр төрөл нь хэрэглээний онцлогт тохирсон байх.
4. **Өрсөлдөхүйц байх:** Бусад ижил төрлийн бүтээгдэхүүнүүдтэй өрсөлдөхүйц байх, аливаа шинж чанараараа ялгарах, өвөрмөц онцлогоо тусгасан болон дэвшилтэт сав баглаатай байх гэх мэт шинжүүдийг агуулна (MAP савалгаатай, Халал, Эко, Органик, Бэлчээрийн г.м.).

⁶³ <https://www.sciencedirect.com/topics/food-science/controlled-atmosphere-packaging>

Дээрх шаардлагуудыг хангасан тохиолдол бүтээгдэхүүн нь гадаад худалдааны маркетингийн нийтлэг шаардлагыг хангасан гэж тодорхойлж байна.

8.1.6. Хонины Халал махны экспортын үр ашгийн тооцоолол (Жишээ)

Эрүүл мал бэлтгэл, Халалын чанарын шаардлагуудыг хангасан тусгаарлагдсан аж ахуй бүхий үйлдвэрээс гарсан 1кг ангилж савласан махны дундаж өртөг 7,354 төгрөг болж байна. Үүнд амьд хонины дундаж жин 43 кг ба махны гарцыг 38%, амьд хониний үнийг 80 мянган төгрөгөөр тооцсон болно.

Хүснэгт 45. Халал аргаар ангилж савалсан махны үйлдвэрлэлийн дундаж өртөг (Катар Улсын жишээ)

Үзүүлэлт		Тайлбар
Амьд хонины дундаж жин, кг	43.00	Дундаж жин
Гулууз гарц, %	38.0%	Махны гарцын хувь
Махны гарц, кг	16.34	Махны гарц
Амьд хонины үнэ, төгрөг	80,000.00	Амьд хонины бөөний дундаж үнэ
1кг махны үнэ, төгрөг	4,895.96	Өртөг шингээгүй 1кг махны дундаж үнэ
Үйлдвэрийн өртөг, төгрөг/кг	1,958.38	Үйлдвэрийн өртөг махны үнийн 40%
Ангилсан махны үнэ, төгрөг/кг	6,854.35	Үйлдвэрийн өртөг шингэсэн махны үнэ
Савалгааны зардал	500.00	Савалгааны зардал
Үйлдвэрлэлийн өртөг	7,354.35	Үйлдвэрийн аргаар ангилж савалсан махны өртөг

Хүснэгт 46. Экспортын үнийн задаргааны жишээ

Зардалын төрөл	\$/кг	Тайлбар
Үйлдвэрлэлийн өртөг	2.72	Үйлдвэрийн аргаар ангилж савалсан мах
Авто тээврийн зардал: Улаанбаатар-Владивосток	0.38	Хөргүүртэй 20 тонны контейнерээр 16 тонн савалсан мах тээвэрлэхэд
Далайн тээврийн зардал: Владивосток-Катар	0.23	Хөргүүртэй 20 тонны контейнерээр 16 тонн савалсан мах тээвэрлэхэд
Импортын татвар (5%)	0.17	Катар улсын импортын гаалийн татвар (5%)
Бусад зардал	0.70	Даатгал, Шинжилгээний зардал, Транзит тээвэр зөвшөөрөл, Ачилт буулгалт, сэлгээний зардал, Мэдүүлэг хураамжийн зардал
Нийт өртөг	4.20	Хонины махны экспортын дундаж өртөг
Импортын гаалийн дундаж үнэ	5.22	Катар улсын гаалийн дундаж үнэ
Ашиг	1.02	
Ашгийн хувь	19.5%	

Халал аргаар ангилж савалсан хонины махны экспортын өртөг нь 4.20 ам.доллар болж байна. Энэхүү өртөгт тээврийн зардлыг 20 тонны хөргүүртэй контейнерт 16 тонн ангилж савалсан хонь, ямааны хэсэглэсэн, хөлдүү ястай мах тээвэрлэх жишээгээр тооцов. Ам.долларын ханшийг 2,700 төгрөгөөр бодов. Катар улсын импортын дундаж үнэ нь 5.22 ам.доллар бөгөөд 1кг хонины махнаас дундажаар 1.02 ам.доллар ашигтай ажиллахаар харагдаж байна. Энэхүү жишээгээр зорилтот орнуудын шаардлагыг хангасан аж ахуйн нэгж тогвортой экспорт хийж жилд нэг мянган тонн мах экспортлоход нэг сая ам доллар буюу 2.7 тэрбум төгрөгийн ашиг хүртэхээр байна. Мөн дотоодын үйлдвэрүүдийн олон улсын худалдааны талаархи мэдлэг, туршлага, ажлын байр нэмэгдэж эх орны эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ. Махны чанар, сав баглаа, маркетингийн үйл ажиллагааг идэвхижүүлэн сайжруулсанаар бүтээгдэхүүний экспортийн үнэлгээг өсгөх боломжтой.

8.2. ТЭЭВЭРЛЭЛТ

Монгол улсын гадаад тээврийн өнөөгийн байдал

Монгол улс далайд гарцгүй, эх газраар хүрээлэгдсэн бөгөөд Замын-үүд болон Сүхбаатар зэрэг хилийн боомтоор БНХАУ болон ОХУ-г холбосон төмөр замаар, мөн Эрэнцав - Соловьевск өртөөгөөр импорт, экспортын ихэнх тээврүүд Хятад, Оросын чиглэлд тээвэрлэгдэж тус улсуудаар транзитаар дамжин өнгөрдөг. Авто-замаар болон агаарын тээврээр тодорхой хэмжээний тээвэр хийгддэг боловч агаарын тээвэр тогтмол ачаа эргэлтгүй, нэг талын тээвэр хийхэд зардал өндөр байна. Авто-замын тээврээр гол төлөв хил орчмын болон бүс нутгийн хэмжээнд тогтмол ачаа тээвэрлэж байна.

8.2.1. Зорилтот орнуудад тээвэрлэлтийн оновчтой байдал

Саудын Араб, Катар, Кувейт

Манай улсын хувьд далайд шууд гарцгүй боловч олон улсын төмөр зам, агаар болон авто замын сүлжээг ашиглан Ойрх Дорнодын орнуудад ачааг хүргэх боломжтой. Тээвэрлэлтийн хугацаа, ачилтын нөхцөлөөс хамаарч хөлдүү махыг ОХУ-ын нутаг дэвсгэрээр авто замаар - ОХУ-ын Владивосток усан порт хүргэж үүнээс Ойрх Дорнодын орнуудад хүргэх боломжтой. Харин Сэврээсэн махны төрлийг авто замаар ОХУ, Азербайжан, Ираны нутаг дэвсгэрээр дамжиж дундаж 10-14 хоногт хүрэх боломжтой ч зарим нэг орнуудын гадаад харилцааны таагүй байдлаас хамаарч өндөр эрсдэлтэйг анхаарах шаардлагатай. Сэврээсэн болон шинэ төрлийн махыг агаарын тээврээр саад бэрхшээлгүй тээвэрлэх боломжтой. Төмөр замын тээвэр нь сэлгэн ачилт, тээвэрлэх нөхцлийн хяналт сул, хугацаа маш урт, олон сэлгэн ачилттай, төмөр замын шууд сүлжээ байхгүй зэргээс шалтгаалан эрсдэл өндөрт тооцогдож байна.

Зураг 23. Зорилтот орнуудын боомт хүртэлх тээврийн дундаж замын урт, хугацаа, өртөг

Ойрх Дорнод хүртэлх тээврийн зам, хугацаа, өртөг

	Замын урт /км/	Хугацаа	Өртөг /нэгж кг, ам.доллар/
	5,400	1-2 хоног	3-5 \$
 Улаанбаатар- Владивосток – 0.38 \$ Владивосток порт – Ойрх Дорнод – 0.8 \$	15,000	20-30 хоног	1-1.3 \$
	9,000	8-14 хоног	2-2.1 \$

Зураг 23т авто тээврийг Улаанбаатраас ОХУ-ын Владивосток усан боомт хүртэл тээвэрлэлтийн үзүүлэлтийг харуулсан болно. Улаанбаатраас ПБХАЗ-ийн орнуудад автомашинаар тээвэр хийхэд нийт 9,000 гаруй км газар туулж дундажаар 2 ам доллар орчим тээврийн зардлаар 8-12 хоног зарцуулж хүрэхээр байна.

Агаарын, далайн болон автозамын тээврийн давуу ба сул талыг судалсанаар агаарын

тээвэр сэлгэн ачилтгүй, богино хугацаанд зорилтот газар хүрэх боломжтой ч хоёр талын ачаагүй тохиолдолд өртөг өндөр байгаа нь харагдаж байна. Цаашид гадаад худалдааны эргэлт, аж ахуйн

нэгжүүдийн хамтын ажиллагааны үр дүнд зардлаа хуваалцах зарчмаар агаарын тээврийн өртгөө бууруулах боломжтойг Саудын Араб манай улсын жишээн дээр авч үзэж болох ба Саудын Арабаас манай улс жилд 2 сая орчим долларын элсэн чихэр импортолж байна. Далайн тээврийн хувьд тээвэрлэх хугацаа урт боловч өртөг харьцангуй хямд байх дүр зураг харагдаж байгаа ба авто-замаар тээвэрлэхэд цаг хугацаа, өртгийн хувьд дундаж байгаа (Зураг 23).


Зураг 24. Агаарын, далайн болон авто-замын тээврийн давуу болон сул талууд

Давуу болон сул талууд



Ойрх Дорнодын улсуудад мах экспортлогчдийг тэргүүлдэг Австрали улсаас зорилтот орнуудад далайн тээврийн замын урт болон хугацааны харьцуулалтыг ОХУ-ын Владивосток боомттой хийхэд 2000 гаран км-ийн зам болон тээвэрлэх хугацааны 5 хоногийн зөрүү гарсан. Улаанбаатраас Владивосток боомт хүртэл авто-зам болон төмөр замаар тээвэр хийх боломжтой ба дундаж хугацаа нь 3-7 хоног байгаа нь нийт тээвэрлэлтийн хугацаа замын урттай харьцуулахад ойролцоо байна.


Зураг 25. Австрали улсын далайн тээврийн харьцуулалт



Зураг 26. Улаанбаатраас ОХУ-ын Владивосток боомт хүртэлх зураглал



Зураг 27. Саудын Араб улсын Даммам боомт хүртэлх зураглал




Зураг 28. Катар улсын Доха боомт Кувейт улс хүртэлх зураглал



Малайз, Индонез Улс

Малайз, Индонез улсын хувьд мөн адил мах болон махан бүтээгдэхүүнийг далайн тээврээр тээвэрлэх нь оновчтой хувилбар гэж үзсэн ба өртгийн хувьд харьцангуй хямд өртөгтэй.

Зураг 29. Владивостокийн боомтоос Индонез, Малайз улс хүрэх зураглал



8.2.2. Зорилт улсуудын тухайн боомтууд хүртэлх тээврийн зардал

Хүснэгт 47. Улаанбаатараас Ойрхи Дорнод хүртэлх тээврийн зардал

Хаанаас	Боомт нэрс	Тээврийн төрөл	Тээврийн зардал (\$/кг)
Улаанбаатар	Владивосток	Авто	0.38
Владивосток	Саудын Араб боомт Даммам	Далай	0.19-0.23
Владивосток	Кувейт боомт	Далай	0.19-0.23
Владивосток	Катар боомт Доха	Далай	0.19-0.23
Нийт тээврийн зардал			0.56-0.8

Эх сурвалж: Ландбридж ХХК

Дээрх хүснэгтээс харахад Улаанбаатараас Ойрх Дорнодын орнуудын усан боомтууд хүртэл 1кг махыг дундажаар 0.56 Ам доллараар тээвэрлэхээр урьдчилсан тооцоо гарч байна. Дээрх үнэд Владивосток порт дээрх буулгах, шилжүүлэн ачих, гаалийн бүрдүүлэлт хийх болон нэмэлт зардлууд ороогүй.

Хүснэгт 48. Улаанбаатараас Зүүн Ази хүртэлх тээврийн зардал

Хаанаас	Боомт нэрс	Тээврийн төрөл	Тээврийн зардал (\$/кг)
Улаанбаатар	Владивосток	Авто	0.38
Владивосток	Малайз боомт	Далай	0.15-0.20
Владивосток	Индонези боомт	Далай	0.15-0.20
Нийт тээврийн зардал			0.53-0.7

Эх сурвалж: BFC ложистикс ХХК

Улаанбаатараас Зүүн Азийн усан боомтууд хүртэлх 1кг махыг дундажаар 0.53 ам доллараар тээвэрлэхээр урьдчилсан тооцоо гарч байна. Дээрх үнэд Владивосток порт дээрх гарах, шилжүүлэн ачих, гаалийн бүрдүүлэлт хийх болон нэмэлт зардлууд ороогүй.

Манай улсаас зорилтот зах зээлд тээвэр хийсэн туршлага

Одоогийн байдлаар Ойрх Дорнодын улсуудын дотор Саудын Араб улсад (Charter) захиалгат нислэгээр тээвэрлэлт хийсэн, ОХУ, Казахстан, Азербайджаны нутаг дэвсгэрээр дамжиж Иран улс хүрч цаашаа усан замаар хүргэгдсэн гэх мэт ганц цөөн тооны тохиолдол байгаа нь тогтмол оновчтой маршрут гарахгүй байгаагийн шалтгаан нь юм. Тээврийн зураглал тооцоо гаргах явц нь Ойрх Дорнодын орнуудын болон дамжин өнгөрөх орнуудын тээврийн нөхцөл, хугацаа, хувилбарууд болон гарцуудыг шинээр тодорхойлоход маш их тооцоолол, хэлэлцээр шаардана. Тээврийн маршрутуудын уялдаа холбоог тодорхойлоход зорилтот орнуудын болон транзитийн улсуудад хамаарч буй олон улсын ачаа тээврийн нөхцөл байдалд үнэлгээ хийгдэхэд хугацаа шаарддаг учраас мах экспортлогчид экспортын гаргах ачаанаасаа хамаарч олон улсад нэр хүндтэй, туршлагатай тээвэр зуучлагч аж ахуйн нэгжүүдийг сонгох нь чухал.

“Бүс ба зам” санаачлага БНХАУ-Пакистаны эдийн засгийн коридор

Судалгааны хүрээнд урт хугацаанд хэрэгжих тээврийн салбарын олон улсын төслүүдийг судалснаар БНХАУ-Пакистаны эдийн засгийн чөлөөт бүсийн хүрээнд тавигдах тээврийн коридорын үзүүлэлтүүдийг үнэлж үзсэн.

Сүүлийн жилүүдэд БНХАУ-ын зүгээс барууныг болон далайн орнуудыг чиглэсэн шинэ

торгоны зам гэж нэрлэгдэх худалдааны сүлжээний дэд бүтцийг байгуулахад асар их хэмжээний хөрөнгө гаргаж хэрэгжүүлж эхлээд байгаа.

БНХАУ-ын “Бүс ба зам” санаачлагын хүрээнд хэрэгжиж эхлээд байгаа “БНХАУ-Пакистаны эдийн засгийн коридор” төсөл нь нийт 46 тэрбум долларын өртөгтэй бөгөөд бүс нутгийн худалдааны харилцааг дэмжих зорилготой. Тус төслийн хүрээнд БНХАУ-ын Шиньжан Уйгурын өөртөө засах орны Урумчи хотыг Пакистан улсын Карачи болон Гвардар усан боомтуудтай холбох авто болон төмөр замын сүлжээг бий болгоно. Гвардар болон Карачи дэхь усан боомтууд нь Арабын тэнгис руу гарах ба ПБХАЗ-ийн орнуудын усан портуудад маш ойртоно.

Ховд аймгийн Ярант боомтоос БНХАУ-ын Урумчи 600 км, Урумчи – Гвардар усан боомт 3800 орчим км ба нийт 4500 гаран км зам туулна (Зураг 30). Харин тус усан портуудаас ПБХАЗ-ийн орнуудын усан портууд маш ойрхон зайтай байгаа нь цаг хугацаа хэмнэж, тээврийн өртгийг бууруулахад чухал ач холбогдолтой.

Цаашид манай улсын баруун бүс мал амьтны эрүүл мэнд болон бусад нөхцлүүдээр мах экспортлоход тохиромжтой бүсэд тооцогдож буйтай холбогдуулан БНХАУ-Пакистаны эдийн засгийн коридорыг тээвэрлэлтийн суваг болгон ашиглах талаар бодлогын түвшинд анхаарах шаардлагатай.

Зураг 30. БНХАУ-Пакистаны эдийн засгийн коридорын зураглал

БНХАУ-ПАКИСТАНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨТ БҮС



Монгол улсын Ховд аймгийн Булган сумаас – Пакистаны Карачи усан порт хүртэл 4500 км.



Пакистаны Карачи усан портоос – Саудын Арабын Даммам усан порт хүртэл 1750 км.

9. ДҮГНЭЛТ

- Манай улсын Засгийн газрын бодлого, мал аж ахуйн өнөөгийн байдал, мах үйлдвэрлэгчид, мал аж ахуйг эдийн засгийн эргэлтэд оруулах, малчдын орлогыг нэмэгдүүлэх бодлого, АХБ, НҮБ, Олон улсын байгууллагуудын зүгээс үзүүлэх дэмжлэг тусалцаа, Олон улсын мал эмнэлэг-эрүүл ахуйн гэрээ хэлэлцээрүүд зэргээс үзэхэд мах экспортлоход тавигдах суурь нөхцөл боломж бүрдсэн байна.
- Монголчууд олон мянган жил бэлчээрийн мал аж ахуй эрхэлж ирсэн бөгөөд үйлдвэрлэлийн мал аж ахуйгаас ялгарах онцлог нь хүний гараар бэлтгэсэн тэжээл, тэжээлийн нэмэлт хэрэглэдэггүй уламжлалтай. Энэ нь Ойрх Дорнодын хэрэглэгчдийн сонирхолд бүрэн нийцэж байдаг.
- Зорилтот орнуудын хүн амын хүнсний соёл нь Халал махтай салшгүй холбоотой бөгөөд хурга, бага насны хонь, ямааны мах хэрэглэх сонирхолтой. Уураг ихтэй хонины махыг шашин болон баяр ёслолын үед хэрэглэж ирсэн уламжлалтай. Арабын орнуудад хонины махны хэрэглээ нь орон нутгийн уламжлал, шашны баяр наадам, тухайлбал Хаж улиралтай холбоотойгоор ихэсч эрэлтийн хэмжээ нэмэгддэг.
- ПБХАЗ – ийн нийт махны хэрэглээ жил ирэх тусам өсөж байгаа бөгөөд 2018 оны байдлаар 28.5% ийн өсөлттэй байна. Үүнд импортын махны эзлэх хувь өндөр байх бөгөөд 2018 оны байдлаар 4.2 тэрбум ам доллар зарцуулснаас Саудын Араб 36%, Кувейт 11%, Катар 9%-ийг эзэлж байна. Үүнээс хонь, ямааны махны импортын дүн нь 776.9 сая ам доллар буюу 18.4%-ийг эзэлж байна.
- Ойрх Дорнодын орнуудын хонь, ямааны махны үнэ ба дундаж хэрэглээ тогтмол өсөлттэй байгаа нь тус орнуудын эдийн засгийн үзүүлэлт, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чиглэсэн бодлого, хөдөө аж ахуйн хязгаарлагдмал байдлаас хамааран цаашид ч тогтмол өсөх хандлага ажиглагдаж байна.
- Саудын Араб, Катар, Кувейт улсуудын хонины импортын махны дийлэнх хувь буюу Австрали улс 70%, Шинэ Зеланд улс 13% хангаж байгаа бөгөөд импортын махны 60% орчим нь хонь, ямааны хөлдүү ястай мах байна.
- Катар улсын жишээн дээр (Гаалийн дундаж үнэ) бизнесийн жишиг тооцоо хийж үзэхэд аж ахуйн нэгжүүд нэгж кг махнаас ойролцоогоор 1 ам.доллар, 1,000 тонд нэг сая орчим доллар (ашгийн коэффициент 18-20%) ашигтай ажиллаж, мөн тогтмол нийлүүлэлт хийж зардлаа буруулж ашиг орлогоо нэмэгдүүлэх боломжтой гэсэн дундаж тооцоолол гарсан.
- Саудын Араб, Катар, Кувейт улсууд нь хаант засаглалтай, Шариатын хуультай боловч өөрийн хууль эрх зүйн тогтолцоогоо олон улсад хэрэглэгдэх хэм хэмжээнүүдэд нийцүүлэн боловсруулж хэрэгжүүлдэг учраас Монгол Улстай худалдааны гэрээ, хэлэлцээр байгуулж хамтарч ажиллах бүрэн боломжтой. Зорилтот орнууд нь Дэлхийн худалдааны, Гаалийн байгууллага зэрэгт элсэн орж олон улсын худалдааны зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулдаг байна.
- Эдгээр улсууд 2003 оноос нэгдсэн Гаалийн холбоо байгуулж худалдаа, эдийн засгийн нэг бүс болох эрх зүйн орчин нь бүрдсэн. Үүнтэй холбоотой гадаад худалдааны эрх зүйн зохицуулалтыг (нийтлэг үйлчлэх) ПБХАЗ-ийн Гаалийн холбооны тухай хууль, стандарт, дүрэм, журмуудаар зохицуулж байгаа. Зорилтот орнуудаас Катар (2011), Кувейт (2007) улсуудтай Монгол улс мал эмнэлгийн салбарт хамтран ажиллах гэрээ,

хэлэлцээр байгуулсан нь Мал эмнэлгийн хорио цээрийн нөхцөл тохирох суурийг бүрдүүлсэн байгаа.

- Ойрх Дорнодын орнуудаас хүлээн зөвшөөрөгдсөн экспортын махны Халал баталгаажуулалтын тогтолцоо нь манай улсад нэвтрээгүй боловч хүн амын тодорхой хувь нь Ислам шашинтай иргэдтэй мөн үйлдвэрүүдэд Мусулман хүний нөөц бэлдэх боломжтой Монгол улсын хувьд Гадаад харилцааны яам, ХХААХҮЯам, Монголын Мусулманы нийгэмлэгүүдийн холбоо, Мал эмнэлгийн ерөнхий газар, Стандартчилал хэмжилзүйн төв, МҮХААТ, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар зэрэг холбогдох байгууллагуудын оролцоо, дэмжлэгээр ПБХАЗ-ийн Халал тогтолцоог нэвтрүүлэх бүрэн боломжтой байна.
- Монгол улс шүлхий өвчний хяналтын хөтөлбөрөө ДМАЭМБ-д албан ёсоор бүртгүүлсэн, холбогдох эрх зүйн баримт бичгийг сайжруулан хэрэгжүүлж, шүлхийн өвчний тандан судалгааг тогтмол хийж, Хуурай газрын мал амьтны эрүүл мэндийн кодын 4-р бүлгийн 1, 2, 3 тоот заалтуудын дагуу малын гоц халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж байгаа боловч одоогоор Манай улс Дэлхийн худалдаанд хориг тавьдаг шүлхий өвчний тайван бус статустай хэвээр байна.
- “Эрүүл бүс тогтоох”, “Хамгаалагдсан аж ахуй байгуулах” замаар малын гаралтай бүтээгдэхүүнийхээ олон улсын худалдааг үргэлжлүүлэн өргөтгөх боломжтой. Энэ бол тогтвортой экспорт хийх гарц мөн бөгөөд экспортлогч, үйлдвэрлэгчдэд эрх зүйн болон мэргэжлийн арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлж татан оролцуулах нь чухал.
- Эрүүл мал бэлтгэж, Халал баталгаажуулалт, мах бэлтгэх үйлдвэрийн технологи-эрүүл ахуйн шаардлагыг чанд мөрдөж ажилласнаар Ойрхи Дорнодын зах зээлд гарах боломж нээлттэй байна.

10. ЗӨВЛӨМЖ

Монгол Улсаас Ойрхи Дорнодын орнуудад мах экспортлох боломжийн судалгаа, боловсруулалтын явцад холбогдох байгууллага, аж ахуйн нэгжид дараах зөвлөмжийг санал болгож байна.

Төрийн зохицуулалт, бодлогын хүрээнд:

- ❖ ПБХАЗ-ийн Ерөнхий нарийн бичгийн газар болон түүний холбогдох газруудтай манай улсын Засгийн газрын түвшинд харилцаа холбоо тогтоож, хамтын ажиллагааны эхлэл тавьж махны экспортын бодлогод тусгаж хэрэгжүүлэх;
- ❖ ПБХАЗ-ийн орнуудыг хариуцсан худалдааны төлөөлөгч томилуулан ажиллуулах асуудлыг салбарын яамнаас Засгийн газарт оруулан шийдвэрлүүлэх;
- ❖ Мал эмнэлэг, хорио цээрийн салбарт хэлэлцээр байгуулсан Катар улсын Эрүүл мэндийн яамны Эрүүл мэнд, хүнсний хяналтын газар, Кувейт улсын Хүнсний хангамжийн асуудал хариуцсан холбогдох мэргэжлийн байгууллагуудтай Монгол Улсын ХХААХҮЯам, Мал эмнэлгийн ерөнхий газар Мал эмнэлэг, хорио цээрийн махны экспортын нөхцөлийг тохирох;
- ❖ Ойрх Дорнодын бүс нутгийн мах, махан бүтээгдэхүүний үлэмж хэсгийг импортлогч Саудын Араб улстай Засгийн газрын түвшинд хамтын ажиллагааг идэвхжүүлж мал

эмнэлэг, хорио цээрийн салбарын хамтын ажиллагааны баримт бичиг, хэлэлцээр байгуулж экспортын хорио цээрийн нөхцөл тохирох эрх зүйн орчин бүрдүүлэх;

- ❖ Саудын Арабын Хүнс болон эмийн хяналтын газартай Монгол Улсын Мал эмнэлгийн ерөнхий газар шууд холбоо тогтоож хамтын ажиллагаа эхлүүлэх, Мал эмнэлэг, хорио цээрийн нөхцөл тохирох эрх зүйн орчинг бүрдүүлэх саналыг өөрсдийн чиглэлээр орон тус бүрийн холбогдох дээд байгууллагуудад уламжлах;
- ❖ Монгол Улсаас дээрхи орнуудад суугаа дипломат төлөөлөгчийн газрууд, холбогдох төрийн болон бизнесийн байгууллагууд зорилтот орнуудад тусгайлсан хурал, үзэсгэлэн зохион байгуулж Монголын бэлчээрийн мал аж ахуй, малын махны онцлогийн тухай сурталчлах, импортлогчдыг урих, тэдгээрээс хөрөнгө оруулах боломжуудыг эрэлхийлэх;
- ❖ ГХЯам, ХХААҮХҮЯам, Монголын Мусулманы нийгэмлэгүүдийн холбоо, Мал эмнэлгийн ерөнхий газар, Стандартчилал хэмжилзүйн үндэсний төв, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим зэрэг төрийн болон мэргэжлийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн Халал итгэмжлэл, баталгаажуулалтыг нэвтрүүлэх ажлын хэсэг байгуулан ажиллаж, улмаар ПБХАЗ-ийн Баталгаажуулалтын байгууллагад хүсэлт гаргаж өөрийн орондоо Халал итгэмжлэлийн эрх авах;
- ❖ Стандарт хэмжилзүйн үндэсний төв, холбогдох байгууллагын хамт төрийн захиргааны төв байгууллагаар уламжилж ПБХАЗ-ийн Стандартын байгууллагатай (GSO) холбоо тогтоож, хамтын ажиллагааг эхлүүлж тус байгууллагын стандартуудын Монгол улсын хууль тогтоомжуудтай нийцэл, хэрэглэх болон нэвтрүүлэх боломж, арга замуудын талаар үнэлгээ хийх;
- ❖ МҮХААТанхим нь зорилтот орнуудын Худалдаа аж үйлдвэрийн танхимуудтай хамтын ажиллагаагаа идэвхжүүлж аж ахуйн нэгжүүдийг хооронд нь холбох, мах, махан бүтээгдэхүүнтэй холбоотой тус улсуудад зохион байгуулагдах олон улсын үзэсгэлэнгүүдэд Монголын экспортлогчдыг оролцуулах, бизнес уулзалтууд хийх, мэдээллээр хангах;
- ❖ ПБХАЗ-ийн Халал бүтээгдэхүүний шаардлага, чанар, аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтийг магадлах мах, махан бүтээгдэхүүний шинжилгээний лабораторийг чадавхижуулах, экспортын бүтээгдэхүүний баталгаажуулалтыг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөх тоног төхөөрөмж, арга зүйгээр хийх нөхцөл бүрдүүлэх, боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх;
- ❖ Зорилтод орнуудад мах, махан бүтээгдэхүүн хамгийн их экспортолдог Австрали (70%), Шинэ Зеланд (13%) болон Казахстаны сайн туршлагаудыг судлан тогтоож, махны экспортын үйл ажиллагаанд нэвтрүүлэх.
- ❖ Тус судалгаанд үндэслэн Ойрх Дорнодын орнуудад Халал мах, махан бүтээгдэхүүн экспортлох боломж, нөхцлийг бодитоор бий болгох үүднээс Халал үйлдвэрлэл бүхий “Хамгаалагдсан аж ахуйн жишиг загвар”-ын ТЭЗҮ, зураг төсвийг боловсруулах, үр дүнгээр нь Монголын Халал мах экспортлогчид, үйлдвэрүүдийг чадавхжуулах.

Аж ахуйн нэгж, экспортлогчдын үйл ажиллагааны хүрээнд:

- ❖ Мал бэлтгэл, төхөөрөх үйлдвэр, мах, махан бүтээгдэхүүн бэлтгэх үйлдвэрлэлээ шаардлагатай стандартын дагуу хөгжүүлэх, технологийн горимоо маш чанд биелүүлэхэд анхаарах;
- ❖ Экспортлогч үйлдвэрүүд мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд өндөр ач холбогдол өгөх;
- ❖ Экспортлогчид зорилтот орнуудын (FASAH, HUKOOMI, AL-NADEEB) нэг цонхны цахим үйлчилгээг ашиглах;
- ❖ Экспортлогч үйлдвэрүүд дангаараа эсвэл консорциум байгуулж зорилтот бүс нутгийн дотоод зах зээлд нэвтрэх худалдааны (Trading) компани байгуулах асуудлыг судлах;
- ❖ Экспортийн чиглэлийн махны үйлдвэрүүд технологийн чадавхаа сайжруулж шаардлагатай хяналт шалгалтыг гүйцэтгэх боломжтой болох;
- ❖ Тогтвортой экспорт хийх бололцоог хангахад чиглэгдсэн хамгаалагдсан аж ахуй байгуулах, малчид, нийлүүлэгчидтэй гэрээгээр хамтран ажиллах, тогтмол үйл ажиллагаа явуулах гарц боломжуудыг тодорхойлж, хэрэгжүүлэх;
- ❖ Стандартын шаардлагыг бүрэн ойлгож, хэрхэн нийцүүлэх талаар туршлага хуримтлуулж байгууллагын дотоод хяналт шалгалт болон мал эмнэлэг, мэргэжлийн хяналттай хамтарч ажиллах, хяналтыг нэмэгдүүлэх, зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх;
- ❖ Экспортлож буй бүтээгдэхүүнийхээ эрүүл ахуй, чанар, сав баглаа, сэврээх, хөлдөөх технологи болон Халалын шаардлагуудыг ягштал биелүүлэх нь маш чухал бөгөөд аливаа зөрчил нь ялангуяа халалтай холбоотой зөрчил нь тухайн улсаас мах авахаас татгалзах хүртэл үр дагаварт хүргэж болзошгүйг анхаарах;
- ❖ Бүс нутгийн хэмжээнд хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчид, бэлчээрийг сайжруулах, хонь, ямаа худалдан авах, бэлтгэх зорилгоор мортгэйж, бизнесийн зээл авах боломжийг бүрдүүлэх;
- ❖ Банкууд хөдөө аж ахуйн зээлдэгч, тодорхой бүс нутаг руу мах экспортлогчдод зориулсан урт хугацааны, тодорхой шалгууртай тусгай бүтээгдэхүүнийг боловсруулж санал болгох.

11. ХАВСРАЛТ

Хавсралт 1. Халал аргаар мал төхөөрөх

Халал төхөөрөх тухай (хоолойг нь огтлон) Куран судрын хэд хэдэн айлдварт дурьдаж тушаасан байдаг. “Аллахын алдраар цус гаргаагүй (хоолойгоо огтлохгүйгээр) алсан аливаа амьтны мах (харам)”⁶⁴ хэмээн айлдсан айлдварт малын мах нь яаж харам болохыг хэлэхээс гадна хоолойг нь огтлоход журмын дагуу Аллахын нэрийн өмнөөс мусулман хүн төхөөрөх ёстой гэдгийг анхааруулсан байдаг.

- 1- Халал аргаар мал төхөөрөхийг зөвхөн Мусулман хүн гүйцэтгэх шаардлагатай. Өөрөөр хэлвэл мусулманчуудын мусулман хэмээн гэрчилсэн хүнийг хэлнэ. Тэгвэл мусулман ёсоор мал төхөөрөх аргыг сайн эзэмшсэн ч гэсэн мал төхөөрч б айгаа хүн мусулман биш л юм бол тэр хүний төхөөрсөн малын махыг идэхийг хориглоно.



- 2- Мал төхөөрөх мусулман хүн: Насанд хүрсэн байх, ухаан санаа эрүүл, сайн мууг ялгаж сурсан, халал журмаар мал төхөөрөхийг эзэмшсэн, ислам шашны анхны мэдэгдэхүүнтэй, хийж байгаа ажлынхаа Аллахын өмнө болон мусулман ард түмний өмнөх үүрэг хариуцлагыг ухаарсан мусулман хүн байх.
- 3- Төхөөрөх мал нь Ислам шашны дагуу махыг нь идэж болох амьтдын төрлүүдээс байх шаардлагатай. Амьтдын болон шувуудын төхөөрөхөөс нь өмнөх идэж уусан тэжээлийг нь ч анхааран хянах хэрэгтэй. Ялангуяа тахиаг төхөөрөхөөс өмнөх 2-3 хоног өтгөн шингэн гэх мэт шашны дагуу бохир гэж үзсэн зүйлсээр тэжээгдээгүйг анхаарах шаардлагатай.
- 4- Мал төхөөрөхөөс өмнө амьд байх. Цохиж ухаан алдуулсан эсвэл тогонд цохиулсан мал нь эргэлзээтэй байдал бий болгодог учраас халал төхөөрөхөд тохиромжгүй болно. Хялбар төхөөрөх зорилгоор тогонд цохиулах эсвэл өөр ямар нэгэн юмаар цохин тэнхээгүй болгох зэрэг үйлдэлүүд нь үхэх магадлал өндөр учраас ислам шашинд зөвшөөрөхгүй. Энэ тохиолдолд мал, амьтад нь цусаа гүйцэд гаргаж чаддаггүй юм. Ислам шашинд цус бол хориглосон харам зүйлсийн нэг.

Малын толгойг огтлоход улаан хоолой, мөгөөрсөн хоолой, гүрээний судас, хураагуур судас гээд дөрвөн зүйл таслагдана. Дээрх дөрвөн зүйл нь хурц иртэй хутгаар ганц удаагийн үйлдлээр таслагдах ёстой. Энэ дөрвийг хутгаар огтлон цус гүйцэд гарсны дараа нурууны ясыг гаргаж нугасыг нь тасална.

⁶⁴ Куран судрын монгол утга агуулга. Майда бүлэг 3. 2019 Улаанбаатар

Хавсралт 2. ПБХАЗ-ийн мах, махан бүтээгдэхүүний стандартууд

Мах, Махан бүтээгдэхүүнд тавигдах стандарт болон техникийн журмууд		
Номер	Дуг аар	
1	СХБ 1816	Татсан Мах المفروم اللحم
2	СХБ 996	Үхэр, Хонь ба Ямааны шинэ мах. الطازجة والمعزة والضأن والجاموس البئر لحوم.
3	СХБ 997	Үхэр, Хонь ба Ямааны хөлдөөсөн, сэврээсэн мах, والمعزة المفرومة والمبردة والمعزة والضأن والجاموس البئر لحوم
4	СХБ 948	Бургерийн махан таташ زة البرجر لحم - زة اللحوم
5	СХБ 814	Prepared meat – Sausage (Махан таташ - Зайдас) السجق - المعهزة اللحوم
6	СХБ 834	Fresh, chilled and frozen Camel meat (Тэмээний шинэ, сэврээсэн болон хөлдөөсөн мах) والمعزة المفرومة والمبردة الطازجة الجمال لحوم
7	СХБ 1293	Prepared meats: canned corned Beef and Mutton meat- Бэлэн бүтээгдэхүүн: Үхэр, хонины лаазалсан мах (الكورنيذ والضأن البئر لحوم) المعلبة.
8	СХБ 504	Canned corned beef. Үхрийн лаазалж, нөөцөлсөн мах لحم المعلب المملح البئر لحم
9	СХБ 2055-1	Halal food part (1): general requirement-Халал хүнс: 1-р хэсэг. Ерөнхий шаардлага
10	СХБ 2055-2	Halal food - part (2): guidelines for Halal food certification bodies and their accreditation requirements- Халал хүнс: 2-р хэсэг. Халал хүнс баталгаажуулах байгууллагын удирдамж, тэдгээрийн магадлан итгэмжлэлийн шаардлага удирдамж (فيذغلا للملا - عزجلا لولأ: تاطار نشلا قمعلا : الشرطاطات العامة لجهات اصردار شهادات المرزبجات الحلال - الجزء الثاني)
11	СХБ 993	Animal slaughtering requirements according to Islamic law -Исламын хууль дүрмийн дагуу мал төхөөрөхөд тавих шаардлага (الشرعية الحكام طبقا الحيوان ذبح اشترطاطات الشريعة السالمية)
12	СХБ 2231	General Requirements for the materials intended to come into contact with food. - Хоол хүнсэнд орж байгаа харьцаж байгаа бэлтгэхэд зориулагдсан хэрэглэгдэхүүнд тавигдах ерөнхий шаардлага
13	СХБ HAC/RCP 58	Code of hygienic practice for meat. (код) (الصحية الشرطاطات مدونة)
14	СХБ 1060	General requirements for preparation and handling of Shawaurma. -Shawaurma-г гар аргаар бэлтгэх, харьцах ерөнхий шаардлага (الشرطاطات العامة الشرطاطات)
15	СХБ 1818	Martadella (Luncheon). (зуурмаг (өдрийн хоол)) المرزبلا لحم
16	СХБ 815	Code of hygienic practice for preparation, transportation, handling and storing of fresh meat.-Шинэ мах бэлтгэх, савлах, хадгалах, тээвэрлэх, гар аргаар ангилах, эрүүл ахуйн дадлын дүрэм
17	СХБ1860	Processed Edible Animal Tallaw.- Мал амьтны боловсруулсан Талло – идэшний өөхөн тос
18	СХБ 2276	Detection of lard in food- Хүнсэнд гахайн өөх илрүүлэх
19	СХБ ISO 5554	Meat products - determination of starch content (reference method). Махан бүтээгдэхүүнүүд-Цардуулын хэмжээний тодорхойлох (хурдавчилсан арга)
20	СХБ ISO 936	Meat and meat products – Determination of Total ash - Мах, махан бүтээгдэхүүн - Нийт үнсний хэмжээг тодорхойлох
21	СХБ ISO 2294	Meat and meat products - determination of total phosphorus content (reference method). Мах, махан бүтээгдэхүүн - Фосфорын хэмжээ тодорхойлох (хурдавчилсан арга)
22	СХБ ISO 2917	Meat and meat products -Measurement of PH (Reference method).-Мах, махан бүтээгдэхүүн - pH тодорхойлох (хурдавчилсан арга)
23	СХБ ISO 2918	Meat and meat products - Determination of nitrite content (Reference method) Мах, махан бүтээгдэхүүн. Нитрит тодорхойлох (хурдавчилсан арга)

24	СХБ ISO 4133	Meat and meat products determination of glucono- delta-lactone content (reference method) Мах, махан бүтээгдэхүүн. Глюкон делта лактон тодорхойлох. (хурдавчилсан арга)
25	СХБ ISO 3496	Meat and meat products –Determination of hydroxyproline content. Мах, махан бүтээгдэхүүн. Гидроксипролин тодорхойлох
26	СХБ ISO 937	Meat and meat products -Determination of nitrogen content (Reference method). Мах, махан бүтээгдэхүүн дэх азот тодорхойлох (хурдавчилсан арга)
27	СХБ ISO 4134	Meat and meat products – Determination of L-(+)- glutamic acid content – Reference method-Мах, махан бүтээгдэхүүнүүд-глутамины хүчил L -(+) тодорхойлох
28	СХБ ISO 13720	Meat and meat products -- Enumeration of presumptive Pseudomonas spp Мах, махан бүтээгдэхүүн. Pseudomonas spp-ын тоог тоолох
29	СХБ 1998	Boiled dried salted anchovies. Чанаж хатаасаасан, давсалсан загас
30	СХБ 835	organs and viscera of mutton, goat, cattle, camel and buffalo (chilled and frozen- Хонь, ямаа, үхэр, тэмээ болон буффало үхрийн хөргөсөн, хөлдөөсөн гэдэс, дотор эрхтэн
31	СХБ 2300	chilled marinated meats- Хөргөж, давсанд сойсон мах
32	СХБ 2203	packaged meat containing vegetables and sauce – Хүнсний ногоо болон сүмстэй савласан мах
33	СХБ 2206	prepared meats - meat treated with salt solution and heat treated. Бэлтгэсэн мах – Давсны уусмал болон дулааны аргаар боловсруулсан мах
34	СХБ 2204	prepared meat - heat treated pressed meats- Бэлтгэсэн мах –Дулааны аргаар боловсруулж вакумдсан мах
35	СХБ 2036	meat products – pastrami-халуун ногоогоор амталж утсан махан бүтээгдэхүүн-
36	СХБ 1924	dried meat.-хатсан мах
37	СХБ 1921	prepared meats : dry and semi-dry fermented sausage - Бэлтгэсэн мах- Бүрэн ба хагас утлагат хиам
38	СХБ 1329	processed meat: chilled or frozen meat kofta.-боловсруулсан мах- Хөргөсөн, хөлдөөсөн Kofta мах
39	СХБ 1882	methods for physical and chemical analysis of meat and meat products.- Мах, махан бүтээгдэхүүний физик-химийн шинжилгээний аргууд
40	СХБ 91	meat and meat products – determination of moisture content (reference method. Мах, махан бүтээгдэхүүн- Чийгийн агууламжийн тодорхойлох (хурдавчилсан арга)
41	СХБ 88	meat and meat products -determination of chloride content (reference method). Мах, махан бүтээгдэхүүн- Хлорын агууламж тодорхойлох (хурдавчилсан арга)
42	СХБ 655	methods of microbiological examination of meat, fish, shell-fish and their products. Мах, загас, хясаа тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний микробиологийн шинжилгээний арга
43	СХБ 593	meat and meat products — physical tests. Мах, махан бүтээгдэхүүн. Физикийн шинжилгээ
44	СХБ 592	methods of sampling meat and meat products. Мах, махан бүтээгдэхүүнээс дээж авах арга
45	СХБ 849	meat and meat products - determination of creatinine content. Мах, махан бүтээгдэхүү. Креатинин тодорхойлох
46	СХБ ISO 3091	meat and meat products - determination of nitrate content (reference method). Мах, махан бүтээгдэхүүн. Нитрат тодорхойлох (хурдавчилсан арга)
47	СХБ ISO 6887-2	Microbiology of food and animal feeding stuffs - Preparation of test samples, initial suspension and decimal dilutions for microbiological examination - Part 2: Specific rules for the preparation of meat and meat products. Хүнс, малын тэжээлийн микробиологи. – Микробиологийн шинжилгээнд дээж бэлтгэх, анхдагч суспенци ба аравтын шингэлэлт хийх. 2-р хэсэг Мах махан бүтээгдэхүүн бэлтгэх тусгай дүрэм

48	СХБ ISO 6887-4	Microbiology of food and animal feeding stuffs - Preparation of test samples, initial suspension and decimal dilutions for microbiological examination - Part 4: Specific rules for the preparation of products other than milk and milk products, meat and meat products, and fish and fishery products. Хүнс, малын тэжээлийн микробиологи. – Микробиологийн шинжилгээнд дээж бэлтгэх, анхдагч суспенци ба аравтын шингэлэлт хийх, 4-р хэсэг Сүү, сүүн бүтээгдэхүүнээс бусад мах махан бүтээгдэхүүн загас, загасан бүтээгдэхүүн бэлтгэх тусгай дүрэм бэлтгэх тусгай дүрэм
49	СХБ ISO 17604	Microbiology of food and animal feeding stuff - Carcass sampling for microbiological analysis. Хүнс, малын тэжээлийн микробиологи. –микробиологийн шинжилгээнд гулуузаас дээж авах


Хавсралт 3. ПБХАЗ-ийн Гаалийн тухай хууль 2003 он

www.gcc-sg.org



Хавсралт 4. ПБХАЗ-ийн орнуудад импортлогдох хүнсний бүтээгдэхүүнд тавих хяналт, шаардлагын удирдамж 2016 он

www.gcc-sg.org



Хавсралт 5. Гаалийн холбооны импортын тариф 2017 он

The Unified Customs Tariffe for GCC States 2017

Section I

LIVE ANIMALS; ANIMAL PRODUCTS

Notes.

- 1.- Any reference in this Section to a particular genus or species of an animal, except where the context otherwise requires, includes a reference to the young of that genus or species.
- 2.- Except where the context otherwise requires, throughout the Nomenclature any reference to "dried" products also covers products which have been dehydrated, evaporated or freeze-dried.

Chapter 1

Live animals

Note.

- 1.- This Chapter covers all live animals except :
- (a) Fish and crustaceans, molluscs and other aquatic invertebrates, of heading 03.01, 03.06 or 03.07; or 03.08
- (b) Cultures of micro-organisms and other products of heading 30.02; and
- (c) Animals of heading 95.08.

DUTY RATE	UINT	DESCRIPTION	H.S CODE	HEADING NO
		Live horses, asses, mules and hinnies.		01.01
		- Horses		
		- - Pure-bred breeding animals:		
Free	VALUE	- - - Of Arab breed	01 01 21 10	
Free	VALUE	- - - Other	01 01 21 90	
		- - Other:		
Free	VALUE	- - - Horses for sport	01 01 29 10	
Free	VALUE	- - - ponies	01 01 29 20	
Free	VALUE	- - - Other	01 01 29 90	
Free	VALUE	- Asses	01 01 30 00	
Free	VALUE	- Other	01 01 90 00	
		Live bovine animals.		01.02
		- bovine :		
Free	VALUE	- - Pure-bred breeding animals	01 02 21 00	
Free	VALUE	- - Other	01 02 29 00	
		- Buffalo:		
Free	VALUE	- - Pure-bred breeding animals	01 02 31 00	
Free	VALUE	- - Other	01 02 39 00	
Free	VALUE	- Other	01 02 90 00	
		Live swine.		01.03
PROHIBITED	ممنوع استيرادہ	- Pure-bred breeding animals	01 03 10 00	
		- Other:		
PROHIBITED	ممنوع استيرادہ	- - Weighing less than 50 kg	01 03 91 00	
PROHIBITED	ممنوع استيرادہ	- - Weighing 50 kg or more	01 03 92 00	
		Live sheep and goats.		01.04
		- sheep:		

DUTY RATE	UINT	DESCRIPTION	H.S CODE	HEADING NO
Free	VALUE	--- Pure- bred breeding	01 04 10 10	
Free	VALUE	--- Other	01 04 10 90	
		- Goats:		
Free	VALUE	--- Pure- bred breeding	01 04 20 10	
Free	VALUE	--- Other	01 04 20 90	

Chapter 2
Meat and edible meat offal

Note.

I - This Chapter does not cover :

- (a) Products of the kinds described in headings 02.01 to 02.08 or 02.10, unfit or unsuitable for human consumption;
(b) Guts bladders or stomachs of animals (heading 05.04) or animal blood (heading 05.11 or 30.02); or
(c) Animal fat, other than products of heading 02.09 (Chapter 15).


DUTY RATE	UINT	DESCRIPTION	H.S CODE	HEADING NO
		Meat of bovine animals, fresh or chilled.		02.01
Free	VALUE	- Carcasses and half-carcasses	02 01 10 00	
Free	VALUE	- Other cuts with bone in	02 01 20 00	
Free	VALUE	- Boneless	02 01 30 00	
		Meat of bovine animals, frozen.		02.02
5%	VALUE	- Carcasses and half-carcasses	02 02 10 00	
5%	VALUE	- Other cuts with bone in	02 02 20 00	
		- Boneless:		
5%	VALUE	--- Minced	02 02 30 10	
5%	VALUE	--- Other	02 02 30 90	
		Meat of swine, fresh, chilled or frozen.		02.03
		- Fresh or chilled:		
special goods	سلع خاصة	- - carcasses and half-carcasses	02 03 11 00	
special goods	سلع خاصة	- - Hams, shoulders and cuts thereof, with bone in	02 03 12 00	
special goods	سلع خاصة	- - Other	02 03 19 00	
		- Frozen:		
special goods	سلع خاصة	- - carcasses and half-carcasses	02 03 21 00	
special goods	سلع خاصة	- - Hams, shoulders and cuts thereof, with bone in	02 03 22 00	
special goods	سلع خاصة	- - Other	02 03 29 00	
		Meat of sheep or goats, fresh, chilled or frozen.		02.04
Free	VALUE	- Carcasses and half-carcasses of lambs, fresh or chilled	02 04 10 00	
		- Other meat of sheep, fresh or chilled:		

DUTY RATE	UINт	DESCRIPTION	H.S CODE	HEADING NO
Free	VALUE	- - carcasses and half-carcasses	02 04 21 00	
Free	VALUE	- - Other cuts with bone in	02 04 22 00	
Free	VALUE	- - Boneless	02 04 23 00	
5%	VALUE	- Carcasses and half-carcasses of lambs, frozen	02 04 30 00	
		- Other meat of sheep, frozen:		
5%	VALUE	- - Carcasses and half-carcasses	02 04 41 00	
5%	VALUE	- - Other cuts with bone in	02 04 42 00	
		- - Boneless:		
5%	VALUE	- - - Minced	02 04 43 10	
5%	VALUE	- - - Other	02 04 43 90	
		- Meat of goats:		
		- - - Carcasses and half-carcasses		
Free	VALUE	- - - - Fresh or chilled	02 04 50 11	
5%	VALUE	- - - - Frozen	02 04 50 12	
		- - - Other cuts with bone in:		
Free	VALUE	- - - - Fresh or chilled	02 04 50 21	
5%	VALUE	- - - - Frozen	02 04 50 22	
		- - - Boneless:		
Free	VALUE	- - - - Fresh or chilled	02 04 50 31	
5%	VALUE	- - - - Frozen	02 04 50 32	
		Meat of horses, asses, mules or hinnies, fresh, chilled or frozen.		02.05
5%	VALUE	- - - Meat of horses	02 05 00 10	

Хавсралт 6. ПББТ –ийн талаарх мэдээлэл, холбогдох хаяг

Цахим хаяг: <http://www.ПББТ.org.sa/en/contact/#>

Зураг байдлаар:

+966112061111 | info@gac.org.sa |
 
 About GAC | GAC Services | Training | Accredited Bodies | Documents | Media Center | Cont

Home → Contact Us

Contact Us

Contacts ▼

Name

Email

subject

message

Our Offices

Address :
Kingdom of Saudia Arabia P.O.Box 85245 Riyadh
11691

Phone number :
+966112061111

Fax :
+966114566479

E-mail :
info@gac.org.sa

Хавсралт 7. Мах, Махан бүтээгдэхүүнийг экспортлоход олгох Халал төхөөрөлтийн гэрчилгээ.

Template No (1): Halal Slaughtering Certificate for Export of Meat and Meat Products

